МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2020

МОНГОЛБАНК

ЖИЛИЙН ТАЙЛАН 2020

Монголбанкны Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэн

Өмнөх үг

Өнгөрсөн 2020 бол эдийн засаг, нийгмийн амьдралд олон өөрчлөлтийг бий болгосон, хүнд сорилтын жил болж өнгөрч байна. Монгол Улсын эдийн засаг 2020 онд 5.3 хувиар агшиж, эдийн засгийн бус шалтгаантай хямралын жил байлаа. Ковид-19 цар тахал бүх улсад, бүх салбарт, бүх хүний амьдралд нөлөөлж байгаа хэдий ч 2020 онд хүлээгдэж байсан эдийн засаг, санхүүгийн салбарын олон том сорилтуудыг бид хамтдаа амжилттай даван гарч чадлаа. Эдгээрээс 3 ажлыг онцолъё.

Нэгд, Ковид-19 цар тахлын үед эдийн засаг, банк, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, иргэд, бизнес эрхлэгчид, санхүүгийн байгууллагуудад учирч буй санхүүгийн хүндрэл, дарамтыг зөөлрүүлэх зорилгоор шаардлагатай арга хэмжээг олон улсын туршлага, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байна. Мөчлөг сөрсөн хэлбэрээр мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлж, 2020 онд бодлогын хүүг 11 хувиас бууруулж түүхэн доод түвшин болох 6 хувьд хүргэлээ. Эдгээр бодлогын арга хэмжээ нь цаашдын эдийн засгийн сэргэлт, зээлийн хүүний бууралтад шууд нөлөөтэй. Хоёрт, Монгол Улс Олон улсын санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх байгууллага (ФАТФ)-ын “Саарал жагсаалт”-аас богино хугацаанд гарав. Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлтэй улс орнуудын “Хар жагсаалт”-аас хасах шийдвэрийг Европын Комиссоос мөн гаргаад байна. Гуравт, цар тахал эдийн засагт хүнд цохилт болж байгаа хэдий ч төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтвортой байлаа. Үүнд, Монголбанкны алтны худалдан авалт нэмэгдсэн, гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх оны түвшинд хадгалагдсан, олон улсын санхүүгийн байгууллага, донорууудын том дүнтэй санхүүжилт орж ирсэн нь гол нөлөө үзүүлэв. Түүнчлэн олон секторт нүүр тулж байсан богино хугацааны гадаад өрийн дарамтыг бууруулав. Тухайлбал, Хятадын ардын банктай байгуулсан мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн хугацааг дахин 3 жилээр сунгасан, 600 сая ам.долларын нэрлэсэн үнэ бүхий Номад бондыг амжилттай арилжаалж Чингис, Мазаалай бондыг дахин санхүүжүүлэв.

Өнгөрч буй 2020 онд Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийг амжилттай дуусгаж, олон улсын санхүүгийн байгууллагууд, донорууудтай хамтын ажиллагаагаа амжилттай үргэлжлүүлж байна. Монголбанк дунд хугацаанд баримтлах стратеги, бодлого, хөтөлбөрийг эрх бүхий байгууллагуудтай хамтран батлан гаргаж, хэрэгжүүлж эхэллээ. Улсын Их Хурлаас “Зээлийн хүүг бууруулах стратеги”, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг, Монголбанкнаас “Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй, үр ашигтай банкны тогтолцоог бий болгох банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг батлав. Эдгээр баримт бичгүүд нь харилцан уялдаатай, эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэж байгаа болно. Энэ хүрээнд инфляцын зорилтыг 2021 оноос эхлэн 6 хувь болгон шинэчилж, банкуудын зээлийн жигнэсэн дундаж хүүг 2023 оны эцэст жилийн 12 хувьд хүргэж бууруулах зорилт тавилаа. Энэ 2020 онд инфляц дунд хугацааны зорилтот түвшинд байж, шинээр олгосон зээлийн дундаж хүү 1.2 нэгж хувиар

буурч, Монголбанкинд тушаасан алтны хэмжээ түүхэн рекорд түвшин болох 23.6 тоннд хүрч, гадаад валютын албан нөөцийн хэмжээ 4.5 тэрбум ам.долларын босгыг давж гарлаа.

Цар тахлын улмаас бодит эдийн засаг агшиж, банк, санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдах төлөв үүссэнийг харгалзан Монголбанкнаас иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах, банкны системийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн арга хэмжээнүүдийг шуурхай хэрэгжүүлж ажиллалаа. 2020 оны 3 дугаар сард “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д онцгой нөхцөл байдал үүссэн хугацаанд мөрдөх нэмэлт, өөрчлөлтийг оруулахын зэрэгцээ эргэн төлөлт нь доголдсон зээлүүдэд бүтцийн өөрчлөлт хийж, төлбөрийн хугацааг хойшлуулахаар шийдвэрлэв. Эдгээр арга хэмжээний хүрээнд 2020 оны эцсийн байдлаар төлбөрийн хүндрэлд орсон 141,171 зээлдэгчийн 1.27 их наяд төгрөгийн хэрэглээний зээл, 2,540 ААН-ийн 2.8 их наяд төгрөгийн бизнесийн зээл, 44,956 өрхийн 2.3 их наяд төгрөгийн ипотекийн зээлийн эргэн төлөлтийг хойшлуулаад байна.

Ирж буй 2021 онд сорилт үргэлжлэх хэдий ч, эдийн засгийн цаашдын төлөв эерэг гэгээтэй байна. Ковид-19-ийн вакцинууд гарч, улс орнуудад вакцинжуулалт эхлээд байгаа тул глобал эдийн засгийн сэргэлт үргэлжилнэ. Төсөв, мөнгөний бодлогын дотоод эдийн засгийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээний үр нөлөө ч цаашид нэмэгдэнэ. Үүний үр дүнд эдийн засаг алгуур үргэлжлэн сэргэж, ирэх жил 6 орчим хувиар өсөх, инфляц зорилтот түвшинд хадгалагдах, төлбөрийн тэнцлийн дарамт бага байхаар байна. Энэхүү эдийн засгийн сэргэлт, түүний иргэн, аж ахуйн нэгж бүрт очих үр нөлөө нэмэгдэхэд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, сорилтыг боломж болгох итгэл, манлайлал чухал үүрэг гүйцэтгэх болно.

Бид хамтдаа сорилтыг боломж болгож, Монгол Улсын эдийн засаг цаашид эрчимтэй өснө гэдэгт итгэл төгс байна. Монголбанк эдийн засгийг дэмжих, тогтвортой байлгахад чиглэсэн санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх бодлого, арга хэмжээгээ цаашид ч үргэлжлүүлэх болно.

Монгол Улс хөгжин цэцэглэж, мандан бадрах болтугай!

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ

ГАРЧИГ

1.МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ 9

1.1.Бодит сектор 9
1.2.Гадаад сектор....13
1.3 Мөнгө, санхүүгийн сектор 18
1.4 Монгол улсын нэгдсэн төсөв 22

2. ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ 27

2.1 Мөнгөний бодлого 27
2.2 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо 31
2.3 Банкны салбарын тогтвортой байдлыг хангах бодлогын хэрэгжилт....36
2.4 Гадаад валютын улсын нөөцийн удирдлага....44
2.5 Монгол улсын үндэсний төлбөрийн систем....45
2.6 Банк санхүүгийн салбарын хууль тогтоомжийн өөрчлөлт, шинэчлэл 50
2.7 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр 51

3.МОНГОЛБАНКНЫ МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА 55

3.1 Нээлттэй захын үйл ажиллагаа....55
3.2 Төв банкны байнгын санхүүжилт....57
3.3 Бусад санхүүжилт 57
3.4 Засгийн газрын үнэт цаас 59
3.5 Монголбанкны валютын захын оролцоо 60
3.6 Алтны санхүүжилт, үнэт металлын худалдан авах үйл ажиллагаа 63

4. МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН 65

4.1 Монголбанкны бүтэц, зохион байгуулалт 65
4.2 Гадаад харилцаа хамтын ажиллагаа....66
4.3 Олон нийттэй харилцах харилцаа 67
4.4 Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх арга хэмжээ....69
4.5 Дотоод аудит....79
4.6 Эрсдэлийн удирдлага....80
4.7 Бэлэн мөнгөний удирдлага....83
4.8 Мэдээлэл технологи....84
4.9 Монголбанкнаас 2020 онд гаргасан эрх зүйн акт, шийдвэрийн хураангуй 85
4.10 Эдийн засгийн судалгаа, сургалтын үйл ажиллагаа 88

5.АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 91

6. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТ (ХУРААНГУЙ) 191

МОНГОЛ УЛСЫН МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

1

1.1 БОДИТ СЕКТОР

Эдийн засгийн бодит сектор

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит хэмжээ 2020 онд өмнөх оноос 5.3%[1]-иар буурчээ. Эрэлт буюу эцсийн ашиглалт[2] талаас эдийн засгийн өсөлтийн 3.8 нэгж хувийг эцсийн хэрэглээ, 10.1 нэгж хувийг цэвэр экспорт, -19.3 нэгж хувийг хөрөнгийн нийт хуримтлал тус тус бүрдүүлжээ.

Ковид-19 цар тахал, түүнтэй холбоотой хориг арга хэмжээнүүдийн нөлөөгөөр бараа, үйлчилгээний импорт 8.9%-иар буурч, эдийн засгийн өсөлтөд 10.2%-ийн эерэг нөлөө үзүүлсэн бол экспорт 0.08%-иар буурч, өсөлтөд 0.1%-ийн сөрөг нөлөө үзүүлсэн. Экспортын дийлэнх хувийг дангаараа бүрдүүлдэг уул уурхайн экспорт 4%-иар өссөн бол уул уурхайн бус бүтээгдэхүүний экспорт ихээр буюу 38%-иар буурч нийт экспорт 0.08 хувиар буурсан байна. Түүнчлэн манай улсын хөрөнгө оруулалтын урсгал цэвэр дүнгээр өмнөх оны гүйцэтгэлээс 42.5%-иар буурч[3], эдийн засгийн өсөлтөд хамгийн их буюу 19.3 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлжээ. Мөн нийт эдийн засгийн өсөлтөд засгийн газрын хэрэглээ 2.2 нэгж хувийн, өрхийн хэрэглээ 1.6 нэгж хувийн эерэг нөлөөг үзүүлэв (Зураг 1. 1).

Зураг 1. 1 ДНБ-ий өсөлт, эцсийн ашиглалтын аргаар

Эх сурвалж: ҮСХ

Зураг 1. 2 ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэлийн аргаар

Эх сурвалж: ҮСХ

Уул уурхай, олборлох салбарын нэмэгдэл өртөг өмнөх оноос 9.4 хувиар буурч, эдийн засгийн өсөлтөд 2 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ. Үүнд чулуун нүүрсний олборлолт болон экспортын хилийн үнэ буурсан нь голлон нөлөөлсөн. Харин дэлхийн зах зээл дээрх алт, зэс, төмрийн хүдрийн үнэ өссөн нь сөрөг нөлөөг саармагжуулсан байна (Зураг 1. 2).

[1] Үйлдвэрлэлийн аргаар тооцсон бодит ДНБ-ий өсөлт
[2] Эцсийн ашиглалтын аргаар тооцсон бодит ДНБ-ий өсөлт -5.4%-тай байна.
[3] Үүнд уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын агшилт хамгийн их нөлөөтэй байна.

Эрдэс баялгийн бус салбар

Уул уурхайн бус салбар нийт эдийн засгийн өсөлтийг 3.4%-иар доош чангаажээ. Тодруулбал тээвэр агуулахын салбар 20.1 хувиар буурч өсөлтөд 1.5 нэгж хувь, худалдааны салбар 11.1 хувиар буурч өсөлтөд 1.4 нэгж хувь, барилгын салбар 7.4 хувиар буурч өсөлтөд 0.3 нэгж хувь болон үйлчилгээний салбар 0.8 хувиар буурч өсөлтөд 0.2 нэгж хувийн сөрөг нөлөөг тус тус эдийн засгийн өсөлтөд үзүүлсэн байна (Зураг 1. 3).

Зураг 1. 3 ДНБ-ий өсөлт, үйлдвэрлэлийн салбаруудаар

Эх сурвалж: ҮСХ

Зураг 1.4 ХАА, аж үйлдвэрлэлийн салбаруудын өсөлт

Эх сурвалж: ҮСХ

Зураг 1. 5 Үйлчилгээний салбаруудын өсөлт

Эх сурвалж: ҮСХ

Инфляц

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлд тусгаснаар Төв банк инфляцыг 2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулах зорилттой ажиллав.

КОВИД-19 цар тахал 2020 онд эдийн засгийн гадаад болон дотоод орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлснээр идэвхжил саарав. Үүнийг дагаад хэрэглээний үнийн индексээр хэмжсэн инфляц улсын хэмжээнд саарах хандлага үргэлжилж, оны эцэст 2.3 хувь болж буурав. Суурь инфляц алгуур саарахын зэрэгцээ нэг удаагийн болон нийлүүлэлтийн шинж чанартай үнийн өөрчлөлт инфляцыг бууруулах чиглэлд хөтлөв (Зураг 1.6).

Тайлант оны эхэнд хэрэглээний зээлийн өсөлт даруухан байсан ч тэтгэврийн зээл тэглэсэн, цалин тэтгэвэр нэмэгдэж өрхийн орлого өссөн зэрэг нь хэрэглээг дэмжин, эрэлтийн гаралтай инфляц харьцангуй тогтвортой байх хүлээлттэй байв. Харин цар тахал болон хөл хорионы арга хэмжээнүүд хэрэглээ болон үйлдвэрлэлд хязгаарлалт үүсгэн, эдийн засагт оролцогчдын хүлээлтэд сөргөөр нөлөөлснөөр дотоод эрэлт суларлаа. Хэдийгээр эдийн засагт үүссэн шокыг зөөллөх зорилготой макро тогтворжуулах бодлогын багц арга хэмжээнүүд эрэлтийг тэтгэх нөлөөтэй байсан ч цар тахлын сөрөг нөлөө давамгайлснаар эрэлтийн шалтгаантай инфляц оны туршид саарах хандлагатай байв.

2020 онд нэг удаагийн болон нийлүүлэлтийн шинжтэй үнэ буурсан нь ерөнхий инфляц бага түвшинд хадгалагдахад нөлөөллөө. Тухайлбал, шатахуун болон хатуу түлш жилийн инфляцыг 2.6 нэгж хувиар бууруулах нөлөө үзүүлсэн байна. Харин өмнөх жилүүдэд инфляцыг өдөөх гол бүрэлдэхүүн болж байсан махны үнэ оны эцэст жилийн инфляцын 1.1 нэгж хувийг бүрдүүлжээ.

Зураг 1.6 Улаанбаатар хотын сарын болон жилийн инфляц

Хүснэгт 1.1 Улаанбаатар хотын жилийн инфляцын задаргаа

Нэр	Жин	Жилийн өсөлт	Жилийн инфляцад эзлэх хувь
Мах	0.10	11.9%	1.1%
Хүнсний ногоо	0.02	20.3%	0.4%
Шатахуун	0.06	-18.4%	-1.0%
Хатуу түлш	0.03	-33.2%	-1.6%
Нийт	0.21		-1.1%

Үнийн түвшний өөрчлөлтөд өндөр жинтэй бараа бүтээгдэхүүнүүдийг авч үзвэл:

- **Махны үнэ:** Хөл хорионы эхэн үед хүнс нөөцлөх хандлага бий болсонтой холбоотой өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнэ, тэр дундаа хэрэглээний сагсанд өндөр жинтэй махны үнэ 1-р сард улирлын хандлагаасаа давж, 11-р сард улирлын хандлагаасаа эсрэг өсч, үнийн нөлөө нь нэмэгдлээ. Харин 12-р сард хөл хорионы арга хэмжээ үргэлжилж байсан ч махны үнэ харьцангуй тогтворжиж инфляцын 1.1 нэгж хувийг бүрдүүлэв.

- **Шатахууны үнэ:** Цар тахлын нөлөөгөөр 2020 онд дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ эрчимтэй буурснаар дотоодын шатахууны үнэ II улиралд 400 орчим төгрөгөөр хямдарсан тул оны эцэст инфляцыг -1.0 нэгж хувиар бууруулах нөлөөг үзүүлжээ.

- **Хатуу түлш:** Засгийн газраас хэрэглээний сагсны хатуу түлшний бүлэгт байдаг сайжруулсан түлшний үнийг хөнгөлөлттэй үнээр худалдах шийдвэр гаргаснаар 12-р сараас эхлэн хатуу түлшний бүлэг инфляцыг -1.6 нэгж хувиар бууруулах нөлөөтэй боллоо (*Сайжруулсан түлшний үнийг 2020 оны 12-р сарын 3-нд 50 хувь, 12-р сарын 14-нөөс 75 хувиар хөнгөлөх арга хэмжээг 2021 оны 4-р сарын 1-ний өдөр хүртэл хэрэгжүүлэхээр болсон*).

Ажил эрхлэлт

Хөдөлмөрийн насны хүн ам 2020 онд өмнөх оноос 1.3 хувиар өсөж, 2,133.3 мянгад хүрлээ. Үүний дотор эдийн засгийн идэвхтэй хүн ам өмнөх оноос 1.7 хувиар буурч 1,251.8 мянга болсон бол идэвхгүй хүн ам 5.9 хувиар нэмэгдэж 881.5 мянгад хүрчээ. Эдийн засгийн идэвхтэй хүн ам буурч, идэвхгүй хүн ам өссөн тул ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оноос даруй 1.8 нэгж хувиар буурч 58.7 хувьд хүрэв. (Зураг 1.7).

Эдийн засгийн идэвхтэй хүн амын дотор нийт ажилчид 2020 онд өмнөх оноос 1.6 хувиар өсөж 1,164.1 мянгад, нийт ажилгүй иргэд 31.3 хувиар буурч 87.8 мянгад тус тус хүрчээ. Ажилгүй иргэдийн[4] тоо хурдацтай буурснаас ажилгүйдлийн түвшин 3.0 нэгж хувиар буурч 7.0 хувьд хүрэв (Зураг 1.8).

Зураг 1. 7 Ажиллах хүчний оролцооны түвшин

Эх сурвалж: ҮСХ

Зураг 1. 8 Ажилгүйдлийн түвшин

Эх сурвалж: ҮСХ

Нийт ажилчдын тоог эдийн засгийн үйл ажиллагааны гол салбаруудаар авч үзвэл 2020 онд 481.4 мянга буюу 41.4 хувь нь үйлчилгээний салбарт, 271.2 мянга буюу 23.3 хувь нь хөдөө аж ахуйн салбарт, 243.3 мянга буюу 20.9 хувь нь аж үйлдвэрийн салбарт, 168.1 мянга буюу 14.4 хувь нь худалдааны салбарт тус тус ангилагдаж байна (Зураг 1.9). Эдгээрээс худалдаа, үйлчилгээний салбарт ажиллагчид өмнөх оноос харгалзан 4.8, 7.4 хувиар өссөн бол хөдөө аж ахуй болон аж үйлдвэрийн салбарт ажиллагчид 6.5 хувь, 1.6 хувиар тус тус буурсан байна.

Зураг 1. 9 Ажилчдын тоо, эдийн засгийн салбараар

Эх сурвалж: ҮСХ

[4] Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

1.2 ГАДААД СЕКТОР

Төлбөрийн тэнцэл

2020 онд төлбөрийн тэнцэл 787 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 334 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна. Тодруулбал, урсгал ба хөрөнгийн данс 572 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 1,504 сая ам.долларын ашигтай, статистикийн алдаа ба орхигдуулга -146 сая ам.доллар гарсан.

Зураг 1. 10 Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл

Зураг 1. 11 Урсгал ба Хөрөнгийн дансны тэнцлийн бүтэц

Эх сурвалж: Монголбанк

Урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 2020 онд өмнөх оноос 71%-иар буюу 1,429 сая ам.доллараар буурсан бөгөөд үүнд барааны дансны ашиг 52%-иар буюу 597 сая ам.доллараар өсч, үйлчилгээний дансны алдагдал 27%-иар буюу 541 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн.

Зураг 1. 12 Санхүүгийн дансны тэнцлийн бүтэц

Зураг 1. 13 Гадаадын шууд хөрөнгө оруулалтын бүтэц

Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцлийн ашиг 2020 онд өмнөх оноос 44%-иар буюу 1,173 сая ам.доллараар буурч 1,504 сая ам.долларт хүрсэн.

Барааны гадаад худалдаа[5]

Монгол Улсын барааны гадаад худалдааны тэнцэл 2020 онд 2,277 сая ам.долларын ашигтай гарч сүүлийн долоон жил дараалан ашигтай гарлаа.

Хүснэгт 1.2 Барааны гадаад худалдаа (сая ам.доллар)

Төрөл	2018	2019	2020	Өөрчлөлт (20'/19')	
				Дүн	Хувь
Эргэлт	**12,887**	**13,747**	**12,875**	**-872**	**-6%**
Экспорт	7,012	7,620	7,576	-43	-1%
Импорт	5,875	6,128	5,299	-829	-14%
Тэнцэл	**1,137**	**1,492**	**2,277**	**785**	**53%**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Худалдааны тэнцэл 2,277 сая ам.долларын ашигтай гарсан нь өнгөрсөн оноос 53%-иар буюу 785 сая ам.долларaар өссөн үзүүлэлт. Харин худалдааны нийт эргэлт өмнөх оноос 6%-иар буюу 872 сая ам.долларaар буурсан байна. Тодруулбал, импорт 14%-иар буюу 829 сая ам.долларaар, экспорт 1%-иар буюу 43 сая ам.долларaар тус тус буурсан.

Экспорт: 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулбал тайлант онд чулуун нүүрс 951 сая ам.долларaар, боловсруулаагүй нефть 216 сая ам.долларaар, жонш, лейцит, нефелит 49 сая ам.долларaар тус тус буурсан. Энэхүү бууралтыг алтны экспортын 1,369 сая ам.долларын өсөлт нөхөснөөр уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 4%-иар буюу 289 ам.долларaар өссөн.

Гэвч мал аж ахуйн гаралтай экспорт өнгөрсөн оны дүнгээс 39%-иар буюу 189 сая ам.долларaар, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт 38%-иар буюу 142 сая ам.долларaар буурсан нь нийт экспортын бууралтад нөлөөлжээ.

Алтны үнэ: Алтны үнийн индекс 2020 онд өнгөрсөн оноос 25%-иар өссөн бөгөөд үүнд Коронавирус цар тахалын уршигаар эдийн засгийн хямрал даамжирч, улмаар АНУ-ын Холбооны нөөцийн сан /Төв банк/ 2008 оноос хойш анх удаа бодлогын хүүгээ бууруулсан нь голлон нөлөөлжээ.

Зэсийн үнэ: Лондонгийн металлын бирж дэх цэвэршүүлсэн зэсийн үнэ 2020 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 28%-иар өссөн нь Ковид-19-ийн эсрэг вакцин гарснаар дэлхийн эдийн засаг сэргэнэ гэсэн эерэг хүлээлттэй холбоотой болно.

Зураг 1.14 Дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнийн индекс (2011/1=1.0)

Эх сурвлж: Блүүмберг

Чулуун нүүрсний хилийн үнэ: БНХАУ-ын дотоодын үйлдвэрүүд шинээр ашиглалтанд орж эхэлснээр зах зээлд дотоодын нийлүүлэлт сэргэсэн. Улмаар импортын нүүрсний хэрэгцээ буурснаар хилийн үнэ оны эхний хагаст буурсан. Харин сүүлийн улиралд хилийн үнэ эргэн өсч эхэлсэн бөгөөд энэ нь БНХАУ-ын Засгийн газраас Австралийн нүүрсний импортод хязгаарлалт тавьсан тул төрийн өмчит эрчим хүчний үйлдвэрүүд нийлүүлтээ тогтвортой байлгахын тулд тонн тутмын үнийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Төмрийн хүдрийн үнэ: БНХАУ-ын үйлдвэрүүд хэвийн үйл ажиллагааны горимд шилжсэнээр төмрийн хүдрийн эрэлт өндөр байснаас шалтгаалан төмрийн хүдрийн үнэ оны туршид өсч, 12-р сард сарын дундаж үнэ түүхэн дээд түвшинд буюу 155 ам.долларт хүрч өслөө.

[5] ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэсэн тоон мэдээлэл бөгөөд аргачлалын ялгаатай байдлаас шалтгаалан Төлбөрийн тэнцлийн статистикаас зөрүүтэй болно.

Түүхий нефтийн үнэ: АНУ-ын нефтийн олборлолт огцом нэмэгдсэнээр, түүхий нефтийн дундаж үнэ 2020 онд өмнөх оноос 33%-иар буурах шалтгаан болсон. Нийлүүлэлт өссөнөөр нефть хадгалах байгууламжууд дүүрч, улмаар үнэ унаж эхэлсэн хэдий ч ОПЕК-ийн гишүүн орнууд үйлдвэрлэлээ танах хэлэлцээрт шилжсэнээр нефтийн үнэ оны сүүлийн хагаст өсөх чиглэлтэй болсон.

Хүснэгт 1.3 Экспорт, голлох ангиллаар (сая ам.доллар)

Төрөл	2019			2020			Өөрчлөлт	
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт
1. Уул уурхай		**6,751**	**89%**		**7,040**	**93%**	**289**	**4%**
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	1,404	1,796	24%	1,395	1,778	23%	(18)	-1%
1.2. Чулуун нүүрс	36,467	3,074	40%	28,587	2,124	28%	(951)	-31%
1.3. Боловсруулаагүй нефть	6,545	367	5%	4,071	151	2%	(216)	-59%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	8,449	576	8%	8,206	640	8%	64	11%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	9,069	418	5%	30,491	1,788	24%	1,369	327%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	135	189	2%	134	168	2%	(21)	-11%
1.7. Жонш, лейцит, нефелинт	699	206	3%	679	156	2%	(49)	-24%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	6	49	1%	6	41	1%	(8)	-17%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	1	7	0%	0	1	0%	(6)	-89%
1.10. Мөнгө /тонн/	-	-	-	201,586	124	2%	124	-
1.11. Бусад	156	69	1%	112	70	1%	1	1%
2. Мал аж, ахуй	**312**	**481**	**6%**	**200**	**292**	**4%**	**(189)**	**-39%**
2.1. Амьд мал, малын мах	40	84	1%	21	41	1%	(43)	-51%
2.2. Арьс, шир	244	13	0%	158	7	0%	(6)	-48%
2.3. Малын өлөн гэдэс	1	9	0%	1	9	0%	0	5%
2.4. Ноолуур	8	344	5%	9	220	3%	(125)	-36%
2.5. Ноос, бусад үс, хялгас	17	28	0%	11	14	0%	(14)	-50%
2.6. Бусад	3	2	0%	0	1	0%	(1)	-51%
3. Газар тариалан	**62**	**16**	**0%**	**46**	**14**	**0%**	**(2)**	**-13%**
4. Аж үйлдвэрлэл	**390**	**372**	**5%**	**206**	**230**	**3%**	**(142)**	**-38%**
4.1. Хүнс	23	59	1%	25	68	1%	9	15%
4.2. Ноолууран эдлэл	1	46	1%	1	33	0%	(12)	-27%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	4	20	0%	5	16	0%	(4)	-20%
4.4. Уул уурхай	180	121	2%	26	70	1%	(51)	-42%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	1	0%	0	1	0%	(0)	-16%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	4	118	2%	2	38	0%	(80)	-68%
4.7. Бусад	179	7	0%	147	5	0%	(3)	-35%
5. Бусад	**1**	**1**	**0%**	**0**	**1**	**0%**	**0**	**12%**
Нийт дүн		**7,620**			**7,576**		**(43)**	**-1%**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Импорт: 2020 онд импорт өнгөрсөн оны үзүүлэлтээс 14%-иар буюу 829 сая ам.долларaар буурахад дараах хүчин зүйлс голлон нөлөөлөв. Үүнд:

- Цар тахлын улмаас хөл хорио тогтоож компаниудын үйл ажиллагаа удааширсантай холбоотойгоор хөрөнгө оруулалтын шинж чанартай бүтээгдэхүүний импорт 14%-иар буюу 371 сая ам.долларaар, үүнд: машин, механик тоног төхөөрөмж, эд ангийн импорт 21%-иар, барилгын материалын импорт 8%-иар тус тус буурав.
- Нефтийн бүтээгдэхүүний импорт 349 сая ам.долларaар буурсан нь дэлхийн зах зээл дээрх нефтийн бүтээгдэхүүний нийлүүлэлт нэмэгдсэнтэй холбоотой үнийн бууралтаас голлон шалтгаалсан байна.
- Харин хэрэглээний барааны импортын хувьд өнгөрсөн оны хэмжээнээс 88 сая ам.долларaар буурсан нь автомашин, түүний сэлбэг хэрэгсэлийн импорт 123 сая ам.долларaар буурсанаас голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 1. 4. Импорт, голлох ангиллаар (сая ам.доллар)

Төрөл	2019		2020		Өөрчлөлт	
	Дүн	%	Дүн	%	Дүн	Өсөлт
Хэрэглээний бүтээгдэхүүн	**1,631**	**27%**	**1,542**	**29%**	**(88)**	**-5%**
Түргэн эдэлгээтэй	859	14%	878	17%	19	2%
Хүнс	605	10%	613	12%	*7*	*1%*
Эм, тариа	109	2%	120	2%	*11*	*10%*
Бусад түргэн эдэлгээтэй бараа	145	2%	146	3%	*1*	*0%*
Удаан эдэлгээтэй	772	13%	664	13%	(108)	-14%
Гутал, хувцас, цүнх	68	1%	73	1%	*5*	*7%*
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	109	2%	107	2%	*(3)*	*-2%*
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	508	8%	384	7%	*(123)*	*-24%*
Бусад удаан эдэлгээтэй бараа	86	1%	100	2%	*13*	*16%*
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	**2,661**	**43%**	**2,290**	**43%**	**(371)**	**-14%**
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	1,801	29%	1,419	27%	(382)	-21%
Барилгын материал	654	11%	599	11%	(54)	-8%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	206	3%	272	5%	65	32%
Аж үйлдвэрлэлийн орц	**665**	**11%**	**634**	**12%**	**(30)**	**-5%**
Нефтийн бүтээгдэхүүн	**1,166**	**19%**	**817**	**15%**	**(349)**	**-30%**
Дизель түнш	669	11%	432	8%	(237)	-35%
АИ-92, АИ-95	289	5%	222	4%	(68)	-23%
А-80 болон бусад	207	3%	163	3%	(44)	-21%
Бусад	**5**	**0%**	**15**	**0%**	**9**	**172%**
Нийт дүн	**6,128**		**5,299**		**(829)**	**-14%**

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар, Монголбанк

Үйлчилгээний гадаад худалдаа

Үйлчилгээний гадаад худалдааны алдагдал 2020 онд өмнөх оноос 27%-иар буурч 1,450 сая ам.долларт хүрсэн.

Үйлчилгээний дансны алдагдал буурахад нөлөөлсөн гол хүчин зүйлс нь тээврийн үйлчилгээний алдагдал 64%-иар буурч 212 сая ам.долларт, бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 37%-иар буурч 343 сая ам.долларт тус тус хүрсэнтэй холбоотой байна.

Аялал жуулчлалын үйлчилгээний алдагдлын өсөлтийн хувьд ковид-19 цар тахлын нөлөөгөөр аяллын үйлчилгээний орлого буурсантай холбоотой.

Хүснэгт 1.5. Үйлчилгээний гадаад худалдаа (сая ам.доллар)

Үйлчилгээний гадаад худалдааны дансны нэр төрөл	2018	2019	2020	Өөрчлөлт (20'/19')	
				Дүн	%
1. Тээвэр	-561	-594	-212	-382	-64%
2. Аялал жуулчлал	-415	-412	-521	109	26%
3. Барилга, барилгын ажил үйлчилгээ	-165	-107	-97	-10	-10%
4. Даатгал болон тэтгэврийн үйлчилгээ	-21	-23	-21	-2	-7%
5. Санхүүгийн үйлчилгээ	-121	-207	-145	-62	-30%
6. Оюуны өмч ашиглах эрхийн төлбөр	-15	-25	-23	-2	-7%
7. Харилцаа холбоо, компьютер, мэдээллийн үйлчилгээ	-64	-55	-70	15	28%
8. Бизнесийн бусад үйлчилгээ	-590	-546	-343	-202	-37%
9. Бусад үйлчилгээ	-27	-23	-18	-5	-24%
Нийт үйлчилгээ	**-1978**	**-1992**	**-1450**	**-541**	**-27%**

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2020 оны эцэст -37,318 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 4%-иар буюу 1,487 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

Монгол Улсаас гадагш хийсэн нийт хөрөнгө оруулалтын дүн буюу гадаад актив 7,930 сая ам.доллар, үүний 57%-ийг гадаад валютын улсын нөөц, 30%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, үлдсэн 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Монгол Улсад оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн буюу пассив 45,248 сая ам.доллар, үүний 54%-ийг шууд хөрөнгө оруулалтын пассив, 36%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 10%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Тэгвэл гадаадын шууд хөрөнгө оруулалтын 53% буюу 12,801 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, 47% буюу 11,406 сая ам.долларыг охин компанийн толгой компаниасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг, санхүүжилт эзэлж байна.

Хүснэгт 1.6 . Монгол Улсын Гадаад хөрөнгө оруулалтын позиц, 2020 оны эцэст (сая ам.доллар)

А. ГАДААД АКТИВ	**7,930**	**Б. ГАДААД ПАССИВ**	**45,248**
1. Шууд хөрөнгө оруулалт (гадаад руу)	697	1. Шууд хөрөнгө оруулалт (гадаадаас)	24,207
2. Багцын хөрөнгө оруулалт	344	2. Багцын хөрөнгө оруулалт	4,645
3. Санхүүгийн дериватив	4	3. Санхүүгийн дериватив	0
4. Бусад хөрөнгө оруулалт	2,359	4. Бусад хөрөнгө оруулалт	16,396
5. Нөөц актив	4,526		
		В. ПОЗИЦ	**-37,318**

Эх сурвалж: Монголбанк

Гадаад хөрөнгө оруулалтын богино позицийн жилийн өсөлтийг данс тус бүрээр тайлбарлавал:

- Гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 1,619 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 893 сая ам.доллараар, санхүүгийн үүсмэл хэрэгслийн богино позиц 6 сая ам.доллараар өсч;
- Багцын хөрөнгө оруулалтын богино позиц 846 ам.доллараар буурч;
- Гадаад валютын улсын нөөц 4%-иар буюу 185 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1.7 . Гадаад хөрөнгө оруулалтын позицын өөрчлөлт (сая ам.доллар)

Үзүүлэлтүүд	**2018**	**2019**	**2020**	**Өөрчлөлт (20'/19')**	
				Дүн	*%*
Гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц	-19,690	-21,891	-23,510	*-1,619*	*7%*
Багцын хөрөнгө оруулалтын позиц	-4,589	-5,146	-4,301	*846*	*-16%*
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн позиц	-1	9	4	*-6*	*-61%*
Бусад хөрөнгө оруулалтын позиц	-12,891	-13,144	-14,037	*-893*	*7%*
Гадаад валютын улсын нөөц	3,542	4,341	4,526	*185*	*4%*
Нийт позиц	**-33,630**	**-35,831**	**-37,318**	***1,486***	***4%***

Эх сурвалж: Монголбанк

Гадаад өр

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2020 оны эцэст 32,362 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 5%-иар буюу 1,660 сая ам.долларраар өсөв. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын гадаад улсаас авсан хөнгөлөлттэй нөхцөлтэй зээл ба өрийн бичгийн үлдэгдэл 11%-иар буюу 848 сая ам.долларраар өссөн.

Төв банкны гадаад өр ОУВС-гийн хөтөлбөрийн зээлийн ашиглалт, алтны санхүүжилт, харилцах хадгаламжийн дансны өсөлтөөс шалтгаалан 12%-иар буюу 236 сая ам.долларраар өссөн.

Хүснэгт 1.8. Монгол Улсын нийт гадаад өр (сая ам.доллар)

Үзүүлэлт	2018	2019	2020	Өөрчлөлт (20'/19') Дүн	%
Нийт гадаад өр	**28,715**	**30,702**	**32,362**	**1660**	**5%**
I. Засгийн газар	7,184	7,806	8,654	848	11%
Засгийн газрын гадаад өр/ ДНБ (%)	*59%*	*57%*	*66%*	*9%*	*16%*
II. Төв банк	2,030	1,985	2,221	236	12%
III. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2,230	2,138	1,651	-487	-23%
Богино хугацаат	764	610	594	-16	-3%
Урт хугацаат	1,466	1,528	1,057	-471	-31%
IV. Бусад сектор	8,042	8,407	8,430	23	0%
Богино хугацаат	609	562	683	121	22%
Урт хугацаат	7,433	7,845	7,747	-98	-1%
V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл	9,228	10,366	11,406	1040	10%

Эх сурвалж: ЗГ-ын мэдээллийг Сангийн яам, бусад мэдээллийг Монголбанк боловсруулав.

Хувийн салбарын гадаад өр компани хоорондын зээлийн өсөлтөөр голлон тайлбарлаж байна. Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн толгой компаниасаа авсан зээлийн санхүүжилт өнгөрсөн онтой харьцуулахад 10%-иар буюу 1,040 сая ам.долларраар өссөн. Харин арилжааны банкуудын гадаад өр 23% буюу 487 сая ам.долларраар буурсан дүнтэй байна.

Засгийн газрын гадаад өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээ 2013-2016 онуудад 29%-41% хооронд тогтвортой түвшинд байсан бол 2017 онд 66% болж өссөн. 2018 он болон 2019 онд харгалзан 59%, 57% байсан ч 2020 оны хувьд дотоодын нийт бүтээгдэхүүний бууралт, Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт зэргээс шалтгаалан 66% болж өссөн үзүүлэлттэй байна. (олон улсын аргачлалын дагуу Хөгжлийн банкны гадаад өрийг бусад сектор хэсэгт ангилсан).

1.3. МӨНГӨ САНХҮҮГИЙН СЕКТОР

Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлт буюу М2[6] мөнгөний жилийн өсөлт 2019 оны эцсийн байдлаар 7 хувь байсан бол 2020 оны сүүлийн хагасаас эхлэн тасралтгүй өссөөр оны эцсийн байдлаар 16.3 хувиар өсч, 24.2 их наяд төгрөгт хүрчээ. М2 мөнгөний өсөлтийг эх үүсвэр талаас нь авч үзвэл бусад хадгаламж[7]ийн өсөлт, түүн дотроо төгрөгийн хадгаламжийн өсөлт 10.9 нэгж хувийг бүрдүүлж байна. Тодруулбал, оны эхнээс төгрөгийн хадгаламж 2,278.7 тэрбум төгрөгөөр, гадаад валютын харилцах 154.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, гадаад валютын хадгаламж 343.6 тэрбум төгрөгөөр буурсан байна. Мөн хамгийн өндөр хөрвөх чадвартай мөнгө болох М1[8] мөнгө 2020 оны II хагасаас өссөн нь мөнгөний нийлүүлэлт өсөхөд 6.2 нэгж хувиар нөлөөлжээ. М1 мөнгөний бүрэлдэхүүнийг задалбал төгрөгийн харилцах 1,158 тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 138.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

[6] М2=М1+бусад хадгаламж
[7] Хадгаламж+гадаад валютын харилцах
[8] М1=төгрөгийн харилцах+хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө

Зураг 1.15 Мөнгөний нийлүүлэлт, пассив буюу эх үүсвэр талаас:

Жилийн өсөлтийн бүрэлдэхүүн **Бүтэц**

Эх сурвалж: Монголбанк *Эх сурвалж: Монголбанк*

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг байршуулалт талаас нь задалбал гадаад цэвэр активын өсөлт 12.4 нэгж хувийг дангаараа тайлбарлаж байгаа ба хадгаламжийн байгууллагууд[9]-ын зээл олголт буурсантай холбоотойгоор аж ахуйн нэгж, иргэдээс авах цэвэр авлагын өсөлт буурчээ. Мөн банкууд дахь засгийн газрын үнэт цаас төлөгдөж, нийгмийн даатгалын сан болон эрүүл мэндийн даатгалын сангийн банкууд дахь хадгаламж буурснаар засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) М2-ын өсөлтөд 4.4 нэгж хувиар нөлөөлсөн байна.

Зураг 1.16 Мөнгөний нийлүүлэлт, актив буюу байршуулалт талаас:

Жилийн өсөлтийн бүрэлдэхүүн **Бүтэц**

Эх сурвалж: Монголбанк *Эх сурвалж: Монголбанк*

Банкуудын олгосон зээлийн жилийн өсөлт 2020 оны эхээс эхлэн буурч, жилийн эцсийн байдлаар 5.0[10] хувиар буурсан байгаа нь өмнөх оноос 10.0 нэгж хувиар буурсан байна. 2020 оны турш хэрэглээний зээл[11] өмнөх мөн үеэс буурч, нийт зээлийн өсөлтөд 7.1 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлэв. Харин уул уурхай болон үл хөдлөх хөрөнгийн салбарын зээлийн өсөлт зээлд нийт 2.5 нэгж хувиар бүрдүүлж байна.

[9] Банк+хадгаламж, зээлийн хоршоод

[10] Тэтгэврийн зээл тэглэсэн нөлөөг оруулж тооцвол зээл 1.2 хувиар буурсан байна.

[11] Хэрэглээний зээл=Цалин+Тэтгэвэр+Бусад хэрэглээний зээл

Нийт зээлийн үлдэгдлийн бүтцийг авч үзвэл хэрэглээний зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оноос 5.7 нэгж хувиар буурч 27.6 хувь байна. Тодруулбал, хэрэглээний зориулалттай зээл өмнөх оноос 1,264.4 тэрбум төгрөг буюу 21.2 хувиар буурчээ. Харин уул уурхай, худалдаа, үл хөдлөх, барилгын салбарын зээлийн нийт зээлийн 56.9 хувийг бүрдүүлж байна.

Зураг 1.17 Банкуудын олгосон зээлийн үлдэгдэл, эдийн засгийн салбарын ангиллаар

Жилийн өсөлтийн бүрэлдэхүүн **Бүтэц**

Эх сурвалж: Монголбанк *Эх сурвалж: Монголбанк*

Санхүүгийн салбар

2020 оны жилийн эцсийн байдлаар Монгол Улсын санхүүгийн салбарт нийт 12 банк, 532 банк бус санхүүгийн байгууллага, 249 хадгаламж зээлийн хоршоо, 15 даатгалын компани, 54 даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч 26 компани үйл ажиллагаа явуулж байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын үйл ажиллагааны цар хүрээ жилээс жилд нэмэгдэж буй боловч санхүүгийн зах зээлд банкны салбартай харьцуулахад бага хувь (нийт санхүүгийн салбарын активын 6.7 хувь)-ийг эзэлсэн хэвээр байгаа юм.

Зураг 1.18 ДНБ-нд эзлэх Санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарын хувь хэмжээ

Зураг 1.19 Санхүүгийн дэд салбаруудын нийт салбарт эзлэх хувь хэмжээ /2020 оны 4 дүгээр улирал, активын хэмжээгээр/

Эх сурвалж: ҮСХ, Монголбанк, СЗХ.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын нийт хөрөнгө 2020 оны 4 дугаар улиралд өмнөх оны мөн үеэс 15.4 хувиар өсч 2.0 их наяд төгрөгт хүрчээ. Түүнчлэн ББСБ-ын зээлийн багц өмнөх оны мөн үеэс 7.0 хувиар буюу 86.8 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт активын өсөлтийн 32.4 хувийг тайлбарлаж байна. ББСБ-ын зээлийн өрийн үлдэгдлийн 84.8 хувь нь хэвийн, 4.9 хувь нь хугацаа хэтэрсэн зээл ба 10.3 хувь нь чанаргүй зээл байна. Нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн эзлэх хувь хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.1 нэгж хувиар, хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь хэмжээ 0.5 нэгж хувиар тус тус өссөн дүнтэй байна.

2020 оны 4 дүгээр улирлын байдлаар Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувиар өсч 256.0 тэрбум төгрөгт, ХЗХ-дын нийт зээлийн үлдэгдэл 7.0 хувиар өсч 167.6 тэрбум төгрөгт тус тус хүрчээ. ХЗХ-дын нийт зээлийн багцын 4.4 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна.

Даатгалын салбарт 2020 оны 4 дүгээр улиралд ердийн даатгалын 15, урт хугацаат даатгалын 1, давхар даатгалын 1 компани нийт 17 даатгагч үйл ажиллагаа явуулж байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 382.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар өссөн байна. Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүр болох даатгалын гүнзгийрэлт (даатгалын хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь хэмжээ)-ийн түвшин олон улстай харьцуулахад доогуур байна. 2020 оны 4 дүгээр улирлын байдлаар даатгалын гүнзгийрэлт 0.57 хувь байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.01 нэгж хувиар өссөн үзүүлэлт юм. Даатгалын салбарын нийт хураамжийн орлогын хэмжээ 205.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний дийлэнхи хэсгийг ердийн даатгалын компаниуд бүрдүүлжээ. Даатгалын компаниуд нийт хураамжийн орлогын 29.0 хувьтай тэнцүү хэмжээний буюу 59.8 тэрбум төгрөгийг даатгалын нөхөн төлбөрт олгосон байна. 2019 оны эцсийн байдлаарх ашигт ажиллагааны үзүүлэлтүүдтэй харицуулахад активын өгөөж 0.7 хувиар, өөрийн хөрөнгийн өгөөж 1.2 хувиар тус тус буурчээ.

2020 онд нийт 65.3 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий үнэт цаасны арилжаа хийгдсэний 99.1 хувийг хувьцааны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа, үлдсэн 0.9 хувийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлжээ. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 3.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 336.3 тэрбум төгрөгөөр буюу 12.5 хувиар өсчээ.

Хүснэгт 1.9. Банкнаас бусад санхүүгийн салбарын голлох үзүүлэлтүүд /2020 оны 4 дүгээр улирлын байдлаар, тэрбум төгрөг/

Үзүүлэлтүүд	ББСБ	ХЗХ	Даатгал
Актив	2006.9	256.0	382.1
Өр төлбөр	556.2	206.5	200.7
Эзэмшигчдийн өмч	1450.7	49.5	109.2
Зээлийн өрийн үлдэгдэл	1327.0	167.6	-
Чанаргүй зээл	136.4	7.4	-
Тайлант үеийн ашиг	154.6	9.2	21.0
Даатгалын хураамжийн орлого	-	-	205.1
Даатгалын нөхөн төлбөр	-	-	59.8

Зураг 1.20 Үнэт цаасны зах зээлийн үнэлгээ.

Эх сурвалж: СЗХ, ҮСХ.

1.4. МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСӨВ

Засгийн газрын санхүү

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр 9’422 тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн дүн 13’961 тэрбум төгрөгт хүрч, төсвийн тэнцэл 4’539 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -12.3 хувьтай тэнцүү байв.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого бүрдүүлэлт 2020 онд өмнөх оноос 14 хувиар хумигдаж, төсвийн тодотголтой харьцуулахад 93.7 хувийн гүйцэтгэлтэй байв. Нийт тэнцвэржүүлсэн орлогын 90.2 хувийг татварын орлого, 9.8 хувийг татварын бус орлого бүрдүүлж байна. Нэгдсэн төсвийн орлогыг бүрэлдэхүүн хэсгээр хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1.10. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, бүрэлдэхүүн хэсгээр

тэрбум төгрөг	2019	2020	2020/2019	
	i.	ii	ii.-i.	ii./i. (%)
Нийт орлого	12040	10402	-1638	-14
Ирээдүйн өв сан	1040	914	-126	-12
Тогтворжуулалтын сан	95	66	-28	-30
Тэнцвэржүүлсэн орлого	10906	9422	-1484	-14
Татварын орлого	9813	8502	-1311	-13
Импорттой холбоотой татварын орлого	3042	2806	-236	-8
Нэмэгдсэн өртгийн албан татвар	1633	1504	-130	-8
Гаалийн албан татвар	790	741	-49	-6
Онцгой албан татвар	619	562	-57	-9
Орлогын албан татвар	2556	2220	-335	-13
Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	2031	1588	-442	-22
Дотоодын бараа, үйлчилгээний татвар	1333	1268	-65	-5
НӨАТ-н буцаан олголт	-235	-352	-117	50
Бусад татварын орлого	1087	970	-117	-11
Татварын бус орлого	1092	920	-172	-16

Эх сурвалж: Сангийн яам

Цар тахлын улмаас 2020 оны ихэнхи хугацаанд хөл хорионы дэглэмтэй, эдийн засгийн идэвхжил сул байв. Үүнтэй холбоотойгоор тэнцвэржүүлсэн орлого **өмнөх оноос 1.5 их наяд төгрөгөөр хумигдлаа**. Өөрчлөлтийг бүрэлдэхүүн хэсгээр өмнөх онтой харьцуулан үзвэл:

- **Нийгмийн даатгалын орлого** – **442 тэрбум төгрөгөөр агшив**
- **Орлогын албан татвар (ОАТ)** – **335 тэрбум төгрөгөөр агшив** - Үүнээс, ААН-ийн ОАТ 262 тэрбум төгрөгөөр буурчээ;
- **Импорттой холбоотой орлого** – **236 тэрбум төгрөгөөр агшив** - Үүний 130 тэрбум төгрөг нь импортын барааны НӨАТ, 60 тэрбум төгрөг нь суудлын автомашины онцгой албан татвар, 49 тэрбум төгрөг нь импортын барааны гаалийн албан татвар буурснаас шалтгаалжээ;
- **Татварын бус орлого** – **172 тэрбум төгрөгөөр агшив** - Үүний 226 тэрбум төгрөг нь түрээсийн орлого буурсан, 53 тэрбум төгрөг нь газрын тосны орлого буурснаас шалтгаалжээ. Харин тусламжийн орлого 51 тэрбум төгрөгөөр нэмэгджээ;
- **Бусад татвар** – **117 тэрбум төгрөгөөр агшив** - АМНАТ-ын орлого 82 тэрбум төгрөгөөр, агаарын

бохирдлын төлбөр 17 тэрбум төгрөгөөр тус тус буурчээ;

- **Дотоодын бараа, үйлчилгээний татвар** – **65 тэрбум төгрөг ↓** - Үүний 30 тэрбум төгрөг нь дотоодын архи, тамхины онцгой албан татварын орлого буурсантай холбоотой байв.

Нэгдсэн төсвийн нийт зардал

Урьдчилсан дүнгээр төсвийн зардал тодотголын 95.8 хувь буюу 14.0 их наяд төгрөгийн гүйцэтгэлтэй гарав. Тодотголоос 600 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсны 400 тэрбум төгрөг нь хөрөнгө оруулалтын зардал байв.

Цар тахлын үед төрөөс хэрэгжүүлсэн багц арга хэмжээний нөлөөгөөр төсвийн зардал өмнөх оноос **2.3 их наяд төгрөг буюу 19.7 хувиар тэлэв.** Зардлын бүрэлдэхүүн хэсгүүдийг өмнөх онтой харьцуулан үзвэл:

- **Татаас, шилжүүлэг** – **1'670 тэрбум төгрөгөөр тэлэв**;
- **Бараа, үйлчилгээний зардал** – **875 тэрбум төгрөгөөр тэлэв** - Үүний 391 тэрбум төгрөг нь цалин хөлсний зардал нэмэгдсэнтэй холбоотой;
- **Хөрөнгийн зардал** – **35 тэрбум төгрөгөөр тэлэв**;
- **Эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ** – **379 тэрбум төгрөгөөр агшив.**

Хүснэгт 1.11. Нэгдсэн төсвийн нийт зардал ба цэвэр зээл, төсвийн тэнцэл, бүрэлдэхүүн хэсгээр

тэрбум төгрөг	2019	2020	2020/2019	
	i.	ii	ii.-i.	ii./i. (%)
Нийт зардал	11662	13961	2299	20
Анхдагч зардал	10801	13001	2201	20
Урсгал зардал /-хүүний зардал/	7368	9912	2545	35
Хөрөнгийн зардал	3017	3052	35	1
Цэвэр зээл	416	38	-379	-91
Хүүний зардал	861	959	98	11
Нийт тэнцвэржүүлсэн тэнцэл	-756	-4539	-3783	
ДНБ-д эзлэх хувь	-2.0%	-12.3%		
Анхдагч тэнцэл	105	-3580	-3685	
ДНБ-д эзлэх хувь	0.3%	-9.7%		

Эх сурвалж: Сангийн яам

Төсвийн алдагдал, өрийн эргэн төлөлтийг санхүүжүүлсэн эх үүсвэр

Тайлант онд төсвийн алдагдал нөхөх, "Чингис", "Мазаалай" бондуудыг дахин санхүүжүүлэх болон бусад төлбөрт нийт 7.4 их наяд төгрөгийн санхүүжилт шаардагдав. Шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Төрийн нэгдсэн сангийн данс болон арилжааны банкин дахь НДС-ийн хуримтлалаас 2.1 их наяд төгрөг, "Номад" бонд шинээр гаргаж 1.7 их наяд төгрөг, шинээр 3.4 их наяд төгрөгийн гадаад зээл авсан бол бусад эх үүсвэрээс 164 тэрбум төгрөг бүрдүүлэв.

Хүснэгт 1.12 Санхүүжилтийн шаардлага болон эх үүсвэр бүрдүүлсэн байдал

тэрбум төгрөг	2019	2020	2020/2019
	i.	ii.	ii.-i.
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр	756	4539	3783
Харилцах болон хадгаламжийн данс	-1103	2143	3246
ЗГ-ийн бонд	-165	-249	-84
Шинээр гаргах	0	1713	1713
Үндсэн төлбөр	-165	-1962	-1797
ЗГ-ийн зээл	1185	2481	1296
Шинээр гаргах	1624	3359	1735
Үндсэн төлбөр	-438	-877	-439
ИӨС-ийн шилжүүлэг	516	0	-516
ТС-ийн хуримтлагдсан үлдэгдэл	322	139	-183
Өмч хувьчлал	1	26	25

Эх сурвалж: Сангийн яам

КОВИД – 19 цар тахлын эсрэг Засгийн газраас хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан

Монгол Улсын Засгийн Газраас Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, ажлын байрыг хадгалах, малчин өрх болон эмзэг бүлгийн иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээний нэмэлт санхүүжилтийн тайланг эхний 9 сарын байдлаар танилцуулжээ.

/2020 оны III улирлын байдлаар, тэрбум төгрөг/

№	Арга хэмжээ	Зарцуулсан хөрөнгө	Тайлбар
1	Эрүүл мэндийн салбарт Засгийн газрын нөөц хөрнгө, олон улсын байгууллагаас олгосон санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрийн зарцуулалт	18.3	Засгийн газрын нөөц хөрөнгөөс 9.4 тэрбум, АХБ-аас 2.4 тэрбум төгрөгийн тусламж, ДБ-аас 6.5 тэрбум төгрөгийн зээлийг авч ашиглаад байна.
2	18 хүртэлх насны хүүхэд бүрт олгож байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлж 100000 төгрөг болгон олгоход зарцуулсан нэмэлт санхүүжилт /4-9 сарын байдлаар/	561.4	Сар тутам 1 сая 118 мянган хүүхэд хамрагдаж байна.
3	Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд олгож байгаа хүнсний бүтээгдэхүүн худалдан авах эрхийн бичгийн үнийн дүнг нэмэгдүүлж хүүхдэд 16000 төгрөг, насанд хүрсэн нэг гишүүнд 32000 тус тус олгоход зарцуулсан нэмэлт санхүүжилт /5-9 сарын байдлаар/	14.7	Сар тутам 242 мянган хүн хамрагдаж байна
4	Нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэвэр болон байнгын асаргаа шаардлагатай16 хүртэлх насны хүүхдийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлж 288000 төгрөг болгон олгоход зарцуулсан нэмэлт санхүүжилт /5-9 сарын байдлаар/	32.0	Сар тутам 68 мянган хүн хамрагдаж байна
5	Ажилгүйдлийн даатгалын сангаас ажлын байраа хадгалж үлдсэн аж ахуйн нэгжүүдийн даатгуулагчдад олгосон дэмжлэг	43.6	7264 аж ахуйн нэгжийн 218001 /давхардсан тоогоор/ тоон даатгуулагчид хамрагдсан байна
6	Малчдын орлогыг нэмэгдүүлэх болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор Монгол Улсын 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, ноолуурын хэмжээг "Монгол ямааны үүлдэр омог. Ерөнхий шаардлага" (MNS 0550-2011) стандартаар тооцож, нэг кг тутамд 20000 төгрөгийн урамшууллыг олгоход гарсан нэмэт санхүүжилт	174.9	2019 оны мал тооллогын бүртгэлийн мэдээлэлд үндэслэн нийт 203441 малчин, мал бүхий этгээд хамрагдсан
7	Ноолуур бэлтгэх зориулалтаар Хөгжлийн банкны эх үүсвэрээр олгосон зээлд хамрагдсан аж ахуйн нэгжийн зээлийн хүүгийн хөнгөлөлтийн зардалд	5.1	48 аж ахуйн нэгж зээлд хамрагдаж хүүгийн хөнгөлөлт эдэлсэн
	Нийт дүн	850.0	

КОВИД-19 цар тахлын хүндрэлтэй цаг үед иргэдийн орлого, ажлын байрыг хамгаалах, бизнесийн үйл ажиллагаа, аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн болон хэсэгчлэн төрөөс хариуцан төлөх зэрэг дараах багц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлсэн гэж тайлагнажээ. Үүнд дараах шийдвэрүүд багтаж байна:

- Хувийн хэвшилд ажиллаж буй 989.4 мянган иргэдийн цалингаас 198.9 тэрбум төгрөгийн орлогын албан татварыг 2020 оны 4-10 сарын хооронд чөлөөлөх;
- 2020оны 4-10 сард 570 мянган иргэний 566.8 тэрбум төгрөгийн НДШ-ийг бүрэн, 10-12 сард 148.7 тэрбум төгрөгийн шимтгэлийг хэсэгчлэн төрөөс хариуцаах;
- Жилийн 1.5 тэрбум төгрөгөөс доош орлоготой 104.4 мянган аж ахуйн нэгжүүдийг 2020 оны 4 дүгээр сараас он дуустал 78.9 тэрбум төгрөгийн орлогын албан татвараас чөлөөлөх;
- Төрийн шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон, орлого нь 50 хувиас дээш буурсан боловч ажлын байраа хадгалж үлдсэн 7,284 аж ахуйн нэгжид 4-7 саруудад хадгалсан ажлын байрны тоогоор тус тус 200,000 төгрөг олгох;
- Түрээсийн төлбөрөө бууруулсан аж ахуйн нэгжүүдэд 2020 оны 2 дугаар сараас татварын хөнгөлөлт үзүүлсний үр дүнд 3,368 түрээслэгчийн 18.9 тэрбум төгрөгийн түрээсийн зардал хэмнэгдсэн;
- 2020 оны 2 дугаар сараас хойш 356.2 мянган иргэд, аж ахуйн нэгжийн 876 тэрбум төгрөгийн татварын өрт ногдох алданги, торгуулийг чөлөөлөх;
- 6,100 аж ахуйн нэгж, байгууллагын 14.4 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн торгууль, алдангийг чөлөөлөх;
- Өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулах зорилгоор 15 мянган тонн улаан буудайн элит үр, 160 мянган тонн хүнсний улаан буудай, бүх төрлийн хүнсний будаа, элсэн чихэр, ургамлын тос импортлоход 24.3 тэрбум төгрөгийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх зэрэг арга хэмжээ багтжээ

Эх сурвалж: Сангийн яам, https://mof.gov.mn/

ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2

2.1 МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ҮНДСЭН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ, ҮР ДҮН

Мөнгөний бодлогыг зах зээлийн зарчимд тулгуурлан хэрэгжүүлж хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг 2020 онд жилийн 8 хувь, дунд хугацаанд 6 хувь орчимд тогтворжуулна.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляц 2020 оны эцэст улсын хэмжээнд 2.3 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 1.9 хувьд хүрэв. Инфляцад үзүүлэх эрэлт, нийлүүлэлтийн шалтгаантай үнийн өсөлт 2020 онд бага байж инфляц Төв банкны зорилтоос доогуур түвшинд хадгалагдлаа. Үнийн хэлбэлзэл өндөртэй бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч тооцсон суурь инфляц болон ерөнхий инфляцын зөрүү 2020 оны 2 дугаар сараас багасч, 2, 3 дугаар улиралд суурь болон ерөнхий инфляц ойролцоо түвшинд байсан бол 12 дугаар сард МУЗГ-аас сайжруулсан шахмал түлшний үнийг хямдруулсантай холбоотойгоор суурь инфляц буурч, оны эцэст 0.2 хувьд хүрчээ.

Зураг 2.1 Ерөнхий болон суурь инфляц

Тайлант онд КОВИД-19 вирусын тархалтаас шалтгаалан эдийн засгийн идэвхжил огцом суларсан тул Монголбанкнаас эдийн засаг болон санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих зорилгоор шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж ажиллав. Ингэхдээ Монголбанкны Мөнгөний бодлогын хороо 2020 онд ээлжит 4 удаа, ээлжит бусаар 3 удаа нийтдээ 7 удаа хуралдаж, мөнгөний бодлого болон макро зохистой бодлогын шийдвэрүүдийг гаргалаа. Мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг 4 удаагийн шийдвэрээр 5 нэгж хувиар бууруулж, бодлогын хүүг түүхэн доод түвшинд буюу 6 хувьд хүргэж, төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг 6 хувь хүртэл бууруулав. Макро зохистой бодлогын хүрээнд эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүллээ. Түүнчлэн, банкны системд зээлийн тасалдал үүсэхээс сэргийлж урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлээд байна.

Дээрх арга хэмжээнүүдийг дэлгэрүүлж тайлбарлавал, инфляц 2020 оны 2 дугаар сард улсын хэмжээнд 6.4 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 6.9 хувь байв. БНХАУ-д КОВИД-19 вирусын тархалт эрчимжиж, гадаад эрэлт, түүхий эдийн үнэ буурсны зэрэгцээ хилийн хориг арга хэмжээнээс шалтгаалан дотоод эдийн засгийн идэвхжил огцом сулрав. Эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан үзээд Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3 дугаар сарын хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулж, санхүүжилтийн зуучлалыг дэмжих

зорилгоор төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулах, Төв банкны репо санхүүжилтийн хүүг бууруулан банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор бодлогын хүүний коридорыг нарийсгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэв.

Дэлхий нийтэд вирусын тархалт нэмэгдсэнээр гадаад, дотоод эдийн засгийн нөхцөл байдал богино хугацаанд өөрчлөгдөж, тодорхой бус байдал нэмэгдсэний зэрэгцээ банкны салбарт эрсдэл хуримтлагдаж болзошгүй байсан тул Мөнгөний бодлогын хороо 2020 оны 4 дүгээр сард ээлжит бусаар хуралдаж, бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэрийг тус тус гаргав. Тус арга хэмжээ нь зээлдэгчийн зээлийн сарын төлбөр буурснаар өрхийн орлогыг бууруулахгүй хадгалах, зээлийн дарамтыг бууруулах, цаашлаад эдийн засагт үүсээд буй хүндрэлийг зөөлрүүлж, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг үзүүлэх зорилготой байв.

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийг даган дотоодын шатахууны үнэ буурч, инфляц 2020 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 3.3 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 3.5 хувьтай гарав. Эдийн засаг агшиж, эрэлтийн шалтгаантай инфляц буурсаны дээр нийлүүлэлтийн шалтгаантай инфляц нэмэгдэхээргүй байсан тул 2020 онд инфляц зорилтот түвшнээс бага байхаар хүлээгдэж байлаа. Гэвч цар тахлын тархалттай холбоотойгоор тодорхой бус байдал өндөр хэвээр хадгалагдаж, төлбөрийн тэнцлийн алдагдал эхний 5-н сард огцом нэмэгдсэнээс эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг хангах шаардлага нь мөнгөний бодлогын төлөвийг сулруулах орон зайг хязгаарлаж байв. Иймээс Мөнгөний бодлогын хорооны 6 дугаар сарын хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалав. Харин банкны салбарын зээлийн долларжилт буурсан ч эх үүсвэрийн долларжилт нэмэгдэх хандлагатай байсан тул эх үүсвэрийн долларжилтыг бууруулж, төгрөгийн өгөөжийг хадгалах, банкны системийн тогтвортой байдлыг хангахад чиглэн өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг хорогдуулах шийдвэрийг гаргалаа.

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сард гаргасан шийдвэрийг үргэлжлүүлэн 8 дугаар сарын ээлжит бус хурлаар эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжүүлэх шийдвэрийг гаргав. Цар тахлын тархалтаас сэргийлсэн хорио цээрийн арга хэмжээ үргэлжилж, тодорхой бус байдал бууараагүй тул өрхийн санхүүгийн дарамтыг багасгах, хэрэглээг дэмжих, банкны системийн тогтвортой байдлыг ханган эдийн засгийн уналтыг зөөлрүүлэх зорилгоор тус шийдвэрийг гаргасан болно.

Инфляц 2020 оны 8 дугаар сард улсын хэмжээнд 2.1 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 1.7 хувьд хүрч буурав. Эдийн засгийн идэвхжил үргэлжлэн суларч, эрэлтийн шалтгаантай инфляц саарсны зэрэгцээ шатахууны үнэ инфляцыг бууруулах чиглэлд нөлөөлж, мах, хүнсний ногооны үнэ улирлын хандлагаараа бууран, нийлүүлэлтийн шалтгаантай инфляцын дарамт бага байлаа. Инфляц 2020 онд бага түвшинд хадгалагдаж, 2021 онд зорилтоос давахааргүй төсөөлөлтэй байсан тул Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 9 дүгээр сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 8 хувьд хүргэхээр шийдвэрлэв. Түүнчлэн, банк, өрх, аж ахуй нэгжийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжин банкны системд зээлийн тасалдах үүсэхээс сэргийлж, урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэрийг гаргав. Ингэснээр зээлийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, банкны системийн тогтвортой байдлыг хангах ач холбогдолтой байв.

2020 оны 11 дүгээр сард КОВИД-19 вирусын халдвар дотоодод тархаж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор эдийн засаг, бизнесийн үйл ажиллагаа богино хугацаанд хумигдав. Цар тахлын үед эдийн засаг, банк, санхүүгийн салбарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэд, бизнес эрхлэгчдэд үүсэх санхүүгийн хүндрэлийг зөөлрүүлэх зорилгоор Мөнгөний бодлогын хороо 11 дүгээр сарын 23-ны өдөр ээлжит бусаар хуралдаж, бодлогын багц шийдвэрүүдийг гаргасан. Үүнд, i) бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх, ii) төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулан 6 хувьд тогтоох, iii) эргэн төлөлт нь

доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэх, iv) жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус салбарын экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэрийг гаргав. Эдийн засгийн идэвхжлээс шалтгаалан инфляц бага түвшинд хадгалагдаж, төгрөгийн ханш тогтвортой байсан нь бодлогын хүүг бууруулах орон зайг бий болгож, цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг саармагжуулахад дэмжлэг үзүүлэхээр байв.

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 12 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг хэвээр хадгалж, жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 1 дүгээр улиралд 250 хүртэлх тэрбум төгрөг олгох шийдвэрийг гаргав. КОВИД-19 цар тахлын тархалттай холбоотой тодорхой бус байдал, гадаад, дотоод орчны эрсдэл өндөр хэвээр байсан тул бодлогын орон зайг тодорхой түвшинд хадгалахын зэрэгцээ зээлийн тасалдал үүсэхээс сэргийлж, төв банкнаас урт хугацаатай санхүүжилтийн эх үүсвэрийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэн дотоод эдийн засгийн уналтыг сааруулж, сэргэлтийг дэмжих арга хэмжээг ийнхүү авч хэрэгжүүлсэн болно.

Мөнгөний зах, хүүний түвшин

Банкуудын зээл олгох эсвэл хадгаламж татах шийдвэр нь банк хоорондын зах дээрх санхүүгийн хэрэгслүүдийн хүүнээс хамаарч байдаг. Иймд Монголбанкнаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо түвшинд хадгалахыг зорьдог билээ (Зураг 2.2).

Зураг 2.2. Мөнгөний бодлогын шилжих механизм

Монголбанк бүтцийн шинжтэй илүүдэл нөөцийг урт хугацаагаар татах, банк хоорондын захын хөгжлийг дэмжих, мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулах зорилгоор 2018 оны 4 дүгээр сараас 28 хоногтой ТБҮЦ, 11 дүгээр сараас 196 хоногтой ТБҮЦ-ыг тус тус арилжаалж эхлээд байна.

Зураг 2.3. Банк хоорондын захын хүү

Эх сурвалж: Монголбанк

Коронавируст (Ковид-19) цар тахлын улмаас эдийн засагт бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор бодлогын хүүг шат дараалан бууруулж, 6.0 хувьд буюу түүхэн доод түвшинд хүргээд байна. Мөн Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 1 дүгээр тогтоолоор хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй байхаар өөрчлөв. Эдгээр бодлогын өөрчлөлтийн үр дүнд 2020 оны эцэст банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 4.7 нэгж хувиар буурч 6.0 хувь орчимд хүрлээ. Мөн хүүгийн коридор нарийссанаас хойш банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний бодлогын хүүнээс хазайх абсолют хазайлт 0.21 нэгж хувь болж буурав (Зураг 2.3).

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2020 оны эцэст 2,849.89 төгрөгт хүрч, оны эхнээс 4.2 хувиар суларсан байна (Зураг 2.4). Монголбанкнаас богино хугацааны валютын эрэлт, нийлүүлэлтийн зөрүү, ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад оролцож, тайлант хугацаанд ханшийн дундаж хэлбэлзэл 0.017 нэгж хувь буюу 2019 оны түвшинд байв. Төгрөгийн ам.доллартай харьцах ханш тайлант хугацаанд нэг өдөрт хамгийн ихдээ 0.17 хувиар буюу 4.75 төгрөгөөр суларч (өмнөх оноос 2.67 төгрөгөөр буурсан), 0.07 хувиар буюу 2.06 төгрөгөөр чангарсан (өмнөх оноос 3.93 төгрөгөөр буурсан) бөгөөд тайлант хугацаанд ханш өдрийн хэлбэлзэл ±0.2 хувийн интервалд байв (Зураг 2.5).

Зураг 2.4. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан хаалтын ханшийн хэлбэлзэл (төгрөгөөр)

Зураг 2.5. Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өдрийн хэлбэлзлийн давтамж

Эх сурвалж: Монголбанк

2.2 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО

I. Монгол Улсыг (Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага) ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу Саарал жагсаалтаас гаргах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас 2017 онд Харилцан үнэлгээ хийж, Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) тогтолцоог дутагдалтай гэж дүгнэсэн бөгөөд Монгол Улс холбогдох арга хэмжээг авч ажилласан боловч 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдөр ФАТФ-аас Монгол Улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу “Саарал” жагсаалтад оруулсан. Үүнтэй холбогдуулан, Саарал жагсаалтаас гарах үйл явцын хүрээнд Монгол Улс ФАТФ-тай хамтран 2021 оны 5 дугаар сар хүртэл авч хэрэгжүүлэх 4, Шууд хэрэгжилттэй холбоотой нийт 6 ажил бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан (Хүснэгт 2.1).

Хүснэгт 2.1. Монгол Улсын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх ажил	Төлөвлөгөөт хугацаа	Хариуцах байгууллага
	Шууд хэрэгжилт 3		
1	Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх	2021 оны 5 сар	Санхүүгийн зохицуулах хороо, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд (Хууль зүй, дотоод хэргийн яам: Монголын Нотариатчдын танхим, Монголын Хуульчдын холбоо; Сангийн яам: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт)
2	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулах		
	Шууд хэрэгжилт 7		
3	Тодорхойлсон эрсдэлтэй уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, прокурорын түвшинд яллах ажиллагааг нэмэгдүүлэх	2021 оны 5 сар	Хууль сахиулах байгууллагууд, Улсын ерөнхий прокурорын газар, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
	Шууд хэрэгжилт 8		
4	Хилээр мэдүүлээгүй/худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах	2021 оны 01 сар	Сангийн яам: Гаалийн ерөнхий газар
	Шууд хэрэгжилт 11		
5	Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах	2020 оны 9 сар	Терроризмтой тэмцэх зөвлөл, Гадаад харилцааны яам, Тагнуулын ерөнхий газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах чиг үүрэг бүхий байгууллагууд (Хууль зүй, дотоод хэргийн яам: Монголын Нотариатчдын танхим, Монголын Хуульчдын холбоо; Сангийн яам: Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт)
6	Санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ авах үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах	2021 оны 5 сар	

Эх сурвалж: Монголбанк, СМА

Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Ерөнхий Сайдын 2019 оны 172 дугаар захирамжаар Сангийн Сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан. Түүнчлэн, 2019 оны 463 дугаар Засгийн газрын тогтоолоор ФАТФ-ын МУТСТ стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас Монгол Улсыг гаргах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагууд, хувийн хэвшил болон

мэргэжлийн холбоодын хамтарсан дэд ажлын хэсгүүд уг төлөвлөгөөний дагуу эрчимтэй ажилласан бөгөөд Санхүүгийн мэдээллийн албанаас төлөвлөгөөт ажлуудыг цаг тухайд нь хийж гүйцэтгэх чиглэлээр байгууллага тус бүртэй хамтран дэмжлэг үзүүлж ажилласан. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь Үндэсний зөвлөл болон Хамтын ажиллагааны зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд анхаарч, шаардлагатай бүхий л хэлэлцээр, хурал, уулзалтыг зохион байгуулж, дотоод болон гадаад хамтын ажиллагааг хангаж ажилласнаас гадна холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээллийг нэгтгэх, хянах, боловсронгуй болгох ажлуудыг хийсэн.

ФАТФ-тай тохиролцсон үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 6 ажлын явцыг агуулсан Ахицын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас нэгтгэн Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлж, ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн 2020 оны 01 дүгээр сард БНХАУ-ын Бээжин хотод зохион байгуулсан хурлаар хэлэлцүүлж, 3 ажлыг хангалттай биелүүлсэн үнэлгээ авсан. Үлдсэн 3 ажлын явцыг тусгасан Ахицын тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас нэгтгэн боловсруулж, 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт хүргүүлсэн бөгөөд 2020 оны 5 дугаар сарын 11-ний өдөр тайлангаа цахим уулзалтаар амжилттай танилцуулж, хамгаалав. Иймд Монгол Улс нийт 4 Шууд хэрэгжилтийг хангах чиглэлээр ФАТФ-аас өгсөн 6 ажлын үүрэг даалгавраа хангалттай биелүүлсэн гэдэг үнэлгээг авсан.

Тухайлбал, Шууд хэрэгжилт 3-ын хүрээнд Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянан шалгах байгууллагын тухайн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, хяналт шалгалтыг эрсдэлд суурилсан аргачлалаар хийж гүйцэтгэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн хариуцлага оногдуулах чиглэлээр ахиц дэвшил гаргасан. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид болох үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллага, хуульч, нотариатч болон нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоодод дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Мөн санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зайны хяналт хийж, эрсдэлийг үнэлэх, улмаар эрсдэл өндөртэй этгээдэд хяналт шалгалт хийх чиглэлээр эрсдэлийн үнэлгээний асуулга болон аргачлалыг олон байгууллагуудын техник туслалцаагаар боловсруулж, шинэчилсэн. Санхүүгийн мэдээллийн албанаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлагыг нотариатч, хуульч болон нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан боловсруулсан бөгөөд Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлдэг тайланг бөглөх заавар, зөвлөмжийг бүх санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулж, боловсруулан хүргүүлсэн.

Шууд хэрэгжилт 7-той холбоотойгоор тодорхойлсон эрсдэлтэй нь уялдуулан мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах, прокурорын түвшинд яллах ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагууд эрчимтэй ажилласан. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэргийн статистикийн маягтыг бэлтгэн хууль сахиулах байгууллагуудад хүргүүлсэн. Үүнээс гадна, Шууд хэрэгжилт 8-ын хүрээнд Гаалийн ерөнхий газраас хилээр мэдүүлээгүй эсхүл худал мэдүүлсэн мөнгөн тэмдэгтийг хураан авах, битүүмжлэх, гаргасан зөрчилд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авсан. Мөн Санхүүгийн мэдээллийн алба Гаалийн ерөнхий газар болон Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хил хяналтын байгууллагын албан хаагч нарт соён гэгээрүүлэх үйл ажиллагааг сургалтын хэлбэрээр хийж гүйцэтгэсэн.

Шууд хэрэгжилт 11-ийн хүрээнд хориг арга хэмжээг хэрэгжүүлэх, урьдчилан сэргийлэх хүрээнд эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс Хамтын ажиллагааны зөвлөлийн харьяа Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсгийн үйл ажиллагаа болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх

санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж ажилласан. Мөн үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн санхүүгийн хориг арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр Санхүүгийн мэдээллийн алба Терроризмтой тэмцэх зөвлөл болон холбогдох хяналт тавих байгууллагуудтай хамтран санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд энэ чиглэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Түүнчлэн, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлийн мэдээлэх үүрэгтэй этгээдийн мэдлэгийг дээшлүүлэх үйл ажиллагааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох олон улсын байгууллагуудын конвенц болон стандартын орчуулгын ажилд идэвхтэй оролцсон.

Ковид-19 цар тахлын хүнд, хэцүү байдлын улмаас ФАТФ-аас Монгол Улсад хийх газар дээрх хяналт шалгалтыг хойшлуулах нөхцөл байдал үүссэн тул газар дээрх хяналт шалгалтад шинжээчдийг ирүүлэх, цахимаар хяналт шалгалтыг зохион байгуулах хүсэлтийг Санхүүгийн мэдээллийн албанаас бэлтгэн ФАТФ, Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг болон Ази, Номхон далайн хамтарсан бүлэгт Сангийн яам, Гадаад харилцааны яам болон Монголбанкаар дамжуулан удаа дараа хүргүүлж, цахим уулзалт, хэлэлцээрийг зохион байгуулсан. Үүний үр дүнд Монгол Улсад газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулахаар болсон.

ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд Сангийн Сайдын 2020 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 151 дүгээр тушаалаар батлагдсан Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх төлөвлөгөөг Санхүүгийн мэдээллийн албанаас боловсруулж, биелэлт, хэрэгжилтийн явцыг тухай бүр тайлагнаж ажилласан. Түүнчлэн Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллага тус бүрт зориулан ФАТФ-ын Зөвлөмж, Шууд хэрэгжилт болон хариуцсан үйл ажиллагааны хүрээнд газар дээрх хяналт шалгалтын үеэр тодруулах боломжтой асуулт, хариултууд бүхий зөвлөмжийг бэлтгэж хүргүүлсэн. Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн албанаас Монгол Улсын газар дээрх хяналт шалгалтын тайланг нэгтгэн боловсруулж, 2020 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр ФАТФ-т хүргүүлснээс гадна Азийн хөгжлийн банкны зөвлөхтэй урьдчилсан бэлтгэл уулзалт, ярилцлагыг зохион байгуулав.

Түүнчлэн Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 105 дугаар тушаалаар “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоонд газар дээрх хяналт шалгалтыг хийх ФАТФ-ын үнэлгээний багийн гишүүдийн манай улсад ирэх, буцах нислэг, байрлах байр болон бүх төрлийн үйлчилгээг чанарын стандартад нийцүүлэх, мэргэжлийн байгууллагуудаас тавих ариутгал, халдваргүйжүүлэлтийн шаардлагыг бүрэн хангах, хяналт шалгалтын хүрээнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий Ажлын хэсэг”-ийг байгуулав. Уг ажлын хэсгийг Санхүүгийн мэдээллийн алба ахалж, газар дээрх хяналт шалгалтын зохион байгуулалтыг хариуцаж ажилласан. Энэхүү ажлын хэсэгт Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам болон халдваргүйжүүлэлт хийх байгууллагууд багтсан.

Монгол Улсад ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтыг 2020 оны 10 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд Улсын онцгой комиссын хяналтан дор Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх шаардлагын дагуу зохион байгуулсан бөгөөд төрийн 22 байгууллага, 19 аж ахуйн нэгж, 4 мэргэжлийн холбоод, хувиараа бизнес эрхлэгчдийн төлөөллөөс бүрдсэн нийт 140 гаруй хүн оролцсон болно. Ази, Номхон далайн хамтарсан бүлгийг төлөөлж АНУ, ОХУ, ИБУИНВУ болон БНХАУ-ын 4 төлөөлөгч биечлэн ирж, цахим байдлаар 10 гаруй олон улсын байгууллагын төлөөлөгчид хяналт шалгалтыг хийсэн. Монгол Улс Ковид-19 цар тахлын хүнд хэцүү цаг үед газар дээрх хяналт шалгалтыг амжилттай зохион байгуулсан нь олон улсын сайн туршлага болсныг ФАТФ-ын чуулга уулзалт дээр онцлон тэмдэглэсэн.

Газар дээрх хяналт шалгалтын үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 13-ны өдөр ФАТФ-ын Олон улсын хамтын ажиллагааны хяналтын бүлгийн хурал дээр гишүүн орнууд хэлэлцэн дүгнэж, 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсыг ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас

гаргасан талаар албан ёсоор мэдэгдсэн. Улмаар Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу 1 жилийн дотор Саарал жагсаалтас гарч чадсан улс болсон. ФАТФ-аас гаргасан мэдэгдлийн талаар Монголбанк болон Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд мэдээлсэн.

Саарал жагсаалтаас гарснаар Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгжүүдийн хийсэн гадаад шилжүүлэг, төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээнд төлөх зардал багасч, гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас гүйлгээнд тавих хяналт буурснаар гадаад төлбөр тооцоо хурдан хийгдэж болох юм. Түүнчлэн гадаадын банк, санхүүгийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжиж, улмаар мөнгөн гуйвуулга, гадаад худалдаа нэмэгдэх, зээлжих зэрэглэлд эерэгээр нөлөөлж, гадаад зах зээлээс эх үүсвэр татах боломж нэмэгдэх юм. Үүний дүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт нэмэгдэж, инфляц буурах, ханш сулрах зэрэгт эерэг дам нөлөө үзүүлэх боломжтой.

II. Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас гарах чиглэлээр

ФАТФ-ын саарал жагсаалтад орсонтой холбоотойгоор Монгол Улсыг 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Европын Холбооны хар жагсаалт гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулсан. Иймд Монгол Улсыг Европын Холбооны жагсаалтаас гаргах хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас Гадаад харилцааны яамаар дамжуулан Европын Холбоонд удаа дараа хүсэлт хүргүүлж, цахим хурал уулзалтуудыг зохион байгуулсан.

Эдгээр арга хэмжээний үр дүнд ФАТФ-аас Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргасантай холбогдуулан Европын Комиссоос 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр 2015/849 тоот тогтоолыг гаргаж, Монгол Улсыг Европын Холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан.

Европын Холбооны өндөр эрсдэлтэй гуравдагч орнуудын жагсаалтаас гарснаар Европын Холбооны гишүүн орны банк, санхүүгийн байгууллагуудтай бизнесийн харилцаа тогтоох, гүйлгээг богино хугацаанд хийж гүйцэтгэх, Европын Холбооны санхүүжилтээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх эерэг үр дагавартай юм.

III. ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээг сайжруулах ажлын хүрээнд

Монгол Улсад ФАТФ-ын олон улсын 40 Зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр холбогдох тайланг Санхүүгийн мэдээллийн албанаас Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэгт хүргүүлж, нийт хэсэгчлэн биелсэн үнэлгээтэй 5 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах, 1 Зөвлөмжийн үнэлгээг хэвээр хадгалах хүсэлтийг гаргасан. Энэ хүрээнд үнэлгээний багаас Монгол Улсын 3 дахь шатны Явцын тайлантай холбоотой тодруулга авах хүсэлтийг 2020 оны 3-5 дугаар саруудад удаа дараа ирүүлсний хариуд Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох тайлбаруудыг тухай бүр өгч ажиллав. Мөн Монгол Улсын Явцын тайланг Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн гишүүн орнуудад хүргүүлэн санал авсан бөгөөд улмаар ирүүлсэн саналуудад хариу тайлбарыг бэлтгэн хүргүүлсэн.

Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлгээс 2020 оны 7 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан Харилцан үнэлгээний хорооны ээлжит бус цахим хурлаар 3 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах саналыг дэмжиж, Монгол Улсын Явцын тайланг 2020 оны 8 дугаар сард баталж, нийтэлсэн. Үүний үр дүнд Зөвлөмж 14-ийн үнэлгээг хоёр шатаар ахиулан Биелүүлсэн, Зөвлөмж 28 болон 35-ын үнэлгээг тус бүр нэг шатаар ахиулан Дийлэнхийг биелүүлсэн.

Тухайлбал, Зөвлөмж 14-ын хүрээнд тусгай зөвшөөрөлгүйгээр мөнгөн гуйвуулгын үйлчилгээ үзүүлсэн этгээдийг илрүүлэх, тэдний гаргасан зөрчилтэй дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлэх арга хэмжээг авах үр дүнтэй хууль эрх зүйн систем, практикийг бий болгоход Санхүүгийн мэдээллийн албанаас

Санхүүгийн зохицуулах хороонд дэмжлэг үзүүлж хамтран ажилласан. Үүнээс гадна, Зөвлөмж 28-ын үнэлгээг ахиулах чиглэлээр бүх зохицуулалттай салбарт эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалыг нэвтрүүлж, ялангуяа хуульч, нотариатч, нягтлан бодогчдыг зохицуулах байгууллагуудын хяналт шалгалтын чадавхыг сайжруулах, санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гарын авлага, заавар, зөвлөмжүүдийг боловсруулж, сургалтууд зохион байгуулсан. Түүнчлэн, Зөвлөмж 35-ын үнэлгээг ахиулах хүрээнд мэдээлэх үүрэгтэй этгээдийн гаргасан зөрчилд ногдуулах торгуулийн хэмжээг нэмэгдүүлснээс гадна Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуулийн дагуу торгууль, шийтгэл ногдуулах зохицуулалтыг тусгасан.

Иймд ФАТФ-ын 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн үнэлгээний хувьд Монгол Улс нийт 37 Зөвлөмжийг дийлэнхийг болон бүрэн биелүүлсэн гэсэн үнэлгээтэй байгаа бөгөөд үлдсэн 3 Зөвлөмжийг хэсэгчлэн биелүүлсэн байгааг дараах хүснэгтэд харуулав (Хүснэгт 2). Үүнд:

Хүснэгт 2.2. Монгол Улсын ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээ

/Бүрэн биелүүлсэн: C-compliant, Дийлэнхийг биелүүлсэн: LC-largely compliant, Хэсэгчлэн биелүүлсэн: PC-partially compliant, Биелүүлээгүй: NC-noncompliant/

Зөвлөмж 1	Зөвлөмж 2	Зөвлөмж 3	Зөвлөмж 4	Зөвлөмж 5	Зөвлөмж 6	Зөвлөмж 7	Зөвлөмж 8
PC	LC	LC	LC	LC	LC	LC	PC
Зөвлөмж 9	Зөвлөмж 10	Зөвлөмж 11	Зөвлөмж 12	Зөвлөмж 13	Зөвлөмж 14	Зөвлөмж 15	Зөвлөмж 16
LC	LC	C	LC	LC	C	PC	LC
Зөвлөмж 17	Зөвлөмж 18	Зөвлөмж 19	Зөвлөмж 20	Зөвлөмж 21	Зөвлөмж 22	Зөвлөмж 23	Зөвлөмж 24
LC	LC	LC	LC	C	LC	LC	LC
Зөвлөмж 25	Зөвлөмж 26	Зөвлөмж 27	Зөвлөмж 28	Зөвлөмж 29	Зөвлөмж 30	Зөвлөмж 31	Зөвлөмж 32
LC	LC	LC	LC	C	C	C	LC
Зөвлөмж 33	Зөвлөмж 34	Зөвлөмж 35	Зөвлөмж 36	Зөвлөмж 37	Зөвлөмж 38	Зөвлөмж 39	Зөвлөмж 40
LC	LC	LC	C	C	LC	LC	LC

Эх сурвалж: Монголбанк, СМА

Цаашид хэсэгчлэн биелүүлсэн үнэлгээтэй 3 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах, бусад Зөвлөмжүүдийн үнэлгээг хэвээр хадгалах зорилгоор 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдөр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний зөвлөлийн дарга бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн сайд "ФАТФ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 Зөвлөмжийн техник хэрэгжилтийн дутагдлыг сайжруулах ажлын төлөвлөгөө"-г баталж, холбогдох байгуллагуудыг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосон. Иймд уг төлөвлөгөөний хүрээнд Зөвлөмж 1-д заасны дагуу Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна. Мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр А-26 тоот тушаалаар батлагдсан "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам"-д холбогдох нэмэлт өөрчлөлтүүдийг оруулахаар болсон. Зөвлөмж 8-ын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас ашгийн бус байгууллагын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бүрдүүлэх, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өргөн явуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Терроризмтой тэмцэх зөвлөлтэй хамтран ажиллаж байна. Үүнээс гадна, Зөвлөмж 15-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А-23 дугаартай тушаалаар байгуулагдсан "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх этгээдтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг судлах, олон улсын стандарт, зөвлөмжийн дагуу хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажилласан бөгөөд олон улсын туршлага, хууль, эрх

зүйн орчинтой холбоотой судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд холбогдох байгууллагуудтай хамтран Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төслийг боловсруулав.

Шигтгээ 1. Виртуал хөрөнгийн салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалт

Сүүлийн үед дэвшилтэд технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд зах зээлд олноор бий болж, дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлтүүдийг авчирсаар байна. Тухайлбал, криптовалют, биткоин зэрэг виртуал хөрөнгийн талаарх ойлголт шинээр бий болж, төлбөр тооцоог уламжлалт санхүүгийн системээр дамжуулахгүйгээр илүү хурдан, хямд, хялбар аргаар хийж гүйцэтгэх боломжийг бий болгосон. Энэ нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээний үр ашгийг дээшлүүлэх ач холбогдолтой боловч нөгөө талаар виртуал хөрөнгийн технологийн онцлог болон нэр, хаягаа нууцлах боломжийг ашиглан гэмт этгээдүүд хууль бусаар олсон хөрөнгө, орлогоо нуун дарагдуулах, цаашлаад гэмт хэрэг үйлдэх, терроризмыг санхүүжүүлэх зэргээр хууль бусаар ашиглах эрсдэлтэй байна. Иймд дэлхийн улс орнууд болон олон улсын байгууллагууд энэхүү асуудлыг анхааралдаа авч, виртуал хөрөнгийн хууль эрх зүйн зохицуулалт, хяналтын тогтолцоог хөгжүүлж эхлээд байна.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх олон улсын стандарт болох 40 зөвлөмжийг гаргадаг бөгөөд 2019 онд шинэ технологийн талаарх Зөвлөмж 15-д өөрчлөлт оруулж, виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шалгууруудыг тогтоосон. ФАТФ-аас виртуал хөрөнгийг дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл гэж тодорхойлсон. Хамгийн анхны виртуал хөрөнгө болох биткоин одоогоос 10 гаруй жилийн өмнө үүсч бий болсон бөгөөд энэ салбар блокчэйн технологид суурилан тасралтгүй хөгжин өөрчлөгдөж байна. Иймд ФАТФ-аас улс орнуудыг виртуал хөрөнгөтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үнэлж, түүнээс урьдчилан сэргийлах арга хэмжээг авах, мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх эсвэл тусгай зөвшөөрөл олгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийж, холбогдох зөрчилд арга хэмжээ авах, улмаар харилцагчдаа таньж мэдэх ажиллагааг хэрэгжүүлж, аливаа сэжигтэй гүйлгээг мэдээлэхийг үүрэг болгосон.

Виртуал хөрөнгийн зах зээл технологийн дэвшилд тулгуурлан хурдацтай хөгжиж, шинэ төрлийн критповалют болон койнууд зах зээлд нэвтэрсээр байгаа тул энэ салбарын ирээдүйн чиг хандлага, хөгжлийг тодорхойлоход хүндрэлтэй байсаар байна. Иймээс дэлхийн улс орнууд ФАТФ-ын шаардлагын дагуу виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр өөрийн онцлогт тохирсон ялгаатай арга хандлагыг хэрэгжүүлж байна. Тухайлбал, хөгжиж буй эдийн засагтай улс орнуудын хувьд виртуал хөрөнгийг хэрэглэх тал дээр бүрэн дэмжсэн эсвэл үгүйсгэсэн байр суурьтай байгаа бол барууны ихэнх улс орнууд болон Ази тивийн орнуудаас Япон, Сингапур улсууд эдийн засгийн инновацийг дэмжих үүднээс илүү уян хатан хандаж байна. Үүнээс Япон улсын хувьд 2016 онд виртуал валютыг зохицуулах хуулийг баталсан бөгөөд Японы Санхүүгийн үйлчилгээг зохицуулах агентлагаас виртуал валютыг төлбөрийн хэрэгслээр ашиглахыг зөвшөөрсөн. Харин манай хөрш Оросын Холбооны Улс 2020 онд Дижитал санхүүгийн хөрөнгө, дижитал валютын тухай хуулийг баталж, 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн бол Бүгд Найрамдах Хятад Ард Улсад криптовалютын үйл ажиллагааг хориглосон байна. Мөн Бүгд Найрамдах Солонгос Улс, Япон, Австрали, Англи, Швейцар зэрэг орнуудад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь Санхүүгийн Зохицуулах Хорооноосоо зөвшөөрөл авснаар үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсад одоогийн байдлаар цөөн тооны виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд иргэд олон улсын банкны картаа ашиглан гадаадын цахим платформоор критпвалютын арилжаанд оролцох, нийгмийн цахим сүлжээнд арилжаанд хэрхэн оролцох тухай группууд идэвхтэй ажиллах болсон. Мөн өнгөрсөн хугацаанд виртуал хөрөнгөтэй холбоотой гэмт хэргүүд хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдэх болсон нь энэ салбарын зохицуулалтыг бий болгох шаардлагыг илтгэж байна. Иймд Монгол Улсын хувьд ФАТФ-ын шаардлагыг биелүүлж Зөвлөмж 15-ын хагас биелэлттэй гэсэн үнэлгээг ахиулах, виртуал хөрөнгийн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт зохицуулалтын тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос эрх бүхий байгууллагуудтай хамтран “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”-ийн төслийг боловсруулаад байна. Энэхүү хуулийн төсөл нь нийт 14 зүйлээс бүрдэх бөгөөд ФАТФ-ын шаардлагад нийцүүлэн виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээг тодорхойлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим, тавигдах шаардлага, бүртгэх, хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тусгаж, хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх этгээд нь Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон шаардлагыг хангасны үндсэн дээр бүртгүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй болох юм.

Эх сурвалж: Монголбанк, СМА

2.3. БАНКНЫ САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

Банкны салбар

Банкны салбарт тайлант оны эцсийн байдлаар нийт 12 банк 15,942 ажилтан, 1,402 салбар нэгжтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Нийт хадгаламжийн дансны тоо 3.0 саяд, нийт зээлдэгчдийн тоо 0.9 саяд хүрлээ.

Зээлийн өсөлт буурч байна. Банкны салбарын зээлийн үлдэгдэл тайлант оны эцэст 17.1 их наяд төгрөгт хүрч, зээлийн цэвэр үлдэгдэл нийт активын 47.1 хувийг бүрдүүлж байна. Банкны системийн хэмжээнд нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 4.6 хувиар буюу 820.3 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд үүний 89.0 хувийг буюу 730.3 тэрбум төгрөгийг хэрэглээний зээлийн бууралт эзэлж байгаа нь төрөөс тэтгэврийн зээлийг тэглэсэн нь нөлөөлсөн байна. Харин үлдсэн 11.0 хувийг цар тахалтай холбоотой банкуудын активын бүтцийн өөрчлөлт, зээлийн агшилт тайлбарлаж байна.

Зураг 2.6. Зээлийн динамик, өсөлт (их наяд төгрөг, хувь)

Зураг 2.7. Зээлдэгчийн бүтэц, зээлдэгчээр (их наяд төгрөг)

Сүүлийн нэг жилийн хугацаанд уул уурхайн салбарын болон үл хөдлөх хөрөнгө, ипотекийн зээлээс бусад салбарын зээл агшсан байна.

Банкны салбарт чанаргүй зээлээс үүдэлтэй эрсдэл хуримтлагдсан хэвээр байна. Тайлант оны эцэст банкны системийн чанаргүй зээлийн харьцаа 10.7 хувь, анхаарал хандуулах зээлийн харьцаа 9.6 хувьтай байна. Чанаргүй зээл өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 25.6 хувиар буюу 371.2 тэрбум төгрөгөөр өссөнд Иргэдийн чанаргүй зээл 149.6 тэрбум төгрөгөөр буюу 61.2 хувиар өссөн нь голлох нөлөөг үзүүлжээ.

Зураг 2.8. Чанаргүй зээлийн хувь, зээлдэгчээр

Зураг 2.9. Чанаргүй зээлийн хувь, зээлийн төрлөөр

Зээл олгосон голлох салбаруудаас уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилгын салбарын чанаргүй зээлийн хувь тус бүр 22.5, 22.0, 16.6 хувь байгаа нь системийн дунджаас өндөр байгаа бол худалдааны салбарын зээлийн чанаргүй зээлийн хувь хамгийн бага буюу 5.0 хувьтай байна.

Зураг 2.10. Эх үүсвэрийн динамик

Зураг 2.11. Өөрийн хөрөнгийн бүтэц

Банкны салбарын татан төвлөрүүлсэн эх үүсвэр 2020 оны эцэст 32.8 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Эх үүсвэрийн өсөлтийн бүтцээс харахад дийлэнх буюу 90 гаруй хувийг харилцах, хадгаламжийн өсөлт эзэлж байгаа бөгөөд банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр болон бусад төрлийн эх үүсвэрүүдийн өсөлт саарсан байна.

Хадгаламж өмнөх оны мөн үеэс **28.6 хувиар** өссөнд гадаад валютын ханшийн өсөлтөөс шалтгаалсан валютын хадгаламжийн өсөлт, харилцах данснаас хадгаламжийн данс руу шилжих шилжилт нөлөөлсөн байж болзошгүй.

Орлого авчирдаг активын харьцаа буурч байна. Банкны салбарын зээлийн өсөлт саарч, хөрөнгө оруулалт буурсан нь банкуудын орлого авчирдаг активын харьцааг бууруулж байгаа нь цаашид банкны хүүгийн орлого, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Зураг 2.12. Банкны цэвэр ашиг(тэрбум төгрөгөөр)

Зураг 2.13. Банкны салбарын орлого, зардлын бүтэц

2019 онд банкны салбар 186.0 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан бол тайлант жилд банкны салбарын цэвэр ашиг 38.8 тэрбум төгрөг, активын өгөөж 0.1 хувьд хүрлээ.

Банкны салбарын нийт орлого 5.0 их наяд төгрөгт хүрсний 67.2 хувийг хүүгийн орлого, 31.3 хувийг хүүгийн бус орлого бүрдүүлж байна. Хүүгийн орлогын 72.2 хувийг зээлийн хүүгийн орлого, 20.7 хувийг үнэт цаасны хүүгийн орлого, үлдэх 7.1 хувийг харилцах, хадгаламжид төлөгдсөн хүүгийн орлого бүрдүүлж байна. Харин нийт зардал тайланд онд 5.0 их наяд төгрөг байгаагийн 46.8 хувийг хүүгийн, 51.2 хувийг хүүгийн бус зардал бүрдүүлж байна. Хүүгийн зардлын 71.5 хувийг харилцах, хадгаламжийн хүүгийн зардал, 18.3 хувийг зээл, үнэт цаасны хүүгийн зардал, 10.2 хувийг бусад хүүгийн зардал бүрдүүлж байна.

Активын чанар, ашигт ажиллагаа сул байгаа нь эрсдэл даах чадварыг бууруулж байна. Банкны салбарын 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 14.3 хувь, нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.4 хувь, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 46.4 хувь байна. Өөрийн хөрөнгийн зохистой харьцааны үзүүлэлтүүд системийн хэмжээнд хэвийн байгаа хэдий ч зээлийн чанар сайжрахгүй, ашигт ажиллагаа сул байгаагаас шалтгаалан системийн хэмжээнд эрсдэл даах чадвар буурч байна.

Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ

Тайлант онд Зээлийн хүүг бууруулах стратегийн бодлогын арга хэмжээний хүрээнд Монголбанкны ажил үйлчилгээний ерөнхий нөхцөлд тусгасан, банкны эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, банкны нэгж байгуулах тусгай зөвшөөрлийн шимтгэлд өөрчлөлт оруулж Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хураамжийн төлбөрийг ”0” болгохоор шийдвэрлэлээ.

Мөн Монголбанк Азийн хөгжлийн банктай хамтын ажиллагааны хүрээнд техник туслалцааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр Азийн хөгжлийн банкны Зүүн Ази бүс нутаг хариуцсан газрын Нийтийн Удирдлага, Санхүүгийн салбар, Бүс Нутгийн Хамтын Ажиллагааны хэлтэстэй дараах гурван зорилтын хүрээнд “Харилцан ойлголцлыг албан бичиг”-ээр 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр баталгаажууллаа. Үүнд:

- Банкны салбарын өмчлөлийн төвлөрлийг бууруулж, банкны үйл ажиллагааны сайн засаглалыг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох;
- Банкны хяналт, зохицуулалтын хэрэгслийг олон улсын жишигт хүргэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;
- Банкны үйл ажиллагааны төрөл, бизнесийн загвар, бусад тодорхой хүчин зүйлүүд дээр үндэслэн банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл болон холбогдох шаардлагыг төрөлжүүлэх;

Түүнчлэн банкны салбар дахь хувь эзэмшилийн төвлөрлийн бууруулах, ил тод нээллтэй, олон нийтийн хяналттай эрхзүйн орчинг бий болгох үүднээс банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг Монголбанкны ерөнхийлөгчийн тушаалаар баталлаа. Уг хөтөлбөрийн хүрээнд хийгдэх томоохон ажил болох эзэмшлийн төвлөрлийг бууруулахтай холбоотой Банкны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн төслийг, нэмэлт өөрчлөлтийг мөрдүүлэх хуулийн төслийн хамт боловсруулж УИХ-ын 2020 оны намрын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна. Мөн банкны тухай хуульд оруулах нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд банкны хянан шалгагч нарын эрхзүйн байдлыг хамгаалах томоохон өөрчлөлт оруулахаар хуулийн төсөлд оруулллаа.

Ковид-19 цар тахлын банк, санхүүгийн салбарт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад шаардлагатай боломжит арга хэмжээг Монголбанк бусад улс орнуудын туршлага болон Банкны тухай хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлж байна. Тухайлбал, Монголбанкнаас банкуудын үйл ажиллагаанд мөрдүүлдэг дараах журмуудын тодорхой зохицуулалтыг доорх нөхцөлтэйгөөр түр хугацаагаар буюу 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдрөөс 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд мөрдүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

1. “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д:

а. Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног, “Анхаарал хандуулах” зээлийн хувьд 91-120 хүртэлх хоног, “Чанаргүй” зээлийн хувьд 121-ээс дээш хоног байхаар тус тус тогтоож мөрдүүлж байна;

б. Хэрэглээний болон бизнесийн зээлийн бүтцийг 2020 оны 01 дүгээр 31-ний өдрөөс хойших хугацаанд өөрчилж, холбогдох гэрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд уг зээлийг журмын дагуу

бүтэц өөрчлөгдсөн активт тооцохгүйгээр, эцсийн ангиллыг хэвээр тогтоосон;

в. Хэрэглээний зээлд 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар тогтоосон чанарын ангиллыг түр зохицуулалт мөрдөгдөх хугацаанд хэвээр мөрдөх;

г. Аливаа зээлд хугацааны ангилал хийхдээ Гамшгаас хамгаалах хуулийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хоногийг хасаж тооцсон;

д. Банкны санхүүгийн бус өмчлөх бус хөрөнгөд тогтоох хугацааны ангилалд хөнгөлөлт үзүүлсэн.

2. "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам"-д:

а. Өөрийн хөрөнгийг хамгаалах нөөц зөрчигдөхөд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээг түдгэлзүүлсэн;

б. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг 25 хувь байсныг 20 хувь болгож бууруулсан;

Эдгээр зохицуулалт нь Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс үүдэн зээлийн эргэн төлөлтөө хийхэд хүндрэл учирч буй зээлдэгчид нь зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрөө түр хугацаагаар эргүүлэн төлөх боломжгүй тохиолдолд тухайн зээлдэгчийн зээлийн ангиллыг хэвээр үлдээж, Зээлийн мэдээллийн санд ангилал бууруулж мэдээлэхгүй байх боломжийг бүрдүүлж байна.

Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банкны үйл ажиллагаа нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас баталсан заавар журмуудтай нийцэж байгаа эсэхийг хяналт шалгалт хийх, банк, банкны нэгдэлд албадлагын арга хэмжээ авах үйл ажиллагааг 2020 онд эрсдэлд суурилсан газар дээрх болон зайны хяналт шалгалтын хэлбэрээр тогтмол гүйцэтгэн ажиллалаа. Үүнд:

Газар дээрх хяналт шалгалт	Зайны хяналт шалгалт	Албадлагын арга хэмжээ
Эрсдэлд суурилсан хяналт шалгалт	**Тогтмол хяналт шалгалт**	**Урьдчилан сэргийлэх арга хэмжээ**
• Банканд хийсэн газар дээрх иж бүрэн шалгалт 2 удаа; • Банканд хийсэн газар дээрх хэсэгчилсэн шалгалт 2 удаа; • Хяналт шалгалтын газрын Томилолтоор хийгдсэн хэсэгчилсэн шалгалт 2 удаа; • Монгол Улсын Хөгжлийн банканд хийсэн Монголбанк болон Сангийн яам хамтарсан иж бүрэн шалгалт хийсэн.	• Банкнаас ирүүлсэн тайлан, мэдээ хүлээн авч, хянаж, системийн нэгтгэлд оруулж, тайлангийн хариу хүргүүлсэн; • Сар болон улирлын зайны хяналтын дүгнэлт; • Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гаргаж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн; • Банкуудын зохистой засаглалын үнэлгээг үнэлж, банкуудад хариуг хүргүүлсэн; • Банкуудын чанаргүй активыг бууруулах төлөвлөгөөг хянаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн; • Банкны дотоод аудитын газраас хийсэн мэдээллийн технологийн үйл ажиллагааны шалгалтын тайланг хянасан.	• Холбогдох банкны хууль тогтоомжийг зөрчсөн нийт 4 банкны 2.3 тэрбум төгрөгийн зөрчилд 22 удаагийн акт, мэдэгдлээр зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн: • Шалгалтаар илэрсэн зөрчилд 44 удаагийн зөрчлийн хэрэг нээж, 421.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан; • Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах үүрэг даалгавар өгсөн; • Төв банкны тухай хуулийн 25[1] дахь зүйлийн дагуу хянагч томилсон. • Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасны дагуу урьдчилсан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүллээ.

<u>Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалтын тухай:</u> Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан удирдамжийн дагуу тухайн банкны эрсдэлтэй хэсэгт газар дээрх хяналт шалгалтыг төвлөрүүлж, эрсдэлтэй үйл ажиллагаатай холбоотой бүх баримт, материалыг газар дээр тулган баталгаажуулалт, хяналт шалгалтын хийж ажиллалаа. Монгол Улсад КОВИД-19 цар тархалттай холбоотойгоор нийтээр

мөрдөж буй хязгаарлалт, хорио цээрийн дэглэмээс шалтгаалан эрсдэлд суурилсан газар дээрх хяналт шалгалт 2020 онд төлөвлөгөөний дагуу хийгдэхгүй нөхцөл байдал үүссэн тул зайны хяналт шалгалтыг чанартай хийж гүйцэтгэхэд голлох анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Тогтмол зайны хяналт шалгалтын тухай: Монголбанкнаас банкны үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтыг газар дээрх болон зайны хяналт шалгалтыг хослуулан авч хэрэгжүүлдэг байсан. Гэвч Дэлхий нийтэд үүсээд буй цар тахлын улмаас авч хэрэгжүүлж буй хөл хорио, халдвар хамгааллын дэглэмтэй холбоотойгоор зайны хяналт шалгалтын горимд бүрэн шилжиж банкны бизнес төлөвлөгөө, чанаргүй активын үзүүлэлт болон банкны үйл ажиллагаанд үзүүлж буй КОВИД-19 цар тахлын нөлөөлөл зэрэгт түлхүү анхаарч эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг гүйцэтгэлээ. Түүнчлэн учирч болзошгүй эрсдэлийг үнэлэх, урьдчилан сэргийлэх чиглэлийн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, банкны системийн найдвартай байдлыг хангах чиглэлийн бүхий л арга хэмжээг авч ажилалаа.

Банкны тухай хуулийн 2018 оны шинэчилсэн найруулгатай холбоотойгоор Банкинд зайнаас хяналт тавих үйл ажиллагааны хүрээнд “Банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцааг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар банкууд мөрдөж эхэлснээр банкны үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, банкны томоохон харилцагч, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт тавих шаардлага, шалгуур нэмэгдсэний дагуу зайны хяналт шалгалтыг сайжруулж ажилласан.

Мөн Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 10.4 дэх заалт болон “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын зарим зохицуулалтад түр хугацаагаар өөрчлөлт оруулсантай холбоотой зайны хяналт шалгалтыг тогтмол хийж гүйцэтгэлээ.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай:Банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх явцад Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, зээлийн багцын чанарыг үнэлэх, өөрийн хөрөнгийн хүрэлцээний асуудал, үйл ажиллагааны бодлого, журам, зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо, эрсдэл даах чадвар, төлбөр зөрчил зэрэг хууль тогтоомж зөрчсөн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, банкны удирдлагад шалгалтын үр дүнг танилцуулж, нэгдсэн танилцуулгыг Хяналт шалгалтын хорооны хурлаар хэлэлцүүлэн банканд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар холбогдох үүрэг даалгаврыг өгөх, түүний биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

Монголбанк банкны салбарын тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтийг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлд ОУВС-тай хамтран банкуудаас өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, банкуудын чанаргүй активыг бууруулах төлөвлөгөөнд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах Үндсэн чиглэлийн дагуу Монгол Улсыг энэ онд оо багтаан ФАТФ-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас гаргах нь Монголбанкны эн тэргүүний ажил байсан.

Энэ зорилгын хүрээнд Хяналт шалгалтын газар нь Санхүүгийн мэдээллийн алба болон түүний дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллагуудтай хамтран ФАТФ-ын Хамтарсан бүлэгт Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тогтолцооны дутгадлыг арилгах, үр дүнтэй хэрэгжилтийг нэмэгдүүлэх чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн, үр дүнг тайлагнах, тайланг хамгаалах ажилд идэвхтэй оролцсон.

Улмаар Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын 2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан чуулганаар Монгол Улсыг ФАТФ-ын саарал жагсаалт буюу мөнгө угаах,

терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах талаар хэлэлцсэн. Хуралд оролцсон 130 орны төлөөлөгчид Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ч чиглэлээр гаргасан ахиц дэвшилийг үнэлж санал нэгтэйгээр Монгол Улсыг саарал жагсаалтаас гаргахаар шийдвэрлэсэн.

Хяналт шалгалтын газар банкны Мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтын арга хэлбэрийг ФАТФ-ын 40 Зөвлөмжид нийцүүлэн эрсдэлд суурилсан хэлбэрт бүрэн шилжүүлсэн бөгөөд банкны салбарын болон банк тус бүрийн эрсдэлийг үнэлгээг хийх ажлыг амжилттай хэрэгжүүлж байна.

Түүнчлэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дуагдалд хариуцлага тооцох, хариуцлагыг хэмжээ, төрлийг ФАТФ-ын 40 Зөвлөмжид заасан зөрчил дутагдалд нь тохирсон байх, дахин үйлдэхээс сэргийлэх, таслан зогсоох шинж чанартай байх зарчмуудад нийцүүлэн шалгалтаар илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцон, дутагдлаа засч сайжруулахад чиглэсэн хугацаат үүрэг даалгавар өгч биелэлтэд нь хяналт тавьж ажилласан.

Тайлант онд Монголбанк Хяналт шалгалтын газар нь ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу МУТС-тэй тэмцэх чиглэлээр ажиллаж байгаа бусад төрийн байгууллагатай Хамтын ажиллагааны зөвлөлийн хүрээнд хамтран ажиллах, бодлого, журмын өөрчлөлтийн төслийг хамтран боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийх, сургалт хийх хэлбэрээр хамтран ажилласан.

10 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд орсон өөрчлөлтүүдтэй Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг нйцүүлэх зорилгоор өөрчлөлтийн төслийг боловвсруулан, төрийн холбогдох байгууллагууд болон олон нийтийн саналыг авч Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулан, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Хяналт шалгалтын газраас банкны салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны эмзэг сул талыг тодорхойлох, түүнийг арилгах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах зорилгоор салбарын эрсдэлийг үнэлгээг бүх банкны төлөөлөл, Монголын банкны холбоо, Санхүүгийн мэдээллийн алба болон төрийн бусад байгууллага, судлаачдыг оролцуулан хийж тайлангийн эхний төслийг бэлэн болгоод байна.

Газар дээрх хяналт шалгалт, авсан арга хэмжээ

Хяналт шалгалтын газраас 2020 онд хийсэн газар дээррх шалгалтаар банкуудын МУТСТ эрсдэлийн үнэлгээний аргачлал, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа, гүйлгээг мэдээлэх, эцсийн өмчлөгчийг таньж мэдэх чиглэлээр тодорхой зөрчил дутагдлууд илэрсэн бөгөөд үүнтэй холбогдуулан нийт 5 удаагийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Мөн илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгах, үйл ажиллагааг нь сайжруулахад чиглэсэн нийт 28 үүрэг даалгаврыг шалгалт хийгдсэн банкуудад өгч хэрэгжилтийн явцыг хянан ажиллаж байна.

Хүснэгт 2.3 ХШГ-ын МУТХ-ийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн газар дээрх хяналт шалгалт.

Үзүүлэлт	2019 он
Эрсдэлд суурилсан газар дээрх хяналт, шалгалт	4
Сэдэвчилсэн хяналт шалгалт	15
Нэгдсэн хяналт шалгалт /СЗХ-той хамтарсан/	-
Шалгалтаар тогтоосон Улсын байцаагчийн акт, мэдэгдэл	-
Ногдуулсан торгууль, шийтгэлийн тоо	5
Шалгалтаар өгсөн үүрэг даалгавар	28

Эх сурвалж: Монголбанкны Хяналт шалгалтын газрын МУТХ

Мөн банкууд Нэгдсэн үндэсний байгууллага (НҮБ)-ийн хоригийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар газар дээрх шалгалтыг бүх банкинд гүйцэтгэсэн ба шалтгалтаар илэрсэн байдалд үндэслэн цаашид ямар арга хэмжээ авах талаар чиглэл, зөвлөмж өгч ажиллаа.

МУТСТ-тэй чиглэлээр хийсэн сургалт, семинар

Монголбанкны Хяналт шалтгалын нэгж нь Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, Тагнуулын ерөнхий газар, Санхүүгийн мэдээллийн алба, Монголын банкны холбоо зэрэг байгууллагууд болон бусад байгууллагатай хамтран ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилт болон МУТСТ талаарх чиглэл бүхий 15 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг хийлээ.

Хүснэгт 2.4 Тусгай хяналтын албаны мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн сургалт, хэлэлцүүлэг.

	Сургалтын нэр	Он, сар	Зохион байгуулагч	Оролцогч-дийн тоо
1	Үндэсний эрсдэлийн үнэлгээ, салбарын эрсдэлийн үнэлгээг хийх зорилгоор банкуудад зориулсан сургалт	2020.05.	СМА, МБХ-ны дэргэдэх Комплаенсийн мэргэжлийн зөвлөлтэй хамтран	28
2	Үй олноор хөнөөх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтод хориг арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны аргачлал	2020.05	ТТЗ	32
3	ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад банкуудыг бэлтгэх сургалт	2020.09	ХАЗ, МБХ-ны дэргэдэх Комплаенсийн мэргэжлийн зөвлөлтэй хамтран	24
4	Салбарын эрсдэлийн үнэлгээний урьдчилсан тайланд санал, шүүмж авах хэлэлцүүлэг	2019.03.20	ХАЗ, МБХ-ны дэргэдэх Комплаенсийн мэргэжлийн зөвлөл	48

Эх сурвалж: Монголбанкны Хяналт шалгалтын газрын МУТХ

2.4 ГАДААД ВАЛЮТЫН УЛСЫН НӨӨЦИЙН УДИРДЛАГА

"Төв банкны тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлд заасны дагуу Монголбанк гадаад валютын нөөцийн найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, дээрх нөхцөлүүд бүрэн хангагдсан тохиолдолд үр өгөөжийг нэмэгдүүлэх гэсэн зарчмын дагуу гадаад валютын улсын нөөц (ГВУН)-ийн удирдлагыг хэрэгжүүлдэг. ГВУН-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт нь олон улсын жишигт нийцсэн, оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан тодорхойлсон давхар хяналтын тогтолцоог бий болгоход чиглэсэн байдаг.

Зураг 2.14. Төв банкны бодлогын хүү (%)

Эх сурвалж: Блүүмберг

Монголбанк 2020 онд ГВУН-ийн бүтцийг хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн түвшинд баталж, түүний хүрээнд нөөцийн актив, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажиллаа.

Ковид-19 вирусын нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн өсөлт удааширч, тодорхойгүй байдал нэмэгдсэн нь олон улсын зах зээлийн хөрөнгө оруулалтын орчинг тогтворгүй болгосон. Дэлхийн олон улсын Төв банкууд эдийн засгийн тодорхойгүй байдлыг харгалзан мөнгөний зөөлөн бодлого баримталж, эдийн засгийн өсөлтийг дэмжив. Тайлант онд АНУ-ын Холбооны нөөцийн банк болон Английн төв банк бодлогын хүүгээ 0 орчим хүртэл бууруулсан бол бусад улсын Төв банк бодлогын хүүгээ тогтвортой хадгалжээ (Зураг 2.14).

Монголбанкнаас валютын нөөцийг дэлхийн эдийн засагт тэргүүлэгч АНУ, Япон, Франц, Англи зэрэг орнуудын Төв банк, Засгийн газар, Олон улсын төлбөр тооцооны банк зэрэг зээлжих зэрэглэл өндөртэй байгууллагуудад харилцах, хадгаламж, үнэт цаас хэлбэрээр байршуулж удирдлаа. Харин нөөцийн урт хугацаат багцыг АНУ-ын Засгийн газар, олон улсын санхүүгийн корпорацийн 0-3 жилийн хугацаатай үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийх замаар удирдаж, олон улсын бенчмарк өгөөжийг давуулан биелүүлэв.

Монголбанкны дотоодын зах зээлээс худалдан авсан алтны хэмжээ 23.57 тн хүрч, өмнөх оны үзүүлэлтээс 55 хувиар өслөө. Олон улсын зах зээлд алтны үнэ өндөр байсан тул нөөцөд эзлэх мөнгөжсөн алтны багцын хэмжээг хэвээр хадгалж, голч түвшнөөс дээгүүр удирдаж ажиллаа.

Зураг 2.15. Гадаад валютын улсын нөөц (сая ам.доллар) ба импортын хэрэгцээг хангах түвшин (сараар)

Эх сурвалж: Монголбанк

Монголбанк 2020 онд ГВУН-ийн бүтцийг хүлээн зөвшөөрөгдөхүйц эрсдэлийн түвшинд баталж, түүний хүрээнд нөөцийн актив, хөрөнгө оруулалтын тохиромжтой хугацаа, хэрэгслүүдийг тус тус тодорхойлон ажиллалаа.Монгол Улсын гадаад валютын албан нөөц 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4,526.59 сая ам.долларт хүрч, оны эхнээс 4.3 хувиар буюу 185.5 сая ам.долларoор өссөн. Энэхүү үзүүлэлт нь:

- Валютын төлбөртэй барааны импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 11 сарын буюу 44 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,
- Валютын төлбөртэй бараа болон үйлчилгээний импортын сүүлийн 3 сарын дундаж гүйцэтгэлээр авч үзэхэд 8.6 сарын буюу 34.4 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшинд,

тус тус байгаа нь олон улсын жишиг доод түвшин болох импортын 3 сарын буюу 12 долоо хоногийн хэрэгцээнээс 4-6 сараар өндөр байна (Зураг 2.15). Харин Монгол Улсын Их хурлын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн үзэл баримтлалд заасан “ГВУН нь валютын төлбөртэй импортын нэг жил буюу 52 долоо хоногийн хэрэгцээг хангах түвшнөөс багагүй байх” тухай шаардлагыг хангахгүй байна.

2.5 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМ

Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааг хөгжүүлэх, олон улсын сайн жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд Монголбанк нь Дэлхийн банкнаас үзүүлэх техник туслалцааны хугацааг 2020 онд дахин нэг жилээр сунгаж, ойрын 5 жилд хийж хэрэгжүүлэх шаардлагатай ажлууд дээр тус банкны мэргэжилтнүүдтэй санал солилцож, Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг хөгжингүй орны жишигт нийцүүлэх стратегийн баримт бичгийг боловсруулах ажлыг эхлүүлж, холбогдох судалгааг хийсэн бөгөөд Стратегийг 2021 онд батлуулахаар ажиллаж байна.

Монголбанкны зүгээс төлбөрийн систем дэх финтек компаниудын үйл ажиллагааг дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд олон улсад түгээмэл нэвтэрсэн “Сэндбокс” зохицуулалтын талаарх судалгааг хийж, Монголбанкны дэргэд инновацийн оффис байгуулахаар шийдвэрлэсэн. Инновацийн оффисыг байгуулснаар төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр зэхэж буй компаниуд зөвшөөрөл авахаас өмнө Монголбанктай илүү ойр хамтран ажиллах, мэдээлэл солилцох, хууль тогтоомж,

Монголбанкны бодлогын талаар илүү мэдээлэл олж авах, шинэлэг технологи, санал, санаачлагыг дэвшүүлэх, шаардлагатай тохиолдолд хязгаарлагдмал хүрээнд, туршилтын журмаар үйл ажиллагаа явуулах боломж нээгдэх юм.

Үндэсний төлбөрийн системийн үйл ажиллагааны найдвартай, үр ашигтай, аюулгүй байдлыг хангаж ажиллах үндсэн зорилгын хүрээнд Үндэсний төлбөрийн ₮ картыг олон улсын EMV чип технологид шилжүүлэх, мөн зайнаас унших боломжтой болгох ажлыг эрчимжүүлж, бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэлээ. Ингэснээр банкууд 2021 оны 2 дугаар улирлаас эхлэн EMV стандартын шаардлагыг хангасан чип бүхий үндэсний брэнд ₮ картыг хэрэглээнд нэвтрүүлэх боломжтой боллоо. Мөн, дээрх ажлын хүрээнд ₮ картын лого, холограм, Үндэсний цахим гүйлгээний төвийн лого зэргийг өөрчилж, стандартыг шинэчлснээр холограмын хэвлэлтийг Монголбанк өөрийн хяналтад авч, карт гаргагч, картын бэлдэц нийлүүлэгч нарт шинэчлэн батлуулсан ₮ картын холограмыг олголоо.

Ковид цар тахлын нөлөөгөөр болон бусад хүчин зүйлсээс шалтгаалж бэлэн бус төлбөр тооцоо өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан Монголбанкны зүгээс чиптэй картын хувьд пин код шаардахгүйгээр үүсгэж болох гүйлгээний дээд хязгаарыг 100,000 (нэг зуун мянга) төгрөг болгон нэмэгдүүлж "Төлбөрийн картын журам"-д холбогдох зохицуулалтыг шинэчлэн тусгасан. Мөн, интернэт худалдан авалтын гүйлгээний баталгаажуулалтыг CVV кодоор баталгаажуулах тохиолдолд карт гаргагч тал тухайн гүйлгээг зөвшөөрдөг байх зохицуулалтыг давхар тусгасан. Ингэснээр хэрэглэгч картаар хийж буй бага дүнтэй худалдан авалт болон интернэт худалдан авалт хийхэд заавал пин код оруулах шаардлагагүй болох юм.

Банк хоорондын бага дүнтэй төлбөрийн системээр дамжиж буй гүйлгээ саатах, буцаагдах эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанкны "Автомат клиринг хаус системийн дүрэм"-д дансны нэгдсэн санд хэрэглэгчийн дансны нэр, дугаарыг заавал тусгах зохицуулалтыг нэмсэн. Ингэснээр Засгийн газраас иргэдэд олгодог хүүхдийн мөнгө, татварын буцаан олголт гэх мэт багцын гүйлгээнүүд цаг тухайдаа иргэдийн дансанд орох зэрэг эерэг үр дагавар үзүүлэх юм.

Азийн хөгжлийн банк (АХБ)-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Төлбөрийн системийн шинэчлэл" төслийн хүрээнд Монголбанкны Үндэсний цахим гүйлгээний төвийн Улаанбаатар хотод байрлах үндсэн дата төв болон Дархан-Уул аймагт байрлах нөөц төвийг тус тус шинэчлэх ажлыг амжилттай гүйцэтгэж, ашиглалтанд оруулав. Шинэ дата төвийг Uptime Institute-ийн TIER II стандартын дагуу шинэчилсэн нь үндэсний төлбөрийн системийн дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийн шинэлэг боломж, бололцоог бий болгож байна. Дата төвийн шинэчлэл нь төлбөрийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахад чиглэсэн нэн чухал дэвшилтэд шийдэл болсон.

АХБ-ны Төлбөрийн системийн шинэчлэл төслийн санхүүжилтээр Үндэсний цахим гүйлгээний төвийн төлбөрийн картын системийг шинэчлэх ажлыг гүйцэтгэж байна.

Монголбанкнаас хэрэгжүүлэх томоохон төсөл бол ухаалаг гар утсанд суурилсан төлбөрийн картын гүйлгээ болон Токен үйлчилгээний систем нэвтрүүлэх ажил юм. Эдгээр системийг нэвтрүүлснээр картын мэдээллийг гар утсандаа бүртгүүлж, мобайл хэтэвч байдлаар ашиглан, зайнаас төлбөр тооцоог хурдан шуурхай, аюулгүй хийх, картын мэдээлэл алдагдах болон залилан, луйврын гүйлгээний эрсдэл буурах юм. Монголбанк нь дээрх дэд системүүдийг нэгдсэн байдлаар нэвтрүүлснээр банк, санхүүгийн байгууллагууд гар утсаар гүйлгээ хийх болон токен үйлчилгээний нэгдсэн системийн үйлчилгээг авах, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын давхардсан зардлаа хэмнэх боломжтой юм.

Төлбөрийн системийн хяналт, зөвшөөрөл

Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийн хүрээнд Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам, Төлбөрийн картын журам, Цахим мөнгөний журмын дагуу Монголбанк энэ онд нийт 21 зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн авсан. Зөвшөөрөл хүсч ирүүлсэн

материалыг судалж үзэн дараах байдлаар шийдвэрлэжээ. Үүнд:

Сунгасан зөвшөөрөл:

- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг 2 банканд.

Шинээр олгосон зөвшөөрөл:

- Төлбөрийн карт гаргах, хүлээн авах зөвшөөрлийг 1 байгууллагад;
- Төлбөрийн карт хүлээн авах зөвшөөрлийг 1 байгууллагад;
- Төлбөрийн хэрэгсэл – цахим мөнгө гаргах зөвшөөрлийг 4 байгууллагад;
- Хөдөлгөөнт банкны процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 байгууллагад;
- Төлбөрийн картын процессорын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2 байгууллагад тус тус олгосон байна.

Монголбанк нь оператор болон оролцогчийн эрх зүйн баримт, мэдээлэл, статистик үзүүлэлтүүдийг тодорхой давтамжтайгаар цуглуулж, дүрэм, журамд нийцэж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна. Газар дээр хийсэн шалгалтын үр дүнг системийн найдвартай, үр ашигтай байдлын үнэлгээнд ашигладаг. Төлбөрийн системийн оролцогчдыг хамруулсан газар дээрх шалгалтыг 2020 онд дараах байдлаар хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Төв банкны хариуцсан төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт /Банксүлжээ систем, ҮЦГТ-ийн бага дүнтэй болон картын клирингийн систем/;
- Бусад төлбөрийн системийн операторын үйл ажиллагааны шалгалт /ХХБ-ны картын клирингийн систем/;
- Төлбөрийн системийн оролцогч банкуудын иж бүрэн шалгалт;
- Хөдөлгөөнт банк болон төлбөрийн картын хэрэглээний тайлангийн шалгалт;
- Цахим мөнгөний үйл ажиллагааны иж бүрэн шалгалт.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүрт мэдэгдэж, залруулах талаар хянан шалгагч нар өөрийн бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч ажиллалаа.

ОУТТБ-аас гаргасан Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийн 24 зарчим, таван үүрэг хариуцлагын хэрэгжилт их дүнтэй төлбөрийн системийн түвшинд хэрхэн хангагдаж байгааг тодорхойлж, хэрэгжилтийн түвшинг ахиулж, тогтмол хангуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Банксүлжээ систем болон Төв банкны үнэт цаасны системд үнэлгээг хийсэн.

Банксүлжээ системийн үнэлгээний үр дүнгээс харахад дэд бүтцийн 24 зарчмын 12 зарчим хэрэгжсэн, 4 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 7 зарчим хамааралгүй ба Төв банкны үнэт цаасны системийн үнэлгээний хувьд 24 зарчмын 13 зарчим бүрэн хэрэгжсэн, 3 зарчим ерөнхийдөө хэрэгжсэн, 1 зарчим хэсэгчлэн хэрэгжсэн, 7 зарчим хамааралгүй байна.

Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2020 оны гүйлгээний нийт тоо, дүнг өмнөх оныхтой харьцуулбал гүйлгээний тоо 45.9 хувиар, гүйлгээний дүн 14.2 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Төлбөрийн системийн оролцогч хоорондын 2019-2020 оны байдлаарх их, бага дүнтэй гүйлгээний тоон үзүүлэлтийг Хүснэгт 2.5, өсөлт бууралтыг Зураг 2.16-д үзүүлэв.

Хүснэгт 2.5. Банк хоорондын 2019-2020 оны гүйлгээний тоо, дүн (мянган ширхэг, их наяд төгрөг)

	2019 он[1]		2020 он			
	Тоо	**Дүн**	**Тоо**	***Өөрчлөлт %***	**Дүн**	***Өөрчлөлт %***
I улирал	13,021.60	69.10	17,375.01	*33.43%*	67.43	*-2.41%*
RTP[2]	12,727.40	2.50	12,599.90	*-1.00%*	3.05	*22.00%*
ACH[3]			4,454.91		0.23	
RTGS[4]	294.2	66.60	320.20	*8.84%*	64.15	*-3.68%*
II улирал	14,856.30	78.15	22,014.99	*48.19%*	84.45	*8.06%*
RTP	14,474.40	3.05	15,498.30	*7.07%*	3.65	*19.67%*
ACH			6,113.57		0.64	
RTGS	381.9	75.10	403.12	*5.56%*	80.16	*6.74%*
III улирал	15,114.00	74.10	24,626.75	*62.94%*	91.33	*23.25%*
RTP	14,727.20	3.20	17,435.66	*18.39%*	4.07	*27.19%*
ACH			6,764.71		0.61	
RTGS	386.8	70.90	426.38	*10.23%*	86.65	*22.21%*
IV улирал	17,532.40	87.60	24,302.57	*38.62%*	109.50	*25.00%*
RTP	17,099.40	3.70	17,705.55	*3.54%*	4.12	*11.40%*
ACH			6,171.82		0.87	
RTGS	433	83.90	425.20	*-1.80%*	104.51	*24.57%*
Нийт	60,524.30	308.95	88,319.32	*45.92%*	352.72	*14.17%*
RTP	59,028.40	12.45	63,239.41	*7.13%*	14.89	*19.61%*
эзлэх хувь	*97.53%*	*4.03%*	*71.60%*		*4.22%*	
ACH	0.00	0.00	23,505.01		2.35	
эзлэх хувь	*0.00%*	*0.00%*	*26.61%*		*0.67%*	
RTGS	1,495.90	296.50	1,574.90	*5.28%*	335.47	*13.14%*
эзлэх хувь	*2.47%*	*95.97%*	*1.78%*		*95.11%*	

Зураг 2.16. Банк хоорондын 2019-2020 оны гүйлгээний тоо, дүн

Зургаас үзэхэд гүйлгээний тоо, дүн I дүгээр улиралд буурдаг өмнөх жилүүдийн хандлага хэвээр байна. Тодруулбал, гүйлгээний дүн 2019 оны IV дүгээр улиралд 87.6 их наяд төгрөг, мөн гүйлгээний тоо 17.5 сая ширхэг байсан бол 2020 оны I дүгээр улиралд 67.4 их наяд төгрөг болж 20.2 орчим их наяд төгрөгөөр, 17.4 сая ширхэг гүйлгээ болж 157.4 мянган ширхэг гүйлгээгээр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Тайланд оны эцэст 24.3 сая ширхэг 109.5 их наяд төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны эцсээс 6.7 сая ширхэг, 21.9 их наяд төгрөгөөр өсчээ.

[1] Монголбанкны дамжуулсан гүйлгээний мэдээг 2019 оны I улирлаас эхлэн их дүнтэй гүйлгээний мэдээнд нэгтгэх болсонтой холбоотойгоор банк хоорондын гүйлгээний дүн огцом өссөн үзүүлэлттэй байна.
[2] RTP - Бага дүнтэй төлбөрийн систем (бодит цагийн гүйлгээ)
[3] ACH - Бага дүнтэй төлбөрийн систем (багцын гүйлгээ)
[4] RTGS - Банксүлжээ буюу их дүнтэй төлбөрийн систем

Төлбөрийн карт

Төлбөрийн картын хэрэглээний үзүүлэлт өсөж байгаа нь бэлэн бус төлбөрийн хэрэгслийг өдөр тутмын төлбөр тооцоонд ашиглах иргэдийн сонирхол өндөр болж байгааг харуулж байна. Банкууд ₮ карт, Виза, Мастеркарт, Юнионпэй, Американ экспресс болон Жэй Си Би гэсэн 6 төрлийн төлбөрийн картыг өөрийн оноосон нэрээр гаргаж байна. Энэ оны байдлаар нийт картын 63.6 хувийг үндэсний брэнд ₮ карт дангаар эзэлж, зах зээлд түлхүү ашиглагдаж байгааг Хүснэгт 2.6-аас харж болно.

Хүснэгт 2.6. Төлбөрийн картын болон төхөөрөмжийн тоо 2017-2020 он.

Картын хэрэглээний тоо (сая)	2017	2018	2019	2020	*Өсөлт (%)*
Картын тоо	3.8	4.3	3.7	4.1	*8.8*
Идэвхитэй ашиглагдаж буй картын тоо	1.7	1.6	1.9	1.86	*-1.9*
Картын тоо - картын төрлөөр (мянга)					
₮ карт	2801.4	3115.6	2600.8	2594.6	*-0.2*
Виза	621.2	680.1	392.7	519.0	*32.2*
Мастеркарт	14.6	28.4	76.3	123.4	*61.8*
ЮнионПэй	394.8	458.0	664.6	828.0	*24.6*
Амекс	12.4	7.3	4.5	4.1	*-8.2*
ЖейСиБи	0.2	1.8	9.2	8.7	*-5.0*
Төхөөрөмжийн тоо[5]					
ПОС	27,304	42,014	59,703	70,753	*18.5*
МПОС	3,499	3,784	2,803	2,036	*-27.4*
ПОБ	2,031	2,177	2,242	2,915	*30.0*
ATM	2,031	2,358	1,259	1,084	*-13.9*
CDM	-	-	388	42	*-89.2*
CRM	-	-	1,674	1,595	*-4.7*
Цахим худалдаа	-	-	773	1,112	*43.9*
КИОСК (пос-той)	-	-	163	264	*61.9*
Бусад	-	-	0	0	*0.0*

Хүснэгтээс үзэхэд тайлант онд төлбөрийн картын тоо 8.8 хувиар өссөн хэдий ч картыг идэвхтэй ашиглагчийн тоо 1.9 хувиар буурсан байна. Төхөөрөмжийн тоон мэдээг авч үзэхэд ПОС төхөөрөмжийн тоо өмнөх оноос 18.5 хувиар өссөн нь бараа үйлчилгээний төлбөр тооцоог төлбөрийн картаар буюу бэлэн бусаар хийх боломж нэмэгдсэнийг харуулж байна.

Хүснэгт 2.7. Төлбөрийн картын гүйлгээний тайлан 2019-2020 он. (мянган ширхэг, тэрбум төгрөг)

№	Төхөөрөмж	Утга	2019 он, IV улирал	2020 он, IV улирал	Өсөлт/бууралт	Өсөлт/бууралт хувиар
1	ПОС	Тоо	80,457.2	99,073.6	18,616.5	*23.1%*
		Дүн	2,013.0	2,311.0	298.0	*14.8%*
2	МПОС	Тоо	82.0	12.3	(69.7)	*-84.9%*
		Дүн	1.4	0.6	(0.8)	*-58.9%*
3	ПОБ	Тоо	421.1	317.3	(103.8)	*-24.7%*
		Дүн	119.4	76.1	(43.3)	*-36.3%*
4	ATM/CRM/CDM	Тоо	31,586.6	22,614.6	(8,972.0)	*-28.4%*
		Дүн	8,200.1	6,251.5	(1,948.6)	*-23.8%*
5	Цахим худалдаа	Тоо	290.7	485.2	194.5	*66.9%*
		Дүн	13.0	20.0	6.9	*53.2%*
6	КИОСК (пос-той)	Тоо	73.2	76.6	3.4	*4.6%*
		Дүн	2.2	1.3	(1.0)	*-43.7%*
7	Бусад	Тоо	0.0	0.0	0.0	*0.0%*
		Дүн	0.0	0.0	0 .0	*0.0%*
Нийт (Улс)		Тоо	112,910.8	122,579.7	9,668.9	*8.6%*
		Дүн	10,349.1	8,660.4	(1,688.8)	*-16.3%*

[5] Төхөөрөмжийн ангиллыг 2019 оны дөрөвдүгээр улирлаас эхлэн 9 төрлөөр бүртгэж эхэлсэн

Гүйлгээний үзүүлэлтийн хувьд тайлант онд ПОС төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний тоо хамгийн өндөр буюу 99.1 сая ширхэг байсан. Харин гүйлгээний дүнгийн хувьд ATM, CRM, CDM төхөөрөмжүүдээр хийгдсэн гүйлгээний дүн хамгийн их буюу 6.3 их наяд төгрөгийн үзүүлэлттэй байна. Өмнөх оны үзүүлэлтээс хамгийн их хэрэглээ нь өссөн төхөөрөмж нь Цахим худалдаа байсан ба гүйлгээ нь 66.9 хувиар, гүйлгээний дүн нь 53.2 хувиар тус тус өссөнийг Хүснэгт 2.5-аас харж болно.

2.6 БАНК САНХҮҮГИЙН САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ, ШИНЭЧЛЭЛ

2020 онд Төрөөс банк, санхүүгийн салбарын талаар баримтлах урт хугацааны хөгжлийн зорилтыг тодорхойлж, банкны зохистой засаглалыг бүрдүүлэх, зээлийн хүүг бууруулах зорилтын хүрээнд хууль тогтоомжийн томоохон шинэчлэл хийгдсэний сацуу Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө, эрсдлийг бууруулах зорилгоор банк, санхүүгийн салбарт хэрэгжүүлэх тусгай арга хэмжээ, зохицуулалтын эрх зүйн үндсийг бий болгосон онцлог жил байв.

Монголбанк нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт болох “Банк санхүүгийн зах зээлийн эрсдэл даах, найдвартай байдал”-ыг хангах хүрээнд Улсын Их Хурлын 2019 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл”-д туссан банк, санхүүгийн салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэн хийж, банкны салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зохистой засаглалын зарчим, олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэв.

Тухайлбал, Банкны хувьцаа эзэмшигчийн өмчийн эрх болон удирдлага, хяналтын оролцооны тэнцвэртэй байдлыг хангах, банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлөөс үүдэлтэй банкны үйл ажиллагааны эрсдлийг бууруулах зорилгоор банкны үйл ажиллагааг зөвхөн хувьцаат компани хэлбэрээр эрхлэх, банкны хувьцаа эзэмшил аливаа этгээд, түүний холбогдох этгээдийн хувьд банкны нийт саналын эрхтэй хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх, банкны хяналт шалгалт, албадлагын арга хэмжээний үндэслэлийг боловсронгуй болгох агуулгатай Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, бусад дагалдах хуулиуд Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжилт чуулганаар баталлаа.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын тохиолдол Монгол Улсад бүртгэгдэж төрийн эрх бүхий байгууллагаас гамшгийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдуулан банкны үйл ажиллагааны эрсдэл, зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, банкны харилцагчид хөнгөлөлт үзүүлэх чиглэлээр Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлын үед санхүү,эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоол, Коронавируст халдвар /ковид=19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тус тус батлагдлаа.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан банк, санхүүгийн салбарын төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах Төв банк цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар зайлшгүй тохиолдолд дараах арга хэмжээний эрх зүйн үндсийг дээрх хууль тогтоомжоор бүрдүүлэв. Тухайлбал, төгрөгийн болон банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангаж, эдийн засгийн тодорхой салбарыг дэмжих, банкны санхүүгийн байдлыг сайжруулах зорилгоор банканд зээл олгох, хуульд заасан арга, хэрэгслийг ашиглах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, зохицуулах зорилгоор дотоод болон гадаадын улс, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хуулийн этгээдээс зээл болон бусад хэлцлээр гадаад валют авах, худалдан авах нөхцөлтэйгөөр дотоодын банк, санхүүгийн байгууллагад зээл олгох, банкны үнэт цаас худалдан авах бүрэн эрхийг Монголбанкинд олгов.

Мөн Цар тахлын үед банкны хугацаагүй хадгаламж, харилцах дансанд хүү тооцохгүй, тусгай нөхцөлтэй хадгаламжид энгийн хадгаламжийн хүү тооцох, иргэн, хуулийн этгээд хоорондын мөнгөн төлбөрийн үүрэг, гүйлгээг гадаад валютаар гүйцэтгэхийг хориглох зохицуулалтаас гадна Банк, эрх бүхий хуулийн этгээдээс цахим хэлбэртэй үйлчилгээнд тухайн банк, эрх бүхий хуулийн этгээдэд данстай, санхүүгийн тогтвортой харилцаа үүсгэсэн этгээдийн бүртгэлтэй баталгаат цахим шуудан, эсхүл техникийн хэрэгсэл, программ хангамж, нууцлалын шаардлага хангасан нууц үг, нууц код, тоон гарын үсэг зэргийг ашиглан гаргасан саналыг банк, эрх бүхий хуулийн этгээд хүлээн авсан бол Иргэний хуулийн 42[1] дүгээр зүйл, 196.1-д заасантай адилаар хэлцэл хийсэн, гэрээ байгуулсанд тооцохоор хуульчилсан байна.

Түүнчлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Валютын зохицуулалтын талаар баримтлах төрийн бодлогын эрх зүйн эх сурвалж болох Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Монгол Улсын эрдэнэсийн эх нөөцийг хамгаалах, төрийн эрдэнэсийн санг бүрдүүлэх, хамгаалах, арвижуулах, тус сангаас хөрөнгө гүйлгээнд оруулах, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон банк, эрх бүхий хуулийн этгээдээс мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйл ажиллагаанд баримтлах ерөнхий нөхцлийг тогтоож, харилцагчийн эрхийг хамгаалах агуулгаар боловсруулсан Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурал хэлэлцэж байна.

Улсын Их Хурлын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Зээлийн хүүг бууруулах стратеги”-ийн баримт бичигт зээл төлөх хөшүүргийг ашиглаж чанаргүй зээлийг төлүүлэх, барьцаа хөрөнгөөр зээлийн төлбөрийн үүргийг хангуулах ажиллагааг эрчимжүүлэх, шүүхийн бус журмаар шийдвэрлэх агуулгаар банкны үйл ажиллагаанд мөрдөгддөг иргэний хууль тогтоомжийг шинэчлэн банкны үйл ажиллагааны зардлыг бууруулахаар тусгагдсан бөгөөд Монголбанкнаас холбогдох байгууллагуудтай хамтран хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах төсөл боловсруулах, арга хэмжээ авах ажлыг хэрэгжүүлж байна.

2.7 ОЛОН НИЙТИЙН САНХҮҮГИЙН СУУРЬ МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд иргэдийн санхүүгийн зах зээлд ухаалгаар оролцох оролцоог нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргалтыг дээшлүүлэх зорилгоор Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, Санхүүгийн Зохицуулах Хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2016 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөтөлбөрийг холбогдох төрийн болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран тэргүүлэх 4 чиглэлээр буюу сургуулийн насанд, залуу үед, хөдөө орон нутгийн иргэд болон цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлж байна.

Санхүүгийн боловсрол дээшилснээр дараах голлох үр дүнд хүрнэ:

- Иргэдийн санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт нэмэгдэж, илүү үр дүнтэй ашиглана;
- Иргэд өөрийн хэрэгцээнд тохирсон, зөв бүтээгдэхүүн сонгох боломжтой болно;
- Санхүүгийн залилангаас урьдчилан сэргийлж, түүнд өртөх иргэдийн тоо буурна;
- Иргэдийн хадгаламж нэмэгдэж, чанаргүй зээлийн түвшин багасна;
- Хөрөнгийн зах зээл дэх оролцоо, хөрөнгө оруулалт өснө.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах гол сэдвүүдэд чиглэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн талаар суурь ойлголтууд;
- Төсөв болон санхүүгийн төлөвлөлт;

- Хадгаламж;
- Зээл;
- Хөрөнгө оруулалт;
- Санхүүгийн эрсдэлээс хамгаалах (Даатгал гэх мэт);
- Тэтгэврийн хуримтлал үүсгэх;
- Нийгмийн даатгал болон татварын талаар ойлголтууд;
- Санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын талаар ойлголтууд.

2020 онд тус хөтөлбөрийн хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд:

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар

Монгол улсын засгийн газрын 2017 оны 299 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын санхүүгийн салбарыг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"–ийн Зорилго 6.2 "Монгол Улсын иргэд өөрийн болон өрхийн санхүүгээ зохистой удирдах мэдлэг, чадвар болон итгэл үнэмшилтэй болгоно" гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл

2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн УИХ-ын "Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай" 98-р тогтоолын Зорилт 3.3 "Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг сайжруулна" хэмээн тусгагдсаныг хэрэгжүүлж ажиллаа.

Санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төсөл

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5-р зүйлийн 1.7-д "банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах" гэж заасны дагуу Монголбанкнаас бусад байгууллагуудтай хамтран санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулан хууль санаачлагч нарт уламжилсан ба УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, зохих саналуудыг тусган УИХ-ын чуулганд танилцуулахаар тогтлоо.

Энэ хуулийн зорилт нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээс санхүүгийн хэрэглэгчтэй харилцах, санхүүгийн үйлчилгээ, бүтээгдэхүүн санал болгох, нийлүүлэхэд тавигдах шаардлагыг тогтоох, мөнгө хүүлэлтийн эсрэг зээлдэгчийн эрх болон санхүүгийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах, түүнтэй холбоотой гомдол, маргааныг хянан шийдвэрлэх, олон нийтэд санхүүгийн боловсрол олгох замаар санхүүгийн зах зээлийн зохистой хөгжил, хүртээмж, чадамжийг дээшлүүлэхэд оршино. Дээрх хуулийн төсөлд "санхүүгийн боловсрол ба хяналт" бүлэг орсон болно.

Зээлийн хүүг бууруулах стратеги

СТБЗ-ийн зөвлөмжөөр Монголбанкнаас "Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023"-ийг хэрэгжүүлж байгаа ба уг стратегийн 11 дэх Зорилтод "Санхүүгийн байгууллага, тэдгээрийн хэрэглэгч болон олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх" заалт тусгагдаж, үүний дагуу ажлууд хийгдэж байна. Мөн энэхүү стратегийн үргэлжлэл болгож 2020 оны 8-р сарын 28-ны өдрийн УИХ-ын хуралдаанаар "Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай" тогтоолыг баталсан. УИХ-ын 21 дугаар тогтоолоор батлагдсан уг стратегийн зээлийн эрсдэлийн зардлыг бууруулах чиглэлд "Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх" заалт тусгагдан, хэрэгжүүлж байна.

Сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад санхүүгийн боловсрол олгох “Бизнес судлал” хичээлийг сонгон судлахаар БСШУ-ны сайдын 2019 оны А/491 тоот “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалыг баталсан. Уг тушаалын хэрэгжилтийг хангаж ЕБС-ийн нийгмийн ухааны багш нар “Бизнес судлал” хичээлийг зааж байгаа ба Монголбанкнаас энэхүү ажилд дэмжин ажиллаж байна.
- Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор үндэсний хэмжээнд Монголбанк Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг дэмжих хүрээнд тус судлагдахууныг заах түүх, нийгмийн ухааны 1870 багшийг чадавхжуулахад Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран ажиллалаа.

Залуучуудад санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хүрээнд 3 кредит бүхий “Хувь хүний санхүү” хичээлийг магадлан итгэмжлэгдсэн 13 их, дээд сургуульд орж байна.
- Цар тахлын улмаас халдвар хамгааллын дэглэмийг сахин танхимын болон цахим сургалтуудыг зохион байгуулж, нийт 1200 орчим оюутан, залуус хамрагдлаа.
- Монголбанк, БШУЯ-ны харъяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Санхүүгийн зохицуулах хороо, Бичил санхүүгийн хөгжлийн сантай хамтран 729 санхүүгийн сургагч багш нарыг өнгөрсөн хугацаанд бэлтгэсэн ба залуучуудад мэдлэг, мэдээлэл өгөх чиглэлээр ажиллав.
- Иргэдэд санхүүгийн мэдлэг олгох 24,000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, “Мөнгөө хэрхэн удирдах вэ?”, “Зээл”, “Өрхийн төсөв”, “Хуримтлал ба хадгаламж”, “Үнийн түвшин”, “Валютын ханш” зэрэг сэдвээр гарын авлагыг түгээж ажиллав.
- Мөн Монголбанк Залууст санхүүгийн боловсрол олгох зорилтот үйл ажиллагааг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хэрэгжүүлэхээр санамж бичигт гарын үсэг зурлаа. Талуудын хамтын ажиллагааны үр дүнд залуусын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлснээр тэдний санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадварыг хөгжүүлэх, хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт хийх мэдлэг, чадварыг дэмжих шинэ боломжийг бий болгох юм. Санамж бичгийн хүрээнд хувь хүний санхүүгийн боловсрол олгох амьдрах ухааны хөтөлбөрийг хамтран боловсруулах, санхүүгийн сургагч багш нарыг бэлтгэх, олон талт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, санхүүгийн мэдлэг олгох гарын авлага, багшийн ном, сургалт явуулахад ашиглагдах материал, видео хичээл болон бусад цаг үеийн хэрэглэгдэхүүнийг боловсруулж, түгээх зэрэг ажлууд хийгдэнэ.

Цахим хуудсаар санхүүгийн боловсрол олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг олгох www.sankhuugiinbolovsrol.mn цахим хуудсыг тогтмол баяжуулан ажиллалаа.
- “Монголбанкны мэдээлэл”, “Монголын эмэгтэйчүүд” сар бүрийн товхимол, ЦЕГ-ын “Амрыг эрье” улирал тутмын товхимолд санхүүгийн боловсрол олгох буланг тогтмол ажиллууллаа.
- “Санхүүгийн боловсрол” фейсбүүк пэйжийг тогтмол мэдээ, мэдээллээр ханган 6000 гаруй дагагчтай боллоо.
- MYOHP-гийн “Санхүүгийн мод” нэвтрүүлгээр 29 дугаарыг шууд эфирээр болон фейсбүүкээр олон нийтэд түгээв. Мөн MYOHP-ын дэргэдэх “Пи 3” радиотой хамтран “Энгийн эдийн засаг” нэвтрүүлгийг хамтран бэлтгэж, 18 дугаарыг санхүү, эдийн засгийн ойлголтыг энгийн, ойлгомжтой олгох чиглэлээр ажиллав.
- Иргэдийн эдийн засгийн мэдлэгт зориулж Ikon.mn цахим сайтад Эдийн засаг энгийнээр буланг нээж тогтмол мэдээллээр баяжуулж ажиллалаа.

Олон улсын байгууллагуудтай хамтарч ажилласан байдал

ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан

- Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын "Остпригнитц-Руппины Шпаркассэ" банктай хамтран "Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх онол, практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх төсөл"-ийг хэрэгжүүлээд 3 жил болж байна. Энэхүү хугацаанд 7 модуль бүхий сургалтад арилжааны 11 банкны нийт 185 оролцогч, сургагч багш бэлтгэх хөтөлбөрт нийт 94 багш амжилттай хамрагдсан байна. Үүнээс энэ жил Улаанбаатар хотод 30 мэргэжилтэн амжилттай хамрагдав. Монголбанк, Хадгаламжийн даатгалын корпораци, Монголын банкны холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, арилжааны 11 банк хамтран "Хуримтлуулах, хялбархан" уриатайгаар 10 дугаар сарын 31-ний өдөр "Дэлхийн хуримтлалын өдөр"-ийг Улаанбаатар хотноо, Дархан-Уул аймагт, 10 дугаар сарын 22-ны өдөр Орхон аймагт, 10 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар аймагт хийж, иргэдэд, хүүхэд багачуудад санхүүгийн мэдлэг олгох, хуримтлалыг хэвшил болгохыг дэмжсэн үйл ажиллагаануудыг өрнүүллээ.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк /EBRD/

Монголбанк, Европын сэргээн босголт хөгжлийн банк хамтран "Бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох стратеги" болон "Сургалтын модуль" бэлтгэж, боловсруулах ажлыг 2020 онд эхлүүллээ. Энэ ажлын хүрээнд сургагч багш нарыг бэлтгэх, БЖДҮ эрхлэгчдэд сургалтанд хамруулах, тэдний санхүүгийн боловсролыг дээшлүүлэх өргөн хэмжээний арга хэмжээг хэрэгжүүлэх ба цаашлаад дэд хөтөлбөр болон батлагдах юм.

OECD/INFE Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагын Олон улсын санхүүгийн боловсролын сүлжээ

ЭЗХАХБ-ын ЕвроАзийн өрсөлдөх чадварыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд ЭЗХАХБ нь бичил, жижиг, дунд үйлдвэрүүдийн санхүүжилтийн хүртээмжийг сайжруулах талаар Монгол Улсын Засгийн газартай хамтран ажиллан үр дүнгийн талаарх мониторинг хийсэн болно. Үүнд өнгөрсөн 3 жилд гаргасан ахиц дэвшлийг үнэлж, цаашид хэрэгжүүлэх зөвлөмжид: ".....хяналт шинжилгээний хүрээнд Монголбанкны санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх стратеги ба арга хэрэгслүүд боловсруулж хэрэгжүүлсэн байдал болон ЭЗХАХБ-ны олон улсын санхүүгийн боловсролын сүлжээнд элссэнийг" онцлов.

МӨНГӨНИЙ ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

3

3.1 НЭЭЛТТЭЙ ЗАХЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төв банкны үнэт цаас

Нээлттэй захын үйл ажиллагаа буюу Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл юм.

Монголбанк 2020 онд мөнгөний захыг хөгжүүлэх зорилгоор хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэрээр ялгаатай 2 төрлийн ТБҮЦ-ыг тогтмол арилжааллаа. Үүнд:

- 28 хоногтой ТБҮЦ-ыг тогтмол хүүтэй, хэмжээ хязгаарлаагүй хэлбэрээр Даваа гараг бүр арилжааллаа. Энэ төрлийн үнэт цаасны хүү нь бодлогын хүү болох бөгөөд банк хоорондын захын хөтөч хүүний үүргийг гүйцэтгэж, системийг илүүдэл нөөцийг татах, банкуудын нөөцийг удирдахад чухал үүрэгтэй.
- 196 хоногтой ТБҮЦ-ыг хүүгээр өрсөлдөх, хэмжээ хязгаарласан хэлбэрээр 2 долоо хоног тутам Лхагва гарагт зохион байгууллаа. Банк хоорондын захын байнгын шинжтэй бүтцийн илүүдэл нөөцийг бууруулах, урт хугацаат хэлцлийн идэвхийг нэмэгдүүлэх, төгрөгийн өгөөжийн муруйн эхлэлийг бүрдүүлэх, мөнгөний бодлогын шилжих механизмыг сайжруулах зорилгоор энэ төрлийн үнэт цаасыг арилжаалсан.

ТБҮЦ-ны үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэрлэсэн дүнгээр 7,975.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 3,311.7 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд нийт үнэт цаасны 96.1 хувийг 28 хоногийн хугацаатай, 3.1 хувийг 196 хоногийн хугацаатай үнэт цаас тус тус эзэлж байв. ТБҮЦ-ны энэхүү өсөлтөд (а) алт худалдан авалтаар 2,862.4 тэрбум төгрөг нийлүүлсэн (б) Засгийн газрын цэвэр зээл 590.8 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна (Зураг 3.1).

Зураг 3.1. ТБҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг, хугацаагаар)

Эх сурвалж: Монголбанк

Репо арилжаа

Төв банкны репо арилжаа нь банкны эзэмшиж буй үнэт цаасыг хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдах нөхцөлтэй худалдан авах хэлцэл юм. Монголбанкнаас зээлийн хүүг бууруулах стратеги болон коронавируст цар тахлын эсрэг хийгдэх ажлын хүрээнд репо арилжааны хугацааг 2 жил хүртэл сунгаж, барьцаа хөрөнгийн жагсаалтыг өргөжүүллээ. Ингэхдээ хүртээмжтэй өсөлтийг бий болгох, эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдол бүхий ЖДҮ, уул уурхайн бус экспортын салбарын өрийн дарамтыг бууруулах зорилгоор репо арилжааны эх үүсвэрийг уг салбарын аж ахуй нэгж, иргэнд Монголбанкны Ерөнхийлөгчийн А-426 дугаар тушаалаар батлагдсан нөхцөлийн дагуу олгож эхлэв. Дээрх өөрчлөлтийг хийснээр (i) Эдийн засгийн уналт, санхүүгийн зуучлалд бий болох сөрөг нөлөөллийг саармагжуулах; (ii) Эдийн засгийг төрөлжүүлэх, экспортлогч аж ахуй нэгжийг дэмжих; болон (iii) Санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн гаргах боломж бүрдлээ. Тайлант онд Монголбанкнаас репо арилжаагаар банкуудад 230.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгов. Уг олгосон санхүүжилтээр банкууд зээл олгож, олгосон зээлээ үнэт цаасжуулан, Монголбанкнаас санхүүжилт авах схемийг Зураг 3.2-д дүрслэн харууллаа.

Зураг 3.2. Хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасаар урт хугацаат санхүүжилт олгох схем

Банк хоорондын захын арилжаа

Монголбанкнаас банк хоорондын захын тогтвортой үйл ажиллагааг өдөр бүр хангаж ажиллаж байгаа бөгөөд тайлант оны хугацаанд сард дунджаар 153.4 тэрбум төгрөгийн овернайт арилжаа, 362.2 тэрбум төгрөгийн репо хэлцэл, 765.3 тэрбум төгрөгийн ТБҮЦ-ны шууд худалдан авалтыг хийсэн байна. Мөн банк хоорондын захын хэлцлийн дундаж хугацаа 12.6 хоног болж, өмнөх оноос 2.5 хоногоор буурчээ (Зураг 3.3).

Зураг 3.3. Банк хоорондын захын арилжаа (тэрбум төгрөг, хугацаагаар)

Эх сурвалж: Монголбанк

3.2 ТӨВ БАНКНЫ БАЙНГЫН САНХҮҮЖИЛТ

Монголбанк нь банкны системийн түр зуурын шинжтэй илүүдэл нөөцийг шингээх, шаардлагатай тохиолдолд нөөц нийлүүлэх нийлүүлэх замаар банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний хэлбэлзлийг бууруулах зорилгоор байнгын хэрэгслүүдийг ашигладаг. Байнгын хэрэгсэлд нөөцийг татах буюу овернайт хадгаламж, нөөцийг нийлүүлэх буюу репо санхүүжилтийн хэрэгсэл багтана.

Түүнчлэн Монголбанк хүүний нэгдсэн бодлогын хүрээнд репо санхүүжилтийн хүү нь Төв банкны хүүний коридорын дээд хязгаар (бодлогын хүү + 1 нэгж хувь), овернаит хадгаламжийн хүү нь Төв банкны хүүний коридорын доод хязгаар (бодлогын хүү - 1 нэгж хувь) болж, банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүний хэлбэлзлийг хязгаарладаг.

Тайлант онд Монголбанк давхардсан тоогоор 154 удаагийн хэлцлээр нийт 3,087.9 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийг 10.3 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкуудад олгожээ. Харин Монголбанк давхардсан тоогоор 601 удаагийн хэлцлээр нийт 32,702.9 тэрбум төгрөгийн овернайт хадгаламжийг 7.2 хувийн жигнэсэн дундаж хүүтэйгээр банкуудаас татан төвлөрүүлжээ.

3.3 БУСАД САНХҮҮЖИЛТ

Өдрийн зээл

Өдрийн зээл нь төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор Монголбанкнаас банканд олгож буй санхүүжилтийн хэрэгсэл бөгөөд тухайн өдөрт багтан эргэн төлөгдөх нөхцөлтэй, хүүгүй зээл юм. Тайлант онд Монголбанкнаас банканд өдрийн зээл олгоогүй байна.

Барьцаат зээл

Монголбанк банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор эцсийн зээлдүүлэгчийн үүргийн хүрээнд “Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн А-174 тоот тушаалаар батлагдсан "Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журам”-ын дагуу банканд барьцаат зээл олгодог.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А-97 тоот тушаалаар Монголбанкнаас банканд олгож буй барьцаат зээлийн нөхцөлд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл дараах өөрчлөлтийг оруулаа.

- Барьцаат зээлийн хугацаа 3 сар байсныг 6 сар хүртэл сунгаж, нэг удаа дахин 6 сараар сунгах,
- Барьцаат зээлийн хүүг 5 нэгж хувиар бууруулж, Монголбанкны санхүүжилтийн байнгын хэрэгслийн хамгийн өндөр хүүтэйтэнцүү хүүтэй зээл олгох болгох;

Гэсэн хэдий ч тус журмын дагуу тайлант онд банканд барьцаат зээл олгоогүй байна.

Харин Коронавируст халдварын цар тахлын үед нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдлыг харгалзан банкны санхүүгийн байдлыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хадгалах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн А-192 тоот тушаалаар "Монголбанкнаас банкинд олгох зээлийн түр журам"-ыг баталсан. Тус журмын дагуу банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах зорилгоор банкинд 6.1 тэрбум төгрөгийн барьцаат зээлийг олгов.

Ипотекийн санхүүжилт

Монголбанк Засгийн газартай хамтран 2013 оноос "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтворжуулах" дэд хөтөлбөрийн 2 дахь хэсэг болгон "Орон сууцны санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Орон сууцны ипотекийн хөтөлбөрийн гол зорилго нь бага, дундаж орлоготой өрхүүдийн орон сууцны нөхцөлийг сайжруулах, агаар болон хөрсний бохирдлыг бууруулах, орон нутгийн шилжилт хөдөлгөөнийг саармагжуулахад оршиж байна.

Хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 2020 оны эцсийн байдлаар нийт 5.2 их наяд төгрөгийн хөнгөлөлттэй хүүтэй зээлийг 91.6 мянган өрхөд Монголбанк, Засгийн газар, банкуудын эх үүсвэрээр олгоод байна (Зураг 3.4).

Зураг 3.4. Ипотекийн зээл олголт, тэрбум төгрөг

Эх сурвалж: Монголбанк

Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндсэн зорилттой нь илүүтэй нийцүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, зорилтот бүлэгт түлхүү чиглүүлэх зорилгоор Монголбанкнаас орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд холбогдох өөрчлөлтийг оруулж, 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн шинээр олгох орон сууцны ипотекийн зээлийн хүүг жилийн 6 хувь байхаар тогтоосон (Хүснэгт 3.1).

Хүснэгт 3.1. 2020 оны ипотекийн зээл олголт, тэрбум төгрөг

Эх үүсвэр	Зээлийн хэмжээ			Зээлдэгчийн тоо		
	8%	6%	Нийт	8%	6%	**Нийт**
Монголбанк	205.7	98.2	303.9	3,084	1,568	**4,652**
Банкууд	87.1	66.0	153.2	970	710	**1,680**
Нийт	**292.8**	**164.3**	**457.1**	**4,054**	**2,278**	**6,332**

Эх сурвалж: Монголбанк

Ийнхүү ипотекийн хөтөлбөрийн хүүг жилийн 6 хувь болгосноор зээлдэгчийн сарын төлбөрийн хэмжээ 20 орчим хувиар буурч, үүнийг дагаад шаардлагатай өрхийн орлогын доод хэмжээ мөн ижил хувиар буурах юм. Энэ нь орлого багатай өрхийн хамрагдах боломжийг нэмэгдүүлэх, цар тахлын эрсдэл өндөр үед зээлийн дарамтыг бууруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх, зээлийн эрсдэлийг бууруулах зэрэг олон эерэг үр дагавартай байна.

Нөгөө талд, тус арга хэмжээний үр дүнд ипотекийн зээлийн эх үүсвэрийн хэмжээ буураад байна. Өөрөөр хэлбэл, өмнө нь Монголбанктай тэнцүү хэмжээгээр банкууд эх үүсвэр олгодог байсан бол тус арга хэмжээний үр дүнд 60:40 харьцаагаар олгосноор нийт эх үүсвэр 16.7 орчим хувиар буурсан. Монгол Улсын ипотекийн зээлийн жилийн хүү 6 хувь болон буурсан нь бусад хөгжингүй болон хөгжиж буй орнууд болох БНХАУ, Шинэ Зеланд, Австрали зэрэг улсуудтай харьцуулагдахуйц түвшинд байна.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын дагуу 2020 оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах хүсэлтийг иргэдээс харилцагч банкууд авч, шийдвэрлэж ажиллалаа. Эргэн төлөлт хойшлуулах хүсэлт гаргасан нийт 2.35 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 46,115 зээлдэгчээс 2 их наяд гаруй төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй 38,152 зээлдэгчийн хүсэлтийг шийдвэрлэж зээлийн эргэн төлөлтийг 6 сарын хугацаанд хойшлуулав. Энэ нь нийт ипотекийн хөтөлбөрийн зээлийн багцын 59 хувийг эзэлж байна.

Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондын санхүүжилт

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хуулийн 10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.6-д заасны дагуу НОСК ХК-ийн хэрэгжүүлж буй түрээслээд өмчлөх орон сууцны хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас 34.4 тэрбум төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бондыг худалдан авч санхүүжүүлснээр 420 төрийн албан хаагчийг орон сууцжуулаад байна.

3.4 ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ЗГҮЦ)

Засгийн газрын санхүүгийн удирдлагыг сайжруулах, мөнгөний бодлоын арга хэрэгслийг нэмэгдүүлэх зорилгоор 2012 оны 10 дугаар сард эхлэн Засгийн газар Монголбанкаар дамжуулан засгийн газрын үнэт цаас (ЗГҮЦ)-ыг анхдагч зах зээл дээр гарган, арилжаасан юм. ЗГҮЦ нь санхүүгийн зах зээл дэх хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл бөгөөд хүүний орлого нь албан татвараас чөлөөлөгддөг давуу талтай. Иймд ЗГҮЦ-ны тогтмол арилжаа нь эрсдэлгүй хүүний жишгийг санхүүгийн захад тогтоох буюу өгөөжийн муруйг бүрдүүлэх, богино хугацаат хүүний урт хугацаат хүүнд нөлөөлөх нөлөөллийг тодорхойлох, санхүүгийн захын идэвхийг нэмэгдүүлэх зэргээр санхүүгийн захын хөгжлийг олон талаар дэмждэг. Гэвч Сангийн яамны шийдвэрийн дагуу 2017 оны 11 дүгээр сараас хойш ЗГҮЦ-ны анхдагч захын арилжаа нээлттэй зарлагдаагүй байна.

ЗГҮЦ-ны үлдэгдэл 2020 оны эцэст 22.8 тэрбум төгрөгөөр буурч, 22.5 тэрбум төгрөгт хүрсэн байна (Зураг 3.5). 2020 оны 10 дугаар сард 3 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны хугацаа дуусч, 2020 оны эцэст

зөвхөн 10 жилийн хугацаатай ЗГҮЦ-ны үлдэгдэлтэй байна.

Зураг 3.5. Монголбанкаар дамжин арилжаалагдсан ЗГҮЦ-ны үлдэгдэл (тэрбум төгрөг)

Эх сурвалж: Монголбанк

2019 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 77-р тогтоолоор батлагдсан "Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч, хоёрдогч зах зээлийн үйл ажиллагааны журам" хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэдий ч 2020 онд ЗГҮЦ-ны хоёрдогч зах дээр арилжаа хийгдээгүй байна. ЗГҮЦ шинээр гаргаагүй, зөвхөн өмнөх ЗГҮЦ төлөгдөж буй энэ нөхцөлд тухай бүр ТБҮЦ-ны эрэлт нэмэгдэж ирсэн бөгөөд ТБҮЦ-ны үлдэгдэл 2019 онд 4.8 их наяд, 2020 онд 8 их наяд болж өсөөд байна.

3.5 МОНГОЛБАНКНЫ ВАЛЮТЫН ЗАХЫН ОРОЛЦОО

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн суурь нөхцөлд нийцтэй, уян хатан тогтох зарчмыг баримтлан эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны зөрүүнээс үүсэх ханшийн огцом хэлбэлзлийг бууруулах зорилгоор валютын захад шаардлагатай үед тухай бүр оролцож ирлээ. Ковид-19 цар тахлын нөлөө, БНХАУ хилийн хоригоо чангатгаснаас улбаалж Монгол Улсаас экспортлож буй нүүрс болон бусад түүхий эдийн экспортын биет хэмжээ 2020 оны эхний хагаст буурч, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдэж байсан нь төгрөгийн ханш сулрах дарамтыг нэмэгдүүлж байв. Харин 2020 оны хоёрдугаар хагаст цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөтэй холбоотойгоор олон улсын санхүүгийн байгууллагуудын зээл, тусламж орж ирэхийн зэрэгцээ дэлхийн зах зээл дээрх нүүрс, зэс, төмрийн хүдэр зэрэг түүхий эдийн үнэ тогтвортой өсөлттэй байж, түүхэн дээд түвшинд хүрсэн нь төлбөрийн тэнцлийн алдагдал, төгрөгийн ханш сулрах дарамтыг харьцангуй бууруулаа.

Улмаар Монголбанк 2020 онд валютын захын оролцооны хэрэгсэлүүдээрээ дамжуулан цэвэр дүнгээр нийт 146.6 сая ам.долларыг валютын зах руу нийлүүлжээ.

Зураг 3.6. Монголбанкны валютын захын цэвэр оролцооны дүн 2012-2020 он /сая ам.доллар/

Эх сурвалж: Монголбанк

Монголбанкнаас дотоодын валютын захад оролцох хэрэгслүүдийн нэг гадаад валютын дуудлага худалдааг 2020 онд нийт 101 удаа зохион байгуулж, дуудлага худалдаа болон цахим талбараар дамжуулан цэвэр дүнгээр 2,503.1 сая ам.долларыг валютын захад нийлүүлэв. Энэ нь өмнөх онтой харьцуулахад ам.долларын арилжаа 10.1 хувиар буюу 280.0 сая ам.долларaар буурсан үзүүлэлт юм. Харин Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, ЗГХЭГ-ын дарга нарын 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 03/3/А-5 дугаар хамтарсан тушаалын дагуу төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдээс тайлант хугацаанд нийт 1,776.5 сая ам.долларыг худалдан авахын зэрэгцээ Төв банкны тухай хуулинд заасан Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн гүйцэтгэх үүргийн дагуу цэвэр дүнгээр 187.9 сая ам.доллартай тэнцэх гадаад зээл, бондын үндсэн ба хүүгийн төлбөрийг хийж гүйцэтгэжээ.

Зураг 3.7. Ам.доллар, юанийн дуудлага худалдаа /сая ам.доллар/

Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын цахим талбар

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлд заасны дагуу валютын дотоодын захын дэд бүтцийг хөгжүүлж, ил тод, үр ашигтай байдлыг хангах зорилгоор 2017 оны 4 дүгээр сард Блүүмберг терминалд суурилсан банк хоорондын валют арилжааны цахим талбар (БХВАЦТ) буюу “B-match” валют арилжааны системийг, 2018 оны 12 дугаар сард Монголбанкны дотоодын програм хангамжид суурилсан “Валют арилжааны систем”-ийг тус тус нэвтрүүлсэн. Уг систем нь банк хооронд

валют арилжаа хийх үйл явцыг хялбаршуулаад зогсохгүй мэдээллийн тэгш байдлыг бий болгосноор зах зээл дэх арилжааны спот ханш бүрэлдэх үйл явцыг тодорхой болгох, арилжаа хийхэд тулгарч буй харилцагчийн болон төлбөр тооцооны эрсдэлийг бууруулах өндөр ач холбогдолтой юм.Тайлант онд Монголбанкны дотоод ажлын төлөвлөгөөнд “Санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, програм хангамжийг сайжруулах, шинэчлэхэд хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх” хэмээн тусгасны дагуу Валютын богино хугацаат своп, форвард хэлцлийг цахим талбараар хийх цонхыг шинээр үүсгэж, амжилттай нэвтрүүлээд байна.

Зураг 3.8. БХВАЦТ-т хийгдсэн арилжаа /сая ам.доллар/

Эх сурвалж: Монголбанк

2020 онд арилжааны банкууд БХВАЦТ-аар дамжуулан 153.9 сая ам.долларын нийт 189 удаагийн арилжаа хийсэн бол Монголбанк цэвэр дүнгээр 877.9 сая ам.долларыг БХВАЦТ-аар дамжуулан валютын захад нийлүүлсэн байна.

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Монголбанк банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварт дэмжлэг үзүүлэх, ханшийн эрсдэл, спот захын дарамтыг бууруулах, дотоодын зах зээл дэх долларжилтыг бууруулах, бодит эдийн засгийг дэмжих зорилгоор банкуудтай богино хугацааны санхүүгийн үүсмэл хэрэгслийг 2010 оноос, урт хугацаат своп хэлцлийг 2014 оноос тус тус байгуулж эхэлсэн. Гадаад болон дотоод зах зээлийн нөхцөл байдал, банкуудын гадаад эх үүсвэрийн өртөг зэргийг харгалзаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 6 дугаар сарын 09-ний өдрийн А-196 дугаар тушаал, 9 дүгээр сарын 21-ний өдрийн А-379 дүгээр тушаалаар урт хугацаат своп хэлцлийн журамд нэмэлт өөрчлөлтийг оруулсан. Ингэснээр Ковид-19 цар тахлын үед бага хүүтэй, урт хугацаат эх үүсвэрээр бодит эдийн засгийг дэмжиж, дотоодын зах зээлд ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх боломжийг нэмэгдүүлэв.

Монголбанкнаас тайлант онд нийт 538.0 сая ам.долларын ам.долларын богино хугацаат своп хэлцлийг арилжааны банкуудтай байгуулан төлбөр тооцоог хийж гүйцэтгэжээ. Харин урт хугацаат своп хэлцлийн хүрээнд банкуудын гадаад зах зээлээс татсан нэг жилээс дээш хугацаатай гадаад валютын эх үүсвэрээр ам.долларын урт хугацаат своп хэлцэл байгуулж байгаа бөгөөд 2020 онд нийт 372.5 сая ам.долларын дүнтэй урт хугацаат своп хэлцлийг банкуудтай байгуулснаас бодит 120.0 сая, бодит бус 252.5 сая ам.долларын хэлцлийн төрөлд хамаарч байна. Нийт байгуулсан хэлцлийн дүн өмнөх оны мөн үеэс 44.4 хувиар буюу 297.7 сая ам.долларaар буурчээ. Мөн тайлант онд нийт 712.3 сая ам.долларын урт хугацаат своп хэлцлийн хугацаа дуусаж, төлбөр тооцоог гүйцэтгэсэн бөгөөд урт хугацаат своп хэлцлийн үлдэгдэл 339.8 сая ам.долларaар буурч, 1,657.8 сая ам.долларт хүрэв.

3.6 АЛТНЫ САНХҮҮЖИЛТ, ҮНЭТ МЕТАЛЛЫН ХУДАЛДАН АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, УИХ-ын 2020 оны 32 дугаар тогтоолыг үндэслэн Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх, Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор 2020 оны 6 дугаар сараас эхлэн алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд арилжааны банкаар дамжуулан хөнгөлөлттэй санхүүжилтийн эх үүсвэрийг олгож эхэлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монголбанкнаас 13 алт олборлогч аж ахуйн нэгжүүдэд урьдчилгаа төлбөрийн 52.85 тэрбум төгрөг, урт хугацаат санхүүжилтийн 71.24 тэрбум төгрөг, нийт 124.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг арилжааны 5 банкаар дамжуулан олгосон бөгөөд санхүүжилт авсан алт олборлогч аж ахуйн нэгжүүд нийт 1,247.99 кг үнэт металлыг Монголбанканд тушаасан.

Монголбанк үнэт металлын худалдан авалтыг өсгөх зорилгоор Дархан-Уул, Баянхонгор аймгуудад үнэт металлын сорьцын шинжилгээний лаборатори байгуулж алт олборлогч иргэд аж ахуй нэгжүүдэд олон улсын зах зээлийн ханшаар үнэт металлаа худалдах боломжийг бүрдүүлэн, сорьцын шинжилгээний үр дүнг цахимаар хүлээн авч, төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх зэрэг ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд Монголбанкны худалдан авсан үнэт металл 2020 онд 23.6 тоннд хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.3 тонноор өсч, гадаад валютын улсын нөөцийг 900 орчим сая ам.доллараар нэмэгдүүлсэн үзүүлэлттэй байна.

Монголбанк 2020 онд худалдан авсан 23.6 тн үнэт металлын 40 хувийг 117 иргэд, 60 хувийг 126 аж ахуй нэгжээс худалдан авсан бөгөөд 2019 онтой харьцуулбал үнэт металл худалдаалж буй иргэдийн тоо 25 хувиар буурч, аж ахуй нэгжийн тоо 12 хувиар өссөн байна.

Зураг 3.9. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (жилээр)

Эх сурвалж: Монголбанк

МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4

4.1 МОНГОЛБАНКНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Монголбанк нь 12 газар, 1 төв, 1 хүрээлэн, 3 бие даасан алба, орон нутаг дахь 5 хэлтэс, 12 салбар, 1 төлөөлөгчийн газартайгаар мөн Төв аппаратад 501, орон нутаг дахь хэлтэс, салбарт 120, нийт 621 батлагдсан орон тоотойгоор үндсэн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Монголбанк 2020 онд дэвшүүлсэн үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн чадавхи болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлээр багагүй ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Монголбанкны бүтэц, зохион байгуулалтын хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А-190 дүгээр тушаалаар Хяналт шалгалтын газрын бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрыг шинээр байгуулсан.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн А-27 дугаар тушаалаар Санхүүгийн мэдээллийн алба, 2020 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А-109 дүгээр тушаалаар Санхүү бүртгэлийн газар, 2020 оны 6 дугаар сарын 22-ны А-214 дүгээр тушаалаар Судалгаа, статистикийн газрын бүтэц, зохион байгуулалтад тус тус өөрчлөлт оруулж, бүтэц орон тоог шинэчлэн баталсан.

Хүний нөөцийн чадавхийг сайжруулах, удирдлагыг боловсронгуй болгож, өндөр мэдлэг чадвартай чадварлаг боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримталж, ажилтнуудаа тасралтгүй сурган хөгжүүлэх, тэдний ажиллах нөхцөл, цалин урамшуулал, нийгмийн асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Гадаад, дотоод албан томилолт, сургалтад нийт 100 гаруй ажилтан хамрагдсан.

Монголбанкны үйл ажиллагаа, төрөөс баримтлах мөнгөний бодлогыг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлэх орон нутаг дахь хэвлэл, мэдээлэл, мэргэжлийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудыг мэдээллээр хангах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 2020 оны 8 дугаар сард банкны салбарын удирдах ажилтны бүсийн зөвлөгөөнийг Завхан аймагт зохион байгуулж, орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсийн удирдлагууд болон мэргэжилтнүүдийн дотоод үйл ажиллагааны чиг үүргийн хүрээнд хэлэлцүүлэг уулзалт, сургалтыг зохион байгууллаа.. Зөвлөгөөний чанар, хамрах хүрээг өргөжүүлж, орон нутгийн засаг захиргаа, арилжааны банкны удирдлагууд болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудыг оролцуулсан уулзалт хэлэлцүүлгийг хийлээ.

Сүүлийн үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх замаар Монголбанкны ажилтнуудыг цахим орчинд үр ашигтай хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ажлын хэрэгцээнд цуглуулсан бүх төрлийн мэдээллийг цахим хэлбэрээр хадгалах, түгээх, ашиглах, түүнд үндэслэн шинжилгээ хийхэд чиглэсэн Мэдээллийн технологийн шинэчлэлийг үе шаттайгаар хийж байна. Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд ERP систем нэвтрүүлэх төслийн нэгжтэй хамтран ажиллаж байна. Монголбанкны үйл ажиллагааг илүү тодорхой болгох, шийдвэр гаргах хэлбэр, үйл явцыг ил тод болгох, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр ажиллаж байна.

4.2 ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монголбанкны гадаад харилцаа, хамтын ажиллагаанд гарсан онцлох үйл явдлууд:

Монголбанк Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)-ын Төв банк хооронд 2011 оны 8 дугаар сарын 14-ний өдөр байгуулсан “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн хүрээнд тус банкнаас хэрэгжүүлдэг “Мэдлэгийн түншлэлийн хөтөлбөр”-т Монголбанк дөрөв дөх жилдээ хамрагдаж, БНСУ-ын Төв банк, Сунг Кюун Кван Их сургуультай хамтран “Ханган нийлүүлэлтийн давтамжтай хомсдол, гадны шокуудын хүрээн дэх мөнгөний бодлогын стратеги” сэдвээр хамтарсан судалгааны ажил хийж, үр дүнг харилцан тайлагнах, эцсийн судалгаа, тайланг хэвлүүлэх ажлыг БНСУ-ын Төв банктай хамтран зохион байгуулж дууслаа.

Монголбанк мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоог сайжруулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх, харилцан үнэлгээний үр дүнг сайжруулах ажилд хамтын ажиллагааны зөвлөлийн гишүүн байгууллага, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк болон Ази, номхон далайн бүсийн байгууллага зэрэг олон улсын байгууллагуудтай идэвхтэй хамтран ажиллан дэмжлэг үзүүлж, газар дээрх хурлыг цар тахлын үед амжилттай зохион байгуулан Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтаас Монгол Улс амжилттай гарлаа.

Хоёр улсын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Монголбанк, Хятадын Ардын Банкны хооронд байгуулсан 15 тэрбум юань буюу 6 их наяд төгрөгийн үндэсний мөнгөн тэмдэгт солилцох своп хэлцлийн гэрээг 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр шинэчлэн байгуулж, своп хэлцлийг дахин 3 жилийн хугацаатайгаар 2023 он хүртэл Монголбанк амжилттай сунгалаа. Своп хэлцлийн ерөнхий гэрээг сунгах ажлын хүрээнд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс өгсөн зөвлөмжүүдийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллав. Тус гэрээг амжилттай сунгаснаар богино хугацааны гадаад өрийн дарамтыг эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр шийдвэрлэж чадлаа.

Монгол Улс Олон улсын валютын сантай хамтран “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийг 3 жилийн хугацаанд амжилттай хэрэгжүүлж, үргэлжлүүлэн Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг хохирол багатай даван туулах, төсөв болон төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар, Монголбанк хамтран Олон улсын валютын сангийн "Шуурхай санхүүжилтийн хөтөлбөр"-т хамрагдаж, 99 сая ам.долларын санхүүжилтийг авав. Тус хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад байрлах суурин төлөөлөгчийн газартай нягт уялдаа холбоотой ажиллаж, шаардлагатай хурал, уулзалтуудыг зохион байгуулж, хэрэгцээт мэдээллээр цаг тухайд нь ханган ажиллалаа.

Мөн хамтын ажиллагааны хүрээнд Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпорацийн дэмжлэгтэйгээр Монголбанканд шаардлагатай техник туслалцааг онлайн хэлбэрээр хэрэгжүүлж ирлээ.

Монголбанк 2020 онд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны судалгаа, сургалтын төвийн жилийн ээлжит болон удирдах зөвлөлийн хурлуудад онлайнаар тогтмол оролцож, тулгамдсан асуудлуудын талаар санал солилцлоо.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Төв банкнаас зохион байгуулсан 2020 оны Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын форумд онлайнаар Монголбанкнаас Евразийн эдийн засгийн хамтын ажиллагаа: Санхүүгийн үүрэг ба тулгамдсан асуудал хэлэлцүүлэгт илтгэл тавин оролцож, олон улсын хамтын ажиллагааны олон амжилт, Монголын банкны тогтолцооны онцлогоос хуваалцлаа. Тус форумд салбар бүрийн хувийн болон төрийн хэвшлийн төлөөлөгчид, бодлого боловсруулагчид оролцож бүсийн

эдийн засгийн хамтын ажиллагааны талаарх туршлага солилцож, цаашдын чиглэл дээр санал бодлоо хэлэлцсэн олон улсын форум боллоо.

Монголбанкны удирдлагууд Олон улсын валютын сангийн Ази Номхон далайн бүсийн газар, Японы Олон улсын Хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын Ази Номхон далайн орнуудын төв банк болон сангийн яамны удирдлагууд, эрдэмтэн судлаач нарыг хамруулсан хуралд оролцлоо. Тус хуралд "Тогтвортой хөгжлийн зорилтууд болон хүртээмжтэй өсөлтөд хүрэх нь" дэд сэдвээр хэлэлцүүлэгт оролцож, тулгамдсан асуудлууд, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр санал солилцов.

Монголбанк 2020 оны эхний улиралд Оросын Холбооны Улсын Төв банктай "Хамтын ажиллагааны гэрээ"-г эцэслэн байгуулж, хоёр орны Төв банкны ажилтнуудыг сургалтад хамруулж харилцан дадлага хийж, чадвараа нэмэгдүүлж, туршлага солилцох болон бүс нутгийн арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулж, оролцох боломжийг бүрдүүлээд байна.

Монголбанкны гадаад харилцааг өргөжүүлж, шинэ хамтын ажиллагааг эхлүүлэх зорилгоор Мэргэшсэн Санхүүгийн Шинжээч (CFA)- ийн цол олгодог Олон улсын мэргэшсэн санхүүгийн шинжээчдийн институттэй хамтран ажиллах боломжийг судалж, харилцаа тогтоосны үндсэн дээр Монголбанк ба Олон улсын мэргэшсэн санхүүгийн шинжээчдийн институтийн хооронд "Тэтгэлгийн гэрээ" байгуулсан бөгөөд 2021 оноос эхлэн Монголбанкны ажилтнууд тус мэргэжлийн цол олгох шалгалтад хөнгөлөлттэй үнээр хамрагдах боломжтой боллоо.

Зүүн өмнөд Азийн Төв банкуудын холбооны судалгаа, сургалтын төв, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Бундесбанк, Бүгд Найрамдах Польш Улсын Төв банк, Швейцарийн Холбооны Улсын Үндэсний Банкны Герзенсий дэх сургалтын төв, Бүгд Найрамдах Франц Улсын Төв банкны Олон улсын банк, санхүүгийн институт, Олон улсын төлбөр тооцооны банкны Санхүүгийн тогтвортой байдлын институт, Олон улсын валютын сангийн Сингапур Улс дахь сургалтын институт, Дэлхийн банкны Нөөцийн зөвлөгөө, удирдлагын түншлэл хөтөлбөр хийгээд бусад орны Төв банк, санхүүгийн байгууллагуудтай хамтран Ковид-19 цар тахлын үед хүний нөөцийн чадавхийг сайжруулах, хөгжүүлэх чиглэлээр нягт холбоотой ажиллаж, онлайн сургалтуудад Монголбанкны ажилтнуудыг тогтмол хамруулж ажиллав.

4.3 ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

Монголбанк бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар тайлбарлан таниулж, Төв банкны нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангах зарчмын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Инфляцын тайлангийн хүртээмжийг сайжруулах

Төв банкны олон нийттэй харилцах гол арга хэрэгслүүдийн нэг болсон инфляцын тайланг тайлбарлан түгээх ажлын хүрээнд 2019 оны 4-р улирлын болон 2020 оны 3, 4, 6, 9 дүгээр сарын инфляцын тайланг танилцуулах ажлыг нээлттэй сонсгол хэлбэрээр болон цар тахал дэгдсэнээс хойш цахим, видео хэлбэрээр тус тус зохион байгууллаа. Мөн тухай бүр "Хураангуй" хувилбарыг олон нийтэд ойлгомжтой, инфографик хэлбэрээр товчлон боловсруулж албан ёсны сошиал хаягуудаар түгээв.

Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг тайлбарлан, түгээх

Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 3, 4, 6, 8, 9, 11, 12 дугаар сарын хурлын шийдвэрийн мэдэгдлийг Монголбанкны цахим хуудсанд байршуулж, хэвлэлийн бага хурлаар танилцуулж, бодлогын хүүг нийт 5 нэгж хувиар бууруулсан, хүүгийн коридорыг нарийсгасан, төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээг бууруулсан, эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг сунгахаар болсон, банкуудын гадаад валютын нөөцийн урамшуулллыг хүү харгалзан харилцан адилгүй тооцож

эхэлсэн, урт хугацаатай репо санхүүжилтийн хэрэгслийг зах зээлд нэвтрүүлэхээр болсон бодлогын шийдвэрүүдийн үндэслэлийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд мэдээлэв. Мөн Мөнгөний бодлогын хорооноос гаргасан шийдвэр, түүний үндэслэлийг эдийн засагт оролцогч талууд буюу судлаач, шинжээчид, хөрөнгө оруулагчид, олон нийтэд тайлбарлахын тулд Монголбанкны албан ёсны веб хуудас, олон нийтийн цахим сүлжээ болон олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг ашиглан мэдээлэл тогтмол бэлтгэж ажиллав. Тэдгээрээс дурдвал, Bloomberg, Eagle телевизүүдээр тусгай нэвтрүүлэг бэлтгэн хүргэснээс гадна МБГ-ын удирдлагууд, Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүд сонин, сайт, телевизүүдэд тухай бүр тайлбар ярилцлага өгөв.

Хэвлэлийн бага хурал

Монголбанкны цаг үеийн асуудал, санхүү, банкны салбарын статистик үзүүлэлтийг мэдээлэх, тайлбарлах зорилгоор Хэвлэлийн бага хурлыг сар бүр зохион байгуулж байна. Ингэхдээ, мөнгөний бодлогын хорооны мэдэгдэл, Монголбанкны хэвлэлийн бага хурал болон цаг үеийн шуурхай хурлын үеэр Фейсбүүк орчинд шууд дамжуулалт хийж хэвшээд байна. Тайлант хугацаанд нийт 16 удаа хэвлэлийн бага хурлыг зохион байгуулснаас Мөнгөний бодлогын хорооны шийдвэрийг танилцуулах хурлыг 7 удаа зарлан танилцуулав. Төв банкны олон нийттэй харилцах харилцаа нь иргэдийн Төв банкинд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, улмаар зах зээл дээрх хүлээлтийг үр дүнтэй удирдахад эерэг нөлөө үзүүлэхийг зорьдог.

Эрдэм шинжилгээний бага хурал, олон нийттэй харилцах судалгаа

Монголбанкны нэрэмжит эрдэм шинжилгээний бага хурлыг цар тахлын нөхцөл байдлаас хамаарч зайнаас, цахимаар зохион байгуулсан нь халдвар хамгааллын дэглэмийг сахихын хамт оюутан, судлаачдын эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх судалгаа хийхийг дэмжсэн, оролцогчдын хүртээмжийг хангасан арга хэмжээ болсон. Түүнчлэн, Монголбанкнаас хийж байгаа судалгаа, мэдээллийн хүртээмжийг сайжруулах, Глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд гарч буй өөрчлөлтүүдийг мэдээлэх зорилгоор долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийг 3 сараас эхлэн, тайлант хугацаанд нийт 28 дугаарыг бэлтгэн хүргэв.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Монголбанкнаас шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлж ажилласан ба тэдгээртэй холбоотой мэдээ, мэдээллийг цахим сувгуудаар тухай бүр хүргэв. Мөн Монголбанкны веб хуудсанд “КОВИД-19: АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ” шинэ цэсийг нээлээ.

Монголбанкны мэдээлэл

“Монголбанкны мэдээлэл” товхимол бэлтгэж түгээх ажлын хүрээнд тайлант хугацаанд нийт 12 дугаар эрхлэн гаргаж, 9600 хувийг хэвлүүлэн, дугаар бүрийг МУЕТГ, УИХ, ЗГ, арилжааны банкууд, Монголбанкны газар нэгжүүд, орон нутаг дахь хэлтэс салбар, аймаг, сумын ЗДТГ, номын сан, сургуулиудад түгээж ажиллалаа.

Монголбанкны бодлого, үйл ажиллагааг тайлбарласан "Эдийн засаг энгийнээр" буланг ажиллуулж, нийтлэл мэдээлэл бэлтгэж, видео шторкуудыг хүргэв. Тухайлбал “Монголбанкны онцлох үйл явдлын товчоон”, “Тэтгэврийн зээлийн дүнг хэрхэн тооцох вэ”, “Өр, орлогын харьцаа”, “Шинэ 5000 төгрөгийн дэвсгэртийн нууцлал”, “Ханш хэрхэн тогтдог вэ?” гэх мэт сэдвүүдээр 12 видео шторк бэлтгэхээс гадна 26 нийтлэл, 42 инфографик бэлтгэн хүргэлээ. 2020 онд “Ятгах тусам нягтал”, “Нягтлах тусам аюулгүй”, “Хуримтлалын өдөр”, “Халаасанд бус хэтэвчинд, Овоонд бус хэрэглээнд” аянуудыг бусад байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран зохион байгуулж ажиллаа.

Монголбанкны сургагч оюутан-багш

Монголбанк, Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо хамтран иргэд, олон нийтэд чиглэсэн санхүүгийн залилан, луйвраас сэрэмжлүүлэх зорилго бүхий "Ятгах тусам нягтал", "Нягтлах тусам аюулгүй" цуврал аянуудыг 2019 оны 12-р сард эхлүүлсэн ба 2020 оны турш хэрэгжүүллээ. Оюутнуудад Монголбанкны бодлого, үйл ажиллагааг таниулж, мэдээлэл түгээх ажлын хүрээнд "Сургагч оюутан багш", "Монголбанкны мэдээллийн цаг" сургалт, уулзалтыг сар бүр тогтмол хийж хэвшээд байсан боловч Засгийн газар, Улсын онцгой комиссын шийдвэрээр бүх хурал, уулзалт, сургалтуудыг цуцалсан тул тайлант хугацаанд нийт 5 удаа зохион байгуулав. "Монголбанкны мэдээллийн цаг" арга хэмжээнд Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч нарыг урьж оролцуулснаар оюутнуудад Монголбанкны удирдлагуудын ажил, мэргэжлийн замнал болон Төв банкны бодлого шийдвэрийн талаарх сонирхолтой лекцүүдийг сонсох боломжийг олгосон өндөр ач холбогдолтой арга хэмжээ болов.

4.4 МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн мэдээллийн албанаас Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах Үндсэн чиглэлд тусгасан Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах хүрээнд дараах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Үндэсний эрсдэлийн үнэлгээ

ФАТФ-ын техник хэрэгжилтийн Зөвлөмж 1 болон үр дүнтэй байдлын Шууд хэрэгжилт 1-ийн шаардлагыг хэрэгжүүлэх хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх ажлыг Дэлхийн банкны техник туслалцаатайгаар гүйцэтгэхээр тохиролцсон. Үүнтэй холбогдуулан, Сангийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тушаалаар Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийх үндсэн ажлын хэсгийг байгуулсан. Мөн Сангийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 90 дүгээр тушаалаар банк, үнэт цаас, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид зэрэг салбар тус бүрийн хувьд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлэх 11 дэд ажлын хэсгийг байгуулав. Улмаар төрийн байгууллагууд болон холбогдох бүхий л салбарын хувийн хэвшлийн нийт 52 байгууллагын 128 төлөөлөгчөөс бүрдсэн том баг Дэлхийн банкны аргачлалд үндэслэн дараах бүдүүвч зурагт үзүүлсний дагуу Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна.

Зураг 4.1 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний бүдүүвч зураг

Эх сурвалж: Монголбанк, СМА

Санхүүгийн мэдээллийн албаны зүгээс долоо хоног бүр ажлын явцыг хэлэлцэх, цаашид хийгдэх ажлуудыг тодорхойлох уулзалтуудыг зохион байгуулсан. Эдгээр уулзалтуудын үр дүнд 2020 оны 3 дугаар улирлын байдлаар салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээг хийх хэлэлцүүлгүүдийг зохион байгуулав. Улмаар салбар тус бүрийн эрсдэлийн үнэлгээний үр дүн, дүгнэлтүүдийг урьдчилсан байдлаар боловсруулсан бөгөөд ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтад бэлтгэх зорилгоор нэгдсэн хэлэлцүүлгийг Санхүүгийн мэдээллийн албанаас бүх ажлын хэсгийн гишүүн байгууллагуудтай хамтран 2020 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулав.

Үүнээс гадна, Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайланг эцэслэн боловсруулах ажлын хүрээнд Санхүүгийн мэдээллийн албанаас холбогдох байгууллагуудтай хамтран 2020 оны 10 дугаар сарын 26-30-ны өдрүүдэд нийт 5 өдөр 11 дэд ажлын хэсэг тус бүрийн хийсэн үнэлгээний талаарх хэлэлцүүлгийг Хууль зүй, дотоод хэргийн яам болон Авлигатай тэмцэх газар дээр амжилттай зохион байгуулав. Тус хэлэлцүүлэгт холбогдох яам, төрийн байгууллага, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллага, судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоод болон хувийн хэвшлийн нийт 250 гаруй төлөөлөл оролцон нийт 11 дэд ажлын хэсгийн боловсруулсан тайланг хэлэлцэн, санал дэвшүүлж, сайжруулах талаар үзэл бодлоо илэрхийллээ.

Дэд ажлын хэсгүүд дээрх хэлэлцүүлгийн үеэр дэвшүүлсэн оновчтой санал, зөвлөмжүүдийг өөрсдийн тайландаа тусган боловсруулж байгаа бөгөөд Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлангийн төслийг Дэлхийн банкны санал, зөвлөмжид үндэслэн холбогдох сайжруулалтуудыг хийж эцэслэхээр ажиллаж байна.

Үндэсний эрсдэлийн үнэлгээний ач холбогдол нь Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох эрсдэлийг үнэлж, тодорхойлох юм. Үүний дагуу, зохицуулах байгууллагууд эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэглэж, эрсдэлийн түвшинг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд ФАТФ-ын Зөвлөмжийн техник хэрэгжилт болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлнэ. Үндэсний эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн Монгол Улсын дунд хугацаанд хэрэгжүүлэх Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийг боловсруулж, батлуулахаар төлөвлөж байна. Энэхүү Үндэсний хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг бууруулах, ФАТФ-ын техникийн хэрэгжилт болон үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг дэлгэрэнгүй тусгах бөгөөд Монголбанк, Санхүүгийн мэдээллийн алба, Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд хамтран хэрэгжүүлж ажиллах болно.

Зураг 4.2. Үндэсний эрсдэлийн үнэлгээний ач холбогдол

Эх сурвалж: Монголбанк, СМА.

Дотоод хамтын ажиллагаа

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь маш өргөн хүрээний, үндэсний хэмжээний асуудал тул холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа хамгийн чухал үүрэгтэй юм. Санхүүгийн мэдээллийн алба нь төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагаа, мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны гадаад, дотоод харилцаа, хамтын ажиллагааг хариуцдаг. Одоогоор Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албаны дэргэд төрийн 20 гаруй байгууллагын оролцоотой Хамтын ажиллагааны зөвлөл болон Үндэсний зөвлөл ажиллаж байна. Энэхүү 2 зөвлөлд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Хууль, зүй дотоод хэргийн яам, Сангийн яам, Гадаад харилцааны яам, хууль сахиулах байгууллагууд болон бусад холбогдох төрийн байгууллагуудын төлөөллүүд багтдаг.

Санхүүгийн мэдээллийн албанаас 2020 онд Үндэсний зөвлөлийн хурлыг 2 удаа, Хамтын ажиллагааны зөвлөлийн хурлыг нийт 5 удаа зохион байгуулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Тухайлбал, Монгол Улсыг ФАТФ-ын стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалтаас гаргах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, ФАТФ-ын техник хэрэгжилтийн 40 Зөвлөмжийн үнэлгээг ахиулах чиглэлээр хийх шаардлагатай ажлууд, Үндэсний эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэх ажлын явц, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох, мөн зөвлөлийн гишүүн байгууллагуудын хоорондох мэдээлэл солилцоог нэмэгдүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах болон бусад холбогдох асуудлуудыг хэлэлцсэн. Санхүүгийн мэдээллийн албанаас хурлаас гарсан шийдвэрүүдийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллав.

Үүнээс гадна Санхүүгийн мэдээллийн алба нь дотоодын эрх бүхий байгууллагуудтай ажлын уялдаа холбоо, хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх үүднээс холбогдох албан тушаалтнуудыг хамруулсан хурал, уулзалтуудыг тогтмол зохион байгуулсан. Тухайлбал, Монгол Улсын Ахицын тайлан, Явцын тайлан, бусад тайлан, судалгаа, асуулгыг холбогдох олон улсын байгууллагуудад хүргүүлэх ажлын хүрээнд хурал, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж ажилласан.

Хяналт шалгалт

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдөр оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд Санхүүгийн зохицуулах хороо болон мэргэжлийн холбоод болох Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, Монголын Хуульчдын холбоо, Монголын Нотариатчдын танхимаас хяналт тавихаар болсон. Үүнтэй холбогдуулан, Санхүүгийн мэдээллийн албанаас нотариатч, хуульч болон нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд хяналт тавих хүрээнд 2020 онд мэргэжлийн холбоодтой хамтран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Энэ хүрээнд мэргэжлийн холбоодыг Олон улсын валютын сангийн техник туслалцааны хүрээнд боловсруулсан зайны хяналтын асуулга болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг ашиглан санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд үнэлгээ хийж, өндөр эрсдэлтэй гарсан этгээдэд газар дээрх хяналт шалгалт хийх, улмаар хяналт шалгалтын үр дүнд үндэслэн зайны хяналтын асуулга болон эрсдэлийн үнэлгээний аргачлалыг шинэчлэхэд Санхүүгийн мэдээллийн албанаас туслалцаа үзүүлж хамтран ажиллав. Мөн соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүрээнд санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулан эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх гарын авлага болон тайлан бөглөх заавар зөвлөмжийг боловсруулж, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргийг биелүүлж ажиллах талаар сургалт, уулзалтуудыг зохион байгуулсан. Дараах хүснэгтэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр нийт мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт болон авсан арга хэмжээний талаар харуулав (Хүснэгт 4.1).

Хүснэгт 4.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн хяналт шалгалтын үйл ажиллагаа

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Банканд хийсэн хяналт шалгалт	2	14	24	19
Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хийсэн хяналт шалгалт	139	1025	269	146
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд тавигдсан актын тоо	29	4	-	1
Банк болон банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд өгсөн хугацаат үүрэг даалгавар	367	272	245	444

Эх сурвалж: Монголбанк, СМА.

IV. Соён гэгээрүүлэх үйл ажиллагаа

Санхүүгийн мэдээллийн албанаас 2020 онд мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд зориулан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлийн соён гэгээрүүлэх, мэдлэгийг дээшлүүлэх бичиг

баримтуудыг боловсруулж, олон нийтэд түгээсэн байна. Тухайлбал:

- Банкуудад зориулан 2019 оны Стратегийн дүн шинжилгээний тайланг боловсруулж, хүргүүлсэн;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, хуульч болон нотариатчдад зориулан гарын авлагыг боловсруулсан;
- Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд зориулсан Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлэх тайлан бөглөх заавар, зөвлөмжийг боловсруулсан;
- Олон нийтэд зориулсан "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь" гарын авлагыг боловсруулж, Монголбанкны сайт дээр нийтлүүлсэн;
- "Нотариатын салбар дахь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн дохио" заавар, зөвлөмжийг боловсруулан Монголын Нотариатчдын танхимд хүргүүлсэн;
- Улс төрд нөлөө бүхий этгээдийг тогтоох талаар мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан гарын авлага;
- Эцсийн өмчлөгчийг тодорхойлох тухай гарын авлагыг боловсруулан Улсын бүртгэлийн ерөнхий газарт албан бичгээр хүргүүлсэн;
- Санхүүгийн мэдээллийн албаны fiu.mongolbank.mn цахим хуудсыг хөтөлж эхэлсэн;
- Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр бүхий л мэдээллийг агуулсан нэгдсэн мэдээллийн порталыг бий болгох ажлыг эхлүүлж, www.amlcft.mn мэдээллийн цахим хуудсыг ажиллуулж эхлэв;
- ФАТФ-ын 40 Зөвлөмж болон үнэлгээ хийх аргачлалыг Монгол хэл рүү орчуулж, ФАТФ болон Монголбанкны цахим хуудсанд байршуулав.

Энэхүү гарын авлага, заавар зөвлөмжүүдийг Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудас fiu.mongolbank.mn дээр байршуулсан байна.

V. Мэдээлэл цуглуулах

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан мэдээлэх үүрэгтэй этгээдээс 20 сая төгрөг, түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон сэжигтэй гүйлгээний тайланг хүлээн авдаг. Мөн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын хилээр бэлнээр нэвтрүүлсэн 15 саяас дээш төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют, санхүүгийн хэрэгсэл, цахим мөнгийг мэдүүлсэн бэлэн мөнгөний мэдүүлгийг гаалийн байгууллагаас авч ажиллаж байна (Хүснэгт 4.2).

Хүснэгт 4.2 Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн тайлангийн тоо

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
Бэлэн мөнгөний гүйлгээний тайлангийн тоо	572,181	669,910	562,926	402,496
Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо	203	1,596	2,385	3,014
Гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоо	98,549	126,944	131,715	143,191

Эх сурвалж: Монголбанк, СМА

2020 онд нийтдээ 3,014 сэжигтэй гүйлгээний тайлан хүлээн авсан нь 2019 онтой харьцуулахад 20 хувиар, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлангийн тоо 8 хувиар тус тус өссөн байна. Сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо сүүлийн дөрвөн жил дараалан өсч байгаа нь Санхүүгийн мэдээллийн албанаас сэжигтэй гүйлгээний тайлан бөглөх, илрүүлэх гарын авлага гаргасан, мэдээлэх үүрэгтэй этгээдтэй тогтмол

уулзалт хийж сэжигтэй гүйлгээ илрүүлэх, мэдээлэх үүргийг тайлбарлаж байгаатай холбоотой гэж үзэж байна. Мөн мэдээлэх үүрэгтэй этгээдүүд сэжигтэй гүйлгээг таних, илрүүлэх үйл ажиллагаагаа жил бүр улам сайжруулж анхаарал хандуулж байгаатай холбоотой. Харин гаалийн мэдүүлгийн тоо өмнөх онтой харьцуулахад 2 дахин буурсан байгаа нь дэлхий нийтэд тархаад байгаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас болж улсын хилийг хааснаар зорчих хөдөлгөөн багассантай холбоотой юм.

Зураг 4.3. Гаалийн мэдүүлгийн тайлангийн тоо

Эх сурвалж: Монголбанк, СМА

VI. Мэдээлэлд дүн шинжилгээ хийх

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-т заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн, түүнчлэн эрх бүхий төрийн болон гадаад улсын ижил төстэй байгууллагын мэдээллийн санд байгаа мэдээллийг хүлээн авах, цуглуулах, түүнд дүн шинжилгээ хийх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг. Энэ хүрээнд 2020 онд дараах байдлаар сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийсэн болно (Зураг 4.4).

Зураг 4.4 Хүлээн авсан сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо болон дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тайлангийн тоо

Эх сурвалж: Монголбанк, СМА

Дүн шинжилгээ хийсэн сэжигтэй гүйлгээний тайланд 2020 онд Санхүүгийн мэдээллийн албанаас онцгой ач холбогдол өгч ажиллаа. Шинжээчдийн ур чадварыг сайжруулах, техник цаг хугацаа их зарцуулдаг ажлуудыг хялбаршуулснаар сэжигтэй гүйлгээний тайланд дүн шинжилгээ хийх хугацаа багассан.

Түүнчлэн, Санхүүгийн мэдээллийн алба нь нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд олон улсын стандарт болон хууль, журамд заасны дагуу стратегийн дүн шинжилгээ хийдэг. Тайлант хугацаанд хууль сахиулах байгууллагууд, прокурор, шүүхийн байгууллагуудаас мэдээлэл цуглуулж Санхүүгийн мэдээллийн албаны 2019 оны Стратегийн дүн шинжилгээний тайланг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлж танилцуулсан. Мөн олон улсын байгууллагаас гаргасан мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох баримт бичиг, тайлан мэдээлэлд судалгаа хийж өөрийн улсад гарч болох сэжигтэй гүйлгээний жишээ типологийн тайланг гаргасан.

VII. Мэдээлэл солилцох

VII.а Дотоодын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, хамтран ажиллах

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д зааснаар Санхүүгийн мэдээллийн алба нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр эрх бүхий байгууллагатай хамтран ажиллаж, мэдээлэл солилцон, гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлж ажилладаг. Энэ хүрээнд дараах байдлаар мэдээлэл солилцон ажиллалаа (Зураг 4.5).

Зураг 4.5. Санхүүгийн мэдээллийн албаны дотоодын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсон байдал

Эх сурвалж: Монголбанк, СМА

Мэдээлэл авах зорилгоор дотоодын хууль сахиулах байгууллагуудаас Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлтийн тоо болон хүсэлтийн дагуу явуулсан хариуны статистик мэдээг гаргахдаа хүсэлтэд дурдаж байгаа этгээдийн тоогоор гаргадаг бөгөөд тухайн онд ирүүлсэн хүсэлтийн тоо болон явуулсан хариуны зөрүүг 2021 оны эхний улиралд гүйцэтгэв.

VII.б Гадаадын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох

Санхүүгийн мэдээллийн алба нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Зөвлөмж 29-д заасны дагуу Эгмонт бүлгээс баталсан “Санхүүгийн мэдээллийн алба хоорондын мэдээлэл солилцох үндсэн зарчим”-ын хүрээнд Эгмонт бүлгийн гишүүн орнуудын Санхүүгийн мэдээллийн албуудтай болон хамтын ажиллагааны

санамж бичиг байгуулсан гадаад улсын эрх бүхий байгууллагуудтай мэдээлэл солилцон хамтран ажилладаг. Энэ хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба нь сүүлийн жилүүдэд дараах байдлаар мэдээлэл солилцон, хамтран ажиллав (Хүснэгт 4.3).

Хүснэгт 4.3. Санхүүгийн мэдээллийн албаны гадаадын эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцсон байдал

Үзүүлэлт /этгээдийн тоогоор/	2017	2018	2019	2020
СМА-наас гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн тоо	393	231	238	353
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудад явуулсан хүсэлтийн дагуу ирүүлсэн хариуны тоо	316	193	202	268
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-нд ирүүлсэн хүсэлтийн тоо	167	126	133	123
Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудаас мэдээлэл авах чиглэлээр СМА-нд ирүүлсэн хүсэлтийн дагуу явуулсан хариуны тоо	151	126	144	112

Эх сурвалж: Монголбанк, СМА

Гадаадын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллага буюу гадаадын Санхүүгийн мэдээллийн албадуудаас мэдээлэл авах чиглэлээр Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлсэн хүсэлтийн тоо болон явуулсан хариуны тоо зөрж байгаа нь VII.а хэсэгт дурдсан шалтгаантай адил болно.

VIII. Мэдээллийн систем, програм хангамж

Санхүүгийн мэдээллийн алба нь 2020 оны 02 дугаар сараас goAML программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлж, программын мэдээлэл хүлээн авах схем болон утгуудыг Монголын хууль эрх зүйн орчин, мэдээллийн төрөлд нийцүүлэн тохируулах, схемийн танилцуулга, заавар болон дагалдах бусад баримт бичгийг боловсруулан банкуудад хүргүүлээд байна.

2020 оны 4 дүгээр сард goAML програмыг нэвтрүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, сервер болон програмын лицензийг бүрэн худалдан авсан бөгөөд 2020 оны 7, 8 дугаар сард Монголбанкны Мэдээллийн технологийн газар болон Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд хамтран худалдан авсан серверүүд дээр суурилуулалтыг хийж гүйцэтгэсэн болно.

Эдгээр ажлуудыг хийж гүйцэтгэсний дараа НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын ажилтнуудтай 2020 оны 8 дугаар сард цахимаар холбогдож, суурилуулсан систем болон мэдээллийн технологийн бүтцийг шалгуулан туршилт хийсэн бөгөөд алдаа тус бүрийг засаж залруулан goAML программын туршилтыг хийхэд бэлэн болсныг баталгаажуулсан. 2020 оны 9 дүгээр сар, 10 дугаар саруудад goAML вэб болон клиент програм дээр мэдээлэл солилцох болон бусад дотоод үйл ажиллагааны туршилт хийж, гарсан асуудал, алдаануудыг НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын тусламжтайгаар засаж, залруулж ажиллав.

Зураг 4.6. goAML программ хангамжийн үйлдлүүд

Эх сурвалж: Монголбанк, СМА

2020 оны 11 дүгээр сард goAML вэб аппликейшн дээр бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, гадаад төлбөр тооцооны гүйлгээний тайлан болон сэжигтэй гүйлгээний тайлан оруулах туршилтын ажлыг хийсэн бөгөөд goAML программын мэдээлэл хүлээн авах схемийг эцэслэн тодорхойлж банкуудад 2020 оны 12 дугаар сард хүргүүлж 2021 онд програмыг бүрэн нэвтрүүлэхээр ажиллаж байна.

IX. Чадавхыг бэхжүүлэх, нөөц бололцоог сайжруулах

Санхүүгийн мэдээллийн алба нь АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хөтөлбөртэй шинжээчдийн чадавхыг бэхжүүлэх, сүүлийн үеийн чиг хандлагын талаар мэдлэг боловсролоо дээшлүүлэх талаар үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна. Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд гадаад, дотоод хамтын ажиллагааны хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр мэргэжлийн сургалт, семинарт байнга хамрагдахаас гадна гадагшаа чиглэсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тухай соён гэгээрүүлэх ажлуудыг ч цаг алдалгүй зохион байгуулав (Зураг 4.7).

Зураг 4.7. Санхүүгийн мэдээллийн албанаас зохион байгуулсан болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинар болон оролцогчдын тоо

Үзүүлэлт	2017	2018	2019	2020
СМА-наас зохион байгуулсан сургалт, семинарын тоо	8	1	7	4
СМА-наас зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо	205	40	444	136
Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарын тоо	4	13	21	20
Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт, семинарт оролцогчдын тоо	205	543	1081	886

Эх сурвалж: Монголбанк, СМА

Эдгээр мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр зохион байгуулсан сургалт, семинараас онцлон дурдвал:

- Хамтын ажиллагааны зөвлөлийн Судалгаа, шинжилгээний ажлын хэсгийн танилцуулга уулзалтаар банкуудын комплаенсийн нэгжийн ажилтнуудад сэжигтэй гүйлгээний талаарх танилцуулга;
- Санхүүгийн мэдээллийн албанаас банк бус санхүүгийн байгууллагын ажилтнуудад “Сэжигтэй гүйлгээг хэрхэн тайлагнах вэ?” сэдэвт сургалт;
- АНУ-ын Сангийн яамтай хамтран санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нарт хяналт шалгалт хийх үүрэгтэй байгууллагуудын хянан шалгагч нарт зориулсан ахисан шатны сургалт;
- Нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нарт зориулсан мэдээлэх үүргийг таниулах чиглэлээрх сургалт;
- Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчдэд сэжигтэй гүйлгээг мэдээлэх тухай сургалт;
- Хил, гаалийн ажилтнуудад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хил, гаалийн байгууллагын оролцооны талаарх сургалт;
- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийг бүртгэхэд анхаарах асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын ажилтнуудад сургалт;
- ФАТФ-ын газар дээрх хяналт шалгалтын тухай холбогдох байгууллагынханд сургалтуудыг тус тус зохион байгуулав.

Түүнчлэн, Санхүүгийн мэдээллийн албаны ажилтнууд өөрсдийн чадавхыг бэхжүүлэх, мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгоор оролцож байсан сургалт, семинараас онцлон дурдвал:

- Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зөвлөхүүдийн "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ"-г хийхтэй холбоотой сургалтууд;
- Татварын ерөнхий газраас "Татварын хяналт шалгалтын тухай" сэдэвт сургалт;
- АНУ-ын Сангийн яамны техник туслалцааны хүрээнд Санхүүгийн мэдээллийн албаны нийт ажилтнуудад зориулсан аюулгүй байдал, нууцлал хамгааллын тухай сургалт;
- Эгмонт бүлгийн Мэдээлэл солилцох ажлын хэсгээс 2020-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний тухай семинар;
- Эгмонт бүлгээс зохион байгуулсан "Виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эмзэг байдал, тус салбарын ФАТФ-ын стандартын нөлөөг шинэчлэн өөрчлөх", "Ковид-19 цар тахлын үеийн дэлхийн улс орнуудын Санхүүгийн мэдээллийн албануудын шилдэг туршлага" болон "Зэрлэг ан амьтадтай холбоотой санхүүгийн гэмт хэргийн тухай" сэдэвт сургалт;
- Улсын ерөнхий прокурорын газраас Санхүүгийн мэдээллийн албаны нийт ажилтнуудад "Зөрчлийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ" сэдвээр сургалт;
- Дэлхийн банкны зөвлөхийн танилцуулсан "Крипто хөрөнгө ба олон улсын хууль эрх зүйн орчны талаар", "Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн төсөлд санал, зөвлөмж өгөх" сэдэвт сургалт;
- НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас goAML програмын талаарх сургалт;
- Олон улсын комплаенсийн холбоо, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас "Харилцагчийг таньж мэдэх нь", "Худалдаанд суурилсан мөнгө угаах гэмт хэрэг" сэдвээр семинар;
- Базелийн хорооны цахим сургалтууд гэх мэт сургалт, семинарт тус тус хамрагдсан байна.

4.5 ДОТООД АУДИТ

Дотоод аудитын газар нь Монголбанкны бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд газар дээрх аудит, шалгалт хийх зайны болон дараалсан хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангах, аудит, хяналт шалгалтын үр дүнгээр шийдвэр гаргуулж, биелэлтийг хангаж ажиллах замаар байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн батлсан аудитын төлөвлөгөө, удирдамжийн дагуу 16 нэгжийн үйл ажиллагаанд иж бүрэн, 9 нэгжийн үйл ажиллагаанд хэсэгчилсэн аудит хийж, үр дүнг удирдлагад танилцуулан Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг батлуулж, биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

Монголбанкны санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулах ажлыг удирдан зохион байгуулж, санхүүгийн тайланг баталгаажуулсан дүгнэлтэд тусгагдсан зөвлөмжүүд болон Монголбанкны Хяналтын зөвлөлийн тогтоолоор өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг холбогдох нэгжүүдээс гаргуулан удирдлагад танилцуулж, тогтмол хяналт тавин ажиллалаа.

Дэлхийн банкнаас Монгол Улсад хэрэгжүүлж буй "Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд дотоод аудитын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан аудит хийх аргачлалыг нэвтрүүлэх зорилготой зөвлөх үйлчилгээнд хамрагдаж олон улсын зөвлөхөөр хөндлөнгийн чанарын үнэлгээ хийлгэсэн. Тус үнэлгээнд үндэслэн боловсруулсан "Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын

хөтөлбөрийн”-ийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны төлөвлөгөөг (2020-2023) баталж, төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу хянан шалгагч нарын чадавхийг бэхжүүлэх, эрсдэлд суурилсан аудит хийх аргачлалыг нэвтрүүлэхэд шаардлагатай мэдлэгийг олгох зорилгоор аудитын менежерийн арга хэрэгслүүд, зөвлөх үйлчилгээ, эрсдэлийн үнэлгээг хэрхэн хийх талаар болон бусад сургалтанд ажилтнууд хамрагдсан болно.

Түүнчлэн, дотоод аудитын үйл ажиллагаатай холбоотой олон улсын нэр томьёог орчуулж, дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын талаар нэгдсэн нэр томьёог ашиглаж, журам заавартаа тусгах ажлыг эхлүүлж, эрсдэлд суурилсан аудитын удирдамжийг төлөвлөх заавар, удирдамжийн төсөл болон аудитын хамрах хүрээ, зорилгыг тодорхойлохдоо нэгжүүдийн удирдлагаас авах асуулгын загварыг боловсруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Монголбанкны дотоод аудитын үйл ажиллагааг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах чиглэлээр Дэлхийн банкны зөвлөхтэй үргэлжлүүлэн хамтран ажиллаж байна.

4.6 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Монголбанк гадаад валютын улсын нөөцийн удирдлага, мөнгөний бодлогын үйл ажиллагаа, болон Төв банкны зээл, санхүүжилтийн үйл ажиллагаанд учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад валютын улсын нөөцийн дунд болон богино хугацаанд баримтлах хөрөнгө оруулалтын бүтэц, бенчмарк, лимитийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлд нь хяналт тавих, тайлагнах, төв банкны зээл, санхүүжилтийн барьцаа хөрөнгийн шалгуурыг тодорхойлох, хөрөнгийн жагсаалтыг боловсруулах, хөрөнгийн үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах, эрсдэлийг хямдруулалтын хувийг тогтоох, гүйцэтгэлд нь хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа. Түүнчлэн үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд төв банканд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэх, хяналт тавих, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж, үүсэх эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахаар удирдан ажиллав.

Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд гадаад валютын улсын нөөцийг хөрөнгө оруулалтын төрлөөр, харилцагч банк, санхүүгийн байгууллагаар, зээлжих зэрэглэл болон улс орноор тус тус хадгаламжийн лимит тогтоож ажилласан бөгөөд Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээлд тодорхойгүй байдал өндөр байсан тул учирч болзошгүй зээлийн эрсдэлээс сэргийлэх үүднээс нөөцийг хөгжингүй орнуудын төв банкууд, засгийн газрын баталгаатай байгууллага, олон улсын санхүүгийн байгууллагуудад түлхүү байршуулсан. Түүнчлэн зээлийн эрсдэлийг хязгаарлах зорилгоор гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулах хадгаламжийн дээд хэмжээг багцын оновчлолын аргаар тодорхойлж, стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийг баталж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллалаа.

Тайлант хугацаанд бусад төв банк, олон улсын санхүүгийн байгууллагын тухайн нэг харилцагч банк, санхүүгийн байгууллагад олгох лимитийг тогтоохдоо ашигладаг зээлийн эрсдэлийн загвар, практикийг судалж, үйл ажиллагаандаа нэвтрүүлж, зээлийн эрсдэлийн загварыг сайжруулах ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөөд байна. Мөн гадаадын харилцагч банк, санхүүгийн байгууллагуудыг үнэлэх, шинжилгээ хийх аргачлалыг судалж, дотоод үйл ажиллагаанд нэвтрүүлэн ажиллалаа.

Дотоод захын санхүүгийн эрсдэлийн удирдлагын хувьд Монголбанк санхүүгийн тайлагналын олон улсын 9 дүгээр стандартын дагуу санхүүгийн хөрөнгөөс хүлээж болзошгүй алдагдлыг урьдчилан тооцоолж, түүнд үндэслэн болзошгүй эрсдэлийн нөөц санг байгуулж, бодит эрсдэл учирсан тохиолдолд эрсдэлийг зохистой удирдах боломжийг бий болгон ажиллав. Тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор Монголбанк бодлогын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд төв банкны барьцаа хөрөнгийн төрлийг нэмэгдүүлж, тэдгээр хөрөнгийн эрсдэлийн хямдруулалтын хувь хэмжээг тогтоох, барьцаа хөрөнгийн үнэ цэнийг тооцох аргачлалыг боловсруулах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Монголбанкны барьцаа хөрөнгийн жагсаалтыг өргөжүүлэх, санхүүгийн хөрөнгийн дахин үнэлгээг хийх аргачлалыг улам бүр сайжруулах зорилгоор судалгаа шинжилгээг тогтмол хийж, бусад орны төв банкуудын туршлагыг судалж үр дүнг тооцоололд тусган ажиллав. Мөн банк хоорондын валютын арилжааны системд оролцогчдын арилжааны өдрийн лимитийг тооцож, валютын арилжааны системийн үндсэн дилерийг улирал тутам сонгох, хэрэгжилтэд нь хяналт тавих ажлыг хийж гүйцэтгэлээ.

Зах зээлийн эрсдэл

Гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын гадаад зээлийн төлбөр, импортын бүтэц, банкуудын гадаад гүйлгээний гадагшлах урсгал болон дотоодын валютын захын бүтцэд үндэслэн ханшийн эрсдэлийг хамгийн бага байлгахад шаардлагатай валютын төрөл, хэмжээг тодорхойлж, стратегийн хөрөнгө оруулалтын бүтцэд тусган нөөцийн удирдлагыг хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллав. Үүний зэрэгцээ зах зээл дэх хүүний өөрчлөлтөөс шалтгаалж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн үнэ цэнэ буурах эрсдэлийг хамгийн бага байлгах үүднээс нөөцийн дэд багц тус бүрийн хувьд үргэлжлэх хугацаа болон түүний хазайлтын оновчтой хэмжээг тогтоох замаар хүүний хэлбэлзлээс үүсч болзошгүй эрсдэлийг удирдан ажиллалаа.

Ковид-19 цар тахлын дэлхийн эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллийн улмаас голлох валютуудын ханш болон үнэт цаасны хүүний муруйнууд өөрчлөлт ихтэй байснаас үүдэн зах зээлийн эрсдэлийг илүү нарийвчлалтайгаар тооцох хэрэгцээ шаардлага өндөр байсан тул гадаад валютын нөөцийн зах зээлийн эрсдэлийн хэмжүүрүүдийг тооцоололд ашиглах програм хангамжийг сайжруулан, үйл ажиллагаандаа өдөр тутам ашиглаж эхэлсэн.

Мөн дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд “Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-т заасны дагуу санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, үүсч болзошгүй зах зээлийн эрсдэлийг тухай бүр тайлан тэнцэлд тусган ажиллалаа. Үүний зэрэгцээ валютын ханшийн эрсдэлээс хамгаалах, гадаад валютын урсгалыг нэмэгдүүлэх, зээлийн хүү, гадаад валютын зээлийн өсөлтийг бууруулах зорилгоор банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийг долоо хоног тутам дахин үнэлж холбогдох тооцооллыг хийж, эрсдэлийн үнэлгээг тухай бүр санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж байна.

Хөрвөх чадварын эрсдэл

Гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд хөрвөх чадварыг хангах зорилгоор нөөцийн багцыг богино хугацаат болон хөрөнгө оруулалтын багцад хуваан удирдав. Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, санхүүгийн зах зээлийн тодорхойгүй байдал их үед богино хугацаат багцыг олон улсын байгууллага болон төв банкуудад түлхүү байршуулав. Нөөцийн хүрэлцээт байдлыг тодорхойлох зорилгоор ОУВС болон бусад төв банкуудын түгээмэл ашигладаг аргачлалуудын дагуу богино хугацаат хөрвөх чадвар өндөртэй багцын оновчтой хувь хэмжээг Монгол улсын нийт богино болон урт хугацаат гадаад өр төлбөрийн хэмжээ, экспорт болон импортын төсөөлөл зэрэг макро үзүүлэлтүүд дээр үндэслэн тодорхойлсон. Түүнчлэн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор нөөцийг харилцах, богино хугацаат хадгаламж, гадаадын засгийн газрын богино хугацаат үнэт цаас зэрэг хөрвөх чадвар өндөртэй хэрэгслүүдэд байршуулж удирдлаа.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын хяналт, тайлагнал

Гадаад валютын улсын нөөцийн хөрөнгө оруулалтын хэрэгслийн зах зээлийн үнэлгээ, эрсдэл болон үр өгөөжийн тооцооллыг өдөр тутам гүйцэтгэж, тогтоосон бүтэц, лимитийн гүйцэтгэлийг тооцон, удирдлагад тайлагнав. Түүнчлэн гадаадын харилцагч банк санхүүгийн байгууллагуудын санхүүгийн үзүүлэлт, зээлжих зэрэглэлийн мэдээллийг улирал тутам шинэчлэн, зээлийн эрсдэлийн шинжилгээг хийж, удирдлагуудад тухай бүр танилцуулж ажиллалаа.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Монголбанк үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд олон улсын төв банкуудын тэргүүн туршлага, жишгийн дагуу эрсдэлийн засаглалын тогтолцоог бэхжүүлж, эрсдэлийг үнэлж, тодорхойлох арга хэрэгслүүдийг амжилттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, олон улсын сүүлийн үеийн чиг хандлагыг нэвтрүүлэх үүднээс эрсдэлийн удирдлагын баримт бичгүүдийг шинэчлэн баталлаа. Тодруулбал, Монголбанкны үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагатай холбоотой бодлогын шинжтэй зохицуулалтыг бие даасан баримт бичиг болгож, үүний хүрээнд үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад баримтлах ерөнхий зарчим, зорилго, хамрах хүрээ, тогтолцоог тодорхойлов. Харин журмын хүрээнд илүү нарийвчилсан зохицуулалтыг тусгасан бөгөөд журмын шинэчилсэн найруулгад үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хэд хэдэн шинэ хэрэгсэл, аргачлалыг нэвтрүүлэхээр тусгасан. Үүнээс гадна Ковид-19 цар тахлын тархалттай холбоотойгоор Монголбанкны хэмжээнд “Гоц халдварт өвчний гамшгийн үед Монголбанкны үйл ажиллагааны хэвийн, аюулгүй, тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө”-г боловсруулан баталж, цар тахлын үед энэхүү төлөвлөгөөний дагуу Монголбанкны үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн зохион байгуулан ажилласан.

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагад түгээмэл ашиглагддаг үнэлгээний хэрэгсэл болох “Өөрийн үнэлгээ” (Risk Control and Self-Assessment)-г тав дахь жилдээ цахим хэлбэрээр бүх ажилтнуудаар хийлгэж, үр дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлт (KRIs)-үүдийг сайжруулан, шинэчлэн баталж, гүйцэтгэлд нь тухай бүр хяналт тавьж, удирдлагад тайлагнан ажиллав. Энэ нь үйл ажиллагааны эрсдэлийг бодит хэмжүүрээр хэмжиж, эрсдэл үүсгэж буй хүчин зүйлийн гол шалтгааныг олж тодорхойлон тохирсон арга хэмжээ авахад чухал хувь нэмэр оруулж байна. Тайлант хугацаанд алт, бэлэн мөнгөтэй холбоотой Монголбанкны үйл ажиллагаанд эрсдэлийн зураглалын үнэлгээг хийж, үр дүнд үндэслэн үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Тайлант хугацаанд үйл ажиллагааны эрсдэлтэй тохиолдлуудын бүртгэл, үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтийн гүйцэтгэлийг тайлагнах “Үйл ажиллагааны эрсдэлийн програм”-ыг ашиглалтанд оруулснаар үйл ажиллагааны эрсдэлийн гүйцэтгэл тайлагнах үйл явц хялбар, боловсронгуй болсон, мөн үйл ажиллагааны эрсдэлийн мэдээлэл нь Монголбанкны мэдээллийн санд хадгалагдаж, мэдээллийг боловсруулах, ашиглахад илүү хялбар боллоо.

Монголбанкны бүх нэгжүүдэд үйл ажиллагааны эрсдэл хариуцсан ажилтан томилогдсон бөгөөд ЭУА нь эдгээр ажилтнуудад зориулж сургалт, хурал уулзалтыг тогтмол зохион байгуулж байна. Энэ нь байгууллагын хэмжээнд эрсдэлийн удирдлагын талаарх мэдлэг, мэдээллийг түгээж, үйл ажиллагааны эрсдэлийн соёлыг төлөвшүүлэх, нөгөө талаар нэгж тус бүр хоорондоо нягт уялдаа, холбоотой хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж байна.

4.7 БЭЛЭН МӨНГӨНИЙ УДИРДЛАГА

Тайлант оны эцсийн байдлаар гүйлгээнд байгаа мөнгөн дэвсгэртийн тоо ширхэг, мөнгөн дүн өмнөх оны эцсийн байдлаас харгалзан 5.7 ба 10.5 хувиар тус тус өсч, 499.07 сая ширхэг буюу 991.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Хүснэгт 4.4. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө

№	Мөнгөн дэвсгэрт	Сая ширхэг			Сая төгрөг		
		2019 он	2020 он	Өөрчлөлт	2019 он	2020 он	Өөрчлөлт
1	1	32.80	33.20	1.2%	32.8	33.2	1.2%
2	5	29.75	30.13	1.3%	148.7	150.7	1.3%
3	10	97.01	102.52	5.7%	970.1	1,025.2	5.7%
4	20	81.12	85.76	5.7%	1,622.4	1,715.1	5.7%
5	50	66.01	70.66	7.0%	3,300.3	3,532.8	7.0%
6	100	65.96	69.94	6.0%	6,596.3	6,994.0	6.0%
7	200	0.18	0.18	-0.7%	36.9	36.6	-0.7%
8	500	16.62	16.48	-0.9%	8,312.4	8,240.5	-0.9%
9	1000	20.29	20.49	1.0%	20,290.7	20,491.8	1.0%
10	5000	13.51	15.52	14.9%	67,544.7	77,622.8	14.9%
11	10000	18.54	21.20	14.3%	185,443.6	211,986.8	14.3%
12	20000	30.15	32.98	9.4%	603,080.9	659,659.7	9.4%
	Нийт	471.96	499.07	5.7%	897,379.9	991,489.2	10.5%

Дэвсгэртүүдээс хамгийн өндөр хувийн өсөлттэй нь 5000-таас дээшхи том 3 дэвсгэрт байсан бол 500-тын дэвсгэрт ганцаараа бууралттай байлаа.

Дэвсгэртийн тоо ширхэгийн хувьд тайлант оны эцсийн байдлаар 10-т, 20-т, 50-т, 100-тын дэвсгэрт нийт дэвсгэртийн 66 хувь, үлдсэн 8 дэвсгэрт нь 44 хувийг эзэлж байна.

Зураг 4.8. Мөнгөн дэвсгэртүүдийн бүтэц, тоо ширхэгээр

Мөнгөн дүнгийн хувьд нийт гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 87.9 хувийг 10,000-т болон 20,000-тын дэвсгэрт, үлдсэн 12.1 хувийг бусад дэвсгэртүүд эзэлж байна.

Зураг 4.9. Дэвсгэртүүдийн бүтэц, мөнгөн дүнгээр

Бэлэн мөнгөний нөөцийн бүрдүүлэлт

Шинэчилсэн хамгаалалтын элемент бүхий 2019 оны 50-т, 20000-тын дэвсгэртийг 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн гүйлгээнд гаргаж, хамгаалалтын хувьд харьцангуй муу байсан 2006 оны 20,000-тын дэвсгэртийг гүйлгээнээс татлаа.

Нөөцийг нь дахин бүрдүүлэх шаардлагатай байсан 100-т, 500-т, 1000-тын дэвсгэртийг тайлант онд дахин үйлдвэрлэхдээ хамгаалалтын орчин үеийн шинэ технологи болох 3-н хэмжээст хөдөлгөөнтэй, хазайлгахад өнгө нь хувирагч элемент, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан товгор таних тэмдэг зэрэг шинэ элементүүдээр баяжуулж сайжруулан гүйлгээнд гаргахад бэлэн болголоо.

4.8 МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

Монголбанкны Мэдээллийн технологийн газар нь 2020 онд банк хоорондын төлбөр тооцооны систем, банк хоорондын валют арилжааны цахим талбар, зээлийн мэдээллийн сангийн систем болон байгууллагын дотоод үйл ажиллагаанд ашиглаж буй цахим мэдээллийн системүүдийн аюулгүй, найдвартай, тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа.

Мөн одоо ашиглагдаж байгаа системүүдийг сайжруулах, боловсронгуй болгохын зэрэгцээ шинэ техник, технологийн судалгаа хийн, үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Банк хоорондын валютын богино хугацаат своп, форвард хэлцлийн програмийг шинээр хөгжүүлж, валют арилжааны цахим талбарт нэгтгэсэн.
- Монголбанкны статистик мэдээллийн вэбийг шинээр хөгжүүлж, ашиглалтанд оруулсан.
- Зээлийн мэдээллийн санд алдаатай мэдээлэл нийлүүлэгдэхээс сэргийлэхийн тулд иргэн болон байгууллагын мэдээллийг Хур системтэй автоматаар тулгаж шалгах програмыг хөгжүүлсэн.
- Монголбанкны бусад газар хэлтсүүдийн ажлын хэрэгцээнд зориулсан дотоод аудитын мэдээллийн сан, тоног төхөөрөмжийн сэлбэгийн бүртгэл, захиалга, зарцуулалтын системийг шинээр хөгжүүлэн ашиглалтад оруулсан.
- Монголбанкны цахим оффис системд хүний нөөцийн модулийг шинээр хөгжүүлж нэвтрүүлснээс гадна орон нутаг дахь салбар, хэлтсийн нийт ажилтнууд ашиглах боломжтой модулиуд

ашиглалтад оруулсан.

- 2020 онд Монголбанкны ажилтнууд гэрээсээ ажиллах шаардлагатай болсон тул байгууллагын дотоод сүлжээ рүү алсын зайнаас холбогдон ажиллах VPN технологийг нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг ханган ажилласан. Үүнтэй холбоотойгоор байгууллагын дотоод цахим оффисийн систем рүү интернэт орчноос хандахад хоёр шатлалт хэрэглэгч таних “Google Authenticator” технологи болон тоон гарын үсэг ашиглах нэмэлт өөрчлөлтийг хөгжүүлж, ашиглалтад оруулсан.
- Монголбанкны дотоод цахим оффисийн системийн тасралтгүй найдвартай ажиллагааг сайжруулах үүднээс виртуал контэйнер /Docker/ технологийг амжилттай нэвтрүүлсэн.
- Монголбанкны шинэ дата төвд сервер, сүлжээний тоног төхөөрөмжийг шилжүүлэн суурилуулж, шинэ барилгын дотоод сүлжээг ашиглалтад оруулсан.
- Монголбанкны улс хоорондын төлбөр тооцооны СВИФТ системийг шинэ хувилбарт амжилттай шилжүүлж, хоёр шатлалт хэрэглэгч таних механизмийг нэвтрүүлсэн.
- Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албаны үйл ажиллагаанд ашиглагдах мөнгө угаалтын мэдээллийн сангийн “GoAML” системийг шинээр суурилуулсан.
- Монголбанкинд шинэ суурь бүртгэлийн систем нэвтрүүлэхтэй холбогдуулан гүйцэтгэгч компанитай хамтран өгөгдөл нэгтгэх, тэстийн орчныг бүрдүүлэх зэрэг ажлууд дээр хамтран ажиллаж байна.

Түүнчлэн мэдээллийн технологийн тасралтгүй үйл ажиллагааг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг дээшлүүлэх, вирусын болон аливаа халдлагаас урьдчилан сэргийлэх, тэдгээрээс хамгаалах, хариу арга хэмжээ авахад чиглэсэн үйл ажиллагааг улам сайжруулахад чиглэсэн арга хэмжээнүүд авч ажиллалаа.

4.9 МОНГОЛБАНКНААС 2020 ОНД ГАРГАСАН ЭРХ ЗҮЙН АКТ, ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

Д/д	Эрх зүйн акт, шийдвэр	Огноо	Дугаар	Агуулга
1	Урт хугацаат своп хэлцлийн журамд өөрчлөлт оруулах тухай	1/24/2020	А-22	МБЕ-ийн 2016.12.14-ний өдрийн А-341 дүгээр тушаалаар батлагдсан "Урт хугацаат своп хэлцэл"-ийн журмын "Тухайн өдөр мөрдөгдөж буй Төв банкны Репо хүү" гэснийг "Хамгийн сүүлд олон нийтэд зарласан 28 долоо хоногтой Төв банкны үнэт цаасны жигнэсэн дундаж хүү" гэж өөрчлөн найруулах.
2	Шинэчилсэн 20,000 төгрөг, 50төгрөгийн дэвсгэртийг гүйлгээнд гаргах, 2006 онд хэвлэгдсэн 20000 төгрөгийн дэвсгэртийг гүйлгээнээс хасах тухай	1/31/2020	А-25	2019 оны 20.000 төгрөг, 50 төгрөгийн мөнгөн дэвсгэртийг 2020.2.3-аас гүйлгээнд гаргасугай. 2006 оны 20.000 төгрөгийн дэвсгэртийг 2020.03.01-ний өдрөөс эхлэн гүйлгээнээс татсугай.
3	Төлбөрийн картын журамд өөрчлөлт оруулах тухай	2/19/2020	А-41	МБЕ-ийн 2019.04.05-ны А-92 тушаалаар батлагдсан Төлбөрийн картын журамын 10.5-д Оролцогч нь энэ журмын 10.3-т заасан үр дүнгийн төлбөр тооцоог дараагийн ажлын өдрийн 17.10 цагт багтаан гүйцэтгэж чадаагүй тохиолдолд клирингийн төв нь тухайн оролцогчийн төлбөрийн картын систем ашиглах эрхийг түдгэлзүүлэх. 10.6-д Эрхийг нь түдгэлзүүлсэн оролцогч энэ журмын 10.5-д заасан үр дүнгийн төлбөр тооцоог Төлбөрийн картын систем ашиглах эрх түдгэлзүүлэх, эрхийг сэргээх агуулга бүхий заалтууд нэмсэн.

4	Зээлийн мэдээллийн сангийн журмыг шинэчлэн найруулах тухай	3/3/2020	А-57	Монголбанкны зээлийн мэдээллийн санг бүрдүүлэх, зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдлыг хангах, өөрийн зээлийн мэдээллийн санг ашиглуулах гэрээ байгуулах, хяналт тавих харилцааг зохицуулах тухай мөн Зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгөх, авах гэрээг баталсан.
5	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	3/11/2020	А-61	Төв банкны бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, жилийн 10 хувиар тогтоох шийдвэрийг 2020 оны 03 сарын 12-ны өдрөөс эхлэн мөрдөх
6	Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулах тухай	3/20/2020	А-97	МБ-ны Ерөнхийлөгчийн А-174 дугаар тушаалын 2.2-т заасан "90 хоногоос" гэснийг "6 сараас" гэж өөрчлөх
7	Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг тогтоох	3/11/2020	А-63	Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 8.5 хувиар, валютын заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 15.0 хувиар тогтоох
8	Дансны нэгдсэн дугаарлалт нэвтрүүлэх тухай	3/13/2020	А-66	Дансны нэгдсэн дугаарлалтын заавар батлан зааврыг 2022.01.01-ээс мөрдөх, дансны дугаарлалтыг тус зааврын дагуу хөрвүүлэх ажлыг 2022.01.01-2024.10.31 хүртэл хийх.
9	Монголбанкнаас банканд олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулах тухай	3/20/2020	А-97	МБ-ны Ерөнхийлөгчийн А-174 дугаар тушаалын 2.2-т заасан "90 хоногоос" гэснийг "6 сараас" гэж өөрчлөх
10	Төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасны жагсаалтыг батлах тухай	3/23/2020	А-98	Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө болон худалдан авах үнэт цаасын жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн батлах
11	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	4/8/2020	А-116	МБ-ны Ерөнхийлөгчийн А-295 дугаар тушаалаар батлагдсан Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд заалт нэмэх
12	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн талаар авах зарим арга хэмжээний тухай	4/8/2020	А-117	Ковид-19 цар тахал болох гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөх тохиолдолууд.
13	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	5/20/2020	А-173	Журмын 2.2 дахь заалтыг Зээл хүсэгч өөрийн эсвэл хамтран зээлдэгчийн өмчлөлд байгаа орон сууцыг барьцаа болгон орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авч, зээлээр худалдан авах шинэ орон сууцны урьдчилгаа төлбөрийг төлж болно гэж өөрчлөн найруулсан.
14	Тушаалд түр хугацаанд өөрчлөлт оруулах тухай	4/13/2020	А-122	Эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдлын улмаас 2020.02 сараас эхлэн эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлүүдийн хувьд үлдэгдэл хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар, зээлийн үлдэгдэл хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр, нэг удаа сунгахыг зөвшөөрөх тухай.
15	Монголбанканд худалдан авах алт, цагаан мөнгөний үнийг тодорхойлох журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	4/21/2020	А-129	МБ-ны Ерөнхийлөгчийн 2018 оны А-138 дугаар тушаалаар баталсан “МБ-нд худалдан авах алт, цагаан мөнгөний үнийг тодорхойлох журам”-ын 2.3 дахь заалтыг “ГВУН-ийн удирдлага,гадаад,дотоодсанхүүгийнзахзээлийннөхцөл байдлаас шалтгаалж худалдан авах алтны үнийг тухай бүр өөрчилж болно.Энэ тухай үндэслэл бүхий саналыг ЭУА боловсруулж, Хөрөнгө оруулалтын хорооны хурлаар хэлэлцүүлнэ” гэж өөрчлөх.
16	₮ картын шинэ лого, холограмыг ашиглах тухай	5/5/2020	А-143	Үндэсний төлбөрийн ₮ картын шинэ лого, түүнийг байршуулах зааврыг энэ тушаалын хавсралт 1-т заасны дагуу, ₮ картын шинэ хлограм, түүнийг байршуулах зааврыг энэ тушаалын хавсралт 2-т заасны дагуу ҮЦГТ шинэ лого, түүнийг байршуулах зааврыг энэ тушаалын хавсралт 3-т заасны дагуу баталсугай.

17	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	5/20/2020	А-173	МБ-ны Ерөнхийлөгчийн А-295 дугаар тушаалаар батлагдсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын 2.2 дахь заалтыг "Зээл хүсэгч өөрийн эсвэл хамтран зээлдэгчийн өмчлөлд байгаа орон сууцыг барьцаа болгон орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авч, зээлээр авч, зээлээр худалдан авах шинэ орон сууцны урьдчилгаа төлбөрийг төлж болно гэж өөрлөх.
18	Алт-2 үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах тухай	5/20/2020	А-177	Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр, хөтөлбөрийг эрчимжүүлэх зорилгоор олгох хөнгөлөлттэй санхүүжилтийн түр журмыг 2 дугаар, алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон шаардлагыг 3 дугаар хавсралтаар тус тус батлав.
19	“МБ-аас банканд олгох зээлийн түр журам” батлах тухай	6/3/2020	А-192	Коронавирус цар тахлын үед нийгэм, эдийн засагт үүссэн нөхцөл байдлыг харгалзан банкны санхүүгийн байдлыг сайжруулж, салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор 2020.12.31 хүртэл хугацаанд мөрдөх банканд олгох зээлийн түр журам.
20	“Төв банкныүнэт цаасны арилжааны журам”-ыг хавсалтаар шинэчлэн батлах тухай	6/17/2020	А-205	Монголбанк мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор нээлттэй захын үйл ажиллагааны хүрээнд Монголбанкнаас үнэт цаас гаргах, арилжаалах үйл ажиллагааг зохицуулах.
21	Журам хүчингүй болсонд тооцох тухай	6/17/2020	А-207	Монголбанкнаас банк, банкны ажилтнуудын үйл ажиллагаатай холбогдсон эрүү, иргэний хэрэгт магадлан шинжилгээ хийх журамыг хүчингүй болсонд тооцсугай.
22	“МБ-ны гадаад валютын спот арилжааны журам”-ыг шинэчлэн батлах тухай	7/2/2020	А-227	Монголбанкнаас гадаад валютын дотоод захад оролцох үйл ажиллагаанд баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, түүнд тодорхойлох, түүнд хяналт тавих нөхцөлийг бүрлүүлэх.
23	“Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн зээлийн мэдээллийг хадгалах, хамгаалах журам” батлах тухай	7/3/2020	А-231	Зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх этгээдийн зээлийн мэдээллийн сангийн мэдээллийг хадгалах, хамгаалах, нууцлал, энэ үйл ажиллагааг эрхлэхтэй холбоотой аюулгүй байдлын стандарт, хяналт удирдлагын тогтолцоо болон зээлийн мэдээлэлтэй холбоотой зээлдэгчийн эрхийг хамгаалах харилцааг зохицуулах.
24	Төлбөрийн картын журам батлах тухай	7/6/2020	А-233	Монгол улсын нутаг дэвсгэр дэх төлбөрийн картын үйл ажиллагааг зохицуулах, зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих.
25	Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	8/24/2020	А-340	Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журамд 4.3 заалт нэмэх, түүнд хяналт тавин ажиллах.
26	Төв банкны бодлогын хүүгийн хувь хэмжээг тогтоох тухай	9/14/2020	А-367	Төв банкны бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, жилийн 8 хувиар тогтоох
27	Урт хугацаат своп хэлцлийн журамд өөрчлөлт оруулах тухай	9/21/2020	А-379	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016.12.14-ний А-341 тушаалын хавсралтыг Своп хэлцлийн үндсэн нөхцөл, Урт хугацаат своп хэлцэл хэсгийн загварыг өөрчлөх тухай.
28	Урт хугацаат своп хэлцлийн хүүний нөхцөлд өөрчлөлт оруулах тухай	9/21/2020	А-380	Урт хугацаат своп хэлцлийн журмын 3.3 дахь заалтын дагуу 2020.06.24-ний өдрөөс хойш шинэчилсэн, шинээр байгуулсан бодит бус хэлцлүүдийн ам.долларын эх үүсвэрийн хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болох валютын харилцах дансны жигнэсэн дундаж хүүг 1.2 хувиар тооцож өөрчлөв.
29	Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журамын 1.2.13, 2.1.2 заалтыг өөрчлөн найруулах.	10/1/2020	А-392	Амины орон сууц гэсэн тодорхойлолтын өөрчлөх, Зээлийн хүү 2020.10.1-ээс өмнө олгосон нь 8 хувь, хойш олгосон нь 6 хувь байхаар тогтоов.

30	“Төв банкны репо арилжааны журам”-ыг батлах тухай	11/25/2020	А-425	Монголбанк мөнгөний бодлого хэрэгжүүлэх зорилгоор банканд репо арилжаагаар санхүүжилт олгох харилцааг зохицуулна.
Мөнгөний бодлогын хорооны шийдвэрүүд				
1	Бодлогын хүүг бууруулах, төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг багасгах болон бодлогын хүүний коридорыг шинэчлэн тогтоох тухай	3/11/2020	2020/01	1) Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 10 хувьд хүргэх, 2) Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувьд тогтоох болон бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +1, -1 нэгж хувийн өргөнтэй болгон өөрчлөх шийдвэрийг тус тус гаргалаа.
2	Бодлогын хүүг бууруулах, хэрэглээний зээлийн хугацааг сунгах тухай	4/13/2020	2020/02	1) Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэх; 2) Эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа.
3	Бодлогын хүүг хэвээр хадгалах, банкны эх үүсвэрийн долларжилтийг бууруулах арга хэмжээний тухай	6/26/2020	2020/03	1) Эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг харгалзан үзээд бодлогын хүүг хэвээр хадгалах; 2) Банкны системийн тогтвортой байдлыг хангах үүднээс банкны эх үүсвэрийн долларжилтыг бууруулах, төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор өндөр хүүтэй гадаад валютын хадгаламж болон хүү төлж буй гадаад валютын харилцахын эзлэх хувиар банкинд олгох төгрөгийн заавал байлгах нөөцийн урамшууллыг бууруулан тооцох шийдвэрийг тус тусгаргалаа.
4	Хэрэглээний зээлийн хугацааг сунгах тухай	8/7/2020	2020/04	Эдийн засгийн хүндрэлтэй нөхцлийн улмаас эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хэрэгжүүлэх шийдвэр гаргалаа.
5	Бодлогын хүүг бууруулах, урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгсэл нэвтрүүлэх тухай	9/14/2020	2020/05	1) Бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 8 хувьд хүргэх; 2) Урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх шийдвэр гаргалаа.
6	Бодлогын хүү, заавал байлгах нөөцийн хувийг бууруулах, хэрэглээний зээлийн хугацааг сунгах, урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэхтухай	11/23/2020	2020/06	1) Бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулж 6 хувьд хүргэх; 2) Банкны төгрөгийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээг 2.5 нэгж хувиар бууруулж 6 хувьд тогтоох; 3) Эргэн төлөлт нь доголдсон хэрэглээний зээлд бүтцийн өөрчлөлт хийж, хугацааг сунгах арга хэмжээг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэл үргэлжлүүлэн хэрэгжүүлэх; 4) Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлэх зэрэг багц шийдвэрий ггаргалаа.
7	Бодлогын хүүг хэвээр хадгалах, санхүүжилтийн хэмжээний тухай	12/18/2020	2020/07	1) Бодлогын хүүг хэвээр хадгалах; Жижиг, дунд үйлдвэрлэл, 2) Уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат дахин санхүүжилтийн хэрэгслээр 2021 оны 1-р улиралд 250 хүртэлх тэрбум төгрөгийг олгох шийдвэрийг гаргалаа.

4.10 ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГАА, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Судалгааны ажил

ЭЗССХ нь 2020 онд Монгол улсын хөгжлийн, эдийн засгийн болон санхүүгийн бодлогын шийдвэрт дэмжлэг болох чиг үүргийн хүрээнд дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- “Ханшийн худалдан авах чадварт үзүүлэх нөлөө”
- “Мөнгөний бодлогын ханшид үзүүлэх нөлөө”

- “Төсвийн бодлогын ханшид үзүүлэх нөлөө”
- “Хөрөнгийн урсгалын ханшид үзүүлэх нөлөө”
- “Монгол улсын эдийн засгийн 2019 оны гүйцэтгэлийн дүн шинжилгээ, 2020 оны төлөв байдал, "өндөржүүлсэн бэлэн байдлын" үеийн эдийн засгийн бодлого”
- “Инфляцын календарь”
- “Мөнгөний бодлогын орлогын ялгаатай бүлгүүдэд үзүүлэх нөлөөлөл”
- “Бүсүүдийн эдийн засаг” – тоо мэдээний тойм
- “Уул уурхайн бус экспортын тоон мэдээллийн шинжилгээ. Уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх маркетинг, санхүүжитлтийн зорилтот төлөвлөгөөний агуулга”
- “The Effectiveness of Currency Intervention in a Commodity-Exporter: Evidence from Mongolia”

Монгол улсын хэмжээнд шаардлагатай, эдийн засгийн бодлогын судалгаагаар төрийн байгууллагуудыг хангаж ажиллах чиг үүргийн хүрээнд дараах ажлыг зохион байгуулав:

Монгол улсын эдийн засгийн 2019 оны гүйцэтгэлийн дүн шинжилгээ, 2020 оны төлөв байдал, "өндөржүүлсэн бэлэн байдлын" үеийн эдийн засгийн бодлогын зөвлөмжийг УИХ-ын гишүүд, Эдийн засгийн байнгын хороо, МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар, УИХ-ын даргын тамгын газар зэрэг төрийн байгууллагуудад хүргүүлэв;

Мөнгө, санхүү баялаг сэтгүүлд хэвлэгдсэн судалгааны ажлуудыг төрийн байгууллагуудад хүргүүлэв.

Сургалт

Монголбанкны ажилтнуудад холбогдох газруудтай хамтран дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулав:

- Монголбанкны орон нутаг дахь салбар, хэлтсийн захирлуудад "Үр дүнтэй харилцаа, зөрчилдөөнийг удирдах нь" сургалт;
- Монголбанкны холбогдох газруудын ахлах эдийн засагч нарт "Манлайлал ба цагийн менежмент" семинар;
- Хянан шалгагч нарт зориулсан сургалтад "Манлайлал, харилцааны менежмент" сэдвээр сургалт;
- Монголбанкны шинэ ажилтны чиглүүлэх сургалтыг 2020 онд хоёр удаа зохион байгуулав.

Мөн энэхүү чиглэлийн хүрээнд Монголбанкны нийт газруудын сургалтын хэрэгцээний үнэлгээг хийсэн ба цахим сургалтын үйл ажиллагааг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Хамтын ажиллагаа

Төрийн бусад байгууллага яам, тамгын газар, агентлагуудтай нягт хамтран ажиллах орчныг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд дараах уулзалтыг зохион байгуулав:

- Швейцар дахь Элчин сайдын яам нь Швейцарын Эдийн засгийн яамнаас санхүүжүүлдэг хөгжиж буй орнуудын Төв банкуудад зориулсан хоёр талын тусламж, чадавхийг бэхжүүлэх хөтөлбөрт оролцохоор Швейцар дахь ЭСЯ, Швейцарын Эдийн засгийн яам болон Төв банктай холбогдох уулзалтуудыг хийж, шаардлагатай бичиг баримтаар хангаж ажиллав.

АУДИТААР БАТАЛГААЖСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

5

МОНГОЛБАНК (ТӨВ БАНК)

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

АГУУЛГА

БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ
АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАНМӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК
БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:	Б. Лхагвасүрэн	Ерөнхийлөгч
	Г.Дөлгөөн	Тэргүүн Дэд Ерөнхийлөгч (2020.05.07-нд томилогдсон)
	Г.Энхтайван	Дэд Ерөнхийлөгч (2020.05.07-нд томилогдсон)
	Д.Ган-Очир	Ерөнхий эдийн засагч
	Н.Батсайхан	Ерөнхийлөгчийн эдийн засгийн зөвлөх
	Б.Гантуяа	Ерөнхийлөгчийн хуулийн зөвлөх
	Б.Баярдаваа	Мөнгөний бодлогын газрын захирал
	А.Энхжин	Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал
	Ц.Нарандалай	Хяналт, шалгалтын газрын захирал
	Н.Ариунбат	Банкны бүтцийн өөрчлөлт, бодлогын газрын захирал
	Р.Саранцэцэг	Мөнгөн тэмдэгтийн газрын захирал
	Д.Аюуш	Хууль, эрх зүйн газрын захирал
	Б.Батдаваа	Судалгаа, статистикийн газрын захирал
	Э.Анар	Төлбөр тооцооны газрын захирал
	Т.Амарсайхан	Дотоод аудитын газрын захирал
	Ж.Батхуяг	Тамгын газрын захирал
	Ц.Гарьд	Санхүү бүртгэлийн газрын захирал
	Д.Баянзул	Эрсдэлийн удирдлагын албаны захирал
	Д.Довчинбазар	Мэдээллийн технологийн газрын захирал

АЛБАН ХАЯГ:

Монголбанкны төв байр
Бага тойруу-3, 15160
Улаанбаатар-46, Монгол Улс

АУДИТОРУУД:

Эрнст энд Янг Монголия Аудит ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК

ЗАХИРЛУУДЫН ЗӨВЛӨЛИЙН ХАРИУЦЛАГЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Монголбанк (цаашид "Банк")-ны санхүүгийн тайланг бэлтгэх нь Захирлуудын зөвлөлийн үүрэг мөн.

Бид энэхүү тайлангийн 6-73 дугаар хуудсанд үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, материаллаг зөрүүгүй илэрхийлсэн болохыг үүгээр мэдэгдэж байна.

Захирлуудын зөвлөл нь Банкны санхүүгийн байдлыг үнэн зөв, үндэслэлтэй толилуулах нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах, санхүүгийн тайлангуудыг Тодруулга 2-т толилуулсан шаардлагад нийцэж байгааг хариуцах үүрэгтэй.

Мөн Банкны хөрөнгийг хамгаалах, залилан, бусад зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг эрх мэдлийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх нь Захирлуудын зөвлөлийн ерөнхий үүрэг болно.

Захирлуудын зөвлөл нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг тууштай баримталж, үндэслэлтэй бөгөөд оновчтой үнэлгээ, тооцооллыг хийж, нягтлан бодох бүртгэлийн холбогдох бүх стандартыг дагаж мөрдсөн гэж үзэж байна.

Захирлуудын зөвлөлийг төлөөлөн гарын үсэг зурсан:

Б. Лхагвасүрэн
Монголбанкны Ерөнхийлөгч

Огноо: 2021 оны 3 дугаар сарын 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

Building a better working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel: +976 11 314032 / +976 11 312005
Fax: +976 11 312042
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Монголбанкны Захирлуудын зөвлөлд

Хязгаарлалттай дүгнэлт

Бид Монголбанк (“Банк”)-ны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр аудиторын тайлангийн Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан асуудлаас үүсч болох үр нөлөөнөөс бусдаар дээрх санхүүгийн тайлангууд нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал болон тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн тайлангийн Тодруулга 23-т толилуулснаар Банкны эрдэнэсийн санд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 916,278 сая төгрөгийн (2019 онд 916,278 сая төгрөг) дансны үнэтэй зооснууд багтсан. Эдгээр нь ихэвчлэн 1925 онд тухайн үеийн төв банкнаас анх гүйлгээнд гаргасан мөнгөн болон зэс зооснууд (цаашид “Зоос”) юм.

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Банк нь эрдэнэсийн санд багтах хөрөнгийг орлогодох эрхтэй ба Банкны дотоод бодлого, журмаар дараах шаардлагыг хангасан хөрөнгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталж, эрдэнэсийн сангийн хөрөнгө гэж үзнэ.

- Тухайн үнэт зүйлийн ач холбогдлын зэргээс хамаарч Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолттой байх;
- Үнэт зүйл нь эрдэнийн чулуу болон үнэт металаар хийгдсэн бол итгэмжлэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн сорилтын дүгнэлттэй байх; эсвэл
- Үнэт зүйлийн түүх, соёлын өндөр ач холбогдолтой болохыг батлах Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлт гэх мэт тухайн чиглэлийн мэргэжилтний тодорхойлолт, судалгааны болон бусад баримтуудтай байх.

Бид дээрх Зооснуудыг Банкны дотоод бодлого, журмын дагуу эрдэнэсийн сангийн хөрөнгө гэж үзсэн хангалттай, зохистой аудитын нотлох баримт олж авах боломжгүй байсан тул уг Зооснууд нь Эрдэнэсийн сангийн хөрөнгөөр бүртгэгдэж, ангилагдах зохих хууль, журмын шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй байсан. Иймд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх эрдэнэсийн санд бүртгэлтэй байгаа 916,278 сая төгрөгийн дансны үнэ (2019: 916,278 сая.төг) бүхий Зооснуудыг эрдэнэсийн сангийн хөрөнгө хэмээн зохистой ангилсан эсэх, үүнтэй холбоотойгоор Банкны өөрийн хөрөнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх эцсийн үлдэгдэл болон 2020 оны 1 дүгээр сарын 1 өдрөөрх эхний үлдэгдэл дэх бусад нөөц санд Зооснуудыг бодит үнэ цэнээр илэрхийлэхэд үүссэн тэг төгрөгийн (2019: 914,539 сая.төг) дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэх нь зүйтэй байсан эсэхийг тодорхойлох боломжгүй байлаа. Банкны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланд 2020 оны 5 дугаар сарын 22-ны өдөр өгсөн бидний дүгнэлт мөн адил шалтгааны улмаас хязгаарлалттай дүгнэлт агуулсан болно.

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (“АОУС”)-уудын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн бидний үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн *“Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага”* хэсэгт харуулав. Бид *Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн (Олон улсын хараат бус байдлын стандартууд багтана)* дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэм болон тэдгээр шаардлагад заасан бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

EY
Building a better working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (Үргэлжлэл)

Монголбанкны Захирлуудын зөвлөлд

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй.

Захирлуудын зөвлөл нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

EY
Building a better working world

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ (Үргэлжлэл)

Монголбанкны Захирлуудын зөвлөлд

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (Үргэлжлэл)

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг Захирлуудын зөвлөлд мэдэгддэг.

Бусад

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын Төв банкны тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн хүсэлтээр аудитыг гүйцэтгэн Банкны Захирлуудын зөвлөлд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Гарын үсэг зурсан

Доржбатын Мандахбаяр
Захирал

Баталсан

Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол улс
Огноо: 2021 оны 3 дугаар сарын 31

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	Тодруулга	2020 Сая.төг	2019 Сая.төг
Хүү, түүнтэй адилтгах орлого	6	694,862	724,318
Хүү, түүнтэй адилтгах зардал	7	(1,095,830)	(1,182,320)
Цэвэр хүүгийн зардал		**(400,968)**	**(458,002)**
Алт, үнэт металын арилжааны болон үнэлгээний цэвэр ашиг	8	879,608	499,822
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн цэвэр алдагдал	9	(381,196)	(227,872)
Гадаад валютын арилжааны болон ханшийн тэгшитгэлийн цэвэр (алдагдал)/ашиг	10	(459,090)	85,335
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	11	(81,355)	(14,521)
Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны болон үнэлгээний цэвэр ашиг	12	3,171	771
Өрийн бичгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал	13	(27,707)	(88,524)
Үйл ажиллагааны бусад орлого	14	29,623	28,847
Үйл ажиллагааны болон бусад зардал	15	(65,464)	(55,735)
Тайлант жилийн алдагдал		**(503,378)**	**(229,879)**
Бусад дэлгэрэнгүй орлого:			
Дараагийн тайлант хугацааны ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдах бусад дэлгэрэнгүй орлого:			
-Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн ашиг	34	95,661	66,702
-Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийг борлуулах үед ашиг, алдагдлын тайланд шилжүүлсэн	34	(3,262)	3,833
Дараагийн тайлант хугацааны ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:			
-Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдэл	34	-	137,035
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого		**92,399**	**207,570**
ТАЙЛАНТ ЖИЛИЙН НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ АЛДАГДАЛ		**(410,979)**	**(22,309)**

Захирлуудын зөвлөлийг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрөв.

Б. Лхагвасүрэн
Монголбанкны Ерөнхийлөгч

Ц. Гарьд
Санхүү бүртгэлийн газрын захирал

Тдруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРИЙН БАЙДЛААРХ
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	Тодруулга	2020 Сая.төг	2019 Сая.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө	16	233,373	214,244
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	17	4,517,392	4,458,508
Дотоодын банкуудад олгосон зээл	18	461,314	442,918
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	19	5,275,129	3,873,142
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	20	6,595	11,734
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	21	4,816,068	3,254,437
Алт, үнэт метал	22	1,785,857	3,108,684
Эрдэнэсийн сан	23	1,071,665	1,068,860
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	24	156,419	260,778
Засгийн газрын үнэт цаас	25	227,407	134,028
Бусад хөрөнгө	26	423,673	492,322
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө	27	115,201	94,149
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө		6,280	1,003
НИЙТ ХӨРӨНГӨ		**19,096,373**	**17,414,807**
ӨР ТӨЛБӨР			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	28	991,470	897,417
Төв банкны үнэт цаас	29	7,952,438	4,629,293
Засгийн газрын хөрөнгө	30	2,132,025	2,201,585
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	31	3,871,397	6,038,704
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	24	303,501	545,040
Гадаад өр төлбөр	32	5,789,508	4,969,684
Бусад өр төлбөр	33	365,317	31,388
НИЙТ ӨР ТӨЛБӨР		**21,405,656**	**19,313,111**
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Дүрмийн сан	34	60,000	60,000
Хуримтлагдсан алдагдал		(4,327,545)	(3,698,110)
Бусад нөөц	34	1,958,262	1,739,806
ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ДУТАГДАЛ		**(2,309,283)**	**(1,898,304)**
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		**19,096,373**	**17,414,807**

Захирлуудын зөвлөлийг төлөөлж энэхүү тайланг нийтлэхийг хүлээн зөвшөөрөв.

Б. Лхагвасүрэн
Монголбанкны Ерөнхийлөгч

Ц. Гарьд
Санхүү бүртгэлийн газрын захирал

Тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

	Дүрмийн сан Сая.төг (Тод 34)	Бусад нөөц Сая.төг (Тод 34)	Хуримтлагдсан алдагдал Сая.төг (Тод 34)	Өөрийн хөрөнгийн дутагдал Сая.төг
2019 оны 01-р сарын 01-ний өдрөөр	**60,000**	**1,135,840**	**(3,071,835)**	**(1,875,995)**
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	–	207,570	(229,879)	(22,309)
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөцөд шилжүүлсэн	–	396,396	(396,396)	–
2019 оны 12-р сарын 31 болон 2020 оны 01-р сарын 01-ний өдрөөр	**60,000**	**1,739,806**	**(3,698,110)**	**(1,898,304)**
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	–	92,399	(503,378)	(410,979)
Хуримтлагдсан алдагдлаас бусад нөөцөд шилжүүлсэн	–	126,057	(126,057)	–
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр	**60,000**	**1,958,262**	**(4,327,545)**	**(2,309,283)**

Тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

	Тодруулга	2020 Сая.төг	2019 Сая.төг
Үйл ажиллагааны мөнгө гүйлгээ			
Тайлант жилийн алдагдал		**(503,378)**	**(229,879)**
Тохируулгууд:			
Өрийн бичгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал	13	27,707	88,524
Алт, үнэт металын арилжааны болон үнэлгээний бодит бус ашиг, цэвэр	8	(151,293)	(382,855)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн цэвэр (ашиг)/алдагдал	9	(138,813)	136,512
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн цэвэр алдагдал/(ашиг)	10	584,891	(13,541)
Үндсэн болон биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдол	15	6,090	4,793
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг борлуулснс гарз	15	–	1,144
Үндсэн хөрөнгийг данснаас хассан болон борлуулснс гарз	15	5	70
Өмчийн үнэт цаас борлуулснс гарз	12	84	–
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	11	81,355	14,521
Мөнгөн бус хандив	27	(111)	–
Хүүгийн орлого	6	(694,862)	(724,318)
Хүүгийн зардал	7	1,095,830	1,182,320
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		**307,505**	**77,291**
Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Алт, үнэт металын цэвэр бууралт/(өсөлт)		1,474,120	(540,172)
Эрдэнэсийн сангийн цэвэр өсөлт		(2,805)	(584)
Урвуу буцаан худалдан авах хэлцлийн цэвэр өсөлт		(1,546,820)	(783,553)
Дотоодын банкуудад олгосон зээлийн цэвэр өсөлт		(25,233)	(2,928)
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын цэвэр (өсөлт)/бууралт		(680,150)	164,877
Бусад хөрөнгийн цэвэр бууралт		20,295	262,037
Төв банкны үнэт цаасны цэвэр өсөлт/(бууралт)		3,316,148	(386,102)
Засгийн газрын хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт		(166,179)	1,041,240
Дотоодын банкуудын харилцах, хадгаламжийн цэвэр (бууралт)/өсөлт		(2,310,184)	1,732,796
Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)		331,892	(85,783)
Үйл ажиллагаанаас орсон хүүгийн өмнөх цэвэр мөнгөн гүйлгээ		**718,590**	**1,479,119**
Хүлээн авсан хүү		637,014	664,423
Төлсөн хүү		(1,097,097)	(1,150,735)
Үйл ажиллагаанаас орсон цэвэр мөнгөн гүйлгээ		**258,507**	**992,807**
Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ			
Үндсэн болон биет бус хөрөнгийн худалдан авалт	27	(44,069)	(32,619)
Үндсэн хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгө		11,756	58
Өмчийн үнэт цаас борлуулснаас хүлээн авсан мөнгө		5,055	–
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулснаас хүлээн авсан мөнгө		–	2,154
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх санхүүгийн хэрэгсэл болон хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх урт хугацаат өрийн хэрэгслийн худалдан авалт		(1,589,766)	(2,943,376)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор илэрхийлэгдэх санхүүгийн хэрэгсэл болон хорогдуулсан өртгөөр илэрхийлэгдэх урт хугацаат өрийн хэрэгсэл борлуулснаас хүлээн авсан мөнгө		933,596	3,635,984
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас орсон/(зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ		**(683,428)**	**662,201**

Тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

МОНГОЛБАНК
2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Тодруулга	2020 Сая.төг	2019 Сая.төг
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөний өсөлт/(бууралт)	28	94,053	(71,201)
Гадаад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт)		238,598	(1)
Санхүүгийн үйл ажиллагаанд орсон/(зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ		**332,651**	**(71,202)**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө		171,961	148,533
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт		**79,691**	**1,732,339**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,672,580	2,940,241
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16	**4,752,271**	**4,672,580**

Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн өр төлбөрийн өөрчлөлт:

	2020 Сая.төг	2019 Сая.төг
2020 оны 01-р сарын 01-ний өдрөөр	**4,969,684**	**4,906,130**
Мөнгөн гүйлгээ		
Татан авалт	284,364	–
Эргэн төлөлт	(45,766)	(1)
Мөнгөн бус гүйлгээ		
Ханшийн тэгшитгэлийн цэвэр алдагдал	581,226	67,552
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр	**5,789,508**	**4,969,684**

Тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Танилцуулга. Монголбанк (цаашид "Банк") нь Монгол Улсын Төв банк бөгөөд Үндсэн хууль, Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад холбогдох хуулиудын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. Монгол Улсын Засгийн газрын 1924 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн тогтоолоор анх байгуулагдсан.

Банк бүх үйл ажиллагаагаа Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулдаг. Монголбанкны системд орон нутгийн нийт 17 хэлтэс, салбар болоод Их Британийн Лондон хот дахь төлөөлөгчийн газар багтдаг.

Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд зааснаар Банкны үндсэн зорилго нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээл болон банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн хөгжилд тэнцвэртэй дэмжлэг үзүүлэх явдал юм.

Банк ашгийн төлөө ажилладаггүй. Төрөөс үүсгэн байгуулсан тусгай хуулийн этгээдийн хувьд Банкны үйл ажиллагааны санхүүгийн үр дүн болон хөрөнгө, өр төлбөр, өөрийн хөрөнгийн бүтэц нь Банкны үйл ажиллагаагаар тодорхойлогддог.

Банк Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн дагуу дараах үндсэн үйл ажиллагааг явуулдаг. Үүнд:

- Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах;
- Эдийн засаг дахь мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах замаар мөнгөний бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;
- Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэх ("Засгийн газар" эсвэл "Төрийн");
- Банкны үйл ажиллагаанд хяналт тавих;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах;
- Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах;
- Эцсийн зээлдүүлэгчийн үүргийг гүйцэтгэх болон дахин санхүүжилтийн системийг зохион байгуулах;
- Бусад хамтын ажиллагаа бүхий төв банкууд, олон улсын банк болон санхүүгийн байгууллагуудад Монгол Улсыг төлөөлөх;
- Санхүү, зээлтэй холбоотой бусад чиг үүргүүдийг хуульд тодорхойлсон хэм хэмжээний дагуу гүйцэтгэх.

Хуульд заасны дагуу Банк нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зорилгоор банкуудад зээл олгох, хоёрдогч зах зээл дээр үнэт цаас худалдах, худалдан авах, гадаад валют, үнэт метал худалдах, худалдан авах, дотоодын ба гадаадын зах зээл дээр үнэт метал болон энгийн металаар хийсэн дурсгалын зоосыг худалдах, Засгийн газрын үнэт цаас гаргах үйл ажиллагааг зохицуулах, Засгийн газар болон Сангийн яам (Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага) гэх мэт бусад төрийн байгууллагууд, Олон улсын байгууллагуудын дансыг Банкинд байршуулах болон өөрийн үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай бусад үйл ажиллагааг явуулдаг.

Банкны дүрмийн санг Монгол Улсын төр бүрэн эзэмшдэг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу Захирлуудын зөвлөлийн үндсэн үүрэг нь мөнгөний бодлогын зарчмыг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавих явдал юм. Түүнчлэн Банкны Ерөнхийлөгч ирэх оны орлого, зардлын жилийн төсвийг батлах, түүний биелэлт гүйцэтгэл болон тайлант жилийн ашгийн хуваарилалтын талаар тайлагнах, Банкны жилийн санхүүгийн тайланг батлах зэрэг Монгол Улсын хууль тогтоомжид заасан эрх мэдлийн хүрээнд бусад чиг үүргийг гүйцэтгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

1. БАНКНЫ ТУХАЙ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бүртгэлтэй хаяг ба үйл ажиллагаа явуулж буй байршил. Банкны бүртгэгдсэн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар 46, Бага Тойруу 3, 15160.

Банкны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн Захирлуудын зөвлөлийн шийдвэрээр баталж, хэвлэн нийтлэхийг зөвшөөрсөн.

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОГТОЛЦОО, ТАЙЛАН БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ БОЛОН ТОЛИЛУУЛГА

Тайлан бэлтгэх үндэслэл. Банкны санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэсэн.

Эдгээр санхүүгийн тайлангуудыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд илэрхийлэгддэг өрийн, өмчийн хэрэгсэл болон засгийн газрын үнэт цаас, бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд илэрхийлэгддэг санхүүгийн хөрөнгүүд, бодит үнэ цэнээр нь бүртгэдэг алт, үнэт метал, санхүүгийн үүсмэл хэрэглүүр, эрдэнэсийн сан болон үндсэн хөрөнгөөс бусдаар түүхэн өртгийн зарчмын дагуу бэлтгэж, тайлагнасан болно.

Тайлагналын мөнгөн нэгж. Санхүүгийн тайлангууд нь Банкны үйл ажиллагааны мөнгөн нэгж буюу Банкны үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг үндсэн эдийн засгийн орчны мөнгөн нэгж болох Монгол Улсын үндэсний

мөнгөн тэмдэгт “төгрөг”-өөр илэрхийлэгдсэн болно. Тодруулгад өөрөөр заагаагүй бол санхүүгийн тайлангийн дүнгүүдийг саятын орноор бүхэлчилж, толилуулав.

Санхүүгийн тайлангийн толилуулга. Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дараалаар толилуулдаг. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас дээш хугацаанд (урт хугацаанд) эргэн төлөгдөх эсвэл барагдуулах төлбөрийн талаарх шинжилгээг Тодруулга 37-д толилуулав.

Хэрэв Банк нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа тохиолдолд л санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулна. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан толилуулаагүй, аливаа нягтлан бодох бүртгэлийн стандарт, тайлбараар шаардаагүй, зөвшөөрөөгүй бол орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнахгүй.

Тасралтгүй байх зарчим. Удирдлага нь эдгээр санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк өөрийн хөрөнгийн дутагдалтай, цэвэр богино хугацаат өр төлбөртэй байсан. Банк нь үндэсний мөнгөн тэмдэгт гаргагч этгээдийн хувьд төгрөгийн хөрвөх чадварын эрсдэлд орохгүй гэж удирдлага үзэж байгаа тул Банк ирээдүйд тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхгүй байх эрсдэлд орохгүй гэдэгт удирдлага итгэлтэй байна. Өөрийн хөрөнгийн удирдлагын талаар Тодруулга 40-с харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БОЛОН ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД

2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон, Банк урьдчилж хэрэгжүүлээгүй доорх стандартууд, СТОУС-ын нэмэлт өөрчлөлтүүдээс бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг өмнөх санхүүгийн жилүүдэд тууштай хэрэгжүүлсэн.

Шинэ болон өөрчлөгдсөн стандарт, тайлбарууд

• СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт	*Бизнесийн тодорхойлолт*
• СТОУС 7, СТОУС 9 болон НББОУС 39-т орсон нэмэлт өөрчлөлт	Жишиг хүүгийн түвшний шинэчлэл
• НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт	Материаллаг байдлын тодорхойлолт
• Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	*2018 оны 3* дугаар сарын 29-нд гарсан
• СТОУС 16-д -т орсон нэмэлт өөрчлөлт	Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт

СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт: Бизнесийн тодорхойлолт

СТОУС 3 Бизнесийн нэгдэлд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр бизнес нь дор хаяж үйл ажиллагаа болон хөрөнгийн цогцдоо эцсийн бүтээгдэхүүнийг гаргах чадамжинд их хэмжээгээр нөлөөлж чадахуйц орц болон бодит үйл явцын нэгдлийг багтаасан байх ёстой. Цаашилбал, бизнес нь эцсийн бүтээгдэхүүнийг бий болгоход шаардагдах бүх орц болон процесстэйгээр оршин тогтнох шаардлагагүй болохыг тодруулсан болно. Уг нэмэлт өөрчлөлт Банкны санхүүгийн тайланд нөлөөгүй боловч Банк ирээдүйд аливаа бизнесийн нэгдэлд орох тохиолдолд нөлөөлж болзошгүй юм.

СТОУС 7, СТОУС 9 болон НББОУС 39-д орсон нэмэлт өөрчлөлтүүд: Жишиг хүүгийн түвшний шинэчлэл

СТОУС 9 ба НББОУС 39 нэмэлт өөрчлөлт, Санхүүгийн хэрэгсэл: Уг стандартын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт хэсэг нь хүүгийн жишиг шинэчлэл нөлөөлж буй бүх хеджийн хэрэгсэлд хэд хэдэн хөнгөлөлтийг үзүүлдэг. Хэрэв хүүгийн жишиг шинэчлэл хеджийн зүйл эсвэл хеджийн хэрэгслийн жишигт суурилсан мөнгөн урсгалын цаг хугацаа ба/эсвэл хэмжээнд тодорхойгүй байдал үүсгэж байвал хеджийн хэрэгсэлд нөлөөлсөн гэж үзнэ. Банкинд хүүгийн хеджийн хэрэгсэл байхгүй тул эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөхгүй.

НББОУС 1, НББОУС 8-д орсон нэмэлт өөрчлөлт: Материаллаг байдлын тодорхойлолт

Нэмэлт өөрчлөлт нь “Материаллаг”-г шинэ тодорхойлолтыг: “Тайлагнагч байгууллагын санхүүгийн тайланд аливаа мэдээллийг орхигдуулах, эсвэл буруу ташаа, тодорхой бус байдлаар илэрхийлэх нь байгууллагын санхүүгийн тайлангийн үндсэн хэрэглэгчдийн уг тайланг үндэслэн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлж болзошгүй тохиолдолд тухайн мэдээллийг материаллаг гэж үзнэ.” гэжээ. Нэмэлт өөрчлөлтүүд нь “материаллаг”-г санхүүгийн тайлангийн агуулгаар, тухайн мэдээллийн шинж чанар ба/эсвэл хэмжээгээс хамаарна гэдгийг тодорхойлсон. Мэдээллийг буруу ташаа илэрхийлэх нь үндсэн хэрэглэгчидийн гаргах шийдвэрт үндэслэлтэйгээр нөлөөлөхүйц бол үүнийг материаллаг гэж үзнэ. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь санхүүгийн тайланд нөлөөлөөгүй бөгөөд цаашид Банкинд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО БОЛОН ТОЛИЛУУЛГАД ОРСОН ӨӨРЧЛӨЛТҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Шинэ болон өөрчлөгдсөн стандарт, тайлбарууд (үргэлжлэл)

2018 оны 3 дугаар сарын 29-ний өдөр гаргасан Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Үзэл баримтлалын хүрээ нь стандарт биш бөгөөд үүнд агуулагдах ойлголтуудын аль нь ч ямар ч стандартын үзэл баримтлал, шаардлагыг үгүйсгэхгүй. Үзэл баримтлалын хүрээний зорилго нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ) -д стандарт боловсруулахад туслах, холбогдох стандарт байхгүй тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тууштай бодлого боловсруулахад туслах, бүх талуудад стандартыг ойлгож, тайлбарлахад туслах явдалд оршино. Энэ нь үзэл баримтлалын хүрээнд үндэслэн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо боловсруулсан аж ахуйн нэгжүүдэд нөлөөлнө. Шинэчилсэн үзэл баримтлалын хүрээнд зарим шинэ ойлголт, шинэчилсэн тодорхойлолт, хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шалгуурыг багтаасан бөгөөд зарим чухал ойлголтыг тодруулсан болно. Эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд нөлөөлөөгүй.

СТОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт: Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлт

2020 оны 5 дугаар сарын 28-нд НББОУСЗ нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийн тухай СТОУС 16 Түрээс- д нэмэлт, өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтүүд нь түрээслэгчдэд Ковид-19 цар тахлын шууд үр дагавраас үүдэлтэй түрээсийн хөнгөлөлтийг бүртгэх түрээсийн өөрчлөлтийн бүртгэлийн талаарх СТОУС 16-н зааврыг хэрэгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлдэг. Энэхүү хөнгөлөлтийн зорилго нь түрээслэгч нь түрээслүүлэгчээс Ковид-19-тэй холбоотой авсан түрээсийн хөнгөлөлтийг түрээсийн өөрчлөлт мөн эсэхийг үнэлэхгүй байж болох сонголтыг оруулж өгсөн. Энэ сонголтыг хийсэн түрээслэгч нь Ковид-19-тэй холбоотой түрээсийн хөнгөлөлтийг СТОУС 16-д заасан түрээсийн өөрчлөлт гэж үзээгүй үед тооцсонтой адил аргаар тооцно. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2020 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс хойших жилийн тайлангийн хугацаанд хамаарна. Эрт хэрэгжүүлж эхлэхийг зөвшөөрнө.

Банк түрээслүүлэгчийн хувьд зөвхөн нэг л түрээсийн гэрээ байгуулсан тул СТОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь Банкны санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно.

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартуд

Банкны санхүүгийн тайлангуудыг бэлтгэж гаргах өдрийн байдлаар батлагдаж гарсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартуудыг доор үзүүлэв. Банк энэхүү стандартуудыг (хэрэв Банкинд хамааралтай бол) хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдрөөс мөрдөх хандлагатай байна.

• СТОУС 17	Даатгалын гэрээ
• НББОУС 1-т орсон нэмэлт өөрчлөлт	Эргэлтийн болон эргэлтийн бус өр төлбөрийн ангилал
• СТОУС 3-т орсон нэмэлт өөрчлөлт	Үзэл баримтлалын хүрээний тайлбар
• НББОУС 16-д орсон нэмэлт өөрчлөлт	Үндсэн хөрөнгө*:* Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого
• НББОУС 37-д орсон нэмэлт өөрчлөлт	Онцгой гэрээ – Гэрээний үүрэг биелүүлэх зардал
• СТОУС 1 СТОУС-ыг анхлан хэрэгжүүлэх	Охин компани нь анхлан *хэрэгжүүлэгч*
• СТОУС 9 Санхүүгийн хэрэгсэл	Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой ‘цент тутамд 10’ тестийн хураамж
• НББОУС 41 Газар тариалан	Бодит үнэ цэнийн хэмжилтэд татвар ногдуулах

1 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжих эхэлнэ.

2 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжих эхэлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

Гадаад валютын хөрвүүлэг

Банкны үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт нь түүний үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн үндсэн орчны үндэсний мөнгөн тэмдэгт байна. Банкны үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох “Монгол төгрөг” юм.

Мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг холбогдох тайлант үеийн эцэст төгрөгийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгжид хөрвүүлж бүртгэнэ. Төлбөр тооцоо хийх болон жилийн эцсийн Төгрөгийн албан ханшид мөнгөн хөрөнгө ба өр төлбөрийг үйл ажиллагааны мөнгөн тэмдэгтэд хөрвүүлэхэд үүсэх ханшийн олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд (гадаад валютын хөрвүүлгийн ашиг, алдагдлаар) хүлээн зөвшөөрдөг.

Түүхэн өртгөөр бүртгэдэг мөнгөн бус зүйлсийг тайлант жилийн хаалтын ханшаар хөрвүүлж бүртгэхгүй. Харин өмчийн хөрөнгө оруулалт зэрэг бодит үнэ цэнэ нь гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг бодит өртгийг тодорхойлсон өдрийн ханшаар хөрвүүлж бүртгэнэ.

Санхүүгийн хэрэгсэл – гол хэмжилтийн нэр томьёо

Бодит үнэ цэнэ нь мэдээлэл бүхий холбоогүй талууд сайн дураараа хоорондоо хөрөнгө солилцох эсвэл өр төлбөр барагдуулахад бэлэн буй үнийг хэлнэ. Бодит үнэ цэнэ нь санхүүгийн хөрөнгийн хувьд идэвхтэй зах зээл дээр зарласан өнөөгийн худалдан авах үнэ, санхүүгийн өр төлбөрийн хувьд өнөөгийн худалдах үнэ болно. Идэвхтэй зах зээл гэдэг нь хөрөнгө ба өр төлбөртэй холбоотой гүйлгээ хангалттай их хэмжээгээр тогтмол хийгддэг, тэдгээрийн үнийн мэдээллийг хэдийд ч авах боломжтой байхыг хэлнэ. Санхүүгийн хэрэгслийн санал болгож байгаа үнэ нь хөрөнгийн зах зээл эсвэл бусад санхүүгийн байгууллагуудаас тогтмол нийтэд зарладаг буюу мэдээлэл нь нээлттэй олдох боломжтой ба эдгээр үнийн дагуу зах зээл дээр холбоогүй этгээдүүдийн хооронд байнгын тогтмол гүйлгээ хийгддэг тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг идэвхтэй зах зээл дээр санал болгосон гэж үздэг.

Харин зах зээлийн үнийн талаар мэдээлэл олдохгүй тохиолдолд зарим санхүүгийн хэрэглүүрийг тэдгээрийн бодит үнэ цэнийг хямдруулсан мөнгөн гүйлгээний үнэлгээний загвар эсвэл холбоогүй талуудын хооронд сүүлийн үед хийгдсэн хэлцлийн үнэ, эсвэл санхүүжигч талын санхүүгийн мэдээлэл дээр үндэслэх гэх мэт үнэлгээний бусад аргачлалыг ашиглан тооцдог. Үнэлгээний аргачлалууд нь зах зээлд тогтмол ажиглагдаагүй мэдээлэл ашиглах тохиолдолд таамаглал хийхийг шаардаж болно. Хэрэв энэ мэт таамаглалыг зохистой өөр боломжит хувилбараар өөрчилсөн тохиолдолд орлого, нийт хөрөнгө эсвэл нийт өр төлбөрийн дүнд томоохон өөрчлөлт гарч болохоор бол холбогдох тодруулгуудыг эдгээр санхүүгийн тайланд хийсэн болно.

Гүйлгээний зардлууд нь санхүүгийн хэрэглүүрийг худалдан авах, шинээр гаргах эсвэл борлуулахтай шууд холбоотой нэмэлт зардлууд юм. Нэмэлт зардал гэж гүйлгээг хийгээгүй тохиолдолд үүсэхгүй байх зардлыг хэлнэ. Гүйлгээний зардалд зуучлагч, борлуулагч (борлуулалтын үүрэг гүйцэтгэж буй ажилтнууд), зөвлөх, брокер, дилерүүдэд төлсөн хураамж шимтгэл, зохицуулах агентлаг, хөрөнгийн биржийн ногдуулсан хураамж төлбөрүүд, мөн шилжүүлгэд ногдуулсан татвар хураамжууд хамаарна. Гүйлгээний зардалд өрийн хямдруулалт болон урамшуулал, санхүүгийн зардлууд, дотоодын захиргааны буюу хадгалалтын зардлууд орохгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хорогдуулсан өртөг (ХӨ) гэдэг нь санхүүгийн хэрэглүүрийг анхлан хүлээн зөвшөөрсөн дүнгээс аливаа үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг хасаж, хуримтлагдсан хүүг нэмж, санхүүгийн хөрөнгийн хувьд үнэ цэнийн бууралттай холбоотой аливаа хасагдуулгыг хассан дүн юм. Хуримтлагдсан хүүнд хойшлогдсон гүйлгээний зардлыг анх хүлээн зөвшөөрөхөд үүссэн хорогдуулга, хугацааны эцэст төлөх дүнг үр ашигт хүүгийн аргаар тооцсон аливаа урамшуулал эсвэл хямдруулалтын дүнгийн хорогдуулалт багтана. Хуримтлагдсан купон болон хорогдуулсан урамшуулал ба хямдруулалтыг (анх хүлээн зөвшөөрөхөд хойшлогдсон шимтгэлийн хамт) оруулсан хуримтлагдсан хүүгийн орлого, хуримтлагдсан хүүгийн зардлыг тусад нь толилуулахгүй, харин санхүүгийн байдлын тайлан дахь холбогдох хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэнд оруулж толилуулна.

Үр ашигт хүүгийн арга нь хүүгийн орлого эсвэл хүүгийн зардлыг хамаарах хугацааны турш дансны үнээс тооцогдох хүүгийн түвшинг тогтмол байлгахаар (үр ашигт хүүгийн хувь) хуваарилах арга юм. Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын орлого, эсвэл гарах зарлагыг (ирээдүйн зээлийн алдагдлыг үл харгалзан) санхүүгийн хэрэгслийн хүлээгдэж буй хугацаа эсвэл зохистой бол түүнээс богино хугацааны турш хямдруулж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн цэвэр дүнг гаргаж авах хүүгийн түвшин юм.

Үр ашигт хүү нь хувьсах хүүтэй хэрэгслийн мөнгөн урсгалыг хүүг өөрчлөх дараагийн мөч хүртэл хямдруулах боловч зах зээлийн хүү рүү тохируулдаггүй бусад хувьсагчид эсвэл тухайн хэрэглүүрт тусгайлан заасан хөвөгч хүүний түвшинд зээлийн эрсдэлийг нэмж тооцсоон урамшуулал, хямдруулалтад хамаарахгүй. Эдгээр урамшуулал болон хямдруулалтыг тухайн хэрэгслийн хүлээгдэж буй нийт хугацааны туршид хорогдуулна.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоололд гэрээний талуудын хооронд төлөх эсвэл хүлээн авах бүх хураамж, шимтгэлийг оруулах бөгөөд тэдгээр нь үр ашигт хүүгийн бүрэлдэхүүн хэсэг болно. Анх хүлээн зөвшөөрөх үед зээлийн үнэ цэнийн бууралттай байсан хөрөнгүүдийн хувьд үр ашигт хүүг зээлийн эрсдэлд тохируулан гэрээний төлөлтөөс илүүтэй анх хүлээн зөвшөөрөх үеийн хүлээгдэж буй мөнгөн урсгалд үндэслэн тооцдог.

Санхүүгийн хэрэгсэл - анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт

Санхүүгийн хэрэгсэл гэж нэг байгууллагын санхүүгийн хөрөнгө, өөр нэг байгууллагын санхүүгийн өр төлбөр эсвэл өмчийн хэрэглүүрийг илэрхийлэх аливаа гэрээ хэлцлийг хэлнэ.

Хүлээн зөвшөөрөх өдөр. Санхүүгийн хэрэглүүрүүдийг Банк нь тухайн хэрэгслийн гэрээний нэг тал болсон өдөр Банкны санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Үүнд хэвийн нөхцөлтэй арилжаа буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаарддаг арилжаа орно.

Санхүүгийн хэрэгслийн анхны хэмжилт. Санхүүгийн хэрэгслийн анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн ангилал нь тэдгээрийн гэрээний нөхцөл болон уг санхүүгийн хэрэглүүрийг удирдах бизнес загварт үндэслэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (БҮЦӨАА) бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад бүх санхүүгийн хэрэглүүрүүдийг гүйлгээний зардал шингээсэн бодит үнэ цэнээр нь анхлан хэмжинэ. БҮЦӨАА-аар илэрхийлэгдэх санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба холбогдох гүйлгээний зардлыг ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод (БҮЦӨБДО) илэрхийлэгдэх өрийн хөрөнгө оруулалтыг анх хүлээн зөвшөөрсний дараа зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) санг хүлээн зөвшөөрөх ба энэ нь нягтлан бодох бүртгэлийн алдагдалд хүргэдэг. Санхүүгийн хэрэглүүрийг анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнэ нь ажил гүйлгээний үнээс ялгаатай үед Банк дор дурдсан “Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдлыг бүртгэнэ.

“Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдал. Ажил гүйлгээний үнэ нь бодит үнэ цэнээсээ ялгаатай бөгөөд бодит үнэ цэнэ нь зах зээлийн ажил гүйлгээнээс ажиглагдахуйц өгөгдөлд суурилсан үнэлгээний аргачлал ашигласан байвал Банк нь бодит үнэ цэнэ болон ажил гүйлгээний үнийн зөрүүг (Эхний өдөр”-ийн ашиг ба алдагдлаар) ашиг, алдагдлын тайланд даруй хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнийг ажиглагдахуйц бус мэдээлэл ашиглан тооцсон тохиолдолд ажил гүйлгээний үнэ болон бодит үнэ цэнийн зөрүүг зөвхөн ашигласан мэдээлэл ажиглагдахуйц болох үед эсвэл санхүүгийн хэрэглүүрийг үл хүлээн зөвшөөрөх үед л ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

i) Санхүүгийн хөрөнгө

Ангилал ба хэмжилт. Банк өөрийн бүх санхүүгийн хөрөнгөө тэдгээрийг удирдах бизнесийн загвар болон гэрээний нөхцөлд үндэслэн Хорогдуулсан өртгөөр (ХӨ) бүртгэх, Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод (БҮЦӨБДО) илэрхийлэгдэх, Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (БҮЦӨАА) бүртгэгдэх гэсэн ангиллуудын аль нэгээр ангилж, хэмжинэ. Өрийн санхүүгийн хэрэгслийн ангилал болон дараа үеийн хэмжилт нь (i) уг хөрөнгийн багцыг удирдах Банкны бизнес модель (ii) хөрөнгийн мөнгөн урсгалын онцлогоос хамаарна.

Банк санхүүгийн үүсмэл хэрэгсэл болон арилжааны үнэт цаасны багцыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилж, хэмждэг. Хэмжилт болон хүлээн зөвшөөрөлтийн нийцгүй байдлыг ихээхэн хэмжээгээр арилгаж, буруулж байгаа нөхцөлд Банк нь санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд бүртгэгдэх гэж тодорхойлж болно.

Бизнес модель. Банк санхүүгийн хөрөнгөө мөнгөн урсгал бий болгох зорилгоор хэрхэн удирдаж байгаагаар бизнес модел тодорхойлогдох ба Банкны зорилго:

(i) зөвхөн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах,

(ii) хөрөнгийн гэрээний мөнгөн урсгал болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалын аль алийг цуглуулж авах,

(iii) хэрэв (i) ба (ii)-ын аль нь ч биш бол санхүүгийн хөрөнгийг «бусад» бизнес модельд хамааруулж, БҮЦӨАА-аар хэмжинэ.

Бизнес моделийг бүлэг хөрөнгүүдийн (багцын түвшинд) хувьд тодорхойлох ба үүнийг үнэлгээ хийх өдрийн байдлаарх багц хөрөнгүүдэд Банкны зүгээс тодорхойлсон зорилгодоо хүрэхийн тулд авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаарх бүхий л нотолгоонд үндэслэн хийнэ. Банкны бизнес моделийн үнэлгээнд суурилсан санхүүгийн хөрөнгүүдийн ангиллыг тодруулга 39-с харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Мөнгөн урсгалын онцлог. Хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах эсвэл гэрээний мөнгөн урсгал болон хөрөнгийг худалдсанаас олох мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилгоор эзэмшиж буй бизнес моделийн хувьд Банк уг мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийг илэрхийлэх шалгуур (ҮТХТ шалгуур)-ыг хангаж байгаа эсэхийг үнэлнэ. Гэрээний мөнгөн урсгал нь ҮТХТ-ийн шалгуурыг давсан эсэхийг тодорхойлоход санхүүгийн үүсмэл хэрэгсэл агуулсан санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь авч үзнэ. Энэ үнэлгээг хийхдээ Банк гэрээний мөнгөн урсгал нь зээлийн гэрээний үндсэн тохиролцоогоор хийгдсэн эсэх, ялангуяа хүү нь зөвхөн зээлийн эрсдэл, мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон зээлийн бусад эрсдэл, ашгийн түвшинг багтаасан эсэхийг харгалзан үзнэ.

Мөнгөн урсгалын онцлог (үргэлжлэл). Гэрээний нөхцөлүүд нь зээлийн үндсэн нөхцөлтэй үл нийцэх эрсдэл болон тогтворгүй байдлыг агуулж байвал санхүүгийн хөрөнгийг БҮЦӨАА-аар хэмжинэ. ҮТХТ шалгуурын үнэлгээг хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрөх үед хийх бөгөөд дараа нь дахин үнэлэхгүй.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг өрийн хэрэглүүрийг санхүүгийн байдлын тайланд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-ын хасагдуулгыг хассан цэвэр дүнгээр тайлагнана. Зээлийн үүрэг болон санхүүгийн баталгааны хувьд ЗҮЦХА-ын санг санхүүгийн байдлын тайлангийн өр төлбөр хэсэгт тусад нь хүлээн зөвшөөрнө. БҮЦӨАА хэмжигдэх өрийн хэрэгслийн хувьд ЗҮЦХА-ын хасагдуулгыг хассан хорогдуулсан өртгийн цэвэр өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөгдөх бөгөөд дансны үнийн бусад өөрчлөлтийг БҮЦӨБДО-ын тайланд БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн хэрэглүүрээс үүссэн ашиг/алдагдлаар тайлагнана.

Дахин ангилал. Хөрөнгийн багцыг удирдаж байгаа бизнес модель бүхэлдээ өөрчлөгдсөн тохиолдолд санхүүгийн хэрэглүүрийг дахин ангилна. Дахин ангилал нь ирээдүйд нөлөө үзүүлэх бөгөөд бизнес модель өөрчлөгдсөний дараах хамгийн эхний тайлагналын үеийн эхнээс хэрэгжинэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт - Зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал (ЗҮЦХА)-ын хасагдуулга. Банк нь хорогдуулсан өртөг болон БҮЦӨБДО-оор бүртгэгдэх санхүүгийн өрийн хэрэгсэл болоод зээлийн үүрэг, санхүүгийн баталгааны ЗҮЦХА-г ирээдүйн төсөөлсөн нөхцөл байдалд суурилан үнэлдэг. Банк тайлант хугацаа бүрт ЗҮЦХА-г хэмжиж, зээлийн үнэ цэнийн бууралтын хасагдуулгыг тохируулдаг. ЗҮЦХА-ын хэмжилт нь дараах өгөгдлүүдийг хамруулдаг. Үүнд:

(i) олон янзын боломжит үр дүнг үнэлж тодорхойлсон зохистой, магадлалаар жигнэсэн дүн;

(ii) мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ;

(iii) тайлагналын хугацаа бүрийн эцэст өнгөрсөн үйл явдлууд, одоогийн нөхцөл байдал болон ирээдүйн эдийн засгийн нөхцөл байдлын талаарх хэт их өртөг, хүчин чармайлтгүйгээр олдох боломжтой үндэслэл бүхий бэлэн мэдээллүүд.

Банк нь анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа зээлийн чанарын өөрчлөлтөд үндэслэсэн үнэ цэнийн бууралтын дараах «3 шатлал» бүхий загварыг ашиглана:

- Шатлал 1: Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш ямар нэг үнэ цэнийн бууралтгүй санхүүгийн хөрөнгүүдийг «1 дүгээр шатлал»-т ангилна. 1 дүгээр шатлалын санхүүгийн хөрөнгүүдийн ЗҮЦХА нь тайлант өдрөөс хойш 12 сарын дотор эсвэл хэрэв түүнээс богино хугацаатай бол гэрээний дуусах хугацаа хүртэлх (12 сарын ЗҮЦХА) хугацаанд үүсч болох зээл чанаргүйдэх үйл явдлаас үүдэн гарах хүлээгдэж буй алдагдлын хэмжээтэй ижил дүнгээр хэмжигдэнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Шатлал 2: Хэрэв Банк анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш зээлийн эрсдэл нь мэдэгдэхүйц нэмэгдсэн гэдгийг тогтоовол хөрөнгийг «2 дугаар шатлал»-д шилжүүлэх бөгөөд ЗҮЦХА нь хөрөнгийн нийт хугацаанд буюу гэрээ дуусах хүртэл хүлээгдэж буй эргэн төлөлтүүдийг харгалзан (Нийт хугацааны ЗҮЦХА) үзсэн хүлээгдэж буй алдагдлын дүнгээр хэмжигдэнэ.
- Шатлал 3: Хэрэв Банк санхүүгийн хөрөнгө үнэ цэнийн бууралтад орсон гэж тодорхойлсон бол уг хөрөнгийг «3 дугаар шатлал» руу шилжүүлэх ба нийт хугацаанд хүлээгдэж буй алдагдлын дүнгээр ЗҮЦХА-г хэмжинэ.

Банкны үнэ цэнийн бууралтад орсон хөрөнгийн тодорхойлолт болон чанаргүйдлын тодорхойлолтыг Тодруулга 37-д тайлбарласан. Анх худалдан авах эсвэл шинээр гаргахад үнэ цэнийн бууралттай байсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд ЗҮЦХА-г үргэлж хөрөнгийн нийт хугацааны турш тооцсон ЗҮЦХА-ын дүнгээр хэмжинэ.

ЗҮЦХА-ыг хэмжих зорилгоор Банк макро эдийн засгийн хувьсагчдын төсөөллийг багтаасан ирээдүйг харсан, баримтаар дэмжигдэх боломжтой мэдээллүүдийг ашигладаг. Гэвч эдийн засгийн аливаа төсөөллийн адил, тэдгээрийн тохиолдох магадлал, төсөөлөл нь тодорхой бус байх өндөр боломжтой тул бодит үр дүн нь төсөөллөөс ихээхэн зөрөх магадлалтай. Тодруулга 37-д ЗҮЦХА загварт ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын техникийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тусгав.

Өөрчлөлт. Банк санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөлийг өөрчлөх эсвэл дахин тохиролцох тохиолдол гардаг. Банк нь гэрээний мөнгөн урсгалын өөрчлөлт нь мэдэгдэхүйц эсэхийг үнэлэхдээ дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд: хөрөнгийн эрсдэлийн үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхээр хүүгийн түвшний томоохон өөрчлөлт, мөнгөн нэгжийн өөрчлөлт, хөрөнгийн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц нөлөөлөх шинэ барьцаа эсвэл зээлийн сайжруулалт, зээлдэгчийн санхүүгийн хүндрэлд ороогүй байх үеийн зээлийн сунгалт гэх мэт гэрээний шинэ нөхцөл (ашгийн хуваарилалт эсвэл өмчид суурилсан өгөөж гм) байгаа эсэх.

Хэрэв өөрчлөгдсөн нөхцөлүүд нь анхны нөхцөлөөс мэдэгдэхүйц зөрүүтэй бол анхны хөрөнгийн мөнгөн урсгал хүчингүй болж, Банк анхны санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрч шинэ хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрнө. Дараа үеийн үнэ цэнийн бууралтыг тооцох зорилгоор дахин тохиролцоо хийсэн өдрийг анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр гэж үзэх ба мөн зээлийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт байгаа эсэхийг харгалзан үзнэ.

Банк нь шинэ зээл буюу өрийн хэрэгсэл нь үндсэн төлбөр болон зээлийн хүүгийн шалгуурт нийцэж байгаа эсэхийг үнэлнэ. Үл хүлээн зөвшөөрсөн анхны хөрөнгийн дансны үнэ болон мэдэгдэхүйц өөрчлөлт орсон шинэ хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү нь өмчлөгчидтэй хийсэн хөрөнгийн гүйлгээтэй холбоотойгоос биш бол уг зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Дахин тохиролцоо нь зээлдэгчийн санхүүгийн хүндрэл болон анхны тохиролцсон төлбөрөө төлөх боломжгүй байдлаас үүдсэн үед хийгдэж байгаа нөхцөлд Банк нь хөрөнгийн шинэчлэгдсэн болон анхны мөнгөн гүйлгээг харьцуулж, гэрээний өөрчлөлтийн үр дүнд хөрөнгийн эрсдэл болон өгөөж ихээхэн хэмжээгээр өөрчлөгдөж байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв эрсдэл болон өгөөж өөрчлөгдөөгүй бол өөрчлөгдсөн хөрөнгө нь анхны хөрөнгөөс мэдэгдэхүйц өөрчлөгдөөгүй гэж үзэн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхгүй. Банк өөрчлөгдсөн гэрээний мөнгөн урсгалыг анхны үр ашигт хүүгийн түвшин (эсвэл анх худалдан авах, шинээр гаргахад үнэ цэнийн бууралттай байсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлээр тохируулсан үр ашигт хүүгийн түвшин)-ээр хямдруулах замаар нийт дансны үнийг дахин тооцоолж, өөрчлөлтийн олз, гарзыг тайлант хугацааны ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үл хүлээн зөвшөөрөлт. Банк санхүүгийн хөрөнгийг дараах тохиолдолд үл хүлээн зөвшөөрнө: (а) хөрөнгийн төлбөрийг авсан эсвэл хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрх дуусгавар болсон, (б) хөрөнгөтэй холбоотой мөнгөн урсгалыг хүлээн авах эрхээ бусдад шилжүүлэн өгсөн эсвэл дараах үед хөрөнгийг дамжуулах хэлцэлд оролцсон (i) хөрөнгийг эзэмшилтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлсэн, эсвэл (ii) хөрөнгийг эзэмшилтэй холбоотой бүхий л эрсдэл болон өгөөжийг бүхэлд нь бусдад шилжүүлээгүй ч, өөртөө авч үлдээгүй буюу хяналтын эрхийг хадгалж үлдээгүй. Гэрээний нөгөө тал хөрөнгийн борлуулалтад нэмэлт хязгаарлалт хийхгүйгээр холбоогүй гуравдагч этгээдэд бүхэлд нь худалдах чадамжгүй тохиолдолд хяналтын эрхийг хадгалж үлдсэн гэж үзнэ.

ii. Санхүүгийн өр төлбөр

Хэмжилтийн ангилал. Санхүүгийн өр төлбөрийг дараахаас бусад тохиолдолд дараа үеийн хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

(i) БҮЦӨАА бүртгэгдэх санхүүгийн өр төлбөр: энэхүү ангилал нь үүсмэл хэрэглүүр, борлуулах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн өр төлбөр (богино хугацаат үнэт цаас гм), бизнесийн нэгдлийн үед худалдан авагч талын хүлээн зөвшөөрсөн болзошгүй үүрэг, анхны хүлээн зөвшөөрөлтийн үед бүртгэсэн бусад санхүүгийн өр төлбөр

(ii) Санхүүгийн баталгааны гэрээ болон зээлийн үүрэг

Үл хүлээн зөвшөөрөлт. Санхүүгийн өр төлбөрийг өр төлбөрийн үүрэг нь барагдах, цуцлагдах эсвэл дуусгавар болоход үл хүлээн зөвшөөрнө. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй гэрээгээр өр төлбөрийг сольсон эсвэл одоо байгаа өр төлбөрийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол тухайн солилцоо болон өөрчлөлтийг анхны хүлээн зөвшөөрсөн санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн анхлан хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ. Анхны санхүүгийн өр төлбөрийн дансны дүн ба төлсөн дүнгийн зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Гадаад болон үндэсний мөнгөн тэмдэгтийн хөрвөх чадварын өөрчлөлтийг мөнгөн гүйлгээний тайланд тусгах зорилгоор тодорхой хэмжээний мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай зүйлсийг оруулдаг. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд бэлэн мөнгө болон богино хугацаанд зарцуулж болох гурван сараас бага хугацаатайгаар байршуулсан хугацаатай хадгаламж, хугацаагүй хадгаламж, түүнчлэн дотоодын мөнгөн тэмдэгтээр засгийн газрын байгууллагууд болон дотоодын банкуудад байршуулсан хугацаагүй хадгаламжууд орно. Тодруулга 16-г харна уу. Зарцуулалтад хязгаарлалт хийсэн эсвэл хөрвөх чадвар муутайгаас шууд мөнгөнд хөрвөдөггүй санхүүгийн хөрөнгийг мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд оруулаагүй. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг (i) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа ба гэрээний мөнгөн урсгал нь үр ашигт хүүгийн аргыг ашиглан ҮТХТ-г илэрхийлж байгаа, (ii) БҮЦӨАА-аар илэрхийлэгдээгүй тул хорогдуулсан өртгөөр бүртгэдэг.

Алт, үнэт метал

Олон улсын стандартад нийцсэн алт, үнэт металыг гадаадын банкинд биет болон биет бус хэлбэрээр хадгалдаг. Байршуулсан алт нь гадаад валютын нөөцийн нэг хэсгийг илэрхийлнэ. Алтыг трой унцаар хэмжиж бүртгэх ба Банкнаас зарласан албан ханшийн дагуу төгрөгөөр үнэлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Алтны албан ханш нь Лондонгийн Алтны захын Холбооноос зарласан үнэт металын ам.долларын ханшийг (тогтмол) Банкнаас зарласан төгрөг-ам.долларын харьцах албан ханшаар төгрөгт хөрвүүлснээр илэрхийлэгддэг болно. Алтыг дээр дурдсан байдлаар ээмшихээс гадна Банк нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг алт олборлогч аж ахуйн нэгж, иргэдээс цэвэршүүлээгүй алт, мөнгийг худалдан авч гадаад зах зээлд цэвэршүүлэн худалддаг (Тодруулга 22-г харна уу).

Алтан болон мөнгөн гулдмайг бодит үнэ цэнээр нь санхүүгийн байдлын тайланд тусгах ба дахин үнэлгээг өдөр бүр хийдэг. Бодит үнэ цэнийг тогтоохдоо алт ба мөнгөний зах зээлийн үнийг харгалзан үздэг. Дахин үнэлгээний олз гарзыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрөх ба энэхүү бодит бус ашиг, алдагдлыг жилийн эцэст өөрийн хөрөнгө дэх “Үнэт металын дахин үнэлгээний нөөц сан”-д хуримтлагдсан ашиг/алдагдлаас шилжүүлдэг (Тодруулга 34-г харна уу). Бусад үнэт метал болох дурсгалын зоос, цэвэршүүлээгүй алт, мөнгө зэрэг бусад үнэт металыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь хэмждэг.

Эрдэнэсийн сан

Эрдэнэсийн сангийн тухай хууль 1994 онд анх батлагдсан. Эрдэнэсийн сангийн тухай хуулиар “Эрдэнэс” гэж түүхий эд, хайлш, химийн нэгдэл, бүтээгдэхүүн, түүх, соёлын дурсгалт зүйл зэрэг ямар ч байдалд байгаа үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ гэж заасан. Эрдэнэсийн сан үндсэн болон гүйлгээ сангаас бүрдэнэ.

Үндсэн санд Улсын их хурлын тогтоолоор “Түүх, соёлын хосгүй үнэт, дурсгалт зүйлс” гэж үзсэн үнэт зүйлс орно. Үндсэн сангийн эрдэнэсийг дотор нь байнгын хэсэг буюу худалдах, шилжүүлэхийг хориглосон зүйлс, байнгын бус хэсэг буюу урьдчилсан зөвшөөрлөөр борлуулах боломжтой зүйлс гэж ангилдаг.

Гүйлгээ санд үнэт металл боловсруулах аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн, мөн эрдэм шинжилгээний ажил, эмчилгээний хэрэгцээнд зориулан гүйлгээнд оруулах цэвэршүүлсэн болон цэвэршүүлээгүй үнэт металл, түүгээр хийсэн зоос, засч өнгөлсөн болон байгалийн төрхөөрөө байгаа эрдэнийн чулуу, сувд болон Банкны “Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам”-аар тодорхойлсон болон Банкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан эрдэнэсийн зүйл гэж үзсэн бүх зүйлс хамаарна.

Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу эрдэнэсийн санд худалдан авах, шилжүүлэн авах үнэт зүйл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Тухайн үнэт зүйлийн ач холбогдлын зэргээс хамаарч Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолттой байх,
- Үнэт зүйл нь эрдэнийн чулуу болон үнэт металаар хийгдсэн бол итгэмжлэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн сорилтын дүгнэлттэй байх, эсвэл
- Үнэт зүйлийн түүх, соёлын өндөр ач холбогдолтой болохыг батлах Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлт гэх мэт тухайн чиглэлийн мэргэжилтний тодорхойлолт, судалгааны болон бусад баримтуудтай байх.

Эрдэнэсийн санг анхлан бүртгэхдээ өртгөөр нь дараа нь бодит үнэ цэнээс нь хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмждэг. Эрдэнэсийн санг таван жилд нэг удаа дахин үнэлэх ба хэрэв хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг хэмжээгээр зөрүүтэй байх үзүүлэлт илэрсэн тохиолдолд дахин үнэлгээ хийж, хөрөнгийн дансны үнийг бодит үнэ цэнээс материаллаг зөрүүгүй байхаар тохируулна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дахин үнэлгээний нэмэгдэл нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэгдэх ба өөрийн хөрөнгө дэх "Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нөөц сан"-г нэмэгдүүлнэ. Өмнө нь ижил төрлийн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтыг ашиг, алдагдлын тайланд тусгасан бол уг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг мөн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Үүнээс гадна дахин үнэлгээний өөрчлөлт нь хөрөнгийн үнэлгээг бууруулах үед уг бууралтыг тухайн хөрөнгөд харгалзах дахин үнэлгээний нэмэгдлээс (хэрэв байвал) бууруулж, дахин үнэлгээний нэмэгдлээс давсан хэсгийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгийг худалдан борлуулах, эсвэл данснаас хасах үед тухайн хөрөнгөд харгалзах дахин үнэлгээний нөөц санг хуримтлагдсан ашиг руу шилжүүлнэ. Дахин үнэлгээний толилуулгыг Тодруулга 38-с харна уу.

Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө

Банк харилцагч банк руу мөнгө шилжүүлж, байршуулснаар бусад банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийг хүлээн зөвшөөрнө. Бусад банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийг дараах тохиолдолд хорогдуулсан өртгөөр нь бүртгэнэ: (i) гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой байршуулсан бөгөөд эдгээр мөнгөн урсгал нь хүү болон үндсэн төлөлтөөс бүрдэж буй, (ii) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар илэрхийлэгдэхгүй.

Банкууд болон бусад зээлдэгч нарт олгосон зээл, тэдгээрээс авах бусад авлага

Банк нь цааш арилжаалах зорилгогүйгээр тусгайлан заасан эсвэл тодорхойлох боломжтой хугацаанд эргүүлэн төлөгдөх нөхцөлтэйгөөр, идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй, үүсмэл бус авлагыг санхүүжүүлэх мөнгөн хөрөнгийг харилцагч банкууд болон бусад зээлдэгчдэд шилжүүлсэн үед банкууд болон бусад зээлдэгч нарт (жишээ нь Сангийн яам, байгууллагууд) олгосон зээлийг хүлээн зөвшөөрдөг.

Эдгээр зээлийн мөнгөн урсгалын онцлог нь гэрээний мөнгөн урсгалыг цуглуулж авах зорилготой бөгөөд ҮТХТ-өөс бүрдэхээс гадна зээлийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд илэрхийлэхгүй тул уг мөнгөн урсгалын онцлог болоод бизнес загварт үндэслэн Банкууд болон бусад зээлдэгч нарт олгосон зээл, тэдгээрээс авах бусад авлагыг хорогдуулсан өртгөөр ангилдаг. Үнэ цэнийн бууралтын санг ирээдүйг таамагласан хүлээгдэж буй зээлийн алдагдал ("ХЗА")-ын загвараар тооцдог. ХЗА-ын загварт ашигласан өгөгдөл, таамаглал, тооцооллын аргуудыг Тодруулга 37 болон 18-аас үзнэ үү.

Тухайн зээл болон бусад авлагыг СТОУС 13-ын шаардлагад зааснаар үндсэн зах зээлийн хэрэгсэл гэж үзсэн тохиолдолд зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэй олгосон зээл болон бусад авлагыг бүртгэхдээ анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг бүртгэхгүй. Харин зах зээлийн хүүгийн түвшнээс доогуур хүүтэй олгосон зээл болон бусад авлага нь үндсэн зах зээлийн шалгуурыг хангахгүй тохиолдолд анхны хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Холбогдох ажил гүйлгээний мөн чанар нь Банкны үндсэн чиг үүрэг болох үндэсний мөнгөн тэмдэгт болон эдийн засгийг хамгаалахад чиглэсэн (мөнгөний бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийг дэмжих болон Монгол Улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зэрэг) үйл ажиллагаатай холбоотой бол зээл ба бусад авлагыг үндсэн зах зээлийн тодорхойлолтын шаардлагыг хангасан гэж үзнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Зээлдүүлсэн үнэт цаас ба буцаан худалдан авах хэлцлүүд

Харилцагч этгээдэд зээлдэгч буцаан төлөх нөхцөлтэй олгогддог худалдах, буцаан худалдан авах гэрээг (“репо хэлцэл”) баталгаажсан санхүүгийн гүйлгээ гэж үздэг. Репо хэлцлээр худалдсан үнэт цааснуудыг санхүүгийн бүртгэлээс хасдаггүй. Харин хөрөнгө хүлээн авагч гэрээний дагуу тус хөрөнгийг борлуулах болон дахин барьцаанд тавих эрхтэй үед уг үнэт цааснуудыг “Буцаан худалдан авах авлага” гэж ангилдаг ба бусад тохиолдолд үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд дахин ангилдаггүй.

Зээлдэгчээс Банкинд эргэн төлөх нөхцөлтэй буцаан худалдах хэлцлийн (“урвуу репо хэлцэл”) дагуу худалдан авсан үнэт цаасыг гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө эсвэл дотоодын банкинд олгосон зээлийн аль тохиромжтойгоор нь бүртгэнэ. Буцаан худалдан авах болон худалдах үнийн зөрүүг хүүгийн орлого гэж хүлээн зөвшөөрөх ба үр ашигт хүүгийн аргаар репо хэлцлийн хугацааны турш хуримтлуулна. Буцаан худалдан авах болон худалдах гэрээгээр зарсан үнэт цаасны ангилалд үндэслэн Банк нь буцаан худалдан авах гэрээнүүдийг хорогдуулсан өртгөөр ангилна.

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Бизнес загвар болон мөнгөн урсгалын онцлогт үндэслэн Банк нь өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх эсвэл бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх гэж ангилна. Хэрэв өрийн үнэт цаасыг гэрээний мөнгөн урсгалыг нь цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд мөнгөн урсгал нь ҮТХТ-өөс бүрдэж байгаа, мөн нягтлан бодох бүртгэлийн зөрүүг ихээхэн хэмжээгээр багасгахын тулд бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх санхүүгийн хөрөнгө гэж бүртгэдэггүй бол өрийн үнэт цаасыг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралтын санг ирээдүйн төсөөлөлд суурилсан ЗҮЦХА-ын загвараар тооцдог, дэлгэрэнгүйг тодруулга 37-с үзнэ үү.

Хэрэв өрийн үнэт цаасыг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмшиж байгаа бөгөөд мөнгөн урсгал нь ҮТХТ-өөс бүрдэж байгаа, мөн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэхгүй бол өрийн үнэт цаасыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх өрийн хэрэглүүрээр бүртгэнэ. Эдгээр хөрөнгийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцож ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. ХЗА-ын загвараар тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Дансны үнийн бусад өөрчлөлтүүдийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Өрийн үнэт цаасыг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод өмнө нь хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан олз, гарзыг ашиг, алдагдлын тайланд шилжүүлнэ.

Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

Бэлэн мөнгө төлөх гэрээний үүрэг хариуцлага агуулаагүй болон хувьцаа гаргагчийн цэвэр хөрөнгөд эзлэх хувь оролцоо байгаа гэдгийг нотлох санхүүгийн хэрэглүүрүүд гэх мэт хувьцаа гаргагчийн хувьд өмчийн тодорхойлолтод нийцэх санхүүгийн хөрөнгийг Банкны оруулсан өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт гэж үзнэ. Энэхүү хөрөнгө оруулалтыг зөвхөн хөрөнгө оруулалтын үр ашгийг хүртэх гэхээсээ илүү стратегийн зорилгоор эзэмшдэг тул өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтуудын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, хэмждэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба уг олз, гарзыг дараа нь ашиг, алдагдлын тайланд (борлуулах үед ч) шилжүүлэхгүй. Хэрэв үнэ цэнийн бууралтын гарз үүсвэл үнэ цэнийн бусад өөрчлөлтөөс тусад нь хэмжихгүй. Ногдол ашиг нь хөрөнгө оруулалтын өгөөжөөс илүү хөрөнгө оруулалтын нөхөн төлбөрийг илэрхийлэхээс бусад тохиолдолд Банк төлбөр хүлээн авах эрхтэй болоход ногдол ашгийг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл

Санхүүгийн үүсмэл хэрэгсэлд дотоодын банкуудтай хийсэн гадаад валютын своп хэлцэл болон валютын хүүгийн своп хэлцлүүд багтана. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл нь БҮЦӨАА-аар бүртгэгдэх санхүүгийн хэрэгсэл бөгөөд бодит үнэ цэнээрээ хэмжигдэнэ. Бүх санхүүгийн үүсмэл хэрэгслийн хувьд бодит үнэ цэнэ нь эерэг бол хөрөнгөөр, сөрөг бол өр төлбөрөөр тусгана. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тухайн жилийн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Банк хейджийн бүртгэл хийдэггүй.

Бусад хөрөнгө

Бусад хөрөнгө нь авлага болон урьдчилж төлсөн зардлаас бүрдэнэ. Өрийн бичгийн авлагаас бусад авлагуудыг аккруэл сууриар бүртгэж, хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Урьдчилж төлсөн зардлыг төлбөр хийгдсэн үед хүлээн зөвшөөрч тухайн ажил үйлчилгээг бүрэн авсны дараа ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Авлагын үнэ цэнийн бууралтын санг ирээдүйг таамагласан ЗҮЦХА-ын загвараар тодорхойлно. ЗҮЦХА-ын загварыг хэмжихэд ашигласан загвар, мэдээлэл, таамаглалуудыг Тодруулга 37-с үзнэ үү.

Зарим өрийн бичгийн авлагыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлын тайланд илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгөөр бүртгэнэ. Бодит үнэ цэнийг тайлант хугацаа бүрийн зах зээлийн хүүнд үндэслэсэн хямдруулсан мөнгөн урсгалын загвараар тооцож, хэмждэг. Өрийн бичгийн зах зээлийн хүүг Монголбанкны бодлогын хүү дээр өрийн бичиг гаргагчийн зээлийн эрсдэлийн түвшинг нэмж тодорхойлсон. Тодруулга 38-с үзнэ үү.

Үлдсэн өрийн бичгийн авлагыг хорогдуулсан өртгөөр бүртгэх ба үнэ цэнийн бууралтыг ирээдүйн төсөөлөлд суурилсан ЗҮЦХА-ын загвараар тодорхойлно. Дэлгэрэнгүйг Тодруулга 37-с үзнэ үү.

Барилга байгууламж болон бусад үндсэн хөрөнгө

Барилга, байгууламжийг дор дурдсанчлан дахин үнэлэгдсэн дүнгээс хуримтлагдсан элэгдэл болон шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын зардлыг хассан дүнгээр хэмждэг.

Банк эзэмшиж буй барилга, байгууламжийг өртгөөр нь анхлан хүлээн зөвшөөрнө. Барилга, байгууламжийг дахин үнэлдэг бөгөөд дансны үнэ болон бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү байгаа эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж, баталгаажуулдаг.

Дансны үнэ дахин үнэлгээгээр нэмэгдсэн тохиолдолд нэмэгдсэн дүнгээр бусад дэлгэрэнгүй орлого хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгийн холбогдох дахин үнэлгээний санг нэмэгдүүлнэ. Тухайн хөрөнгийн өмнө үүссэн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулж буй дахин үнэлгээний хорогдлыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, өөрийн хөрөнгөд өмнө хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нөөцийн санг бууруулах ба үнэлгээний бусад бүх бууралтыг тайлант хугацааны ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийг данснаас хасах үед өөрийн хөрөнгө дэх холбогдох дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашиг эсвэл хуримтлагдсан алдагдал руу шууд шилжүүлнэ.

Банк эзэмшиж буй бусад үндсэн хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон шаардлагатай бол үнэ цэнийн бууралтын зардлыг хассан дүнгээр бүртгэнэ. Урсгал засварын зардлыг гарсан тухай бүрт нь бүртгэнэ. Барилга байгууламж, тоног төхөөрөмжийн томоохон бүрэлдэхүүн хэсгийг сольсон бол холбогдох зардлыг хөрөнгийн дансны үнэд капиталжуулж, сольсон хэсгийг данснаас хасна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Үндсэн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэхийг удирдлага тайлант хугацаа бүрийн эцэст үнэлдэг. Үнэ цэнэ буурсан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд удирдлага хөрөнгийн бодит үнэ цэнээс тухайн хөрөнгийг борлуулахтай холбоотой зардлыг хассан дүн болон түүний ашиглалтын үнэ цэнийн дүнгийн аль ихээр нь нөхөгдөх өртгийг тооцно. Дансны үнийг нөхөгдөх өртөг хүртэл бууруулж, гарзыг тухайн тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд бүртгэдэг (барилгын хувьд өөрийн хөрөнгө дэх дахин үнэлгээний сангаас хэтэрсэн тохиолдолд). Хөрөнгийн ашиглалтын үнэ цэнэ эсвэл бодит үнэ цэнээс борлуулах өртгийг хассан үнэ цэнийн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх жилүүдэд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана.

Үндсэн хөрөнгийн борлуулалтын олз, гарзыг борлуулалтаас хүлээн авсан мөнгөн дүн болон дансны үнийг харьцуулж тооцох ба тухайн тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд (үйл ажиллагааны бусад орлого, зардлын хэсэгт) бүртгэнэ.

Элэгдэл. Дуусаагүй барилгыг элэгдүүлэхгүй. Барилга болон бусад үндсэн хөрөнгийг үлдэх өртөг хүртэл тэдгээрийн ашиглалтын хугацааны турш шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

	Ашиглалтын хугацаа, жилээр
Барилга, байгууламж	6 – 60 жил
Тавилга, компьютер төхөөрөмж	3 – 20 жил

Банк ашиглаглалтын хугацаа нь дуусч байгаа хөрөнгийн үлдэх өртгийг тухайн хөрөнгийн борлуулалтаас олох боломжтой үнээс борлуулахад гарах зардлыг хассан дүнгээр тооцдог. Хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацааг тайлант хугацааны эцэс бүрт хянаж, шаардлагатай гэж үзвэл тохируулна.

Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгө нь ашиглалтын тодорхой хугацаатай бөгөөд голчлон капиталжуулсан програм хангамжуудын лицензээс бүрддэг. Худалдаж авсан компьютерын програм хангамжуудын өртөг нь тэдгээрийг худалдан авах, ашиглахад бэлэн болгох явцад гарсан зардлуудаас бүрдэнэ. Биет бус хөрөнгийг үлдэх өртөг хүртэл нь тооцсон ашиглалтын хугацаа болох 4 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө нь Монголбанкнаас 1993 оны 9 дүгээр сард гүйлгээнд гаргасан төлбөрийн хэрэгслээр ашиглагдах боломжтой цаасан болон зоосон мөнгөн тэмдэгтийг илэрхийлнэ. Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг Монголбанкнаас дотоодын банкууд болон бусад харилцагчдад бэлэн мөнгө олгох үед нэрлэсэн үнээр нь өр төлбөрөөр бүртгэдэг. Банк нь бусад банкууд болон харилцагчид бэлэн мөнгө олгох үед гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө ба зоосыг нэрлэсэн үнийн дагуу өр төлбөрөөр бүртгэдэг. Банк бэлтгэл сан болон гүйлгээ касст буй төгрөгийг гүйлгээнд гаргасан бэлэн мөнгөнд оруулж тооцдоггүй.

Төв Банкны үнэт цаас

Банкны гаргасан үнэт цаасыг бодит үнэ цэнээр нь анх бүртгэх ба дараа нь үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо үнэт цаасыг гаргах үед үүссэн хөнгөлөлт эсвэл урамшуулал болон үр ашигт хүүний нэг хэсэг болох үнэт цаас гаргалттай холбоотой зардлуудыг авч үзнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Засгийн газрын харилцах, хадгаламж

Засгийн газар болон бусад төрийн байгууллагуудын данс нь засгийн газар болон бусад харилцагчдад төлөх үүсмэл бус өр төлбөр бөгөөд үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр бүртгэгдэнэ. Засгийн газрын дансдын дийлэнх нь Олон Улсын Валютын Сан (ОУВС), Герман улсын засгийн газар (КФВ), Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэй хөтөлбөрийн хүрээнд Сангийн яамнаас авсан урт хугацаат зээлтэй холбоотой. Тодруулга 30-г харна уу.

Дотоодын банкуудын харилцах, хадгаламж

Банкинд харилцагч банкуудаас мөнгө шилжин ирэхэд дотоодын банкуудын харилцах, хадгаламжийг хүлээн зөвшөөрдөг. Үүсмэл бус өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Тодруулга 31-г харна уу.

Гадаад өр төлбөр

Гадаад өр төлбөрийг анхлан бодит үнэ цэнээр нь бүртгэх ба дараа нь үр ашигт хүүгийн аргаар тооцсон хорогдуулсан өртгөөр бүртгэнэ. Гадаад өр төлбөрийн дийлэнх хэсгийг Хятадын Ардын Банк (Хятадын Төв банк)-аас авсан зээл болон Эм Ю Эф Жи Банкаас авсан шинэ зээл бүрдүүлнэ, Тодруулга 32-г харна уу.

Болзошгүй алдагдлын нөөц сан

Энэ нь цаг хугацаа болон дүн нь тодорхойгүй санхүүгийн бус өр төлбөр юм. Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулийн дагуу, эсвэл хууль эрх зүйн дагуу үүрэг хариуцлага хүлээх болсон, мөн уг үүрэг хариуцлагыг шийдвэрлэх явцад эдийн засгийн өгөөж агуулсан зарлагын урсгал гарах өндөр магадлалтай үед, мөн энэхүү үүргийг мөнгөн дүнгээр бодитой илэрхийлэх боломжтой болсон тохиолдолд нөөц санг бүртгэнэ.

Олон Улсын Валютын Сантай хамааралтай үйл ажиллагаа

Монгол Улс болон Олон Улсын Валютын Сан (ОУВС) хоорондын харилцаанд үзүүлэх Банкны үндсэн үүргээс шалтгаалж Банк нь ОУВС-тай хамтран ажилладаг. СТОУС-ын дагуу хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтын нөхцөлийг хангасан ОУВС-ийн хөтөлбөртэй холбоотой тооцоог Банкны санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрдөг. СТОУС-ын дагуу хөрөнгө болон өр төлбөрийн тодорхойлолтод нийцэхгүй ОУВС-тай хамаарал бүхий тооцоог Банк өөрийн санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөхгүй.

ОУВС-тай холбоотой хөрөнгө ба өр төлбөрүүд

Эдгээр санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөгдсөн ОУВС-тай холбоотой хөрөнгөнд Зээлжих Тусгай Эрх (ЗТЭ)-ийн хөрөнгө багтана, Тодруулга 17-г харна уу. ОУВС-д өгөх өр төлбөрт ЗТЭ-ийн хуваарилалт бүхий өр төлбөрүүд багтана, Тодруулга 32-с лавлана уу.

ЗТЭ-ээр бүртгэгдсэн хөрөнгө, өр төлбөрүүдийг тайлант өдрийн ЗТЭ-ийн төгрөгтэй харьцах албан ханшаар хөрвүүлдэг. Төгрөгийн ЗТЭ-тэй харьцах албан ханшийг ОУВС-гийн тогтоосон ЗТЭ, ам.долларын ханшийн мэдээлэл болон Банкны тайлант хугацааны ам.доллар болон төгрөгийн албан ханшид үндэслэн тооцдог.

Монгол Улсын Засгийн газрын ОУВС-тай холбоотой хөрөнгүүд

Банк ОУВС-гийн санхүүжилтийн худалдан авалттай холбоотой ямар нэг гэрээт үүрэг, хариуцлага хүлээгээгүй тул ОУВС-тай холбоотой тодорхой хөрөнгүүд хөрөнгө ба өр төлбөр хүлээн зөвшөөрөх СТОУС-ын тодорхойлолтод нийцдэггүй. Эдгээр хөрөнгөд ОУВС-д хувь нийлүүлсэн хөрөнгө болон

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

ОУВС-аас Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрийн хүрээнд авсан зээл багтана. Банк нь Монгол Улс болон ОУВС хоорондын харилцаанд Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэдэг. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагчийн үүргийг гүйцэтгэнэ. Иймд Монгол Улсын ОУВС-аас авах авлага болон (ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө зэрэг) ОУВС-д төлөх өр төлбөрүүд нь Сангийн яамны хөрөнгө, өр төлбөр болох учир Банкны санхүүгийн тайланд тусгагдаагүй.

ОУВС-д нийлүүлсэн хувь хөрөнгө. Энэхүү хувь хөрөнгө нь тусгай төрлийн хөрөнгө бөгөөд ОУВС-гийн гишүүн орны хувьд Монгол Улсын хувь нийлүүлсэн хөрөнгийг илэрхийлнэ. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь улс орон бүрийн хувьд өөр байдаг бөгөөд эдийн засгийн хэмжээ, цар хүрээнд тулгуурлан ОУВС-гийн Удирдах зөвлөлөөс тогтоодог. Хувь нийлүүлсэн хөрөнгө гишүүн орнуудын саналын эрх, тусгай сангаас хүртэх санхүүгийн нөөцийн хязгаар болон зээлжих тусгай эрх (оруулсан хөрөнгийн хэмжээтэй нь хувь тэнцүүлэн)-д үндэслэн оролцогчийн хувь хүртэх хязгаарыг тодорхойлдог. Монгол Улсын оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дийлэнх хэсэг нь Сангийн яамнаас ОУВС-д гаргасан хүүгүй үнэт цаасаар төлөгдсөн ба ОУВС-ын №1, №2 дугаар дансуудад кредит талыг бүртгэсэн болно. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Монгол Улсын ОУВС-д оруулсан хувь хөрөнгийн үлдэгдэл 72.3 сая ЗТЭ (2019 онд 72.3 сая ЗТЭ). Сангийн яам нь өрийн бичиг гаргаж энэхүү квотын төлбөрийг хийдэг тул энэхүү дүн нь Сангийн яамны хөрөнгөөр бүртгэгдэнэ.

ОУВС-д гаргасан үнэт цаас. Энэхүү үнэт цаас нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээрх ОУВС-гийн хөрөнгө бөгөөд а дээр дурдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн төлбөрт гаргасан өрийн бичиг юм. Сангийн яам нь ОУВС-тай зээлийн эрхийн ашиглалтын талаар гэрээ байгуулсан тохиолдолд өрийн бичгээр баталгаажуулдаг.

ОУВС-ийн №1, №2 дугаар дансууд. Нийлүүлсэн хувь хөрөнгийн төлбөр, санхүүжилтийн худалдан авалт болон буцаан худалдан авалтын гүйлгээнд №1 дүгээр дансыг ашигладаг. Монгол төгрөгөөр гүйцэтгэх ажил гүйлгээнд №2 дугаар дансыг ашигладаг. Данс №1 болон №2 нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 700.6 сая төгрөгийн (2019: 673.3 сая төгрөг) үлдэгдэлтэй байна.

Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)

2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн Удирдах зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (“ӨСХ”)-ийн хүрээнд гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий өргөтгөсөн санхүүжилтийг баталсан. ӨСХ нь ОУВС-гаас Монгол Улсад олгосон жилийн 1.53% - 1.59% хүүтэй зээлийг илэрхийлнэ. Зээлийн санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-ны өдөр Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Монголбанкинд нээсэн холбогдох дансанд шилжүүлсэн.

Зээл, түүний эргэн төлөлт нь ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Монголбанк нь Сангийн яамны өмнөөс ОУВС-д зээлийн эргэн төлөлтийг төлөх ба 2028 оны 11 дүгээр сараас өмнө төлж барагдуулахаар хүлээгдэж байна. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд өгөх 3 жилийн хугацаатай өр төлбөрийн хэмжээ 157.5 сая ЗТЭ буюу 645,616 сая төгрөг (2019: 157.7 сая ЗТЭ буюу 594,794 сая төгрөг) гэж Тодруулга 30-д толилуулсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дүрмийн сан

Дүрмийн сан нь Өөрийн хөрөнгөнд багтдаг, дэлгэрэнгүйг Тодруулга 34-с харна уу.

Ерөнхий нөөцийн сан. Төв банк /Монголбанк/-ны тухай хуулиар тайлант жилийн цэвэр орлогын 40 хувийг (хамгийн багадаа) ерөнхий нөөцийн санд хуваарилах ба үлдэх хэсгийг (хамгийн ихдээ 60 хувь хүртэлх) Улсын Төсөвт шилжүүлэхийг заасан. Ерөнхий нөөцийн сан нь өмнөх жилүүдэд хуримтлуулсан, тайлант жилийн цэвэр орлогын дээр дурдсан хэсгээс бүрдэх ба Банк уг санг бүрэн захиран зарцуулах эрхтэй. Энэ санд Улсын төсөвт өмнөх жилүүдэд хуваарилсан болон цаашид хуваарилах дүнг оруулдаггүй. 2020, 2019 онуудад Банк хуримтлагдсан алдагдалтай ажилласан тул ерөнхий нөөцийн санд шилжүүлэг хийгээгүй.

Бусад нөөц сан. Бусад нөөц сан нь гадаад валют, алт, үнэт метал (мөнгө), барилга байгууламж, болон эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний сангуудаас гадна болон БҮЦӨБДО-д илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний сангаас бүрддэг. Банк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу гадаад валют, алт үнэт металын ханшийн тэгшитгэлийн бодит бус ашгийг гадаад валют болон алт, үнэт металын дахин үнэлгээний санд жил бүрийн эцэст шилжүүлдэг ба харин бодит бус алдагдлыг холбогдох сангуудаар хаадаг.

Зээлтэй холбоотой үүрэг хариуцлага

Банкинд зээлтэй холбоотой үүрэг хариуцлага байдаг ба үүнд аккредитив болон Хятадын Ардын Банк (БНХАУ-ын Төв Банк, цаашид “ХАБ” гэх) –тай байгуулсан хэлэлцээр орно. Хэлэлцээр нь ХАБ-аас Банкинд юаниар олгосон санхүүжилт болон Банкнаас ХАБ-д төгрөгөөр олгосон санхүүжилт юм (Тодруулга 35).

Тайлант хугацааны эцэс бүрт төлбөрийн үүрэг хариуцлага нь i) анхны хүлээн зөвшөөрөлтийн хорогдуулалтыг тооцоогүй төлбөрийн тооцооны үлдэгдэл дээр нэмээд ii) ЗҮЦХА-ын загвараар тодорхойлсон эрсдэлийн сангийн дүнгээр хэмжигддэг. Хэрэв дуусгавар болгоогүй төлбөрийн үүрэг хариуцлагын дүнд хураамж авдаг бол түүнийг тухайн үүргийн хүчинтэй хугацаанд харгалзуулан орлого гэж хүлээн зөвшөөрдөг.

Орлого, зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүгийн орлого, зардлыг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар илэрхийлэгддэгээс бусад өрийн хэрэгслүүдийн хувьд аккруэл суурьяр, үр ашигт хүүгийн аргаар тооцоолон бүртгэнэ. Энэ арга нь талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу төлөгдсөн эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал, урамшуулал болон хөнгөлөлтийг үр ашигт хүүгийн нэг хэсэг гэж үзэж цаг хугацааны хувьд хойшлуулах ба үр ашигт хүүгийн аргаар бодсон хүүгийн орлого эсвэл зардлаар бүртгэдэг. Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар илэрхийлэгддэг өрийн хэрэгслийн (өрийн бичиг) хүүгийн орлогыг нэрлэсэн хүүгээр тооцоолж тайлант үеийн ашиг, алдагдлын тайлангийн “Өрийн бичгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал” гэж толилуулна.

Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлыг аккруэл суурьт үндэслэн тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт үзүүлэх үйлчилгээнээс бодитоор үзүүлсэн үйлчилгээний хувь хэмжээгээр тооцож ашиг, алдагдлын тайланд бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бэлэн мөнгө хэвлэхтэй холбогдож гарсан зардлууд

Банк нь Монгол Улсын цаасан мөнгөн дэвсгэрт болон зоосон мөнгөний хэвлэлтийг удирддаг ба тэдгээрийг хэвлүүлэхтэй холбоотой урьдчилж гарсан зардлыг “Бусад хөрөнгө” дансанд бүртгэх ба хэвлэсэн мөнгөн тэмдэгтийг үйлдвэрлэгчээс Банкны үндэсний мөнгөний тэмдэгтийн нөөц санд шилжүүлэх үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Ажилчдын зардал болон холбогдох шимтгэлүүд

Цалин хөлс, түүнтэй холбоотой бусад зардлуудыг (ээлжийн амралт, өвчтэй байх үеийн нөхөн олговор, шагнал урамшуулал болон мөнгөн бус тэтгэмж гэх мэт) Банк ажилтнуудын холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд харгалзуулан зардал гэж хүлээн зөвшөөрдөг. Ээлжийн амралтын мөнгө, нөхөн олговортой бусад богино хугацаат чөлөө авалтыг ажилтнуудад ирээдүйд нөхөн олговортой чөлөө авах эрхийг үүсгэх үйлчилгээг үзүүлсэн үед, харин өвчний улмаас чөлөө авах гэх мэт нөхөн олговортой богино хугацаат чөлөө авалтыг чөлөө авсан тухайн үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

Ажилчдын тэтгэмж

Банк нь дотоод дүрэм журмын дагуу ажилтнуудынхаа ажлын нөхцөл байдлыг сайжруулах, нийгмийн халамжийн асуудлыг шийдэх үүднээс тодорхой хөрөнгийг нийгмийн хөгжлийн санд хуваарилж, хуримтлуулдаг. Эдгээр дансдыг тэтгэмж, нөхөн олговор, ажилтнуудын гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллыг олгох, ажилтнуудын нийгмийн халамжийн хүрээнд бусад хэрэгцээг хангах зорилгоор ашигладаг.

Удирдлага нь 2019 оны 12 дугаар сарын 31 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Нийгмийн хөгжлийн сангийн дүн нь эдгээр богино болон урт хугацаат төлбөрүүдийг төлөх бүрэн боломжтой, мөн хүлээн зөвшөөрсөн тусламж, тэтгэмжийн өр төлбөр нь тухайн тайлант өдрөөр тусламж тэтгэмжийн үүргүүдийн өнөөгийн үнэ цэнээс хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа үнэлгээний тооцоо (актуар)-ны олз, гарз болон гарсан үйлчилгээний зардлыг хассан дүнгээс материаллаг хэмжээгээр зөрөхгүй гэж үзэж байна.

Орлогын албан татвар

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу Банк нь орлогын албан татвар төлөгч биш.

Холбоотой талуудын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон аж ахуйн нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(a) Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- (i) Банкинд дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Банкинд томоохон нөлөөлөлтэй эсвэл;
- (iii) Банкны гол удирдах албан тушаалтнуудын нэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

(б) Дараах нөхцөлүүдийн аль нэгийг хангасан байгууллага нь Банкны холбоотой тал гэж үзнэ. Үүнд:

(i) Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд;

(ii) Нэг нь нөгөө байгууллагын хараат эсвэл хамтын хэлэлцээрт байгууллага байх;

(iii) Аль аль байгууллага нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт талууд байх;

(iv) Нэг байгууллага нь гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт байгууллага бөгөөд нөгөө байгууллага нь уг гуравдагч этгээдийн хараат байгууллага байх;

(v) Байгууллага нь Банкны эсвэл Банктай холбоотой талын ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Банк нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Банктай холбоотой тал болно.

(vi) (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон байгууллага;

(vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн нь байгууллагад ихээхэн нөлөөлөлтэй эсвэл уг байгууллагын гол удирдах албан тушаалтнуудын нэг;

(viii) Банкийг гол удирдах албан тушаалтнаар хангадаг байгууллага.

Холбоотой талуудын боломжит бүх хамаарлыг авч үзэхдээ зөвхөн хуулийн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан болно. Холбоотой талуудтай хийсэн бүх материаллаг ажил гүйлгээ болон үлдэгдлийг санхүүгийн тайланд толилуулсан ба дэлгэрэнгүйг Тодруулга 36-с харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. НЯГТЛАН БОДОХ БҮРГГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ БОЛОН ТӨСӨӨЛЛҮҮД

Банк санхүүгийн тайлангийн дүнгүүд болон дараагийн тайлант жилийн хөрөнгө, өр төлбөрт нөлөөлөхүйц таамаглал, үнэлэмжийг хийдэг. Удирдлага нь өөрсдийн туршлага болон ирээдүйн үйл явдлын талаарх нөхцөл байдалд зохистой гэж үзсэн үнэлэлт, таамаглал зэрэг бусад хүчин зүйлүүдэд суурилан тооцооллыг тогтмол хянадаг. Мөн удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэх явцад ач холбогдол бүхий тооцооллуудаас гадна тодорхой үнэлэмжүүдийг хийдэг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүнгүүдэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх үнэлэмжүүд болон дараагийн тайлант жилд хөрөнгө, өр төлбөрийн дүнгүүдэд томоохон тохируулга хийх шаардлага үүсэж болох ба үүнд дараах зүйлс хамаарна.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт. СТОУС9-ийн дагуу бүх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тооцоход үнэлэмж шаардагддаг. Ялангуяа ирээдүйн мөнгөн урсгалын дүн болон хугацаа, барьцаа хөрөнгийн үнэлгээ мөн зээлийн эрсдэлийн томоохон өөрчлөлтийг тодорхойлоход үнэлэмж шаарддаг. Эдгээр тооцоолол нь хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж болох бөгөөд эдгээрийн өөрчлөлт нь өөр өөр түвшний үнэ цэнийн бууралтын үр дүнд хүргэж болно.

Банкны зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдлын (ЗҮЦХА) тооцоолол нь хувьсах өгөгдөл болон тэдгээрийн харилцан хамаарлыг сонгоход ашигласан олон төсөөллүүдээс бүрдсэн цогц загварын үр дүн юм. ЗҮЦХА загварын элементүүд нь доорх нягтлан бодох бүртгэлийн үнэлэмж болон тооцооллыг шингээсэн байна:

- Үнэлгээ бүрт ашиглах чанаргүйдлийн магадлалыг (ЧМ) тодорхойлдог Банкны дотоод зээлийн үнэлгээний загвар
- Банкны шатлалын үнэлгээ
- Банкны санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр ихэссэнийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд хийгээд үүний үр дүнд санхүүгийн хөрөнгүүдийн нөөц санг нийт хугацааны ЗҮЦХА болон чанарын үнэлгээ ашиглан тооцох
- Өгөгдлүүдийн сонголт болон томьёонуудыг ашиглан ЗҮЦХА загварын хөгжүүлэлт
- ЗҮЦХА загварын ЧМ-ыг тооцоход ашиглах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлох макро эдийн засгийн хувилбаруудын болон эдийн засгийн өгөгдлүүдийн харилцан холбоо хамаарлыг тодорхойлох, ирээдүйг төсөөлсөн макро эдийн засгийн хувилбаруудын сонголт, тэдгээрийн жигнэсэн дундаж магадлалыг тодорхойлох
- Барьцаа хөрөнгөөр баталгаажсан санхүүгийн хөрөнгийн хувьд Чанаргүйдэлд өртөх дүн (ЧӨД)-г тооцоолохын тулд барьцаа хөрөнгийн үл нөхөгдөх дүнг тодорхойлох
- Ковид-19 цар тахлын нөлөөг тусгасан эсэхийг харгалзан ЗҮЦХА загварыг дахин үнэлэх.

Банк нь хорогдуулсан өртгөөр болон бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэгдэх гэж ангилсан бүхий л өрийн үнэт цаасанд ЗҮЦХА-ын хэмжилтийг хийдэг ба хүлээгдэж буй зээлийн алдагдлын тооцоолол болон бодит зээлийн алдагдлын хоорондын зөрүүг багасгах үүднээс модель болон түүнд ашигласан өгөгдлүүдийг байнга хянаж үздэг. Тодруулга 37-г харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ БОЛОН ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнэ. Банк гадаад валютын урсгалын нэмэгдүүлэх, хүүгийн түвшин болон гадаад валютын зээлийн хэмжээг бууруулах, гадаад валютын ханшийн өсөлтийн эрсдэлийг саармагжуулах гэх мэт бодлогын шинж чанартай авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хүрээнд ихэвчлэн дотоодын банкуудтай санхүүгийн үүсмэл хэрэгслийн хэлцлүүдийг тогтмол хийдэг. Эдгээр үүсмэл хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь хэмждэг.

2014 оны эхний улирлаас эхлэн Банк нь дотоодын банкуудтай урт хугацааны своп хэлцлүүдийг хийж эхэлсэн. Эдгээр нь 2 - 5 хүртэлх жилийн хугацаатай урт хугацаат төгрөг/ам.долларын своп хэлцлүүд юм. Түүнчлэн 2017 оны 12 дугаар сараас хойш Банк дотоодын банкуудтай шинэ төрлийн урт хугацаат, хүүгийн своп хэлцлүүдийг хийж эхэлсэн. Эдгээр нь 1 - 8 жилийн хугацаатай хүүгийн загварт суурилсан төгрөг-ам.долларын своп хэлцлүүд юм.

Дээрх хэлцлүүдийн форвард ханшийг Мөнгөний Бодлогын Газраас эконометрик загвар ашигласан үнэлгээний аргачлалаар тооцоолсон. Дээрх урт хугацаат хэрэгслүүдийн үнийн талаар зах зээлийн хангалттай мэдээлэл байдаггүй. Удирдлага эконометрик загвар ашиглан форвард ханшийг тооцоолох нь хүүгийн загварт суурилсан томьёог ашигласнаас илүү оновчтой гэж үзсэн. Ажиглагдахуйц зах зээлийн мэдээлэлд үндэслээгүй төсөөлөл ашиглан үнэлсэн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг Тодруулга 38-с үзнэ үү.

Удирдлага дээрх санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэх эсэхийг харгалзан үзсэн ба хэлцлүүд зах зээлд оролцогчдын хувьд сайн дурын үндсэн дээр явагдсан тул олз гарз үүсэхгүй гэж үзсэн. Мөн тус үнэлэмжийг хийхдээ эдгээр хэрэглүүрийн үндсэн зах зээлийг илэрхийлж байна гэж удирдлага үзсэн.

Өрийн бичгийн бодит үнэ цэнэ. Банк нь тодорхой томоохон хэдэн харилцагчдад жилийн 21 хувийн хүүтэй, тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд зээлийн хүүг жилийн 7 - 8 хувь хүртэл бууруулах нөхцөлтэй зээлийг тэдний гаргасан өрийн бичгийг худалдан авах замаар олгосон ба 2014 онд 350,000 сая төгрөг, 2016 онд 465,000 сая төгрөгийг тус тус санхүүжүүлсэн. Өрийн бичиг нь БҮЦӨАА-аар бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр ангилагдсан.

Удирдлага өрийн бичгийн бодит үнэ цэнийг хямдруулсан мөнгөн урсгалын загвараар тооцдог. Бодит үнэ цэнийн тооцоололд холбогдох боломжит мэдээлэлд үндэслэн дараах үнэлэмжүүдийг ашигласан. Үүнд:

- Ирээдүйн мөнгөн урсгалын магадлал: Удирдлага ирээдүйн мөнгөн урсгалын магадлалыг өрийн бичиг гаргагчийн санхүүгийн түүхэн мэдээлэлд үндэслэл үнэлсэн ба зарим өрийн бичгийн эргэн төлөлт хугацаандаа бүрэн хийгдэнэ гэж үзсэн.
- Хямдруулалтын хүүгийн түвшин: Банкны бодлогын хүү дээр харилцагчийн зээлийн эрсдэл болох 2%-11.8% (2019: 2%-14.5%) нэмж тооцсон ба энэ нь компаниудын үйл ажиллагааны цар хүрээ, шинж чанар болон хүү төлөх чадварын харьцааг харгалзан үнэлсэн эрсдэлээс хамаарч олгох төгрөгийн санхүүжилтийн зах зээлийн хүүний түвшинг ойролцоогоор илэрхийлнэ гэж үзсэн.

Ажиглагдахуйц зах зээлийн мэдээлэлд үндэслээгүй төсөөлөл ашиглан үнэлсэн өрийн бичгийн бодит үнэ цэнийн талаарх мэдээллийг Тодруулга 38-с үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

5. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ, ТООЦООЛОЛ БОЛОН ТӨСӨӨЛЛҮҮД (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрдэнэсийн сан

Хүлээн зөвшөөрөлт. Монгол Улсын Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Банк нь Эрдэнэсийн сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулах эрхтэй цор ганц байгууллага юм. Эрдэнэсийн сан нь түүх, соёлын хосгүй үнэт, дурсгалт зүйлс, 1925 онд гаргасан мөнгөн зоос зэргээс бүрддэг. Эрдэнэсийн сангийн үнэт зүйлсийг музейд тавих, үзэсгэлэн гаргах байдлаар олон нийтэд танилцуулдаг бөгөөд музейн тасалбараас олсон орлогыг Банкны ашиг, алдагдлын тайланд үйл ажиллагааны бусад орлого дансанд бүртгэдэг. Банкны Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааг, тэдгээрийн засвар үйлчилгээ, харуул хамгаалалтыг удирдан зохион байгуулж, хариуцдаг.

Банк нь Эрдэнэсийн сангийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн тайлбартай холбогдуулан мэргэжлийн хуульчаас хуулийн зөвлөгөө авсны үндсэн дээр удирдлага нь эрдэнэсийн санг Банкны санхүүгийн байдлын тайланд хөрөнгөөр бүртгэх нь зүйтэй гэж үзсэн. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Банк эрдэнэсийн санг удирддаг ба уг сангийн эдийн засгийн үр өгөөжийг Банк хүртдэг гэж үзсэн нь энэхүү хуулийн тайлбарт нөлөөлсөн гол үндэслэл юм.

Хэмжилт. Тодруулга 4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд-д толилуулснаар Эрдэнэсийн санг анхлан бүртгэхдээ өртгөөр нь дараа нь бодит үнэ цэнээс нь хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр хэмжинэ. Банк Эрдэнэсийн сангийн бодит үнэ цэнийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний компанийн бэлтгэсэн тайланд үндэслэн тодорхойлдог. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Эрдэнэсийн сан нь 1,071,665 сая төгрөгийн (2019 онд 1,068,860 сая төгрөг) үлдэгдэлтэй байна. Эрдэнэсийн сангийн бодит үнэ цэнийг 3 дугаар түвшинд ангилсан ба энэ түвшний бодит үнэ цэнийн тооцоолол ажиглагдахуйц бус зах зээлийн мэдээлэлд суурилж, удирдлагаас ихээхэн хэмжээний үнэлэмж шаардаг. Бодит үнэ цэнийн хэмжилтийн дэлгэрэнгүйг Тодруулга 38-с харна уу.

6. ХҮҮ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Үр ашигт хүүгийн аргачлалаар тооцсон хүүгийн орлого		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод тайлагнах болон хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн үнэт цаас	161,561	157,048
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	27,474	87,080
Урвуу буцаан худалдан авах гэрээ	19,041	45,645
Дотоодын банкуудад олгосон зээл	13,063	14,933
Засгийн газрын үнэт цаас	13,223	11,732
	234,362	316,438
Бусад хүү, түүнтэй адилтгах орлого		
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдлын тайланд бүртгэх бусад хөрөнгө	42,810	46,247
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	417,690	361,633
	460,500	407,880
	694,862	724,318

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

7. ХҮҮ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Үр ашигт хүүгийн аргачлалаар тооцсон хүүгийн зардал		
Төв банкны үнэт цаас	465,875	514,534
Гадаад өр төлбөр	253,217	250,319
Дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон хүү (Тод.31)	52,378	76,035
Засгийн газрын хөрөнгө	27,297	60,820
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	15,377	11,870
Бусад хүүгийн зардал	2,267	1,041
	816,411	914,619
Бусад хүү болон түүнтэй адилтгах зардал		
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	279,419	267,701
	1,095,830	1,182,320

8. АЛТ, ҮНЭТ МЕТАЛЫН АРИЛЖААНЫ БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ЦЭВЭР АШИГ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Мөнгөжсөн алт, үнэт металын арилжааны цэвэр ашиг	688,344	81,328
Алт цэвэршүүлэлтийн зөрүүнээс үүссэн цэвэр ашиг	39,971	35,639
Мөнгөжсөн алтны дахин үнэлгээний бодит бус ашиг, цэвэр (Тод.22)	151,293	382,855
	879,608	499,822

9. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЛИЙН ЦЭВЭР АЛДАГДАЛ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит алдагдал, цэвэр	(520,009)	(91,360)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит бус ашиг/(алдагдал), цэвэр	138,813	(136,512)
	(381,196)	(227,872)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

10. ГАДААД ВАЛЮТЫН АРИЛЖААНЫ БОЛОН ХАНШИЙН ТЭГШИТГЭЛИЙН ЦЭВЭР (АЛДАГДАЛ)/АШИГ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит бус (алдагдал)/ашиг, цэвэр	(584,891)	13,541
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн бодит ашиг, цэвэр	127,157	71,705
Гадаад валют арилжааны (алдагдал)/ашиг, цэвэр	(1,356)	89
	(459,090)	85,335

11. САНХҮҮГИЙН ХӨРӨНГИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДАЛ

Санхүүгийн хөрөнгүүдийн тайлант жилийн ашиг алдагдлын тайланд бүртгэгдсэн ЗҮЦХА-ын алдагдал/(буцаалт):

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Бусад санхүүгийн хөрөнгө (Тод.26)	36,287	7,175
Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт (Тод.19)	31,128	5,298
Дотоодын банкуудад олгосон зээл (Тод.18)	8,679	2,726
Засгийн газрын үнэт цаас (Тод.25)	3,635	(611)
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө (Тод.17)	1,687	(141)
Урвуу буцаан худалдан авах хэлцэл (Тод.21)	(61)	74
	81,355	14,521

12. ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРИЛЖААНЫ АШИГ

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны цэвэр ашиг/(алдагдал) нь хөрөнгийг борлуулах болон хугацаа дуусгавар болох үед дахин үнэлгээний нөөцөөс ашиг, алдагдлын тайлан руу шилжүүлсэн бодит ашиг, алдагдлын зөрүүг илэрхийлнэ.

	2020 Сая.төг	2019 Сая.төг
БҮЦӨБДО тайланд бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны цэвэр ашиг/ (алдагдал)	3,262	(3,833)
Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын арилжааны цэвэр алдагдал	(84)	–
БҮЦӨАА тайлан бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын борлуулсны болон арилжсаны цэвэр (алдагдал)/ашиг	(7)	4,604
	3,171	771

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

13. ӨРИЙН БИЧГИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АЛДАГДАЛ

Өрийн бичгийн бодит үнэ цэнийн алдагдал 27,507 сая төгрөг (2019 онд 88,524 сая төгрөгийн алдагдал) нь зөвхөн БҮЦӨАА тайланд илэрхийлэгдэх өрийн бичгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг илэрхийлнэ.

14. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ОРЛОГО

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Шимтгэлийн орлого	17,472	14,018
Торгуулийн орлого	9,917	12,175
Үндсэн хөрөнгийн түрээсийн орлого	575	580
Бусад орлого	1,659	2,074
	29,623	28,847

15. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН БУСАД ЗАРДАЛ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Цалин, урамшууллын зардал	23,310	20,231
Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх зардал	15,549	11,527
Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдол (Тод.27)	6,090	4,793
Алтны санхүүжилттэй холбоотой зардал	5,501	1,329
Алт тээвэрлэлт, ачилтын зардал	2,596	1,557
Харилцаа холбоо, ашиглалтын зардал	2,034	1,823
Харуул хамгаалалтын зардал	1,657	1,382
Системийн засварын зардал	1,008	860
Зар сурталчилгааны зардал	864	1,054
Гишүүнчлэл болон мэргэжлийн үйлчилгээний зардал	787	658
Үндсэн хөрөнгийн засварын зардал	684	308
Тээврийн болон албан томилолтын зардал	629	1,305
Сургалтын зардал	209	463
Хуулийн үйлчилгээний зардал	56	813
Борлуулах зорилготой үндсэн хөрөнгө борлуулсны гарз	–	1,144
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	5	70
Бусад зардал	4,485	6,418
	65,464	55,735

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

16. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Бэлэн мөнгө	233,373	214,244
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө (Тод.17)		
- Гадаад валютын богино хугацаат хадгаламж	3,509,327	3,553,803
- Хугацаагүй хадгаламж	878,068	769,362
- Зээлжих тусгай эрх	131,503	135,171
Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоорх нийт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4,752,271	4,672,580

Дээрх дүнгүүдийг мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө гэж тайлагнасан.

17. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Гадаад валютын богино хугацаат хадгаламж	3,509,327	3,553,803
Хугацаагүй хадгаламж	878,068	769,362
Зээлжих тусгай эрх	131,503	135,171
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	179	172
Бусад хувь хөрөнгө	13	11
Нийт дүн	4,519,090	4,458,519
Хасах нь:Үнэ цэнийн бууралтын сан	(1,698)	(11)
Цэвэр дүн	4,517,392	4,458,508

Богино хугацаат хадгаламж. нь Гадаадын төв банкууд, бусад санхүүгийн байгууллагад байршуулсан 29 хүртэлх хоногийн хугацаатай (2019: 84 хоног) ам.доллар, фунт, юаны богино хугацаат хадгаламж болно.

Хугацаагүй хадгаламж. Гадаадын төв банкууд, бусад санхүүгийн байгууллага дахь харилцах дансдын үлдэгдлийг илэрхийлнэ.

Зээлжих тусгай эрх (ЗТЭ). ОУВС-д Монгол Улсаас төлөх хувь хэмжээтэй холбоотой нөөцийн хөрөнгийг нөхөх зээлжих тусгай эрхийн хадгаламжийг илэрхийлнэ. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 35.8 сая ЗТЭ (2019 онд 35.8 сая ЗТЭ) байсан бөгөөд хүү тооцогддог.

Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Дэлхийн банкны гишүүнчлэлийн нөхцөлийн дагуу байршуулсан хадгаламж болон түүнд оруулсан хувь хөрөнгө юм. Энэ дүн нь харгалзах өр төлбөрийн дүнтэй таарч байгаа ба хүү тооцдоггүй (Тодруулга 32). Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банк болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул энэ хөрөнгөнд үнэ цэнийн бууралт үүсэхгүй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

17. ГАДААДЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДАД БАЙРШУУЛСАН ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад хувь хөрөнгө. Энэ үлдэгдэл нь Монгол улс СВИФТ сүлжээнд нэгдэн орох үед төлсөн хураамжтай холбоотой.

Гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд ЗҮЦХА-г хэмжих зорилгоор 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх гадаадын банкуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийн үлдэгдлийг зээлийн эрсдэлийн чанарыг харуулав. Бүх үлдэгдэл нь эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан байгаа тул 1 дүгээр шатлалд багтсан. Банкны зээлийн эрсдэлийн чанарын үнэлгээний тайлбарын талаар болон ЗҮЦХА-ын хэмжилтийн аргачлалыг мөн гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн үлдэгдэлд хамаарах чанаргүйдэл болон зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн тодорхойлолтыг Тодруулга 37-с үзнэ үү.

Гадаадын байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламжийн үнэ цэнийн бууралтын сан **(үргэлжлэл)**

Доорх хүснэгтэд гадаадын банкуудад байршуулсан хөрөнгийн 2020 болон 2019 онуудын ЗҮЦХА-ын сангийн тохируулгыг харуулав.

	12 сарын ЧМ	Гадаад валютын богино хугацааны хадгаламж	Хугацаагүй хадгаламж	Зээлжих тусгай эрх	Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	Бусад хувь хөрөнгө	Нийт
		Сая.төг	Сая.төг	Сая.төг	Сая.төг	Сая.төг	Сая.төг
2020 оны 12 сарын 31							
-Онц сайн	0%-0.06%	3,509,327	878,068	131,503	179	13	4,519,090
Нийт дүн		3,509,327	878,068	131,503	179	13	4,519,090
(-) ЗҮЦХА-ын сан		(1,677)	(21)	–	–	–	(1,698)
Цэвэр дүн		3,507,650	878,047	131,503	179	13	4,517,392
2019 оны 12 сарын 31							
-Онц сайн	0%-0.06%	3,553,803	769,362	135,171	172	11	4,458,519
Нийт дүн		3,553,803	769,362	135,171	172	11	4,458,519
(-) ЗҮЦХА-ын сан		–	(11)	–	–	–	(11)
Цэвэр дүн		3,553,803	769,351	135,171	172	11	4,458,508

Үнэ цэнийн бууралтын сангийн хөдөлгөөн:

	2020	2019
	Сая.төг	Сая.төг
1-р сарын 1-ний өдрөөр	11	152
Тайлант жилийн үнэ цэнийн бууралтын алдагдал/(буцаалт) (Тод.11)	1,687	(141)
12-р сарын 31-ний өдрөөр	1,698	11

ОУВС-ын зээлжих тусгай эрх, Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө болон бусад хувь хөрөнгө Банкыг зээлийн эрсдэлд оруулахгүй бөгөөд энэхүү хөрөнгө эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын Төв банкууд болон бусад нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудад байршуулсан тул бүрэн эргэн төлөгдөнө гэж үзэж байна. Эдгээр хөрөнгийн аль нь ч барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй. Газар зүйн байршлын шинжилгээ, валютын ханшийн эрсдэл, хүүгийн эрсдэл болон дуусгавар хугацааны шинжилгээг Тодруулга 37-с үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Үнэ тогтворжуулах дэд хөтөлбөрийн зээл	383,799	442,104
Бусад зээл	93,960	8,580
Нийт дүн	477,759	450,684
Хасах нь:Үнэ цэнийн бууралтын сан	(16,445)	(7,766)
Хорогдуулсан өртгөөрх дотоодын банкуудад олгосон зээл	461,314	442,918

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл

2012 оны 11 дүгээр сараас Банк нь засгийн газартай хамтран хэрэгжүүлсэн үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд тодорхой салбаруудын (шатахуун, хүнс, барилга гэх мэт) дотоодын компаниудад дамжуулан зээлдүүлэх зорилгоор төгрөгийн зээлийг дотоодын банкуудад олгосон. Эдгээр зээлүүд засгийн газрын хамтарсан шийдвэрээр тодорхойлсон нөхцөлийн дагуу олгогдсон бөгөөд Банкны зүгээс нөхцөлийг тогтоох эрх мэдэл байгаагүй. Мөн энэхүү хөтөлбөрт хамрагдах компаниудыг засгийн газар тодорхойлсон бөгөөд зээл олгох шийдвэр гаргасан тохиолдолд дотоодын банкууд Банкнаас санхүүжилтийг нэхэмжлэн авч, компаниудад дамжуулан олгосон.

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл (үргэлжлэл). Үүний үр дүнд дотоодын банкуудад олгосон зээлийн хүүгийн түвшин нь жилийн 0.89%-4% байх боломжийг Засгийн газар бүрдүүлсэн. Удирдлага дээрх санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхөд олз, гарз үүсэх эсэхийг харгалзан үзсэн. Энэхүү зээл нь Төв банкны үндсэн үүрэг болох мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, инфляцыг тогтворжуулах зорилгын хүрээнд зах зээлд мөнгөний нийлүүлэлтийг хийсэн бөгөөд зээлүүд тусдаа зах зээлийн сегментийн гүйлгээ (жишээ нь үндсэн зах зээл) мөн болохыг удирдлага харгалзан үзсэн ба эдгээр зээлийг анх хүлээн зөвшөөрөх үед ямар нэгэн алдагдал, олзыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж дүгнэсэн.

Банк нь Засгийн газар, Монголын ипотекийн корпорац (МИК) болон дотоодын банкуудтай байгуулсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн эх үүсвэрийн гэрээ”-ний дагуу дотоодын банкуудад Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн төлбөрийн дүнд давуу эрхтэй “Ипотекийн зээлээр баталгаажсан бонд” (ИЗББ) авсан.

Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон зээлийн үлдэгдэл нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 383,799 сая төгрөг (2019 онд 442,104 сая төгрөг) байна. Банкнаас дотоодын банкуудад олгосон ипотекийн зээлийн санхүүжилт жилийн 1%-4% хүүтэй.

2020 онд батлагдсан “Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн хүрээнд Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон Монголбанкны Ерөнхийлөгчийн А-428а тушаалын дагуу иргэдийн санхүүгийн дарамтыг хөнгөлөх зорилгоор Банк дотоодын банкуудад олгосон орон сууцны зээлийн санхүүжилтийн хүүг 2020 оны 11 дүгээр сарын 25-наас эхлэн 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд зогсоосон. Үүнийг зээлийн гэрээний өөрчлөлтөд тооцогдох ба удирдлага холбогдох зээлийн хүү зогсоосон хугацаанд хүлээх алдагдлыг тооцоолж, санхүүгийн тайланд материаллаг нөлөөгүй гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бусад зээл

Төгрөгөөр олгосон зээл. Бусад зээлийн нэг хэсэг болох төгрөгөөр олгосон зээлд АХБ-ны дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 3,088 сая төгрөгийн (2019 онд 2,020 сая төгрөг) зээл, Герман Улсын засгийн газрын (КФВ) дэмжлэгтэйгээр дотоодын банкуудад олгосон 11,944 сая төгрөгийн (2019 онд 5,498 сая төгрөг) зээл, Алт-2 үндэсний хөтөлбөрийн хүрээнд банкуудад олгосон 72,828 сая төгрөгийн (2019: 0 төг) зээл болон 6,101 сая төгрөгийн (2019: 0 төг) барьцаат зээлүүд багтаж байна.

АХБ-ны зээлийг ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон. АХБ-ны ажлын байр нэмэгдүүлэх төсөлтэй холбоотой зээл нь үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинэ ажлын байрыг бий болгох зорилготой. зээл нь жилийн 7 хувь (2019 онд жилийн 7-хувь)-ийн хүүтэй бөгөөд эргэн төлөлтийн хугацаа олгосон өдрөөс хамаарч ялгаатай байгаа болно.

Монгол Улсын жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгоор дотоодын банкуудаар дамжуулан олгосон зээл нь КФВ-ын I болон II хөтөлбөрүүдээр дамжин хэрэгждэг. Зээлийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкин дахь данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор баталсан “Алт-2 үндэсний хөтөлбөр”, 2020 онд батлагдсан Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Их хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын хүрээнд Банк нь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алт олборлогч аж ахуй нэгжүүдэд дотоодын банкуудаар дамжуулан эргэлтийн хөрөнгийн зээл олгож эхэлсэн. Зээлийн жилийн хүү бодлогын үү дээр 3% нэмсэнтэй тэнцэх ба 24 сар хүртэлх хугацаатай. Санхүүжилтийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Монголбанкин дахь харилцах данснаас хөрөнгийг шууд татах эрхтэй.

Гадаад валютын зээл. “Бусад зээл”-ийн нөгөө хэсэг болох гадаад валютаар олгосон зээлийн дийлэнх хувийг Герман Улсын засгийн газрын (КФВ) Монгол Улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дотоодын банкуудад олгосон 2020 онд бүрэн төлөгдөж дууссан (2019 онд 290 сая төгрөг) зээл, банкуудын мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшлүүлэх, банкны системийг сайжруулах АХБ-ны хөтөлбөрийн 738 сая төгрөг (2019 онд 772 сая төгрөг)-ийн зээл тус бүр бүрдүүлж байна.

Герман Улсын засгийн газраас Монгол Улсын жижиг, дунд аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор дотоодын банкуудад олгосон зээл нь бие даасан хоёр тусдаа КФВ хөтөлбөрөөр хэрэгжиж байна. Эдгээр зээл нь жилийн 1.25%- 1.75% хүүтэй бөгөөд ямар нэгэн үнэт цаасаар баталгаажаагүй. Эдгээр хөтөлбөрийн зээлийг дотоодын гурван банкаар дамжуулан КФВ-ийн тогтоосон тодорхой шалгуурт нийцсэн зээлдэгчдэд олгосон. Иймээс эргэн төлөлтийн хугацаа нь олгосон өдрөөс хамааран ялгаатай байна. Зээлийн гэрээний дагуу Банк зээлийн төлөх хугацаа болмогц тухайн дотоодын банкны Банк дахь данснаас шууд татах эрхтэй.

Гадаад валютын зээл (үргэлжлэл). Дотоодын банкны ажилтнуудын ур чадварыг дээшлүүлж, банкуудын програм хангамжийг сайжруулах зорилготой зээлийг Монгол Улс болон Азийн хөгжлийн банкны хооронд байгуулагдсан гэрээний дагуу “Ди-Эй-Ай” (Тайланд) Лимитед компанийн зохион байгуулсан сургалтыг санхүүжүүлэх зорилгоор олгосон. Энэхүү зээл 14 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын банкуудад олгосон зээл үнэ цэнийн бууралтын сан

2020 оны 12 дугаар сарын 31-ний болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хорогдуулсан өртгөөр бүртгэсэн банкуудад олгосон зээлийн үнэ цэнийн бууралтын санг дор харуулав:

Үнэ цэнийн бууралтын алдагдал	ЧӨД Сая.төг	Ирээдүйн дундаж ЧМ	АХЧ	ЗҮЦХА Сая.төг
2020 оны 12 дугаар сарын 31				
Шатлал 1	458,819	2.8% - 3.3%	63%	8,707
Шатлал 2	6,100	13.8%-15.5%	0%*	–
Шатлал 3	12,840	100%	70%	7,738
	477,759			16,445
2019 оны 12 дугаар сарын 31				
Шатлал 1	437,453	2.6% - 4.4%	25%	3,059
Шатлал 2	13,231	100%	38%	4,707
	450,684			7,766

*Шатлал 2 дээр буй санхүүгийн хөрөнгө нь хангалттай барьцаатай.

Доорх хүснэгтэд дотоодын банкуудад олгосон зээлийн дансны дүн ба холбогдох ЗҮЦХА-ын өөрчлөлтийг харуулав. Банкны шатлалын ангилал болон ЗҮЦХА-ын тооцооллын аргачлал зэрэг бодлого журмыг тодруулга 37-д дэлгэрэнгүй тусгасан болно.

	Шатлал 1 Сая.төг	Шатлал 2 Сая.төг	Шатлал 3 Сая.төг	Нийт Сая.төг
Зээлийн нийт дүн				
2020 оны 1-р сарын 1-ний өдрөөр	437,453	–	13,231	450,684
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан хөрөнгө	288,675	–	–	288,675
Шатлал 2 руу шилжсэн	(6,100)	6,100	–	–
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө	(261,261)	–	(339)	(261,600)
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр	458,767	6,100	12,892	477,759
2019 оны 1-р сарын 1-ний өдрөөр	447,334	–	–	447,334
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан хөрөнгө	386,979	–	–	386,979
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө	(383,629)	–	–	(383,629)
Шатлал 3 руу шилжсэн	(13,231)	–	13,231	–
2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр	437,453	–	13,231	450,684

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

18. ДОТООДЫН БАНКУУДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЗҮЦХА-ын сан

2020 оны 1-р сарын 1-ний өдрөөр	3,059	–	4,707	7,766
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 11)	5,648	–	3,031	8,679
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр	8,707	–	7,738	16,445
2019 оны 1-р сарын 1-ний өдрөөр	5,040	–	–	5,040
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 11)	2,726	–	–	2,726
Шатлал 3 руу шилжсэн	(4,395)	–	4,395	–
Шатлал хоорондын шилжилтээс ЗҮЦХА-ын санд үзүүлэх нөлөө	(312)	–	312	–
2019 оны 12-р сарын 31-ний өдрөөр	3,059	–	4,707	7,766

Тодруулга 37-д толилуулснаар Монгол Улсын ихэнх банкуудыг олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллагын зүгээс үнэлсэн. Дээрх шинжилгээ олон улсын зэрэглэл тогтоогч байгууллагуудын үнэлгээ өгсөн байдалд суурилсан болно. Зэрэглэл тогтоогдоогүй байгаа Монгол Улсын бусад банкуудын хувьд Банк тухайн банкны хамгийн сүүлийн санхүүгийн мэдээллүүд, санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа, холбогдох хөрөнгүүдийн зээлийн чанарыг үнэлэхэд зориулсан бусад мэдээллүүдийг харгалзан авч үздэг болно. ЗҮЦХА-ын тооцоололд ашиглаж буй өгөгдлийн өөрчлөлтийг Тодруулга 37-с харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
БҮЦӨБДО-оорх өрийн үнэт цаас:		
-РАМП хөрөнгө оруулалтын данс	930,566	870,831
-Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	898,352	–
-АНУ-ын засгийн газрын үнэт цаас	278,804	260,422
-Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт	146,569	136,676
-Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк	47,800	67,444
-КФВ-ны бонд	30,554	67,814
-Хятадын засгийн газрын бонд	–	35,746
-Олон улсын төлбөр тооцооны банкны гаргасан бонд	17,575	10,910
Дансны дүн	2,350,220	1,449,843
Хорогдуулсан өртгөөр бүртгэгдэх өрийн үнэт цаас		
-Давуу эрхтэй ИЗББ	2,324,824	2,380,404
-Эрдэнэс бонд	547,155	–
-Хөгжлийн банкны үнэт цаас	55,650	49,522
-Түрээсийн хөрөнгөөр баталгаажсан бонд	34,694	–
Нийт дүн	2,962,323	2,429,926
Хасах нь:Үнэ цэнийн бууралтын сан	(37,414)	(6,627)
Цэвэр дүн	2,924,909	2,423,299
Нийт өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	5,275,129	3,873,142

1) БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт

“Рамп” Хөрөнгө оруулалтын данс. Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк нь Дэлхийн банкны “Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлага” төслийг 2011 оноос хэрэгжүүлсэн.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл нь 0.34 сая ам.доллар буюу 956 сая төгрөг (2019 онд 0.32 сая ам.доллар буюу 864 сая төгрөг) бүхий мөнгөн хөрөнгө, 326 сая ам.доллар буюу 929,610 сая төгрөг (2019 онд 319 сая ам.доллар буюу 869,976 сая төгрөг)-ийн үнэт цааснаас бүрдэж байна. Хөрөнгө оруулалтын дансыг АНУ-ын Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан.

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) бонд. Өрийн үнэт цаас ба бондын зах зээлийн үнэд тулгуурласан бодит үнэ цэнээр хэмжигддэг. Дээрх бүх бондууд 893,532 сая төгрөгийн үнэтэй (2019: 0 төг.) жилийн 2.44% (2019: жилийн 2.44%) хүүтэй богино хугацаатай буюу дуусах хугацаа нь хамгийн ихдээ 117 хоног (2019: 94 хоног) хүртэлх хугацаатай. Банк эдгээр бондыг өндөр нэр хүндтэй ОУТТБ-ын хувьд бага эрсдэлтэй гэж үзэж хөрөнгө оруулсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

АНУ-ын Засгийн газрын үнэт цаас болон Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк. Санхүүгийн жилийн эцсээрх уг хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 114 сая ам.доллар буюу 326,935 сая төгрөг (2019 онд 327,866 сая төгрөг) байна. Уг бондын хугацаа нь 1-ээс 3 жил (2019: 2-с 3 жил) ба жилийн 1.125%- 2.75% (2019: жилийн 0.9%- 2.75%) хүүний өгөөжтэй. Энэ хөрөнгө оруулалтуудыг 1 дүгээр шатлал гэж үзсэн. Барьцаагүй.

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) хөрөнгө оруулалтын данс. Гадаад валютын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Монголбанк нь ОУТТБ-тай Нөөцийн удирдлагыг сайжруулах зөвлөгөө ба нөөцийн удирдлагын төслийг 2019 оноос хэрэгжүүлсэн. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл нь 51 сая ам.доллар буюу 146,569 сая төгрөг (2019: 50 сая ам.доллар буюу 136,676 сая төгрөг) байна.

Олон улсын төлбөр тооцооны банкны (ОУТТБ) хөрөнгө оруулалтын данс (үргэлжлэл). Хөрөнгө оруулалтын данс дахь өрийн үнэт цаасны зээлийн эрсдэлийн чанарыг Стандарт энд Пүүрс болон Мүүдийсийн рейтингээр үнэлэхэд Аа3-аас Ааа зэрэглэлтэй буюу Онцсайн байсан, 1-р шатлалын хөрөнгө гэж үзсэн. Дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 37-с харна уу.

Доорх хүснэгтэд БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн хэрэгслийн 2020 болон 2019 оны 12 дүгээр сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнийн өөрчлөлтөд харгалзах ЗҮЦХА-ын санг шатлал бүрээр харуулав.

	2020		2019	
	Шатлал 1		Шатлал 1	
	Бодит үнэ цэнэ	ЗҮЦХА	Бодит үнэ цэнэ	ЗҮЦХА
	Сая.төг	Сая.төг	Сая.төг	Сая.төг
1-р сарын 1-ний өдрөөр	1,449,843	80	2,255,400	120
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан хөрөнгө	1,589,766	381	2,630,433	–
Төлсөн эсвэл үл хүлээн зөвшөөрсөн хөрөнгө	(758,893)	(40)	(3,491,616)	(40)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт (Тод.34)	4,854	9,440	9,440	–
Хуримтлагдсан хүү	2,478	(263)	(263)	–
Гадаад валютын ханшийн зөрүү	62,172	46,449	46,449	–
12-р сарын 31-ний өдрөөр	2,350,220	56,047	1,449,843	80

2) Хорогдуулсан өртгөөрх өрийн үнэт цаас

МИК-ийн охин компаниудын гаргасан давуу эрхтэй ипотекийн зээлээр баталгаажсан бонд (Давуу эрхтэй ИЗББ). Банк нь 2013 оны 6 дугаар сарын 13-ны өдөр МИК болон дотоодын банкуудтай гурван талт “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн ерөнхий гэрээ”-г байгуулсан. 2016 оноос эхлэн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсан ба Монгол Улсын засгийн газар гэрээнд оролцогч тал болсон. Уг гэрээний хүрээнд Банк дотоодын банкуудад олгосон бага хүүтэй зээлийн төлбөрт МИК-иас гаргасан давуу эрхтэй ИЗББ-ыг хүлээн авсан, энэ талаар Тодруулга 18-аас харна уу. Тус бонд нь 20 хүртэлх жилийн хугацаатай, жилийн 4.5% хүүтэй.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эрдэнэс Бонд. 2020 оны 1 дүгээр сард батлагдсан "Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх тухай" хуулийн дагуу төрийн өмчит "Эрдэнэс монгол" ХХК тус бүр нь 1 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 6% хүүтэй, 5 жилийн хугацаатай, 929,861 ширхэг бонд (цаашид "Эрдэнэс бонд") гаргаж, уг бондоор дотоодын банкуудын шалгуур хангаж буй тэтгэвэр барьцаалсан зээлийн үлдэгдлийг төрөөс хаасан ба Монголбанк дотоодын банкуудаас энэхүү бондыг худалдан авах үүрэг хүлээсэн.

Уг бондын эргэн төлөлт төрийн өмчит "Эрдэнэс Монгол" ХХК-ийн охин компанийн эзэмшлийн Салхитын мөнгө, алтны ордыг эдийн засгийн эргэлтэд оруулсан орлогоос засгийн газрын хүртэх өгөөжөөр төлөгдөнө.

Хөгжлийн банкны үнэт цаас. Банк нь 2015 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр Хөгжлийн банкны нийт 60,000 сая төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 4% хүүтэй өрийн бичгийг худалдан авсан ба уг өрийн бичгийг удирдлага зах зээлийн хүүнээс доогуур хүүтэй гэж үзсэн. Энэхүү өрийн бичгийн анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнэ 31,397 сая төгрөг байсан бөгөөд Хөгжлийн банкны үнэт цаасны нэрлэсэн үнэ болон бодит үнэ цэнийн хоорондын зөрүү болох 28,603 сая төгрөгийг 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн. Хүүгийн төлөлт хагас жил тутамд хийгддэг.

Түрээсийн орлогоор баталгаажсан бонд. Төрийн болон тусгай албан хаагчдыг орон сууцжуулахтай хөтөлбөртэй холбоотойгоор Банк 2020 оны 10 дугаар сарын 07-ны өдөр "Нийслэлийн орон сууцны корпораци (НОСК)" ХК-аас үүсгэн байгуулсан "НОСК нэг ТЗК"-ийн гаргасан, тус бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий, жилийн 8% хүүтэй, 15 жилийн хугацаатай, 343,555 ширхэг бонд худалдан авсан. Уг бонд нь НОСК ХК-ийн эзэмшилд байгаа түрээсийн орон сууцнаас олох түрээсийн төлбөр болон орон сууцны барилгаар баталгаажсан.

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын сан

Доорх хүснэгтэд Банкны дотоод зээлийн үнэлгээний систем, 12 сар ЧМ шатлал болон жилийн эцсийн шатлалаар ангилсан ЗҮЦХА-ын сангийн дүнг харуулж байна. Банкны дотоод үнэлгээний систем, ЗҮЦХА-ын журам болон хэмжилтийн аргачлалын дэлгэрэнгүйг тодруулга 37-с харна уу.

		Шатлал 1		
2020 оны 12 дугаар сарын 31	**ЧӨД**	**Ирээдүйн**		**ЗҮЦХА**
Дотоодын үнэлгээ	**Сая.төг**	**дундаж ЧМ**	**АХЧ**	**Сая.төг**
Онц сайн	2,350,641	0% - 0.59%	60.0%	421
Сайн	2,380,474	1.9% - 10.4%	62.71%	5,471
Үнэлгээгүй*	581,849	3.9%-11.9%	48%-52%	31,943
	5,312,964			37,835
2019 оны 12 дугаар сарын 31				
Дотоодын үнэлгээ				
Онц сайн	1,449,923	0% - 0.26%	25%	80
Сайн	2,429,926	2.57% - 4.42%	1.57%- 4.42%	6,627
	3,879,849			6,707

*Үнэлгээгүй хөрөнгө нь Эрдэнэс бонд болон Түрээсийн орлогоор баталгаажсан бондыг илэрхийлнэ. Бондын 50 орчим хувийн эргэн төлөлт Монгол Улсын Хөгжлийн банк (МУХБ)-ны баталгаагаар баталгаажсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

19. ӨРИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

БҮЦӨБДО-д бүртгэгдэх өрийн үнэт цаасны 421 сая төгрөгийн (2019 онд 80 сая төгрөг) ЗҮЦХА-ын сан нь тухайн тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан.

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын ЗҮЦХА-ын сангийн өөрчлөлтийг доорх хүснэгтэд харуулав.

	2020 Сая.төг	2019 Сая.төг
2020 оны 01-р сарын 01-ний өдрөөр	6,707	1,409
Шинээр худалдан авсан хөрөнгө	34,391	5,298
ЗҮЦХА-н тооцоололд ашигласан өгөгдлийн өөрчлөлт	(3,183)	–
Хугацаа дуусан	(80)	–
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр	**37,835**	**6,707**

20. ӨМЧИЙН ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
БҮЦӨБДО-оорх өмчийн үнэт цаас:		
Бусад өмчийн хөрөнгө оруулалт	6,595	6,595
МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт	–	5,139
Нийт өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт	6,595	11,734

МИК Холдинг ХК-д оруулсан өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт. Банк МИК Холдинг ХК-ийн 421,241 ширхэг энгийн хувьцааг эзэмшиж байсан бөгөөд 2020 оны 4 дүгээр улиралд 5,055 сая төгрөгөөр зарсан.

Бусад өмчийн хөрөнгө оруулалт. Үүнд Олон улсын хөрөнгө оруулалтын банк, Эдийн засгийн хамтын ажиллагааны олон улсын банк болон Монголын банкны холбоонд оруулсан хөрөнгө оруулалтууд багтдаг ба бодит үнэ цэнээр нь бүртгэдэг. Удирдлага бодит үнэ цэнийг хөрөнгө оруулалтын өртөгтэй ойролцоо байна гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

21. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	4,393,375	2,700,444
Дотоодын банкууд	422,706	554,067
Нийт дүн	4,816,081	3,254,511
Хасах нь:Үнэ цэнийн бууралтын сан	(13)	(74)
Цэвэр дүн	4,816,068	3,254,437

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк. Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкинд байршуулсан хадгаламжтай холбоотойгоор Банк "Автомат хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-т хамрагдсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд хадгаламжийн дүн 250,000 ам.доллараас илүү гарсан тохиолдолд давсан дүнгээр Нью-Йоркийн Холбооны нөөцийн банкны буцаан худалдан авах гэрээ (буцаан худалдан авах репо)-нд хөрөнгө оруулалт хийгддэг.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр буцаан худалдан авах репо гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт нь 1,541.8 сая ам.доллар буюу 4,393,375 сая төгрөг (2019: 988 сая ам.доллар буюу 2,700,444 сая төгрөг) байна. Энэхүү хөрөнгө оруулалт 4 хоногийн (2019: 3 хоног) хугацаатай бөгөөд жилийн 0 хувийн (2019: 1.45%) хүүтэй. Холбогдох хөрөнгө оруулалтыг барьцаагаар баталгаажуулдаг боловч тус хөтөлбөрийн хүрээнд худалдан авсан үнэт цаасыг тодорхойлох боломжгүй байдаг.

Дотоодын банкууд. Дотоодын банкуудтай байгуулсан "Төгрөгийн" урвуу буцаан худалдан авах гэрээнүүд нь Хөгжлийн банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас болон Төв банкны үнэт цаасуудаар баталгаажсан урт болон богино хугацаат зээлийг илэрхийлдэг.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дотоодын банкууд дахь төгрөгийн овернайт буцаан худалдан авах хэлцлийн дүн 129,141 сая төгрөг, 4 хоногийн хугацаатай, жилийн 7% хүүтэй (2019: 494,291 сая төгрөг, 2 хоногийн хугацаатай, жилийн 13% хүүтэй) байсан. Энэ гэрээ нь Засгийн газрын үнэт цаасаар баталгаажсан.

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар урвуу буцаан худалдан авах хэлцлийн нэрлэсэн үнэ нь 65,000 сая төгрөг (2019: 65,000 сая төгрөг), 6 жилийн хугацаатай (2019: 3-6 жил), жилийн 7.5% хүүтэй (2019: жилийн 7.5% хүүтэй) ба Хөгжлийн банкнаас гаргасан үнэт цаасаар баталгаажсан. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх дансны үнэ нь 62,327 сая төгрөг (2019: 59,600 сая төгрөг) байсан. Нэрлэсэн үнэ ба бодит үнэ цэнийн зөрүү болох 23,426 сая төгрөгийг анх хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг 2016 оны ашиг алдагдалын тайланд бүртгэсэн.

2020 оны 12 дугаар сарын 31-нээр үлдэж буй дотоодын банктай хийсэн урт хугацаат, төгрөгийн урвуу буцаан худалдан авах хэлцлийн дүн 230,000 сая төгрөг (2019: 0 төг.), 2 жилийн хугацаатай, жилийн 6.5% хүүтэй ба Төв банкны үнэт цаасаар баталгаажсан. Хэлцлийн 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх дансны үнэ 231,238 сая төгрөг (2019: 0 төг.). Гэрээний дагуу, хэлцэл хүчин төгөлдөр болсон өдрөөс 3 сарын дотор бүх банк уг хэлцлийн барьцааг хэвийн зээлийн багцаар баталгаажсан үнэт цаасаар солих заалттай.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

21. УРВУУ БУЦААН ХУДАЛДАН АВАХ ХЭЛЦЭЛ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Урвуу буцаан худалдан авах хэлцлийн үнэ цэнийн бууралтын сан

Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк болон дотоодын банкуудтай байгуулсан урвуу буцаан авах хэлцлүүд Банкны дотоод үнэлгээний системээр 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдөр онц сайн болон сайн үнэлгээтэй, 1-р шатлалд ангилагдаж байна. Дэлгэрэнгүйг Тодруулга 37-с харна уу.

	Дансны дүн Сая.төг	12 сар ЧМ шатлал	АХЧ	ЗҮЦХА сан Сая.төг
2020 оны 12 сарын 31				
Дотоодын үнэлгээ				
Онц сайн	4,393,362	0.09%-0.3%	60%	(13)
Сайн	422,706	2.44%-3.31%	0%*	–
	4,816,068			(13)
2019 оны 12 сарын 31				
Дотоодын үнэлгээ				
Онц сайн	2,700,444	0%	25%	–
Сайн	553,993	2.57%-4.42%	0%-4.4%	(74)
	3,254,437			(74)

* Эдгээр хөрөнгүүд нь Төв банкны үнэт цаас болон МУХБ-ны бондоор баталгаажсан.

ЗҮЦХА-ын сангийн буцаалт 61 сая төгрөгийг (2019: 74 сая төгрөгийн алдагдал) ашиг алдагдлын тайланд бүртгэсэн болно. Тодруулга 11-г харна уу.

22. АЛТ, ҮНЭТ МЕТАЛ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Бодит үнэ цэнээр		
Мөнгөжсөн алт	1,404,034	3,053,057
Мөнгөжсөн мөнгө	1,853	4,472
Өртгөөр		
Худалдан авсан алт	353,458	36,800
Цэвэршүүлэхээр ачуулсан алт	24,309	12,375
Дурсгалын зоос	2,203	1,980
	1,785,857	3,108,684

Мөнгөжсөн алт болон мөнгө нь Английн Төв банк болон Джей Пи Морган Чейз банкинд байршдаг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар мөнгөжсөн металын дахин үнэлгээний бодит бус ашиг 151,293 сая төгрөг (2019: 382,855 сая төгрөг). Тодруулга 8-аас харна уу.

Мөн дотоодын олборлогчдоос худалдан авсан, цэвэршүүлэхээс өмнөх мөнгөжөөгүй алт болон мөнгийг хадгалдаг болно. Бусад үнэт метал болох дурсгалын зоосыг бараа материалаар бүртгэж өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь бүртгэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

23. ЭРДЭНЭСИЙН САН

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Үндсэн сан	145,701	145,063
Гүйлгээ сан	925,964	923,797
	1,071,665	1,068,860

Доорх хүснэгтэд Эрдэнэсийн сангийн эд зүйлсийг шинж чанар, ангиллаар 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулав:

Бодит үнэ цэнээр	**Зоос** **Сая.төг**	**Соёлын үнэт зүйлс** **Сая.төг**	**Нийт** **Сая.төг**
2019 оны 1-р сарын 1-ний өдрөөр	**838,639**	**92,602**	**931,241**
Нэмэгдсэн	7	588	595
Дахин үнэлсэн	78,902	58,122	137,024
2019 оны 12-р сарын 31 буюу 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөр	**917,548**	**151,312**	**1,068,860**
Нэмэгдсэн	37	2,768	2,805
Дахин үнэлсэн	–	–	–
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөр	**917,585**	**154,080**	**1,071,665**

Эрдэнэсийн сан нь түүх соёлын хосгүй үнэт болон үнэт зүйлс, 1925 онд гаргасан зоос зэргээс бүрдэнэ. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх зоосны дийлэнх хэсгийг 1925 онд тухайн үеийн төв банкны анх гүйлгээнд гаргасан мөнгөн болон зэс зооснуудаас бүрддэг ба 916,278 сая төгрөгийн (2019 онд 916,278 сая төгрөг) дансны үнэтэй байна.

Удирдлага 2018 оноос эхлэн эрдэнэсийн сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогоо өөрчлөн бодит үнэ цэнээр нь хэмжиж эхэлсэн (Тодруулга 4-өөс дэлгэрэнгүйг харна уу) ба хөндлөнгийн үнэлгээний компани болох “Мэйк э Диффэрэнс” ХХК-аар олон улсын үнэлгээний стандартын дагуу эрдэнэсийн сангийн эд зүйлсийг дахин үнэлүүлсэн. Эрдэнэсийн сан дахь эд зүйлсийг шууд харьцуулалтын арга болон орлуулах өртгийн аргаар үнэлсэн. Шууд харьцуулалтын арга нь гарал үүсэл, нөхцөл байдал, бэлэг тэмдгийн нэр, одоогийн эзэмшигч, тухайн зүйлийн онцгой байдал зэрэг тодорхой зах зээлийн хүчин зүйлсэд тохируулсан харьцуулж болох үнийг ашиглан олон нийтийн болон онлайн дуудлага худалдаа зэрэг зах зээлд тулгуурласан нотолгоог суурь болгон ашигладаг арга юм.

Өртгийн арга нь эд зүйлийн анхны шинж чанар, материалын насжилттай аль болох ойролцоо чанартай хөрөнгийг дахин үйлдвэрлэх өнөөгийн өртгийг тооцоолж гаргадаг арга юм. Бодит үнэ цэнийн хэмжилтийн тухай дэлгэрэнгүйг Тодруулга 38-с харна уу.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

24. САНХҮҮГИЙН ҮҮСМЭЛ ХЭРЭГСЭЛ

Доорх хүснэгтэд хөрөнгө, өр төлбөр болон нэрлэсэн үнийг үүсмэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнээр харууллаа. Нэрлэсэн үнэ нь нийт дүнгээрээ үүсмэл санхүүгийн хэрэгслийн суурь үнэт цаасны дүн байх бөгөөд суурь хүү эсвэл хүүгийн индексээс шалтгаалан үүсмэл санхүүгийн хэрэгслийн үнэлгээнд өөрчлөлт орно. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах боловч зах зээлийн эрсдэл эсвэл зээлийн эрсдэлийн алийг нь ч илэрхийлэхгүй.

Своп	Нэрлэсэн үнэ сая ам.доллар	Нэрлэсэн үнэ Сая.төг	Бодит үнэ цэнэ Хөрөнгө Сая.төг	Бодит үнэ цэнэ Өр төлбөр Сая.төг
2020	1,658	4,374,155	156,419	(303,501)
2019	1,998	4,797,569	260,778	(545,040)

Үүсмэл санхүүгийн хэрэгслийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсвэл огт шаардагдахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байдаг. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний бага хэмжээний өөрчлөлт нь ч банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Банк нь үүсмэл санхүүгийн хэрэгслийн гэрээний эрсдэлд өртөх дүнг банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хянадаг. Эрсдэлийн удирдлагын стратеги мөн хэрхэн эрсдэлийг удирдахыг тодруулга 37-д харуулав.

25. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС

	2020 Сая.төг	2019 Сая.төг
БҮЦӨБДО-оор бүртгэгдэх Засгийн газрын үнэт цаас,	231,365	134,351
Хасах нь:Үнэ цэнийн бууралтын сан	(3,958)	(323)
Цэвэр дүн	227,407	134,028

Банк нь 2016 онд Засгийн газрын хэрэгжүүлсэн “Сайн” хөтөлбөрийн дагуу 453,712 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0-3.0 хувийн хүүтэй, 1-15 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасыг худалдан авсан ба удирдлага нь үүнийг зах зээлийн хүүний түвшнээс доогуур гэж үзсэн. Засгийн газрын үнэт цаас нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй тул үүнийг идэвхтэй зах зээл болон зах зээлийн бус хүүгээр олгогдсон гүйлгээ эсэхийг тодорхойлоход удирдлагын үнэлэмж шаардагдсан. Тус үнэлэмжийг хийхэд хийхдээ холбоогүй талуудын хооронд хийгдсэн ижил төстэй ажил гүйлгээ болон үр ашигт хүүгийн аргыг ашигласан. Эдгээр үнэт цаасны бодит үнэ цэнэ анх хүлээн зөвшөөрөх үед 123,668 сая төгрөг байсан. Энэ нь зах зээлийн хүүний түвшингөөс доогуур байсан ба нэрлэсэн хүүний эсрэг үр ашигт хүү нь ойролцоогоор жилийн 18 хувь байсан тул 330,044 сая төгрөгийг “Эхний өдөр”-ийн ашиг, алдагдлаар 2016 онд хүлээн зөвшөөрсөн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

25. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС (ҮРГЭЛЖЛЭЛ)

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр хорогдуулсан өртгөөр бүртгэгдэж байсан Засгийн газрын үнэт цаасны бизнес модель 2019 онд өөрчлөгдөж, гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байсныг мөнгөн урсгал цуглуулахаас гадна худалдан борлуулах зорилгоор эзэмших болсон тул бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэх ангилалруу дахин ангилсан.

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Засгийн газрын үнэт цаасны үлдэгдэл нь 374 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0 хувийн купонтой, 15 жилийн хугацаатай байна. (2019 онд нь 374 сая төгрөгийн нэрлэсэн үнэтэй, жилийн 1.0 хувийн купонтой, 15 жилийн хугацаатай). Бодит үнэ цэнийн тодруулгыг Тодруулга 38-с харна уу.

Дансны үлдэгдэл нь зээлийн эрсдэлийн дээд хэмжээг илэрхийлэх ба 2020, 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн чанарын үнэлгээгээр сайн үнэлгээтэй байна. Банкны дотоод үнэлгээний систем болон ЗҮЦХА-ын тооцооллын аргачлалыг Тодруулга 37-д дэлгэрэнгүй тусгасан болно.

БҮЦӨБДО-оор бүртгэгдэх Засгийн газрын үнэт цаасны 3,635 сая төгрөгийн (2019: 611 сая төгрөг) ЗҮЦХА-ын сан нь тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдсан.

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Засгийн газрын үнэт цааснуудын аль нь ч барьцаанд тавигдаагүй ба холбоотой талын ажил гүйлгээний дэлгэрэнгүйг Тодруулга 36-с харна уу.

Доорх хүснэгтэд БҮЦӨБДО-оор бүртгэгдэх Засгийн газрын үнэт цаасны 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнийн өөрчлөлтийг харгалзах ЗҮЦХА-ыг сангийн тохируулгын хамт харуулав.

Шатлал 1

	2020		2019	
	Бодит үнэ цэнэ	ЗҮЦХА	Бодит үнэ цэнэ	ЗҮЦХА
	Сая.төг	Сая.төг	Сая.төг	Сая.төг
2020 оны 1-р сарын 1-ний өдрөөрх	134,028	323	65,265	934
Шинээр үүссэн эсвэл худалдан авсан хөрөнгө	–	–	7,668	–
ЗҮЦХА-ын сангийн алдагдал/(буцаалт) (Тодруулга 11)	–	3,635	–	(611)
Бодит үнэ цэнийн өөрчлөлт	93,379	–	61,095	–
2020 оны 12-р сарын 31-ний өдрөөрх	227,407	3,958	134,028	323

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУСАД ХӨРӨНГӨ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Хорогдуулсан өртгөөрх бусад санхүүгийн хөрөнгө		
Хадгаламжийн Даатгалын Корпорациас авах авлага	148,958	149,092
Татан буугдсан Анод банкнаас хүлээн авсан хөрөнгө	58,839	58,965
Аж ахуйн нэгжүүдээс авах авлага	60,360	58,111
Татан буугдсан Капитал банкнаас авах авлага	55,271	54,480
Капитал банкны өрийн бичгийн авлага	47,732	–
Гадаадын санхүүгийн байгууллагуудаас авах зарга	24,912	23,898
	396,072	344,546
Хасах нь:Үнэ цэнийн бууралтын сан	(305,127)	(265,577)
	90,945	78,969
БҮЦӨАА-аарх бусад санхүүгийн хөрөнгө		
Өрийн бичгийн авлага	282,545	394,621
Хорогдуулсан өртгөөрх бусад санхүүгийн бус хөрөнгө		
Урьдчилж төлсөн зардал	31,425	10,228
Бусад	18,758	8,504
	50,183	18,732
Нийт бусад хөрөнгө	423,673	492,322

Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага. 2013 онд Банк Монголын банкны секторыг тогтворжуулах үндсэн зорилгоор 119,900 сая төгрөгийн жилийн 0.5%-ийн хүүтэй 10 жилийн хугацаатай зээлийг ХДК-д олгосон. Уг зээл нь 2023 оны 9 дүгээр сарын 30-нд эргэн төлөгдөх, жил бүр хүү төлөх гэрээний нөхцөлтэй. Төрийн банкны хувьцааг худалдан авах засгийн газрын шийдвэрийн хүрээнд Банк мөн онд ХДК-д 85,000 сая төгрөгийн богино хугацаат санхүүгийн дэмжлэгийн хамт нэг өдөр олгосон. Үүний үр дүнд ХДК нь Төрийн банк ХХК-ийн 75 хувийг эзэмших болсон. Гэрээнд зааснаар, Төрийн банк ХХК-ийн хувьчлалын орлогоос болон Төрийн банк ХХК-ийн тухайн санхүүгийн дэмжлэгийг эргэн төлүүлнэ гэж заасан байдаг.

Монгол улсын банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилго болон банкны системийн дахин санхүүжилтийг эцсийн зээлдүүлэгчийн хувьд зохион байгуулсан онцлог байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр удирдлага тус санхүүгийн дэмжлэг бүхий зээл үндсэн зах зээлийн хүүгийн түвшинг илэрхийлнэ гэж дүгнэсэн. Эдгээр зээлийн дансны үлдэгдэл 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 54,230 сая төгрөг (2019 онд 43,185 сая төгрөг).

2014 болон 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийг Төрийн банкны хувьчлал зогсонги байдалд орсны улмаас эргэн төлөлт хийгдэх эсэх нь тодорхойгүй гэж дүгнэн бүхэлд нь эрсдэлийн сан байгуулсан.

2018 оны 5 дугаар сард засгийн газар хэлэлцэж “2018 – 2020 онуудад төрийн өмчийн банк/ компаниудын хувьчлал”-ыг УИХ-д танилцуулахаар дэмжигдсэн бөгөөд УИХ-ын намрын чуулганаар батлуулна гэсэн хүлээлттэй байсан тул удирдлага нь хувьчлалтай холбоотой ахиц гарсны үндсэн дээр дахин үнэлгээ хийснээр зээлийг 115,000 сая төгрөгийн эрсдэлийн нөөц сангийн хамт 3 дугаар шатлалаар үнэлж үр дүнд нь 78,700 сая төгрөгийн эрсдэлийн нөөц сангийн буцаалтыг орлого зарлагаар хүлээн зөвшөөрсөн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага (үргэлжлэл). Жилийн 0.5 хувийн хүүтэй 119,900 сая төгрөгийн авлагын хувьд удирдлага нь тусгай үнэ цэнийн бууралтын үнэлгээг хийсэн ба 2020 онд 11,179 сая төгрөгийн (2019: 9,093 сая төгрөг) үнэ цэнийн сангийн буцаалт нь хямдруулалтын хүү буурснаас үүссэн. 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл 63,952 сая төгрөг (2019: MNT 64,086 сая төгрөг) байна.

2019 онд Капитал банкны дампууралтай холбоотойгоор Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан даатгалын тохиолдол бий болж, улмаар Монголбанк болон ХДК-ийн хооронд Зээлийн төлбөр барагдуулах гэрээ, Шаардах эрх шилжүүлэх гэрээг үндэслэн даатгалын нөхөн төлбөр болох 44,663 сая төгрөгөөр авлагыг бууруулсан ба 2020 онд 134 сая төгрөгийн эргэн төлөлт хийгдсэн.

Татан буугдсан Анод банкнаас авах авлага 2015 онд Анод банкны эрх хүлээн авагчийн хугацаа дуусах үед Банк 73,662 сая төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг хүлээн авсан. Үүнээс 2020 болон 2019 онд харгалзан 126 сая болон 1,650 сая төгрөгийг эргүүлэн төлүүлсэн. Эдгээр хөрөнгүүдийн хувьд 58,839 сая төгрөгийн (2019 онд 58,965 сая төгрөг) алдагдлын санг өмнөх онтой адил 100 хувь байгуулсан. СТОУС 9-ийн дагуу хөрөнгийг 3 дугаар шатлалаар үнэлж чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн хэмжээ нь 100% байна.

Аж ахуйн нэгжүүдээс авах авлагад Банктай хийсэн алтны опцион хэлцлийнхээ үүргийг өмнөх жилүүдэд биелүүлээгүй алт олборлогч компаниудаас авах авлага багтаж байгаа бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 40,085 сая төгрөг (2019 онд 38,456 сая төгрөг)-ийн авлагын дүнд найдваргүй байдлыг тооцон болзошгүй алдагдлын нөөцийн санг бүрэн байгуулсан бөгөөд 3 дугаар шатлалаар үнэлж чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн хэмжээ нь 100% байна.

Бусад аж ахуйн нэгжүүдээс авах авлагын хувьд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 20,275 сая төгрөг (2019 онд 19,655 сая төгрөг) байна. Өмнөх онуудад авлагыг бүхэлд нь нөөц сан байгуулсан бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 3 дугаар шатлалаар авч үзэж чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн хэмжээ нь 100% байна.

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах авлага. Клирингийн авлага 5,215 сая төгрөг, Заавал байлгах нөөцийн торгууль 4,602 сая төгрөг, ХДК-тай холбоотой авлага 44,663 сая төгрөг болон Банк 2020 онд авсан өрийн бичгийн торгуулийн авлага 791 сая төгрөг байна.

Капитал банкны эрх хүлээн авагчаас авах өрийн бичгийн авлага. 2020 оны 6 дугаар сард Банк Капитал банкны эрх хүлээн авагчаас гаргасан 41 тэрбум төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан хүүтэй, нийт 46.7 тэрбум төгрөгийн дүнтэй, 13 сарын хугацаатай өрийн бичгийг дор дурьдсан БҮЦӨАА-аар бүртгэгдэх өрийн бичгийн хэсэгчилсэн төлбөрт суутган худалдан авсан. 2020 оны 7 дугаар сард уг өрийн бичгийн хугацаа дууссан ба Банк ЗҮЦХА-ын 3-р шатлалд шилжүүлж, чанаргүйдэх магадлалыг 100 хувиар тооцсон. Тайлант жилд санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал 29,474 сая төгрөгийг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн.

Гадаадын санхүүгийн байгууллагаас авах зарга. Холбогдох гадаадын байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон учир эргэн төлөгдөхгүй гэж үзэн бүтэн дүнгээр болзошгүй алдагдлын нөөцийн санг байгуулсан. 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Банк эдгээр хөрөнгийг 3 дугаар шатлалаар үнэлсэн, чанаргүйдлийн магадлал болон алдагдалд хүргэх чанаргүйдлийн хэмжээ нь 100% байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Өрийн бичгийн авлага. Өрийн бичгийн авлага нь БҮЦӨАА-аар бүртгэгдэх дотоодын компаниудаас гаргасан доорх өрийн бичгүүдийг илэрхийлэх бөгөөд үүнд:

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк 367,425 сая төгрөгийн (2019: 470,000 сая төгрөг) нэрлэсэн үнэтэй дотоодын хоёр (2) компанийн (2019 онд таван (5) компани) болон дотоодын нэг банкны гаргасан өрийн бичгүүдийг эзэмшиж байна. Эдгээр өрийн бичгүүд нь 5-7 жилийн хугацаатай бөгөөд гэрээгээр тодорхойлж заасан хүүгийн түвшинтэй болно. Ихэнх өрийн бичгийн гэрээнүүд нь тодорхой нөхцөл хангагдсан тохиолдолд хүүгийн түвшин буурах нөхцөлтэйгээр баталгаажсан, тухайлбал эдгээр гэрээнүүд анхны хүүгийн түвшин өндөр байхаар заасан боловч тодорхой нөхцөл байдал хангагдсан тохиолдолд зээлийн хүүг зах зээлийн хүүгээс доогуур түвшин хүртэл бууруулах боломжтой. Банкны удирдлага болон хуулийн газар эдгээр гүйлгээг Төв банкны болон Монгол Улсын бусад холбогдох хуулийн заалтуудыг зөрчөөгүй гэж үзсэн.

Тайлант жилийн өрийн бичгийн бодит үнэ цэнийн бууралтын талаар Тодруулга 13-аас, бодит үнэ цэнийн хэмжилтийн талаар Тодруулга 38 -аас харна уу.

Бусад санхүүгийн бус хөрөнгө. Бусад санхүүгийн бус хөрөнгөд ихэвчлэн урьдчилгаа төлбөрүүд, ажилтнуудад олгосон урьдчилгаа, хангамжийн материал, бичиг хэргийн материал болон зардлын тооцоо, Банкын Эрдэнэсийн санг нэмэгдүүлэх зорилгоор алт цэвэршүүлэлтий компаниас хүлээн авсан шижир алт, мөнгө багтана. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шижир алт болон мөнгийг өртөг, бодит үнэ цэний аль багаар бүртгэсэн ба 29,020 сая төгрөг (2019: 0 төг.)-ийн үлдэгдэлтэй, АХБ-наас авах авлага 4,875 сая төгрөг (2019 онд 4,270 сая төгрөг), төслийн хөрөнгө оруулалтын дүн 8,191 сая төгрөг (2019 онд 3,377 сая төгрөг) байна.

Бусад хөрөнгийн үнэ цэнийн бууралтын сан. Доорх хүснэгтэд 2020 болон 2019 оны үнэ цэнийн бууралтын сангийн жилийн хөдөлгөөнийг харуулав:

	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3						
	12 сар ЗҮЦХА	ЗҮЦНХХА	(Нийт хугацаанд зээлийн үнэ цэнийн хүлээгдэж буй алдагдал-ЗҮЦНХХА)						
2020 оны 12-р сарын 31	**Бусад санхүүгийн хөрөнгө**	**Капитал банкны өрийн бичиг**	**ХДК-аас авах авлага**	**Капитал банкнаас авах авлага**	**Капитал банкны өрийн бичиг**	**Анод Банкнаас авах авлага**	**Бусад ААН-үүдээс авах авлага**	**Гадаадын санхүүгийн байгуулл-агаас авах авлага**	**Нийт**
	Сая.төг	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**
Нийт дүн									
2020 оны 01-р сарын 01-ний байдлаар	–	–	149,092	54,480	–	58,965	58,111	23,898	344,546
Нэмэгдсэн	49,532	–	–	791	–	–	–	–	50,323
Шилжилт/ Шатлал 3 руу	(49,532)	–	–	–	49,532	–	–	–	–
Ханшийн тэгшитгэл	–	–	–	–	–	–	2,249	1,014	3,263
Тухайн жилийн эргэн төлөлт	–	–	(134)	–	(1,800)	(126)	–	–	(2,060)
2020 оны 12-р сарын 31-ний байдлаар	–	–	148,958	55,271	47,732	58,839	60,360	24,912	396,072
ЗҮЦХА сан									
2020 оны 01-р сарын 01-ний байдлаар	–	–	105,907	18,696	–	58,965	58,111	23,898	265,577
Алдагдлын сангийн ханшийн тэгшитгэл	–	–	–	–	–	–	2,249	1,014	3,263
Нэмэгдсэн/(Буцаасан) алдагдлын сан	7,531	–	(11,179)	18,118	21,943	(126)	–	–	36,287
Шатлал шилжсэнээс жилийн эцсийн ЗҮЦХА-д үзүүлсэн нөлөө	(7,531)	–	–	–	7,531	–	–	–	–
2020 оны 12-р сарын 31-ний байдлаар	–	–	94,728	36,814	29,474	58,839	60,360	24,912	305,127
Цэвэр дүн	–	–	54,230	18,457	18,258	–	–	–	90,945

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

26. БУСАД ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3					
2019 оны 12-р сарын 31	**Бусад санхүүгийн хөрөнгө**	**Бусад санхүүгийн хөрөнгө**	**ХДК-аас авах авлага**	**Капитал банкнаас авах авлага**	**Анод Банкнаас авах авлага**	**Анод Банкнаас авах авлага**	**Гадаадын санхүүгийн байгуул-лагаас авах авлага**	**Нийт**
	Сая.төг	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**
Нийт дүн								
2019 оны 01-р сарын 01-ний байдлаар	3,353	–	193,710	–	60,615	56,352	23,106	339,156
Нэмэгдсэн	–	–	425	54,480	–	–	–	54,905
Ханшийн тэгшитгэл	–	–	–	–	–	1,759	792	2,551
Тухайн жилийн эргэн төлөлт	(3,353)	–	(45,043)	–	(1,650)	–	–	(50,046)
2019 оны 12-р сарын 31-ний байдлаар	–	–	149,092	54,480	58,965	58,111	23,898	344,546
ЗҮЦХА сан								
2019 оны 01-р сарын 01-ний байдлаар	778	–	115,000	–	60,615	56,352	23,106	255,851
Алдагдлын сангийн ханшийн тэгшитгэл	–	–	–	–	–	1,759	792	2,551
Нэмэгдсэн/(Буцаасан) алдагдлын сан	(778)	–	(9,093)	18,696	(1,650)	–	–	7,175
2019 оны 12-р сарын 31-ний байдлаар	–	–	105,907	18,696	58,965	58,111	23,898	265,577
Цэвэр дүн	–	–	43,185	35,784	–	–	–	78,969

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ

Өртөг эсвэл дахин үнэлгээгээр	Барилга байгууламж Сая.төг	Дуусаагүй барилга Сая.төг	Тавилга, компьютер төхөөрөмж Сая.төг	Нийт биет хөрөнгө Сая.төг	Биет бус хөрөнгө Сая.төг	Нийт Сая.төг
2020 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар	87,549	38,495	16,740	142,784	2,603	145,387
Нэмэгдсэн*	2,125	29,505	10,592	42,222	1,958	44,180
Дахин ангилсан	50,781	(53,925)	–	(3,144)	3,144	–
Худалдан борлуулсан	(270)	(11,727)	(2,004)	(14,001)	(118)	(14,119)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөд шилжүүлсэн	(5,277)	–	–	(5,277)	–	(5,277)
Данснаас хассан	–	–	(37)	(37)	–	(37)
2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	134,908	2,348	25,291	162,547	7,587	170,134
Хуримтлагдсан элэгдэл/хорогдол						
2020 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар	(43,778)	–	(6,845)	(50,624)	(614)	(51,238)
Тухайн жилийн элэгдлийн зардал (Тодруулга 15)	(1,639)	–	(3,123)	(4,762)	(1,328)	(6,090)
Худалдан борлуулсан	254	–	1,991	2,245	118	2,363
Данснаас хассан	–	–	32	32	–	32
2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	(45,163)	–	(7,945)	(53,109)	(1,824)	(54,933)
Цэвэр дүн	89,745	2,348	17,346	109,438	5,763	115,201
Өртөг эсвэл дахин үнэлгээгээр						
2019 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар	86,423	14,996	13,609	115,028	496	115,524
Нэмэгдсэн	1,994	23,499	4,642	30,135	2,484	32,619
Худалдан борлуулсан	(13)	–	(1,451)	(1,464)	(377)	(1,841)
Данснаас хассан	(855)	–	(60)	(915)	–	(915)
2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	87,549	38,495	16,740	142,784	2,603	145,387
Хуримтлагдсан элэгдэл/хорогдол						
2019 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар	(42,994)	–	(5,655)	(48,650)	(423)	(49,073)
Тухайн жилийн элэгдлийн зардал (Тодруулга 15)	(1,577)	–	(2,673)	(4,250)	(543)	(4,793)
Худалдан борлуулсан	–	–	1,431	1,431	352	1,783
Данснаас хассан	793	–	52	845	–	845
2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар	(43,778)	–	(6,845)	(50,624)	(614)	(51,238)
Цэвэр дүн	43,771	38,495	9,895	92,160	1,989	94,149

*Үндсэн хөрөнгийн нэмэгдсэн хөрөнгөд 111 сая төгрөгийн мөнгөн бус хандив багтсан.

Банк барилга, байгууламжаа 2018 оны 12 дугаар сарын 31-нд бодит үнэ цэнээр дахин үнэлүүлсэн. Үнэлгээг хөндлөнгийн үнэлгээний “Гроут Финанс Аудит” ХХК-аар хийлгэсэн. Үнэлгээнд ашигласан үнэлгээний суурь нь зах зээлийн үнэ, орлуулалтын өртөг, орлогын хандлагын арга байсан. Бодит үнэ цэнийг тохирсон үнэлгээний аргаар тооцоолсон ба дараах таамаглалуудыг ашигласан: Ихэнх барилга, байгууламжийн хувьд гол зах зээл дээр харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байсан учир зах зээлийн арга илүү тохиромжтой байсан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

27. ҮНДСЭН ХӨРӨНГӨ БА БИЕТ БУС ХӨРӨНГӨ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Орон нутгийн хоёр салбарын хувьд тухайн байршилд ижил төрлийн болон харьцуулж болох хөрөнгийн мэдээлэл хангалттай байгаагүй бөгөөд байгаа мэдээлэл нь их зөрүүтэй байсан учир өртгийн арга болон орлогын аргыг ашигласан. Ажиглагдахуйц бус зах зээлийн мэдээлэлд суурилсан бодит үнэ цэнийн хэмжилт болон мэдрэмтгий байдлын шинжилгээг Тодруулга 38-аас харна уу.

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хөрөнгийг өртгөөс хасах нь элэгдэл гэж бүртгэсэн бол барилга байгууламжийн дансны дүн нь 59,414 сая төгрөг (2019 онд 13,440 сая төгрөг) байх байсан. Барилга байгууламжийн дансны үнийг доор харуулав:

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Санхүүгийн байдлын тайланд барилга, байгууламжийн дахин үнэлэгдсэн дүн	89,745	43,771
Өмчийн тайлан дахь дахин үнэлгээний нөөц (Тодруулга 34)	(30,331)	(30,331)
Барилга, байгууламжийн өртгөөс хасах нь хуримтлагдсан элэгдлийн дүн	**59,414**	**13,440**

2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар зээлийн барьцаанд тавьсан үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгө байхгүй байна.

28. ГҮЙЛГЭЭНД ГАРГАСАН БЭЛЭН МӨНГӨ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	1,151,315	927,051
Тоолж шалгаагүй цаасан тэмдэгт	(159,867)	(29,655)
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	22	21
	991,470	897,417

	2019 оны 12-р сарын 31-ний байдлаар Сая.төг	Өсөлт 2020 Сая.төг	Бууралт 2020 Сая.төг	2020 оны 12-р сарын 31-ний байдлаар Сая.төг
Гүйлгээнд гаргасан цаасан тэмдэгт	927,051	1,879,681	(1,655,417)	1,151,315
Гүйлгээнд гаргасан зоосон тэмдэгт	21	60	(59)	22
Дотоодын банкуудаас хүлээн авсан цаасан тэмдэгт*	(29,655)	2,302,890	(2,433,102)	(159,867)
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	897,417	4,182,631	(4,088,577)	991,470

*Дотоодын банкуудаас хүлээн авсан цаасан мөнгөн тэмдэгт нь Банкинд хадгалж хамгаалуулах зорилгоор дотоодын банкуудаас шилжүүлсэн илүүдэл цаасан мөнгөн тэмдэгтүүд ба банкуудын хүсэлтээр буцааж шилжүүлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

29. ТӨВ БАНКНЫ ҮНЭТ ЦААС

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Үнэт цаасны өглөг	7,952,438	4,629,293

Энэхүү үлдэгдэл нь Банкнаас дотоодын банкуудад гаргасан үнэт цаас юм. Эдгээр үнэт цаас нь 7-с 184 хоногийн (2019 онд 7-с 184 хоног) хугацаатай бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар хүүгийн түвшин нь жилийн 7-11 хувь (2019 онд: 11 хувь) байна.

30. ЗАСГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Сангийн яамны харилцах данс	1,451,593	1,556,508
Сангийн яаманд төлөх зээлийн өр төлбөр:		
- Олон Улсын Валютын Сан (ӨСХ)	647,687	594,974
- Германы засгийн газар (КФВ)	–	16,331
- Азийн Хөгжлийн Банк (АХБ)	27,936	28,630
- Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)	4,809	5,142
	2,132,025	2,201,585

Сангийн яамны харилцах дансууд. Эдгээр нь Банкин дахь Сангийн яамны хүү тооцогддоггүй харилцах дансууд юм. Гэхдээ 2020 онд зөвхөн нэг дансанд дунджаар жилийн 3.5 хувийн (2019 онд жилийн 4.5 хувь) хүүг холбогдох гэрээний дагуу тооцож олгосон.

Олон улсын байгууллагуудаас авсан зээллэгтэй холбоотойгоор Сангийн яаманд төлөх өр төлбөр. Эдгээр нь Монгол Улсын Засгийн газар Олон Улсын Валютын Сан (ОУВС), “КФВ” (Герман Улсын Засгийн газрыг төлөөлж), Азийн Хөгжлийн Банктай (АХБ) болон Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА)-тай байгуулсан зээлийн гэрээтэй холбоотой. Энэхүү зээлд Монгол Улсын Сангийн яам санхүүгийн зуучлагчаар, Банк нь энэ төслийг хэрэгжүүлэгчээр ажиллаж байна.

Олон Улсын Валютын Сан (ОУВС). 2017 оны 5 дугаар сарын 24-нд ОУВС-гийн Удирдах Зөвлөл Монгол Улсын эдийн засгийн реформыг дэмжих зорилгоор Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөр (ӨСХ)-ийн хүрээнд гурван жилийн хугацаатай 314.5 сая ЗТЭ-ийн дүн бүхий өргөтгөсөн санхүүжилтийг баталсан. ӨСХ нь ОУВС-гаас Монгол улсад ӨСХ-ийн хүрээнд олгосон жилийн 1.53-аас 1.59 хувийн хүүтэй зээл бөгөөд 2028 онд эргэн төлөлт төлөгдөж дуусахаар байна.

Санхүүжилтийг 2017 оны 5 дугаар сарын 25-нд Монголбанк болон Сангийн яамны хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичигт үндэслэн Банк руу шилжүүлсэн. Эдгээр зээл нь Сангийн яамны өр төлбөр болно. Сангийн яам нь Монгол Улсын санхүүгийн зуучлагч болохын хувьд ОУВС-гийн ӨСХ-ийн хүрээнд олгосон зээлийн эргэн төлөлттэй холбоотой өрийн бичгийг гаргасан бөгөөд дээрх зээлийн эргэн төлөлтийг ОУВС-гийн өмнө хүлээнэ.

Олон Улсын Валютын Сан (ОУВС).Зээл болон түүний эргэн төлөлт нь ЗТЭ-ээр илэрхийлэгдсэн бөгөөд Монголбанк Сангийн яамны өмнөөс ОУВС-д хуваарийн дагуу эргэн төлөлтийг хийнэ. 2020 оны

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

30. ЗАСГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ (ҮРГЭЛЖЛЭЛ)

12 дугаар сарын 31-ний байдлаар ӨСХ-ийн хүрээнд Сангийн яаманд өгөх өр төлбөрийн хэмжээ гурван жилийн хугацаатай 157.5 сая ЗТЭ буюу 645,616 сая төгрөг (2019 онд 158 сая ЗТЭ буюу 594,974 сая төгрөг) байсан.

КФВ-аас авсан зээл нь жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилготой 1995 он болон 2003 оны хөтөлбөрийн дагуу олгогдсон. Эдгээр зээлүүд нь еврогоор олгогдсон бөгөөд жилийн 0.75 хувийн хүүтэй, тус тус 30-аас 40 жилийн хугацаатай. Зээлийн үндсэн төлөлт 2005 оноос эхэлсэн ба 2012 оноос эхлэн хоёр дахь хөтөлбөрийн үндсэн төлбөр төлөгдөж эхэлсэн.Тайлант жилд уг зээл төлөгдөж дууссан (2019: 16,331 сая төгрөг).

Азийн Хөгжлийн Банк (АХБ)-аас авсан зээл нь Монголд ядуурлыг бууруулах, хувийн бизнесийн салбарыг хөгжүүлэх, Засгийн газарт болон төрийн бус байгууллагууд, банкуудад зөвлөгөө өгөх, сургалт явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгогджээ. Зээл нь жилийн 1 болон 2.5 хувийн хүүтэй, 17- оос 27 жилийн хугацаатай байна.

Дээр дурьдсан эх үүсвэрүүд нь маш бага буюу жилийн 0.75-аас 1 хувийн хүүтэй, сонгогдсон эдийн засгийн секторууд болон бусад бага хүү шаардлагатай өөр бусад тусгай зорилтуудыг хангах зорилгоор зээлдүүлэх нөхцөлтэй. Удирдлага нь энэхүү зээлийг анхны хүлээн зөвшөөрөлт болон эхэлж бүртгэхдээ ашиг бүртгэх шаардлагатай эсэхийг харгалзан үзсэн. Ингэхдээ эдгээр зээлийг харилцан тохиролцсон төсөлд заасан тусгай зорилготой зах зээлд зориулсан буюу нийтийн ашиг сонирхолд үйлчлэх хүүгүй эсвэл маш бага хүүтэй зээлийн хэрэгсэл хэмээн удирдлага үзсэн. Энэхүү зээлийн эх үүсвэрийг ашиглан тодорхой шалгуур хангасан арилжааны банкуудад бага хүүгээр санхүүжилт хийх буюу зээл олгох боломжтой байна. Иймд эдгээр зээлийн анхны хүлээн зөвшөөрөлтийн олзыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй.

Санхүүжилтийн үр дүнд Банк нь шаардлага хангасан банкуудад хөнгөлөлттэй нөхцлөөр зээл олгох боломжтой болсон. Удирдлага нь дээрх хэрэгслүүдийг анхлан хүлээн зөвшөөрөх үед алдагдал хүлээн зөвшөөрөх шаардлагатай эсэхийг авч үзсэн. Эдгээр зээлүүд нь холбоогүй талуудад олгогдсон учир зээлийг зах зээлийн хүүгээр олгосон бөгөөд анх хүлээн зөвшөөрөлтийн алдагдлыг хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн. Дээрх үнэлэмжид эдгээр хэрэгслүүд нь анхдагч зах зээлд олгогдсон гэдгийг авч үзсэн болно.

Сангийн яам нь Засгийн газрыг төлөөлөн хэрэгжүүлэгч агентын үүрэг гүйцэтгэдэг учир Банк ОУВС, КФВ болон АХБ-ны төлбөр тооцоонд шууд хариуцлага хүлээхгүй. Гэхдээ эдгээр зээлийн төслүүдийг хэрэгжүүлэгчийн хувьд Банк нь зээлийн хөрөнгийг дотоодын банкуудад оновчтой хуваарилах үүрэгтэй бөгөөд тэдгээр дотоодын банкууд нь ОУВС, КФВ болон АХБ-ны шалгуурт тэнцсэн зээлийн эцсийн хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагааг хариуцна.

Сангийн яам ба Банк хоорондын гэрээний дагуу Банк нь Сангийн яамнаас ОУВС, КФВ болон АХБ-ны гэрээний ижил нөхцөлтэйгээр эдгээр зээлүүдийг авсан байна. Банк нь эдгээр зээлийн хөрөнгийг өөрийн дансанд байршуулж буйн хувьд, ОУВС, КФВ, АХБ болон Сангийн яамны хоорондын төлбөр тооцоог зохицуулах үүрэгтэй. Энэхүү зээлийн хөрөнгөөс дотоодын банкуудад олгогдсон зээлийн дэлгэрэнгүйг Тодруулга 18-аас харна уу.

Олон улсын хөгжлийн агентлаг (ОУХА) Монгол улсыг төлөөлж Сангийн яамны авсан зээл нь хувийн хэвшлийг дэмжих төсөл болон санхүүгийн чадавхыг дээшлүүлэх төслүүдэд зориулагдсан бөгөөд Сангийн яамнаас жилийн 1-3 хувийн хүүтэй, 14-өөс 15 жилийн хугацаатай зээлүүд болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

31. ДОТООДЫН БАНКУУДЫН ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Харилцах дансууд:		
- төгрөгөөр	1,249,089	1,999,419
- валютаар	2,316,318	2,415,955
Төгрөгийн овернайт хадгаламж	106,515	496,622
Гадаад валютын хадгаламж	199,475	1,126,708
	3,871,397	6,038,704

Эдгээр нь дотоодын банкуудаас харилцагчдынхаа хадгаламжийн тодорхой хувиар тооцож Банкинд заавад байлгах нөөц болон бусад төрлийн хадгаламжууд юм.Банк нь заавал байлгах нөөцийг хэмжээг тогтоодог ба шаардлагын хангасан үед банкуудад урамшууллын хүүг олгодог.

Урамшууллын хүү нь Банкны овернайт хадгаламж хүүгийн 50 хувьтай тэнцүү буюу 2020 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар жилийн 2.5 хувийн хүүтэй (2019 онд жилийн 4.5 хувийн хүү) байна. 2020 онд дотоодын банкуудын заавал байлгах нөөцийн биелэлтэд олгосон урамшуулал 52,378 сая төгрөг (2019 онд 76,035 сая төгрөг) байна. Тодруулга 7-с харна уу.

2020 оны 12 дугаар сарын 31-нээрх төгрөгийн овернайт хадгаламж нь дотоодын банкуудын байршуулсан жилийн 5 хувийн хүүтэй 4 хоногийн хугацаатай (2019 онд 9 хувийн хүүтэй 2 хоногийн хугацаатай) хадгаламж болно.

Гадаад валютын хадгаламж нь 28 хоногийн хугацаатай, жилийн 0.19 хувийн хүүтэй дотоодын банкуудын байршуулсан ам.долларын хадгаламжийг илэрхийлнэ.

32. ГАДААД ӨР ТӨЛБӨР

	2020 Сая.төг	2019 Сая.төг
ХАБ-тай байгуулсан хэлэлцээр	5,332,233	4,785,483
Эм Ю Эф Жи банкнаас авсан зээл	255,613	–
ОУВС-гийн ЗТЭ-ийн хуваарилалт	200,102	183,945
Дэлхийн банкны харилцах данс	1,281	33
Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	179	172
АХБ-ны харилцах данс	61	12
ОУХА-д оруулсан хувь хөрөнгө	39	39
	5,789,508	4,969,684

Хятадын Ардын банк (ХАБ)-ны санхүүжилт. Энэ нь дотоодын банкуудыг юаниар хангах зорилгоор ХАБ-аас 7-8 сарын хугацаатай (2019: 7-8 сар), юаниар авсан санхүүжилтийг илэрхийлнэ. Жилийн хүүгийн түвшин нь Шанхайн банк хоорондын санал болгосон хүүгийн түвшин (“ШИБОР”) дээр 200 нэгж нэмсэнтэй тэнцэнэ. Уг хэлэлцээртэй холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 35-аас үзнэ үү.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

32. ГАДААД ӨР ТӨЛБӨР (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эм Ю Эф Жи банкнаас авсан зээл. Алт олборлогч аж ахуй нэгжүүдэд санхүүжилт олгох замаар алт цэвэршүүлэгч Самсунг компанид цэвэршүүлэх Монголбанкны алтны нийлүүлэлтийн нэмэгдүүлэх зорилгоор Банк 2020 оны 6 дугаар сарын 12-ны өдөр Эм Ю Эф Жи Банк болон Сумитомо Мицуй Банк Корпорацитай нийт 10,800 сая иенийн гэрээ байгуулсан. Гэрээнд Эм Ю Эф Жи Банк нь санхүүжүүлэгч, зохицуулагч банк болон агент, Сумитомо Мицуй Банк Корпораци санхүүжүүлэгчээр оролцсон. Зээлийн хүү нь жилийн 3 сарын хугацаатай Лондонгийн банк хоорондын санал болгосон иенийн хүүгийн түвшин (“ЛИБОР”) дээр 2.5 хувь нэмсэнтэй тэнцэнэ. Банк зээлийг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Самсунгруу 7 удаагийн алтны ачилтаар төлж барагдуулах бөгөөд алтны ханшийг Лондонгийн үнэт цаасны захын алтны унцын үнээр тооцно. Гэрээгээр заасан ачилтын хэмжээ нь үндсэн төлбөрийн хэмжээнээс өндөр байхаар тогтоосон бөгөөд үлдэх төлбөрийг Банк харилцах дансандаа хүлээн авна. Хэрэв Банк ачилт бүрт нийлүүлэхээр тохиролцсон алтны хэмжээг дутаасан тохиолдолд дутаасан хэмжээнд үндсэн хүүгээр төлөх үүрэгтэй. Энэхүү гэрээтэй холбоотойгоор Банк 47.8 сая иен (1.26 тэрбум төгрөг)-н алт цэвэршүүлэлтийн хураамжийг Самсунг компанид үл буцаан дуудагдах нөхцөлтэйгээр төлнө.

Зээлжих Тусгай Эрхийн Хуваарилалт(“ЗТЭ”). ОУВС-ийн гишүүн орнуудад ОУВС-д нийлүүлсэн хөрөнгөтэй хувь тэнцүүлэн ЗТЭ хуваарилдаг. Энэ нь Тодруулга 17-д тайлбарласан ЗТЭ-ийн дансанд буй хөрөнгөтэй харгалзах ОУВС-д Банкны өр төлбөрийг илэрхийлнэ. Энэхүү хуваарилалтын дүн нь 48,757 сая ЗТЭ-тэй тэнцэх 200,102 сая төгрөг (2019: 48,757 сая ЗТЭ -тэй тэнцэх 183,945 сая төгрөг) байна.

Дэлхийн банк ба ОУХА-д оруулсан хувь хөрөнгө. Энэ нь Банкны Дэлхийн банк ба ОУХА-нд гишүүнчлэлийн нөхцөлийн дагуу хувь оруулсан үүргийг илэрхийлнэ.

33. БУСАД ӨР ТӨЛБӨР

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Бусад санхүүгийн өр төлбөр		
Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгө	324,941	6,789
Бусад өглөг	38,216	23,067
Бусад өр төлбөр		
Нийгмийн хөгжлийн сан	2,160	1,533
	365,317	31,389

Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж. Банк бус санхүүгийн байгууллагаас байршуулсан хадгаламж нь Үнэт цаасны төлбөр тооцооны төв, Хадгаламжийн даатгалын корпорацийн харилцах дансуудаас бүрдэнэ.

Нийгмийн хөгжлийн сан. Банк дотоод журмынхаа дагуу тодорхой хэмжээний хөрөнгийг ажилтнуудын ажлын болон амьжиргааны нөхцөлийг сайжруулах зорилгоор Нийгмийн хөгжлийн санд хуваарилдаг. Энэхүү хөрөнгө Банкны ажилтанд тэтгэмж, тусламж олгох, ажлын үзүүлэлтээр урамшуулах, ажилтны нийгмийн байдлыг хангах үүднээс орон сууц худалдан авахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед нь санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд зориулагдсан байна. Банкны удирдлага санхүүгийн жилийн эцсээр Нийгмийн хөгжлийн санд хуваарилсан хөрөнгийг хүлээгдэж буй үүргээ биелүүлэхэд хангалттай гэж үзсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САНГУУД

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Дүрмийн сан	60,000	60,000

Бусад нөөцийн дэлгэрэнгүйг дор үзүүлэв:

	БҮЦӨБДО-оорх хөрөнгө оруулалтын үнэт цаасны дахин үнэлгээний сан Сая.төг	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний сан Сая.төг	Үнэт металын дахин үнэлгээний сан Сая.төг	Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний сан Сая.төг	Нийт Сая.төг
2019 оны 01 дүгээр сарын 01-нээр	4,437	30,331	176,343	924,729	1,135,840
БҮЦӨБДО-оор илэрхийлэгдэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн ашиг	67,353	–	–	–	67,353
Бодит үнэ цэнийн өөрчлөлтөд багтсан ЗҮЦХА-н дүн	(651)	–	–	–	(651)
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн	3,833	–	–	–	3,833
Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдэл	–	–	–	137,035	137,035
Хуримтлагдсан алдагдлаас шилжүүлсэн	–	–	396,396	–	396,396
2019 оны 12 дугаар сарын 31-нээр буюу 2020 оны 01 -р сарын 01-нээр	74,972	30,331	572,739	1,061,764	1,739,806
БҮЦӨБДО-оор илэрхийлэгдэх өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийн ашиг	91,685	–	–	–	91,685
Бодит үнэ цэнийн өөрчлөлтөд багтсан ЗҮЦХА-н дүн	3,976	–	–	–	3,976
Борлуулах үед ашиг алдагдал руу шилжүүлсэн	(3,262)	–	–	–	(3,262)
Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдэл	–	–	–	–	–
Хуримтлагдсан алдагдал - (руу)/аас шилжүүлсэн	(4,624)	–	130,681	–	126,057
2020 оны 12-р сарын 31-нээр	162,747	30,331	703,420	1,061,764	1,958,262

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

34. ДҮРМИЙН САН БОЛОН БУСАД НӨӨЦ САНГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

БҮЦӨБДО илэрхийлэгдэх өрийн үнэт цаасны дахин үнэлгээний нөөц сан. Энэхүү санд бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэх өрийн үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бүртгэнэ. ЗҮЦХА-ын сангийн хөдөлгөөнд БҮЦӨБДО-оор бүртгэгдэх засгийн газрын үнэт цаас болон өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралт багтана. Тайлант жилд 4,624 сая төгрөгийн МИК Холдинг ХК-ийн энгийн хувьцааны бодит үнэ цэнийн сан нь уг хөрөнгө оруулалтыг борлуулах үед хуримтлагдсан алдагдалруу шилжсэн.

Барилга байгууламжийн дахин үнэлгээний нөөц сан. Банкны барилгын дахин үнэлгээнээс үүссэн нэмэгдлийг өөрийн хөрөнгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний санд бүртгэсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 27-с харна уу.

Мөнгөжсөн алт, үнэт металын болон Гадаад валютын дахин үнэлгээний нөөц сан. Энэхүү санд мөнгөжсөн алт, үнэт металын ханшийн тэгшитгэлээс үүссэн мөн гадаад валютаар илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн тэгшитгэлээс үүссэн бодит бус ашгийг бүртгэсэн.

Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нөөц сан. Энэ санд Эрдэнэсийн сангийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэсэн. Дэлгэрэнгүйг Тодруулга 23-с харна уу.

35. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Шийдэгдээгүй хэрэг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дээрх заргуудаас өөр ямар нэгэн материаллаг гарз учруулах нэхэмжлэгчээр дуудагдсан шүүн таслах хуулийн хэргийн талаар удирдлагад мэдээлэл байхгүй байна. Иймд ямар нэг санг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг. Банк нь Монгол Улсын засгийн газар, түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий салбарт (бараа үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг хүлээдэг. Эдгээр хэрэгслүүдийн гол зорилго нь Засгийн газар болон холбогдох талуудыг шаардлагатай эх үүсвэрээр хангахад оршино.

Гаргасан аккредитивүүд нь зээл болон аккредитивийн хэмжээнээс ашиглагдаагүй үлдсэн хэсгийг илэрхийлнэ. Банк ийм зээлтэй холбоотой төлбөрийн үүргийн хувьд уг зээлээс ашиглагдаагүй үлдсэн хэмжээгээр алдагдал хүлээх эрсдэлтэй юм.

Гэвч ихэнх зээл нь зээлийн эрсдэл багатай харилцагчдад олгогддог тул энэхүү болзошгүй алдагдлын хэмжээ нь нийт ашиглагдаагүй байгаа төлбөрийн үүргийн хэмжээнээс бага байна. Зээлтэй холбоотой төлбөрийн хариуцлагын хэмжээг дор харуулав:

	2020 Сая.төг	2019 Сая.төг
Болзошгүй өр төлбөр		
Импортын аккредитивүүд	(35,898)	(77,387)
Төлбөрийн үүрэг хариуцлага		
Хятадын ардын банкинд өгөх ашиглаагүй зээлийн шугамын эх үүсвэр	(6,000,000)	(5,400,000)
	(6,035,898)	(5,477,387)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

35. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Импортын аккредитивүүд. Импортын аккредитив нь Монгол Улсын Засгийн газарт импортын гэрээ хэлцэлтэй холбоотойгоор олгогдоно. Импортын аккредитивээр Банк Монгол Улсын Засгийн газрын эсвэл төрийн байгууллагуудын өмнөөс тэдгээрт болон Засгийн газрын хүсэлтээр бусад байгууллагуудад үйлчилгээ үзүүлсэн ба бараа бүтээгдэхүүн нийлүүлсэн гадаадын хуулийн этгээдүүдэд төлбөр шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Хятадын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээр. Банк нь 2011 оны 5 дугаар сард Хятадын Ардын банктай "Хятадын юань/Монгол төгрөг солилцох своп хэлэлцээр"-ийн гэрээ байгуулсан ба гэрээг 2014 оны 8 дугаар сард болон 2017 оны 7 дугаар сард шинэчлэн баталсан. Төв банкууд уг мөнгийг хоёр улсын хоорондох худалдааг санхүүжүүлэх, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор богино хугацаанд хөрвөх чадварыг хангах болон гэрээгээр тохирсон бусад зорилгоор ашиглах боломжтой.

Гэрээний дагуу Хятадын Ардын банк болон Банк нь хятадын юаниар төгрөг, монгол төгрөгөөр юань худалдан авах, худалдах хэлцлийг цаашид тодорхой хугацаанд хийх боломжтой. Гэрээнд зааснаар энэхүү хөрөнгийн ашиглах хугацаа 12 сар хүртэл байна. Хөрөнгө ашиглах зөвшөөрлийг нэг тал нь нөгөө талаас авах ёстой ба тухайн ашиглах хөрөнгийн дээд хэмжээ нь Банкны хувьд гэрээний дүн болох 15,000 сая юань (2019 онд 15,000 сая юань), Хятадын Ардын банкны хувьд 6,000,000 сая төгрөгөөр (2019 онд 5,400,000 сая төгрөг) хязгаарлагдана.

Хөрөнгийг ашиглах банк хөрөнгийн хэмжээндээ гэрээнд заагдсан хүүг тооцон төлөх үүрэгтэй. Банк юань ашигласан тохиолдолд, хүүгийн түвшин нь Шанхай-Интер банкны санал болгосон түвшин ("ШИБОР") дээр 200 үндсэн оноо нэмсэнтэй тэнцэх ба ашиглах хугацааны турш тооцно. Харин Хятадын Ардын банк төгрөг ашигласан тохиолдолд, харгалзах ашиглалтын хугацаанд хүүгийн түвшин нь банк хоорондын төгрөгийн жигнэсэн дундаж хүүгийн түвшинтэй тэнцүү байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкны зээлтэй холбоотой үүрэг хариуцлага нь ашиглагдсан дүн болох 12,000 сая юань буюу 5,233,560 сая төгрөг (2019: 12,000 сая юань буюу 4,693,440 сая төгрөг) ба ашиглагдаагүй дүн болох 3,000 сая юань буюу 1,308,390 сая төгрөг (2019: 3,000 сая юань буюу 1,173,360 сая төгрөг) байгаа нь Банкны хувьд цаашид хүлээн авч болох санхүүжилтийн үүргийг илэрхийлнэ.

Банкны удирдлага нь аккредитивийн гэрээ болон зээлийн шугамтай холбоотой өр төлбөрийн дүн нь материаллаг бус гэж үзсэн. Эдгээр ашиглагдаагүй зээлийн шугам болон аккредитив нь санхүүжилт хийгдэлгүйгээр хугацаа дуусах боломжтой. ЗҮЦХА-г зээлийн хөрвүүлгийн факторын аргаар үнэлсэн бөгөөд эдгээр үлдэгдлийн хүлээгдэж буй зээлийн алдагдал нь материаллаг бус дүнг илтгэнэ. Иймд Банк ямар нэг санг зээлийн үүрэг хариуцлагын хувьд болон санхүүгийн баталгааны хувьд хүлээн зөвшөөрөх шаардлагагүй гэж үзсэн.

Хөрөнгийн үүрэг. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 2,388 сая төгрөгийн хөрөнгийн үүрэг (2019 онд 15,608 сая төгрөг) хүлээсэн ба энэ үүргийн ихэнх нь Төв банкны шинэ барилгын ажил болон мэдээллийн технологийн баазтай холбоотой.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

36. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ

Банк 2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дараах холбоотой талуудтай хийсэн гүйлгээ болон данснуудын үлдэгдлийг тодруулгад тусгасан. Үүнд: Засгийн газар (Сангийн яам зэрэг удирдлагыг нь Улсын Их Хурал болон Засгийн газраас томилдог байгууллагуудыг оролцуулна), Сангийн яам бүрэн эзэмшиж УИХ-аас удирдлагыг томилдог дотоодын банк болох Төрийн банк, мөн засгийн газрын эзэмшилд байж ЗГ-аас удирдлагыг томилдог Хөгжлийн банк, ба ХДК хамаарна. ХДК нь бүрэн төрийн өмчит бөгөөд үйл ажиллагааных нь бүх шийдвэр Банкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгчийн тэргүүлдэг Үндэсний Хорооны долоон гишүүний саналаар батлагдах ёстой.

Банк НББОУС 24-т орсон өөрчлөлт болох “Төрийн байгууллагуудын тодруулгад тавигдах шаардлагыг хэсэгчлэн чөлөөлөх“ заалтыг ашигласан. Иймд төрийн байгууллагуудтай хийсэн материаллаг бус гүйлгээнүүдийг тус санхүүгийн тайланд тусгаагүй болно. 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх холбоотой талуудын эзэмшиж буй дансны үлдэгдэл доорх байдалтай байна:

2020 оны 12-р сарын 31	**Засгийн газар**	**Төрийн банк**	**Хөгжлийн банк**	**ХДК**	**Нийт**
	Сая.төг	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**	**Сая.төг**
Засгийн газрын үнэт цаас	227,408	–	–	–	227,408
Хөгжлийн банкны үнэт цаас	–	–	55,650	–	55,650
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	–	5,028	–	–	5,028
Дотоодын банкуудад олгосон зээл	–	38,158	–	–	38,158
Санхүүгийн бус байгуулагуудад олгосон зээл	–	–	–	148,958	148,958
Дотоодын банкуудтай хийсэн своп хэлцэл	–	(710)	(52,435)	–	(53,145)
Төв банкны үнэт цаас	–	(921,758)	(98,936)	(169,453)	(1,190,147)
Дотоодын банкуудын хөрөнгө	–	(184,959)	(40,874)	–	(225,833)
Банк бус байгууллагуудын хөрөнгө	–	–	–	(320,436)	(320,436)
Засгийн газрын хөрөнгө	(2,132,025)	–	–	–	(2,132,025)
Нийт	(1,904,617)	(1,064,241)	(136,595)	(340,931)	(3,446,384)
Хүүгийн орлого	12,348	4,135	90,512	321	107,316
Хүүгийн зардал	(31,139)	(62,723)	(73,334)	(31,326)	(198,522)
Хураамж шимтгэлийн орлого	73	2,128	–	–	2,201
Нийт	(18,718)	(56,460)	17,178	(31,005)	(89,005)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

36. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2019 оны 12-р сарын 31

Засгийн газрын үнэт цаас	134,028	–	–	–	134,028
Хөгжлийн банкны үнэт цаас	–	–	49,522	–	49,522
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	–	–	–	–	–
Дотоодын банкуудад олгосон зээл	–	51,732	–	–	51,732
Санхүүгийн бус байгуулагуудад олгосон зээл	–	–	–	149,092	149,092
Дотоодын банкуудтай хийсэн своп хэлцэл	–	–	31,932	–	31,932
Төв банкны үнэт цаас	–	(774,323)	–	(206,068)	(980,391)
Дотоодын банкуудын хөрөнгө	–	(322,036)	(140,528)	–	(462,564)
Банк бус байгууллагуудын хөрөнгө	–	–	–	(5,889)	(5,889)
Засгийн газрын хөрөнгө	(2,201,585)	–	–	–	(2,201,585)
Нийт	(2,067,557)	(1,044,627)	(59,074)	(62,865)	(3,234,123)
Хүүгийн орлого	11,603	6,404	97,029	425	115,462
Хүүгийн зардал	(60,819)	(72,686)	(117,952)	–	(251,458)
Хураамж шимтгэлийн орлого	239	1,647	–	–	1,886
Нийт	(48,977)	(64,635)	(20,923)	425	(134,110)

Бизнесийн ердийн үйл ажиллагааны үр дүнд дээр дурдсан үлдэгдэл дүнгүүд үүссэн болно. Холбоотой талд олгосон зээлээс бусад тайлант жилийн эцсээрх үлдэгдэл дүнгүүд барьцаагүй.

Импортын аккредитив гэрээ. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банк 35,898 сая төгрөгийн (2019: 77,387 сая төгрөг) холбоотой талуудын импортын аккредитив гэрээний өр төлбөртэй байсан. Дэлгэрэнгүйг Тодруулга 35-аас харна уу.

Банкны үндсэн удирдлагын цалин болон бусад тэтгэмжийн талаарх мэдээллийг дор толилуулав:

	2020	**2019**
	Сая.төг	**Сая.төг**
Цалин хөлс	1,406	1,292
Нийгмийн болон тэтгэврийн санд төлсөн шимтгэл	207	240
Тэтгэмжүүд	249	191
Бусад олговор	189	30
	2,051	1,753

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банкны үйл ажиллагаа нь ямагт эрсдэлтэй байдаг ба тэдгээрийг зөв тодорхойлж, хэмжиж, хянаж байснаар эрсдэлийг хязгаарлаж, бусад хяналтын бодлогоор удирддаг. Эрсдэлийг зохистой удирдах нь банкуудын үйл ажиллагааг хэвийн явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах, мөнгөний бодлого явуулах, тухайлбал инфляцыг зохистой түвшинд барихад чухал ач холбогдолтой. Эрсдэлүүд нь банкны үндсэн зорилгодоо хүрэх чадварыг хязгаарлах үр дагавартай байж болно. Ийм өндөр үр дагавартай эрсдэл Банкинд илүүтэй илрэх бөгөөд гадаад валютын хөрвүүлгээс хүлээх санхүүгийн гэнэтийн алдагдал нь үүний нэг жишээ болно. Санхүүгийн алдагдал нь бүхий л төрлийн санхүүгийн эрсдэлээс хамааралтай үүсдэг.

Үүнээс гадна Банк нь зээлийн, хөрвөх чадварын, зах зээлийн, үйл ажиллагааны, нэр хүндийн зэрэг эрсдэлд өртөж болно. Одоогийн банкны эрсдэлийн удирдлага нь төвлөрсөн бус ба газар, хэлтэс тус бүр тэдгээрийн үйл ажиллагаанд учирсан аливаа эрсдэлээс сэргийлэх бодлогыг баримталдаг. Банк нь Монгол Улсын Төв банк учраас түүний эрсдэлүүд онцгой байдаг ба тэдгээр эрсдэлүүдийг Банк стратеги төлөвлөлтийн үйл явцаар дамжуулан хянаж, илрүүлж байдаг. Үүнээс гадна Банк нь эрсдэлийн хяналтын стратегийг боловсруулах ба зарчим, хүрээ, бодлого хязгааруудыг хэрэгжүүлэх ажлыг ерөнхийлөн хариуцах “Эрсдэлийн хороо”-г байгуулах боломжийг идэвхтэй судалж байна.

Одоогоор Хөрөнгө оруулалтын хороо нь эрсдэлийн стратегийг боловсруулж, шаардлагатай хязгаарыг тогтоох үүрэгтэй ба Эрсдэлийн удирдлагын алба болон Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь үүнтэй холбоотой зарчмууд, үйлчлэх хүрээ, бодлого, хязгаарыг хэрэгжүүлдэг.

37.1 Эрсдэлийн удирдлагын бүтэц

Захирлуудын зөвлөл нь эрсдэлийг хянах ба энэ асуудлаар эцсийн хариуцлагыг хүлээнэ. Гэхдээ эрсдэлийг тодорхойлох, удирдах, хянах үүрэг бүхий бие даасан нэгжүүд байдаг.

Захирлуудын Зөвлөл. Захирлуудын Зөвлөл ерөнхий эрсдэлийн удирдлага болон эрсдэлийн стратеги, бодлогыг батлахаас гадна эрсдэлтэй холбоотой асуудлаар Банкны Ерөнхийлөгч, Тэргүүн Дэд Ерөнхийлөгчид зөвлөмж өгдөг.

Хяналтын Зөвлөл. Хяналтын зөвлөл нь Банкны дотоод бүтэц, зохион байгуулалтад харьяалагддаггүй бөгөөд бие даасан хяналт тавьж, Банк доторх ерөнхий эрсдэлийн үйл явцыг нь хянах үүрэгтэй.

Хөрөнгө оруулалтын хороо. Хөрөнгө оруулалтын хороо нь Банкны санхүүгийн эрсдэлийг удирдах үүрэгтэй хамгийн үндсэн нэгж бөгөөд Захирлуудын Зөвлөл болон Ерөнхийлөгчид санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлогын талаар зөвлөмж өгдөг. Хөрөнгө оруулалтын хорооны бүрэлдэхүүнд Тэргүүн Дэд Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Эрсдэлийн удирдлагын албаны захирал, Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал, Санхүү бүртгэлийн газрын захирал багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо нь тайлант оны “Жилийн хөрөнгө оруулалтын бодлого”-ыг хэлэлцэж, зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинг тодорхойлдог. Энэхүү зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд үндэслэн улсын гадаад валютын нөөцийн бүтцийг гарган Ерөнхийлөгчид танилцуулж, батлуулдаг байна. Үүнд гадаад валютын нөөцийн бүтэц, түүний зохистой хэлбэлзэл, хөрөнгийн хуваарилалт, хөрөнгө оруулалтын хугацаа, боломжит хэрэгсэл, харилцагч байгууллагад тавьсан хязгаарлалт зэргийг тусгасан байдаг. Мөн Ерөнхийлөгч гадаад валютын нөөцтэй холбоотой харилцагч банк санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт тавих лимитийг улирал тутамд батлах ба энэ нь гадаад валют, зээл, хөрвөх чадвар, хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол арга хэрэгсэл болдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны санхүүгийн эрсдэлүүдээс гадаад валютын нөөцийн эрсдэл нь хамгийн чухал байдаг. Тиймээс Хөрөнгө оруулалтын хороо болон холбогдох газруудын үйл ажиллагаа нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийг удирдахад түлхүү чиглэгдсэн байна. Хөрөнгө оруулалтын хорооны өөр нэгэн үүрэг бол Эрсдэлийн удирдлагын алба, бусад холбогдох газруудад хяналт тавих, санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн эрсдэлийн бодлогын хэрэгжилт нийцтэй байгаа эсэхийг хянах үүрэгтэй байдаг. Санхүүгийн эрсдэлийг удирдах зорилгоор ашигласан аргуудыг доор толилуулав.

Эрсдэлийн Удирдлагын Алба. Эрсдэлийн удирдлагын алба (“ЭУА”) нь гадаад валютын улсын нөөцтэй холбоотой эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, бусад эрсдэлтэй холбоотой үйл ажиллагаанд хараат бус хяналт тавих үүрэгтэй. Мөн гадаад валютын нөөцийн удирдлага, эрсдэлийн бодлого боловсруулах, бенчмаркийн биелэлтийг хангуулах, лимитийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг эрхэлдэг. Мөн түүнчлэн ЭУА гадаад валютын улсын нөөцийн эрсдэл, бүртгэлийн системтэй холбоотой эрсдэлийн арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх үүрэгтэй.

Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журамд зааснаар, нөөцийн удирдлагын үндсэн зорилго нь төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийг тогтвортой байлгах, төлбөрийн тэнцлийн алдагдлыг хямралын үед санхүүжүүлэх, богино хугацаат гадаад өр төлбөрийг барагдуулахад шаардлагатай зохих хэмжээний гадаад валютын нөөцийг бүрэлдүүлэн бэлэн байлгахад оршино. Гадаад валютын улсын нөөцийг эзэмшиж буй гол зорилго нь:

- Мөнгөний бодлогыг дэмжих;
- Валютын зах зээлийн ханшийн хэт хэлбэлзлийг зохицуулах;
- Засгийн газрын гадаад валютын өр төлбөрт баталгаа гаргах;
- Улс орны хэмжээнд тохиолдсон гамшиг болон онцгой байдлын үед мөнгөний эх үүсвэр болгон хэрэглэх зэрэг болно.

Санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бодлоготойгоор удирдаж, хянах нь гадаад валютын нөөцийн эрсдэлийн удирдлагын дээрх зорилгод дэмжлэг болно. Гадаад эрсдэлийг хянах зорилгоор Банк нь гадаад активыг сонгох, хуваарилах стратегийг тодорхойлдог. Үүнд нөөцийг байршуулах чөлөөтэй хөрвөх валютыг сонгох, валютуудын бэлэн байлгах хэмжээ, ямар бүтэцтэй байлгах, хөрвөх чадварын болон аюулгүй байлгах шаардлагуудад нийцүүлж хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийг ямар түвшинд барих, хүүгийн эрсдэлийг хянахын тулд хэрэгслүүдийн хугацаа ямар байх ёстой гэх мэт параметрүүдийг тогтоох зэрэг багтдаг.

Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газар нь хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхой нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлэх үүрэгтэй. Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газрын захирал нь хөрөнгийн багцын бүтэц буюу хөрөнгийн бүрдэл хэсэг, хэрэгслүүд, харилцагч талууд, дуусгавар хугацаа, гадаад валютын нөөцийн хязгаарлалт зэргийг удирдах, хянах үүрэгтэй.

Дотоод аудитын газар. Банк нь зорилгодоо хүрэх, бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн тулд Банкны үйл ажиллагаан дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо зохистой, үр ашигтай эсэхийг шалгах, үнэлэх нь Дотоод аудитын газар (ДАГ)-ын эрхэм зорилго юм. ДАГ нь Банкны мөрдөж буй бодлого, холбогдох горимуудын төлөвлөлт болон зохион байгуулалт, зохицуулалт, хэрэгжилттэй холбоотой үйл ажиллагааны, эрсдэлийн удирдлагад хяналт тавих санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээллийн иж бүрэн байдал, аюулгүй байдлыг хангах зэрэг үйл ажиллагаанууд нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхийг шалгах үүрэг бүхий нэгж болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ДАГ нь эрсдэлийн ерөнхий болон тусгайлсан үнэлгээг хийдэг. Эрсдэлийн зэрэгт нь тааруулан дотоод боловсон хүчний нөөцийг зохистой хуваарилах үүднээс урт хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулж эрсдэлийн ерөнхий үнэлгээг тодорхойлж гүйцэтгэдэг бол эрсдэлийн тусгайлсан үнэлгээг тодорхой нэг асуудал үүссэн цаг тухай бүр хийдэг. ДАГ нь Банкны 2020 оны хяналт, шалгалтын ажлын хөтөлбөр, жилийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд үйл ажиллагааны хэсэг нэг бүрийн болзошгүй болон бодит эрсдэлийн зэргийг тусган харуулж чадах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж хяналт шалгалтын ажлын дэс дараалыг тогтоосон байна.

Энэ зорилгын үүднээс тодорхой зарим нэг шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулдаг ба шалгах гэж буй үйл ажиллагаанаас хамааран шалгуур үзүүлэлтийн төрөл нэг бүр дээр зохих жигнэсэн оноог гаргана. Үйл ажиллагааны хэсэг нэг бүр дээр жинлэсэн онооны нийт дүнг гаргаж, тэдгээрийг эрсдэлийн зэргээр нь өндөр, дунд, бага гэж ангилна.

Дотоод хяналтын системийг үнэлэх ажил нь дотоод аудитын ажлын маш чухал хэсэг юм. Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь зохистой горимууд, чадварлаг гүйцэтгэл байгаа эсэхийг баталгаажуулах түүнчлэн санхүүгийн тайлагналын системийн найдвартай байдал, бүх үйл ажиллагааны хууль журмын нийцлийг баталгаажуулах явдал юм. ДАГ нь хяналтын дүгнэлт болон өөрсдийн зөвлөмжүүдийг Ерөнхийлөгч болон Хяналтын зөвлөлд тайлагнадаг. Шалгалт бүрийн эцэст ДАГ Банкны удирдлагуудтай шалгалтын үр дүнг хэлэлцэж, удирдлагын авч хэрэгжүүлсэн арга хэмжээг эргэн хянадаг.

37.2 Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулсан хэрэглэгч, үйлчлүүлэгч, харилцагч талууд үүргээ биелүүлж чадахгүйд хүрснээс үүдэн алдагдал хүлээж болох нэг төрлийн эрсдэл юм. Банкны харилцагч талуудтай хийсэн ажил гүйлгээ болон банкны зээл олголтоос үүдэн зээлийн эрсдэл бий болдог бөгөөд энэ нь санхүүгийн хөрөнгөө нэмэгдүүлэх болон тэнцлийн гадуурх зээлтэй холбоотой үүрэг хариуцлагыг үүсгэдэг.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайланд санхүүгийн хөрөнгийн дансны дүнгээр тусгагддаг. Санхүүгийн баталгаа, ашиглаагүй зээлийн шугам болон импортын аккредетивын хувьд хамгийн их өртөх магадлалтай эрсдэл нь үүрэг хариуцлагын дүнгийн хэмжээ байна.

Зээлийн эрсдэлийг хөрөнгө оруулалтын хөрөнгийг зөв сонгох, хөрөнгө оруулалтын хөрөнгийн зээлийн чанарыг хянах, хөрөнгө оруулалтын хөрөнгө бүрийн оруулах хөрөнгө оруулалтын хэмжээнд хязгаарлалт тавьж өгөх зэргээр удирдаж, хянана. Хөрөнгө оруулалтын төрлөөр нь зээлийн эрсдэлийн хэмжээнд тавих хязгаарлалтын хэмжээ болон оролцогч талыг сонгоход удирдлагаас байнга зөвшөөрөл авна. Эдгээр эрсдэлүүдийг тойрох байдлаар хянадаг бөгөөд жил бүр эсвэл бүр ойр давтамжтайгаар хяналт тавина.

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд гадаад валютын нөөцийг Ааа-с Аа3 болон Ааа зэрэглэлтэй засгийн газар (эсвэл Төв банк)–ын болон олон улсын байгууллагуудын үнэт цаасанд хөрөнгө оруулдаг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хадгаламж болон мөнгөний зах зээлийн хэрэгслүүдэд учрах зээлийн эрсдэл нь олон улсын үнэлгээний байгууллагуудаас А3 болон түүнээс дээш зэрэглэл авсан харилцагчидтай ажил гүйлгээ явуулах замаар хязгаарлагдаж байна. Хэрэв харилцагч нь нэгээс дээш үнэлгээний байгууллагаас үнэлгээ (рейтинг) авсан бол хамгийн бага үнэлгээнд нь үндэслэдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын мөнгөний бодлогын үйл ажиллагааны хувьд Банк зээлийн эрсдэлээ бууруулахын тулд барьцаа хөрөнгийг түлхүү хэрэглэдэг. Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад заасан үндсэн төрлийн барьцаа хөрөнгүүдийг дор дурдав:

1. Төв банкны үнэт цаас (ТБҮЦ);
2. Засгийн газрын үнэт цаас;
3. Хөгжлийн банкны үнэт цаас;
4. Санхүүгийн байгууллагуудын гаргасан зээл.

Банкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүх зээлдэгч банкууд хангах үүрэгтэй ба хэрэв дотоодын зээлдэгч банкууд энэхүү харьцаануудаас нэгийг биелүүлээгүй тохиолдолд Банк тухайн банкинд олгох буюу олгосон зээлийн үйл ажиллагааг цуцалдаг.

Зээлийн хязгаарлалт

Цаашилбал гадаад валютын улсын нөөцийн хувьд бүх харилцагчдад зээлийн хязгаар тогтоосон бөгөөд энэ нь зээлдэгчийн зэрэглэл, хөрөнгө, бусад хүчин зүйлд үндэслэнэ. Монголбанкны Ерөнхийлөгч нь зээлийн хязгаарыг улирал бүр тогтоох бөгөөд зээл нь тухайн хязгаартаа байгаа эсэхийг Эрсдэлийн удирдлагын алба өдөр тутам хянана. Банк өөрийн зээлийн эрсдэлийг хянахын тулд санхүүгийн хөрөнгийнхөө, ялангуяа банкуудад олгосон зээл болон бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 18 болон 26)-ийн насжилтын шинжилгээг хийж зээлээ эргэн төлөх чадвар нь муудаж буй харилцагчдын талаарх мэдээллийг захирлуудын зөвлөлд танилцуулах бөгөөд тус хурал дээр хэлэлцэн үзэж, холбогдох шийдвэрийг гаргана.

Тодруулга 35-д толилуулснаар Банк нь тодорхой хэмжээний зээлтэй холбоотой үүрэг хариуцлага хүлээсэн бөгөөд Монгол Улсын засгийн газар эсвэл түүний харьяа байгууллагуудын хүсэлтээр Монгол Улсын хувьд чухал ач холбогдол бүхий (бараа, үйлчилгээ экспортлох гэх мэт) зээлийн үүрэг хүлээдэг. Энэхүү хэрэгслийн гол зорилго нь засгийн газарт болон бусад төрийн байгууллагуудад санхүүжилтийн хөрөнгийг хангалттай байлгахад оршино. Нээсэн аккредитивүүд нь Банк өмнөөс нь төлбөрийг нь барагдуулах зайлшгүй үүрэг хүлээснийг илэрхийлдэг ба эдгээр хэрэгслийн эрсдэл нь зээлийн эрсдэлтэй ижил юм. Энэ төрлийн эрсдэлийг зээлтэй ижил аргаар бууруулж болно. зээлтэй холбоотой үүрэг нь Хятадын Ардын банктай хийсэн гэрээтэй холбоотой (Тодруулга 35) ба ашиглаагүй хэмжээг тодорхойлно. Хийсэн шинжилгээндээ үндэслэн Банкны удирдлага нь энэ төрлийн харилцагчаас үүдэлтэй зээлийн эрсдэлд орох магадлал нь бага хэмээн дүгнэжээ.

Банк зээлийн эрсдэлд өртөх хамгийн их магадлал нь санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн хөрөнгийн бүртгэлээрх дүнд нөлөөлдөг. зээлийн эрсдэл нь Тодруулга 21-д үзүүлсний дагуу барьцаа хөрөнгөөр багасч болно. Аккредитивууд болон своп хэлэлцээрийн ашиглах хэмжээг нэмэх хүсэлтээс үүдэх үүргийн хувьд зээлийн эрсдэлийн дээд хэмжээ нь энэхүү үүрэг, хариуцлагын дүнгээр илэрхийлэгдэнэ. (Тодруулга 35).

Үнэ цэнийн бууралтын үнэлгээ

Үл төлөгдөлт, үнэ цэнийн бууралт ба сайжруулалтын тодорхойлолт

Зээлдэгч гэрээгээр хүлээсэн төлбөрөө 90 болон түүнээс дээш хоногоор хугацаа хэтрүүлсэн эсвэл Банк зээлдэгчийн барьцаа хөрөнгийг борлуулах замаар эргэн төлөлтийг гүйцэх магадлалтай бүх тохиолдолд тухайн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай гэж үзэн хүлээгдэж буй алдагдлыг тооцдог.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Харилцагчдын санхүүгийн хэрэгслийг чанарын үнэлгээгээр үнэлж зээлийг "үнэ цэнийн бууралттай" гэж үзэх болон эргэн төлөгдөхгүй байх магадлалуудыг Банк авч үздэг. Энэ тохиолдолд Банк харилцагчийн санхүүгийн хэрэгслийг үл төлөгдөх магадлалтай эсэхийг нарийвчлан шинжилж хүлээгдэж буй алдагдлыг 2-р шат эсвэл 3-р шатны алинд нь тооцоологдохыг тодорхойлох замаар үнэлгээг хийнэ. Чанарын үнэлгээг хийхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үздэг. Үүнд:

- Зээлдэгч нь эрсдэлд орох нөхцөл байдал үүссэн эсвэл ойрын хугацаанд эрсдэх магадлалтайг тодорхойлсон Банкны дотоод үнэлгээ;
- Зээлдэгч Банкнаас яаралтай эх үүсвэр авах хүсэлт гаргах;
- Зээлдэгч нь бусад зээлдүүлэгчдэд хугацаа хэтэрсэн өр төлбөртэй байх;
- Зээлдэгч нас барах;
- Зээлийн барьцаа хөрөнгийн борлуулалтаас эргэн төлөлт хүлээгдэж байсан боловч барьцаа хөрөнгийн үнэ цэнэ материаллаг хэмжээгээр буурах;
- Зээлдэгчийн эргэлтийн хөрөнгө материаллаг хэмжээгээр буурах эсвэл томоохон харилцагчаа алдах;
- Зээлийн гэрээний нөхцөл, шаардлагыг зөрчих;
- Зээлдэгч (эсвэл зээлдэгчийн хамаарал бүхий аливаа хуулийн этгээд) нь дампуурлын талаарх өргөдөл мэдэгдэл гаргах
- Зээлдэгчийн тухай цуу яриа эсвэл санхүүгийн бэрхшээлтэй холбоотой баримтуудын улмаас хөрөнгийн биржид бүртгэлтэй зээл эсвэл хөрөнгийн эх үүсвэр нь цуцлагдах

Үл төлөгдөх магадлалд орох эсэх шалгууруудын хүчин зүйл нь дараалсан зургаан сар үргэлжлэн илрээгүй бол санхүүгийн хэрэгслийг «үнэ цэнэ сайжирсан» гэж үзэн 3-р шатлалаас шилжүүлэх эсэхийг Банк өөрийн бодлогоор зохицуулна. Хөрөнгийн зээлийн үнэлгээ сайжирсны улмаас 1 дүгээр шатлал болон 2-р шатлалд дахин ангилах эсэх шийдвэр нь тухайн зээлийн болон зээл олгох үеийн дотоод үнэлгээтэй харьцуулахад эрсдэл хэрхэн өөрчлөгдсөн байгаагаас хамаарна.

Банкны дотоод үнэлгээний систем

Зээлийн эрсдэлийг үнийн дүнгээр нь санхүүгийн хэрэгслийг үнэлэх болон зээлийн эрсдэлийг хэмжихийн тулд Банк нь хөндлөнгийн олон улсын үнэлгээний байгууллагууд (Мүүдийс, Стандард энд Пүүрс, Фитч)-ын гаргасан зээлжих зэрэглэлийн үнэлгээг ашигладаг. Олон улсын санхүүгийн зах зээлийн тогтвортой бус байдлаас үүдэн Банк нь тодорхой талуудтай тэдний үнэлгээг авч үзэхгүйгээр худалдаа хийхээ бүрэн больсон бөгөөд оролцогч талын эрсдэлээ зохистойгоор авч үзээгүйгээс үүдэн системийн эрсдэлд хүргэх боломжтой байдаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд хөндлөнгийн зээлийн үнэлгээг чанаргүйдлийн магадлалтай хувьтай нь хамт үндсэн хэмжүүртэй нь тохируулж харуулсан:

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр	Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын өгсөн тохирох үнэлгээ	
	Стандард энд Пүүрс	Мүүдийс
Онц сайн	AAA to A-	AAA to A3
Сайн	BBB+ to B-	Baa1 to B3
Хангалттай	CCC+ to CCC-	Caa1 to Caa3
Тусгайлан хянах	CC to C	Ca to C
Чанаргүйдэл	Чанаргүйдэл (дефолт)	Чанаргүйдэл (дефолт)

Зээлийн эрсдэлийн үнэлгээний үндсэн хэмжүүр бүрээр зээлжих чадварын зэргийг тодорхойлсон:

- Онц сайн – зээлийн чанар маш сайн, зээлийн эрсдэл бага;
- Сайн – зээлийн чанар сайн, зээлийн эрсдэл дунд зэрэг;
- Хангалттай – зээлийн чанар дунд зэрэг, зээлийн эрсдэл хангалттай;
- Тусгайлан хянах– ойроос хянах шаардлагатай, сайжруулах удирдлагыг баримтлах хэрэгслүүд;
- Чанаргүйдэл – чанаргүйдэл/дефолт болсон хэрэгсэл.

Монголын томоохон банкууд нь олон улсын үнэлгээний байгууллагуудаар зэрэглэлээ тогтоолгодог учир дотоодын банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийг энэхүү үнэлгээн дээр тулгуурлан хянана. Зээлжих зэрэглэлийн үнэлгээгүй банкуудын хувьд, Банк тэдгээр банкуудын сүүлийн үеийн санхүүгийн мэдээлэл, Банкны Хяналт шалгалтын газраас гаргаж буй санхүүгийн харьцааны шинжилгээ болон хамааралтай хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхэд хэрэглэдэг мэдээлэл болон бусад мэдээлэлд тулгуурлан дүгнэлт гаргадаг. Одоогоор Банк нь өөрийн боловсруулсан зээлийн үнэлгээний системийг банкуудад байршуулсан санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэлийг үнэлэхдээ ашигладаггүй байна.

Чанаргүйдэл болон зээлийн шатлал тодорхойлох нь

Банк нь дараах хүчин зүйлсээс нэг болон түүнээс илүү нь тохиолдож байвал чанаргүйдлын үнэлгээг хийдэг.

- Зээлдэгч гэрээний төлбөрийг 90-ээс дээш хоногоор хугацаа хэтэрсэн;
- Дотоодын банкны өөрийн хөрөнгийн зохистой байдал Банкны тогтоосноос их үед;
- Санхүүгийн хөрөнгийн зээл, барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа нь 100 хувиас их;
- Альтманий Z үнэлгээ нь дотоодын банкуудын хувьд 1.1 болон байгууллагууд (хөгжиж буй орнууд) 1.8-оос доош байх;
- Зээлдэгч төлөхгүй байх магадлалын доорх шалгуурыг хангасан:
  - гэрээний үүрэгт хүү эсвэл үндсэн төлөлтийг төлөөгүй эсвэл хугацаа хэтэрсэн.
  - дампуурлаа зарласан эсвэл хуулийн эрх хүлээн авсанаас үүдэн гэрээгээр хүлээсэн өр төлбөрийн эргэн төлөлтийг төлөхгүй байх эсвэл хугацаа хэтрэх магадлалтай болсон.
  - валютын ханшийн хямрал.
  - зээлийн гэрээний эргэн төлөлтийн нөхцөлд өөрчлөлт орсон эсвэл эрх бүхий байгууллагаас гэрээ байгуулсанаас үүдэн санхүүгийн үүрэг хариуцлагыг нь бууруулсан, үүнд гэрээний валютыг хүчээр өөрчилсөн (зээлдэгч эсвэл зээлдэгчийн эрх бүхий байгууллагаас) эсвэл анхны амлалтын зарим зүйлсийг хүчээр өөрчилсөн, жишээ нь индексац, дуусах хугацаа гэх мэт.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны удирдлана дараах шалгуурын дагуу санхүүгийн хөрөнгийн шатлалыг тодорхойлдог:

№.	Шалгуур	Шатлал 1	Шатлал 2	Шатлал 3
1	Зээлийн гэрээний эргэн төлөлтийн хоцролт	30 хүртэлх хоног	30-аас 90 хүртэлх хоног	90 хоногоос дээш
2	Дотоодын банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шинжилгээ	Монголбанкны шаардлагыг хангасан	Монголбанкны шаардлагыг хангаагүй.	Татан буугдсан/ дефолт
3	Дотоодын банкуудын Альтманий Z үнэлгээ	Банкууд: Z-оноо > 2.6 Байгууллагууд: Z-оноо > 3	Банкууд: 1.1 <Z-оноо>2.6 Байгууллагууд: 1.8<Z-оноо>3	Банкууд: Z-оноо < 1.1 Байгууллагууд: Z-оноо < 1.8
4	Зээл, барьцаа хөрөнгийн үнэлгээний харьцаа	70 хувиас бага	70-аас 100 хувь	100-аас илүү хувь

Дээр дурдсан шалгуур үзүүлэлтүүдээс гадна Банк олон улсын үнэлгээний байгууллагуудын банкууд болон байгууллагад өгсөн үнэлгээг хянадаг. Олон улсын байгууллагуудаас гаргасан зээлжих зэрэглэлийн ахих, буурах нь санхүүгийн хөрөнгийн шатлал тодорхойлоход тусгагддаг.

Чанаргүйдэлд өртөх дүн

Чанаргүйдэлд өртөх дүн (“ЧӨД”) нь үндсэн үлдэгдэл ба хүүний эргэн төлөлт, зээлийн төлбөрийн хоцролт дээр хуримтлагдсан хүү, г.м., тайлагналын өдрийн дараа бүртгэлийн дүнд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж ирээдүйд чанаргүй болох өдрийн хүлээгдэж буй зээлийн бүртгэлийн дүнг хэлнэ.

1-р шатлалд буй зээлийн ЧӨД-г тооцоолохын тулд Банк нь 12 сарын хугацаанд үүсэж болох чанаргүйдэх үйл явдлыг Зээлийн Үнэ Цэнийн 12 сарын Хүлээгдэж буй Алдагдал (ЗҮЦ12сХА)-г тооцоход авч үзнэ. 2-р шатлал болон 3 дугаар шатлалуудад ЧӨД-г тодорхойлохдоо нийт хугацааны түүхэн чанаргүйдэх үйл явдлыг авч үзнэ (ЗҮЦНХХА).

Алдагдалд хүргэх чанаргүйдэл

Алдагдалд хүргэх чанаргүйдэл (АХЧ)-ийг Бизнесийн эрсдэлийн хэлтсийн зээлийн эрсдэлийн шинжээчид жил бүр үнэлдэг. АХЧ нь санхүүгийн хөрөнгийн чанаргүй болсон үнийн дүнд Банкны хүлээх алдагдлын түвшинг илтгэнэ. АХЧ нь харилцан тохиролцсон хэлбэр, нэхэмжлэлийн төрөл болон зэрэглэл, барьцаа хөрөнгө эсвэл бусад зээлийн дэмжлэг зэргээс шалтгаалан харилцан адилгүй байдаг. АХЧ нь ЧӨД-ийн хувиар илэрхийлэгддэг. АХЧ-ийг 12 сар эсвэл зээлийн хугацааны туршид тооцдог бөгөөд 12 сарын АХЧ-ийг дараагийн 12 сард чанаргүйдэл болох тохиолдолд гарах алдагдлын хувиар тооцдог. Зээлийн хугацааны турш дахь АХЧ-ийг үлдэгдэл зээлийн хугацаанд гарах алдагдлын хувиар тооцдог.

Санхүүгийн хэрэгсэлд барьцаа хөрөнгө байхгүй, чанаргүйдлийн түүхэн өгөгдөл хангалтгүй байгаа тохиолдолд Банк шинжээчдийн дүгнэлтийг ашигладаг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

АХЧ-г тооцоолоход алдагдлын талаарх тоон мэдээллийн боломжит байдлаас хамаарч дараах аргачлалуудаас тохирохыг нь сонгоно:

- Дотоодын загвар бий болгоход алдагдлын талаарх хангалттай мэдээлэлтэй үед: Макро эдийн засаг, тухайн сектор, алдагдлын талаар хангалттай тоон мэдээлэлтэй үед загвар хөгжүүлэх замаар симуляцийн арга ашиглан ирээдүйд учрах алдагдлыг тооцох.
- Алдагдлын талаар тодорхой хэмжээний мэдээлэлтэй үед: Багцын арга буюу зээлийн барьцаагаар хангагдсан хэсэг болон барьцаагаар хангагдаагүй хэсэгт нэгэн ижил алдагдлын хувь тооцох, симуляцийн арга ашиглан ирээдүйд учрах алдагдлыг тооцох.
- Алдагдлын талаар мэдээлэл хомс буюу байхгүй үед: Ижил төстэй санхүүгийн хөрөнгийн алдагдлын хувь хэмжээний мэдээлэл, эсвэл гадаадын зохицуулалтын байгууллагаас гаргасан өгөгдлийг ашиглах.

Түүхэн өгөгдөл хязгаарлагдмал тул 2020 онд Банк АХЧ-г тооцоолохдоо Томсон Ройтерсийн өгөгдлийн терминалаас авсан, байгууллагын үнэлгээ болон гэрээний хугацаа бүрт харгалзах эргэн төлөлтийн хувийг ашигласан. Харин 2019 онд Банк АХЧ-г Базелын хорооны тоон нөлөөллийн судалгаа 3-т суурилж тооцсон.

Доорх хүснэгтэд 2020 болон 2019 онуудад санхүүгийн хөрөнгө бүрт тодорхойлсон АХЧ-г харуулав.

	Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө	Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	Урвуу буцаан худалдан авах Хэлцэл	Засгийн газрын үнэт цаас	Дотоодын банкуудад олгосон зээл	Бусад санхүүгийн хөрөнгө
	(Тод.17)	**(Тод.19)**	**(Тод.21)**	**(Тод.25)**	**(Тод.18)**	**(Тод.26)**
2020	60%	47%-63%	0%-60%	63%	63%	72%
2019	25%	0%-25%	3.9%	15.5%	25%-38%	31%-38%

Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт

Банк нь ЗҮЦХА-д хамаарах бүх хөрөнгийг тасралтгүй хянадаг. Санхүүгийн хэрэгсэл эсвэл санхүүгийн хэрэглүүрээс бүрдсэн багцын үнэ цэнийн бууралтыг ЗҮЦ12сХА эсвэл ЗҮЦНХХА-ын аргачлалаар тооцох нь зохистой эсэхийг тодорхойлохын тулд Банк нь анхлан хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгийн зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (“ЗЭМӨ”) ажиглагдсан эсэхийг үнэлдэг.

Банк нь гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц ихэссэн тохиолдолд чанарын шинжилгээ хийдэг.Зарим тохиолдолд зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийн шалтгааныг чанаргүйдэл бус “Чанаргүйдлийн тодорхойлолт”-д дурдагдсан үйл явдлуудтай холбож тайлбарладаг.

Ижил төстэй бүлэг хөрөнгүүдийн хувьд ЗҮЦХА-г тооцож байгаа тохиолдолд мөн дээрхтэй ижил буюу анх хүлээн зөвшөөрөх үеийн зээлийн эрсдэлийн хэмжээнд мэдэгдэхүйц өсөлт гарсан эсэхийг шинжилдэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

ЗҮЦХА-ын загварын ирээдүйн мэдээллийн тохируулга

Банк нь ЗҮЦХА-ын загварын бүрэлдэхүүн хэсэг болох ЧМ-г ирээдүйн мэдээлэлд үндэслэн тохируулснаар ЗҮЦХА-ын загварт ирээдүйн макро эдийн засгийн хөгжил хэрхэн нөлөөлж болохыг тусгадаг. Банк ЗҮЦХА-ын загварын ЧМ-г санхүүгийн хөрөнгийн онцлогоос хамаарч бүлгийн болон тусгай үнэлгээгээр тооцоолдог. Арга зүйн хувьд, оновчтой макро эдийн засгийн хүчин зүйлүүдийг урьдчилан сонгохын тулд хамаарлын шинжилгээг хийсэн. Улмаар энгийн регрессийн шинжилгээг ашиглан коэффициентуудыг тодорхойлсон. Тодорхойлсон коэффициентууд болон таамаглалуудыг ашиглан чанаргүйдлийн хувийн урьдчилсан таамаглал болон түүхэн дундаж чанаргүйдлийн хувийн харьцааг тооцож, ЧМ-н ирээдүйн мэдээллийн тохируулгыг тооцоолсон. Банк нь дараах ирээдүйн мэдээлэлд үндэслэн ЧМ-г тохируулж тооцооллыг гүйцэтгэсэн.

- Дотоодын банкуудад олгосон зээл

Банк нь олон улсын үнэлгээний байгууллагын (Стандарт энд Пурс) чанаргүйдлийн түүхэн үнэлэмж болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ЧМ-ыг тооцсон:

- Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн
- Хэрэглээний үнийн индекс (1 жилээр хоцорсон)
- Зээлийн хүүгийн хувь (1 жилээр хоцорсон)
- Ажилгүйдлийн түвшин

Банк сүүлийн 20 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон ЧМ-ын түүхэн өгөгдөл дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- Дотоодын банкинд олгосон барьцаат зээл

Банк нь олон улсын үнэлгээний байгууллагын (Стандарт энд Пурс) чанаргүйдлийн түүхэн үнэлэмж болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ЧМ-ыг тооцсон:

- Жилийн дотоодын нийт бүтээгдэхүүн
- Хэрэглээний үнийн индекс (1 жилээр хоцорсон)

Банк сүүлийн 21 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон ЧМ-ын түүхэн өгөгдөл дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

- ИЗББ болон Түрээсийн Орлогоор Баталгаажсан Бонд

Банк нь өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ЧМ-ыг тооцсон:

- Улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн
- Нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлаар хоцорсон)
- Ажилгүйдлийн түвшин

Банк сүүлийн 10 жилийн макро эдийн засгийн хувьсагчид болон нийт ипотекийн зээлд эзлэх чанаргүй зээлийн түүхэн хувь дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Эрдэнэс Монгол Бонд

Банк нь өөрийн сайтаар олон нийтэд нийтэлдэг нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь болон макро эдийн засгийн үзүүлэлт дээр үндэслэн ирээдүйн мэдээлэлд суурилсан ЧМ-ыг тооцсон:

- Улирлын дотоодын нийт бүтээгдэхүүн (2 улирлаар хоцорсон)
- Нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн хувь (1 улирлаар хоцорсон)

Банк сүүлийн 10 жилийн макро эдийн засгийн хувьсагч болон нийт уул уурхайн зээлд эзлэх чанаргүй зээлийн түүхэн хувь дээр шугаман регрессийн шинжилгээ хийсэн ба уг шинжилгээгээр нь эдгээр хувьсагчид нь статистик ач холбогдолтой макро эдийн засгийн үзүүлэлт болох нь нотлогдсон.

Эдгээр тохируулгын хүчин зүйлс болон тохируулагдсан ЧМ хувиуд нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн талаар сайн төсөөлөл өгч чадах тул ЗҮЦХА загварын суурь төсөөлөл гэж үзсэн. Хамгийн сайн болон хамгийн муу төсөөллүүдийг тухайн загвараар таамагласан чанаргүйдлийн хувь дахь түүхэн тохируулагч хүчин зүйлүүдийг үндэслэн тооцсон ба тохируулагч хүчин зүйлийн тархалтыг тодорхой тоонуудаар хэмжсэн.

Өөр өөр эдийн засгийн хувилбар дахь ЗҮЦХА-г тухайн төсөөлөлд хамаарах ЧМ хувьд үндэслэн тооцсон ба эцсийн ЗҮЦХА нь өгөгдсөн гурван төсөөллийн ач холбогдлын хувиар жигнэж тооцогдоно. Үүнд: хамгийн сайн болон хамгийн муу төсөөлөлд тус бүр 30% ба суурь төсөөлөлд 40% ач холбогдол өгсөн.

Эдийн засгийн хувилбарууд болон түүний тохируулагч итгэлцүүрийг ашиглан гарсан ЗҮЦХА-н үр дүнг дор харуулав. Бусад эдийн засгийн хувьсагчууд нь нөлөө хожуу ордог хувьсагчууд тул бодит статистикийг мэдээллийг ашиглав.

			2021 оны
2020 оны 12-р сарын 31	ЗҮЦХА хувилбар	Ач холбогдол	**Төсөөлөл**
Түлхүүр үзүүлэлтүүд			
ДНБ-ий өсөлтийн %	Хамгийн сайн	30%	8.3%
	Суурь	40%	6.4%
	Хамгийн муу	30%	4.5%
Ажилгүйдлийн түвшин	Бүх хувилбарт	100%	10.8%

Дараах хүснэгтэд бие даасан хувьсагчид болон түүхэн ЧМ-ын шугаман регрессийн загварын үр дүнд гарсан ирээдүйн тохируулга болон ЗҮЦХА-ын загварын эдийн засгийн хувилбар бүрт ашигласан ЧМ-ыг харуулав.

	Дотоодын банкуудад олгосон зээл		Барьцаат зээл		ИЗББ*		ТХББ**		Эрдэнэс бонд	
ЧМ суурь:	Стандард энд Пүүрс ЧМ				*Ипотекийн чанаргүй зээлийн %*		*Орон сууцны чанаргүй зээлийн %*		*Уул уурхайн чанаргүй зээлийн %*	
	Үржүүлэгч	ЧМ	Үржүүлэгч	ЧМ	Үржүүлэгч	ЧМ	Үржүүлэгч	ЧМ	Үржүүлэгч	ЧМ
Хамгийн сайн (30%)	0.52	2.76%	0.50	12.39%	1.33	1.95%	1.33	3.90%	0.88	11.55%
Суурь (40%)	0.60	3.19%	0.57	14.12%	1.34	1.96%	1.34	3.93%	0.89	11.68%
Хамгийн муу (30%)	0.67	3.56%	0.63	15.61%	1.35	1.98%	1.35	3.96%	0.91	11.94%

*Ипотекийн зээлээр баталгаажсан бонд

** Түрээсийн орлогоор баталгаажсан бонд

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Эдийн засгийн хувилбарууд болон түүний тохируулагч итгэлцүүрийг ашиглан гарсан ЗҮЦХА-ын сангийн үр дүнг дор харуулав.

2020 оны 12-р сарын 31	**Гадаадын санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө**	**Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт**	**Урвуу буцаан худалдан авах хэлцэл**	**Засгийн газрын үнэт цаас**	**Дотоодын банкуудад олгосон зээл**	**Бусад санхүүгийн хөрөнгө**
Сая.төгрөгөөр	(Тод.17)	(Тод.19)	(Тод.21)	(Тод.25)	(Тод.18)	(Тод.26)
Хамгийн сайн (30%)	509	11,351	4	1,187	4,934	19,886
Суурь (40%)	679	15,134	5	1,583	6,578	26,515
Хамгийн муу (30%)	509	11,351	4	1,187	4,934	19,886
Нийт ЗҮЦХА	1,698	37,835	13	3,958	16,445	66,288
2019 оны 12-р сарын 31						
Хамгийн сайн (30%)	–	1,474	16	–	2,090	5,605
Суурь (40%)	11	2,706	30	323	3,106	7,478
Хамгийн муу (30%)	–	2,527	28	–	2,570	5,613
Нийт ЗҮЦХА	11	6,707	74	323	7,766	18,696

Удирдлага нь гадаадын байгууллагуудад эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө буюу гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, гадаадын байгууллагуудын өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт зэрэгт ЗҮЦХА тооцохдоо Блумберг терминалын Чанаргүйдэх Магадлалын Үнэлгээний судалгааг ашигласан ба үүнд зээлдэгч талын зээлийн үнэлгээ нь ирээдүйн мэдээллээр тохируулагдсан гэж таамагласан. Үүний дагуу ЗҮЦ12сХА-г эдийн засгийн хувилбар бүрт өгөгдсөн чанаргүйдэх магадлалаар тооцоолсон. 2019 онд ЗҮЦ12сХА-г тооцохдоо Банк хамгийн шилдэг нэг хувилбарыг ашигласан.

37.3 Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйн орж ирэх мөнгөн урсгалын дүн нь зах зээлийн хувьсагчууд болох хүү болон валютын хөрвүүлгээс шалтгаалан хэлбэлзэх эрсдэлийг хэлнэ. Зах зээлийн болон эргэн төлөгдөх чадварын эрсдэлийг тодорхойлохдоо удирдлагын гол анхаардаг зүйлийн нэг нь гадаадын байгууллагуудад төлөх өр төлбөр болон импортын бүтцэд зөрүүг тодорхойлох явдал юм. Банк энэхүү эрсдэлийг мэдрэмтгий байдлын шинжилгээг ашиглан удирдаж хянадаг. Гадаад валютын төвлөрлийг эс тооцвол Банкинд зах зээлтэй холбоотой өөр ноцтой зах зээлийн эрсдэл байхгүй байна. Одоогоор Банк нь үнийн бусад эрсдэлд онцгой байдлаар өртөөгүй болно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

37.4 Ханшийн эрсдэл

Ханшийн эрсдэл нь санхүүгийн хэрэгслийн үнэ цэнэ нь валютын ханшийн хэлбэлзлээс үүдэн өөрчлөгдөж байх эрсдэлийг хэлнэ. Ханшийн эрсдэлийг гадаад валютын багцыг төрөлжүүлэх замаар удирдаж болох ба дараах параметрүүдээр тодорхойлно:

- Гадаад валютын нөөцийн удирдлага
- Гадаад валютын нөөц болон гадаад валютаар илэрхийлэгдэх урт ба богино хугацаат хөрөнгө оруулалтын багцад эзлэх тухайн гадаад валютын хамгийн их байх хэмжээ

Гадаад валютын нөөцийг бүрдүүлэх валютын бүтцийг Захирлуудын зөвлөлөөс жил бүр баталдаг. Дараах хүснэгтэд тайлант хугацааны эцэст гадаад валютын болон ЗТЭ-ийн ханшийн төгрөгтэй харьцах харьцангуй боломжит өөрчлөлтөд (бусад бүх хувьсагчид тогтмол байхад) ашиг, алдагдал болон өөрийн хөрөнгөд үзүүлэх мэдрэмтгий байдлыг харуулсан. Хүснэгт дэх сөрөг утгатай дүнгүүд нь ашиг, алдагдал дахь болзошгүй цэвэр бууралтыг илэрхийлэх ба эерэг утгатай дүнгүүд нь боломжит цэвэр өсөлтийг илэрхийлнэ.

	2020			2019		
Ханш	**Валютын ханшийн өөрчлөлт %**	**Ашиг/алдагдал дахь нөлөө сая.төг**	**Өмч дахь нөлөө сая.төг**	**Валютын ханшийн өөрчлөлт %**	**Ашиг/алдагдал дахь нөлөө сая.төг**	**Өмч дахь нөлөө сая.төг**
Ам.доллар	+10	744,093	(108,249)	+10	365,132	(251,478)
Юань	+10	(479,091)	–	+10	(422,174)	–
Евро	+10	(16,504)	–	+10	(1,861)	–
ЗТЭ	+10	(71,512)	–	+10	(65,299)	–
Бусад	+10	157,758	–	+10	328,872	–

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх ханшийн эрсдэлд мэдэгдэхүйц өртөж буй санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг валют болон ЗТЭ-ээр илэрхийлэн харуулж байна.

2020 оны 12-р сарын 31	**Төгрөг сая.төг**	**Ам.доллар сая.төг**	**Юань сая.төг**	**Евро сая.төг**	**ЗТЭ сая.төг**	**Бусад сая.төг**	**Нийт сая.төг**
Бэлэн мөнгө	47	164,131	17,089	37,576	–	14,530	233,373
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	–	3,225,376	583,672	98,224	131,503	478,617	4,517,392
Дотоодын банкуудад олгосон зээл	460,576	738	–	–	–	–	461,314
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	2,924,909	2,306,627	43,593	–	–	–	5,275,129
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	–	–	–	6,595	–	–	6,595
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	422,693	4,393,375					4,816,068
Алт ба үнэт метал	–	–	–	–	–	1,405,887	1,405,887
Засгийн газрын үнэт цаас	227,407	–	–	–	–	–	227,407
Бусад санхүүгийн хөрөнгө	373,490	–	–	–	–	–	373,490
Нийт санхүүгийн хөрөнгө	4,409,122	10,090,247	644,354	142,395	131,503	1,899,034	17,316,655
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(991,470)	–	–	–	–	–	(991,470)
Төв банкны үнэт цаас	(7,952,438)	–	–	–	–	–	(7,952,438)
Засгийн газрын харилцах, хадгаламж	(888,930)	(479,219)	(9)	(94,288)	(646,516)	(23,063)	(2,132,025)
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	(1,355,604)	(2,156,843)	(103,018)	(213,149)	–	(42,783)	(3,871,397)
Гадаад өр төлбөр	(1,381)	(179)	(5,332,233)	–	(200,102)	(255,613)	(5,789,508)
Бусад санхүүгийн өр төлбөр	(350,083)	(13,074)	–	–	–	–	(363,157)
Нийт санхүүгийн өр төлбөр	(11,539,906)	(2,649,315)	(5,435,260)	(307,437)	(846,618)	(321,459)	(21,099,995)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	935,403	(1,082,485)	–	–	–	–	(147,082)
Цэвэр санхүүгийн хөрөнгө/ (өр төлбөр)	(6,195,381)	6,358,447	(4,790,906)	(165,042)	(715,115)	1,577,575	(3,930,422)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2019 оны 12-р сарын 31	Төгрөг сая.төг	Ам.доллар сая.төг	Юань сая.төг	Евро сая.төг	ЗТЭ сая.төг	Бусад сая.төг	Нийт сая.төг
Бэлэн мөнгө	55	148,585	15,474	37,609	–	12,521	214,244
Гадаадын санхүүгийн байгууллага дахь хөрөнгө	–	3,212,079	595,213	102,239	135,171	413,806	4,458,508
Дотоодын банкуудад олгосон зээл	441,856	772	–	290	–	–	442,918
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	2,423,299	1,414,097	35,746	–	–	–	3,873,142
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	5,139	–	–	6,595	–	–	11,734
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	553,993	2,700,444	–	–	–	–	3,254,437
Алт ба үнэт метал	–	–	–	–	–	3,057,529	3,057,529
Засгийн газрын үнэт цаас	134,028	–	–	–	–	–	134,028
Бусад санхүүгийн хөрөнгө	473,590	–	–	–	–	–	473,590
Нийт санхүүгийн хөрөнгө	4,031,960	7,475,977	646,433	146,733	135,171	3,483,856	15,920,130
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(897,417)	–	–	–	–	–	(897,417)
Төв банкны үнэт цаас	(4,629,293)	–	–	–	–	–	(4,629,293)
Засгийн газрын харилцах, хадгаламж	(808,763)	(754,991)	–	(20,075)	(604,211)	(13,545)	(2,201,585)
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	(2,496,041)	(3,088,642)	(82,688)	(138,671)	–	(232,662)	(6,038,704)
Гадаад өр төлбөр	(84)	(172)	(4,785,483)	–	(183,945)	–	(4,969,684)
Бусад санхүүгийн өр төлбөр	(17,356)	(12,499)	–	–	–	–	(29,855)
Нийт санхүүгийн өр төлбөр	(8,848,954)	(3,856,304)	(4,868,171)	(158,746)	(788,156)	(246,207)	(18,766,538)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	2,230,522	(2,514,784)	–	–	–	–	(284,262)
Цэвэр санхүүгийн хөрөнгө/ (өр төлбөр)	(2,586,472)	1,104,889	(4,221,738)	(12,013)	(652,985)	3,237,649	(3,130,670)

37.5 Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний хэлбэлзлээс ирээдүйд орж ирэх мөнгөн урсгал эсвэл санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ өөрчлөгдөх эрсдэлийг хүүгийн түвшний эрсдэл гэнэ. Хүүгийн түвшний эрсдэлийг удирдах гол зорилго нь хөрөнгө оруулалт тус бүрээс эрсдэлийн хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тогтвортой үр ашиг хүртэх явдал юм.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Банкны хөрөнгө болон өр төлбөрийн ихэнх хувь нь тогтмол хүүгийн түвшинтэй эсвэл хүүгүй байгаа нь хүүгийн түвшний эрсдэлийг ихээхэн хэмжээгээр бууруулдаг. Стратегийн харьцуулсан үзүүлэлтийг тодорхойлох явцдаа, хүүгийн түвшний эрсдэлийг багасгах зорилгоор Банк гадаад валютын нөөцийн багцад хугацааг нь зааж өгдөг. Энэхүү хугацааны хэрэгжилтийг өдөр бүр хянадаг. Хөрөнгө оруулалтын хугацаа нь хөндлөн шинжилгээний аргаар тодорхойлогдоно. Хөрөнгө оруулалтын хугацааг 1 жилээр, хамгийн бага үр өгөөжийн түвшинг сөрөг үр өгөөжөөр (1 жилийн хугацаанд үр өгөөжийн өөрчлөлт сөрөг бол), сөрөг үр өгөөжийн хүлээн зөвшөөрөх боломж 5 хувиас ихгүй байхаар өөрийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, ирээдүйн өгөөжийг таамаглах аргаар зохистой хугацааг тооцдог.

Дараах хүснэгтэд Банкны хүүгийн түвшний эрсдэлийн байдлыг харуулжээ. Энэ хүснэгтэд Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг дансны үлдэгдэл дүнгээр, мөн гэрээнд заасан хүүгийн түвшин өөрчлөгдсөн буюу зээлийн хугацаа дуусгавар болсон өдрүүдийн аль түрүүнд болсноор ангилан үзүүлсэн байна:

Дараах хөрөнгө болон өр төлбөрийн хүүг хувьсах хувь хэмжээгээр хуримтлуулдаг: ЗТЭ (Тодруулга 17), ЗТЭ-ийн хуваарилалт, банк болон Хятадын Ардын банкнаас авсан зээлүүд (Тодруулга 32). Хэрэв 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бусад бүх хувьсагчийн хувьд тогтмол хүүгийн түвшин 100 суурь нэгжээр бага/өндөр байвал тухайн жилийн алдагдлын хэмжээ (Хятадын ардын банкнаас авсан хувьсагч хүүтэй зээл болон “Эм Ю Эф Жи Банк”-аас авсан зээлийн хүүгийн өр төлбөр бага байсны үр дүнд) 68,325 сая төгрөг (2019 онд 37,991 сая төгрөг)-өөр бага/өндөр байх байсан.

Банкны актив хөрөнгө болон өр төлбөрийн дийлэнх хэсэг нь тогтмол хүүтэй эсвэл хүүгүй бөгөөд Банк нь хувьсагч хүүтэй материаллаг актив хөрөнгө болон өр төлбөр байхгүй тул 2020 оны хүүгийн түвшний эрсдэлийн нөлөөлөл их биш гэж Банкны удирдлагууд үзсэн. Банк өөрийн санхүүгийн хэрэгслийн хүүгийн түвшинг хянаж байдаг. Доорх хүснэгтэд харгалзах тайлант өдрөөрх хүүгийн түвшинг удирдлагын тайланд үндэслэн нэгтгэсэн. Хөрөнгийн биржид бүртгэлтэй үнэт цааснуудын хувьд хүүгийн түвшин нь тайлант өдрийн байдлаар дуусгавар өдөр хүртэлх хугацааны өгөөжийн зах зээл дээрх түвшинг илэрхийлнэ.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгт нь 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх Банкны санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүүгийн мэдээллийг харуулж байна.

Жилийн хүү	2020				2019				
	Төгрөг	Ам. доллар доллар	Юань	Бусад	Төгрөг	Ам. доллар	Евро	Юань	Бусад
Хөрөнгө									
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө	–	0.25%	2.50%	0.01%	–	1.75%	–	2.81%	0.70%
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	–	1.00%	2.38%	–	–	1.90%	–	3.60%	–
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	7.00%	–	–	–	12.36%	2.20%	–	–	–
Засгийн газрын үнэт цаас	1.00%	–	–	–	1.00%	–	–	–	–
Дотоодын банкуудад олгосон зээл	5.50%	0.75%	–	–	4.33%	0.75%	1.25%	–	–
Өр төлбөр									
Төв банкны үнэт цаас	6.75%	–	–	–	11.06%	–	–	–	–
Засгийн газрын харилцах, хадгаламж	3.50%	2.57%	–	1.08%	–	2.53%	0.75%	–	1.00%
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	5.00%	0.19%	–	–	9.00%	1.78%	–	–	–
Гадаад өр төлбөр	–	–	4.87%	2.50%	–	–	–	5.08%	–

Хүснэгт дэх “-“ тэмдэг нь Банк харгалзах валютаар, харгалзах хөрөнгө, өр төлбөргүйг илтгэнэ

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Газар зүйн эрсдэлийн төвлөрөл. 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх Банкны санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн газар зүйн төвлөрлийг доорх хүснэгтээр харуулав:

2020	**Монгол сая.төг**	**ЭЗХАБ-ын сая.төг**	**ОУВС сая.төг**	**ЭЗХАБ-ын сая.төг**	**Нийт сая.төг**
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	233,373	–	–	–	233,373
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	–	3,802,217	131,503	583,672	4,517,392
Дотоодын банкуудад олгосон зээл	461,314	–	–	–	461,314
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	2,924,909	2,306,627	–	43,593	5,275,129
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	6,595	–	–	–	6,595
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	422,693	4,393,375	–	–	4,816,068
Алт ба үнэт металл	–	1,405,887	–	–	1,405,887
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	156,419	–	–	–	156,419
Засгийн газрын үнэт цаас	227,407	–	–	–	227,407
Бусад санхүүгийн хөрөнгө	373,490	–	–	–	373,490
Нийт санхүүгийн хөрөнгө	4,806,196	11,908,106	131,503	627,265	17,473,074
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(991,470)	–	–	–	(991,470)
Төв банкны үнэт цаас	(7,952,438)	–	–	–	(7,952,438)
Засгийн газрын харилцах, хадгаламж	(2,132,025)	–	–	–	(2,132,025)
Банкуудын харилцах, хадгаламж	(3,871,397)	–	–	–	(3,871,397)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(303,501)	–	–	–	(303,501)
Гадаад өр төлбөр	–	(257,173)	(200,102)	(5,332,233)	(5,789,508)
Бусад санхүүгийн өр төлбөр	(363,157)	–	–	–	(363,157)
Нийт санхүүгийн өр төлбөр	(15,613,988)	(257,173)	(200,102)	(5,332,233)	(21,403,496)
Цэвэр санхүүгийн хөрөнгө/(өр төлбөр)	(10,807,788)	11,650,933	(68,599)	(4,704,968)	(3,930,422)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 35)	(35,898)	–	–	(6,000,000)	(6,035,898)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

2019	Монгол сая.төг	ЭЗХАБ-ын сая.төг	ОУВС сая.төг	ЭЗХАБ-ын сая.төг	Нийт сая.төг
Бэлэн мөнгө	214,244	–	–	–	214,244
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хадгаламж	–	3,728,124	135,171	595,213	4,458,508
Дотоодын банкуудад олгосон зээл	442,918	–	–	–	442,918
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	2,423,299	1,414,097	–	35,746	3,873,142
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	5,201	6,533	–	–	11,734
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	553,993	2,700,444	–	–	3,254,437
Алт ба үнэт металл	–	3,057,529	–	–	3,057,529
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	260,778	–	–	–	260,778
Засгийн газрын үнэт цаас	134,028	–	–	–	134,028
Бусад санхүүгийн хөрөнгө	473,590	–	–	–	473,590
Нийт санхүүгийн хөрөнгө	4,508,051	10,906,727	135,171	630,959	16,180,908
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	(897,417)	–	–	–	(897,417)
Төв банкны үнэт цаас	(4,629,293)	–	–	–	(4,629,293)
Засгийн газрын харилцах, хадгаламж	(2,201,585)	–	–	–	(2,201,585)
Банкуудын харилцах, хадгаламж	(6,038,704)	–	–	–	(6,038,704)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(545,040)	–	–	–	(545,040)
Гадаад өр төлбөр	–	(256)	(183,945)	(4,785,483)	(4,969,684)
Бусад санхүүгийн өр төлбөр	(29,855)	–	–	–	(29,855)
Нийт санхүүгийн өр төлбөр	(14,341,894)	(256)	(183,945)	(4,785,483)	(19,311,578)
Цэвэр санхүүгийн хөрөнгө/(өр төлбөр) as 31 ber 2019	(9,833,843)	10,906,471	(48,774)	(4,154,524)	(3,130,670)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг (Тодруулга 35)	(77,387)	–	–	(5,400,000)	(5,477,387)

Бусад эрсдэлийн төвлөрөл. Банкны удирдлага дээр дурдсан харилцагчдын хязгаар бүрт зээлдэгчдийн талаарх тайлан мэдээллийг авах замаар зээлийн эрсдэлийн төвлөрлийг судалж, хяналт тавьдаг. 2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Банкинд ийм төрлийн томоохон эрсдэлийн төвлөрөл байхгүй байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Санхүүгийн хэвийн болон хүнд нөхцөл байдалд өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлийг төлбөрийн чадварын эрсдэл гэнэ. Гадаад валютын хөрвөх чадварын эрсдэл нь Банкинд учирдаг хамгийн гол эрсдэлүүдийн нэг юм. Импортоос ихээхэн хамааралтай, Засгийн газрын гадаад өрийг байнга төлж байх шаардлагатай, дотоодын зах зээл дээрх валютын эрэлт, нийлүүлэлт байнга хэлбэлзэж байдаг нөхцөл байдлын үед төлбөрийн чадвар нь гадаад валютын нөөцийн удирдлагын авч үзэх ёстой чухал асуудал юм. Төлбөрийн чадварыг удирдахын тулд Банк гадаад валютын нөөцийн багцыг хоёр дэд багцад хуваадаг. Үүнд:

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

- Богино хугацаат хөрөнгө оруулалтын багц (бэлэн мөнгөний удирдлага эсвэл төлбөрийн чадварын багц орно): Энэ багцыг зээлийн өр төлөх, валютын зах зээлийн үйл ажиллагааг тогтвортой болгох зорилгоор ашигладаг. Уг багц бэлэн мөнгө, овернайт ба хугацаагүй хадгаламжаас бүрдэнэ. Энэхүү багц нь мөн хугацаат хадгаламжид, өндөр төлбөрийн чадвар (эргэн төлөгдөх чадвар) бүхий мөнгөний зах зээлийн хэрэгсэлд долоо хоногоос 12 сар хүртэлх дуусах хугацаа бүхий үнэт цаасанд болон мөнгөжсөн алтанд хөрөнгө оруулалт болон хийгддэг байна.
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын багц: Энэ багцын хөрөнгө оруулалтад дунд болон урт хугацааны, өндөр төлбөрийн чадвар бүхий Засгийн газрын бонд, үнэт цаас зэрэг санхүүгийн үүсмэл хэрэгслүүд багтдаг.

Хөрөнгө оруулалтын хороо гадаад валютын багцын хязгаарыг санал болгодог. Төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулахын тулд Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журмын дагуу дараах хөрөнгийн бүтцийг дагаж мөрддөг:

- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртэлх) хөрөнгө болгон харилцах данс болон валютаар илэрхийлэгдсэн бэлэн мөнгө хэлбэрээр байршуулах;
- Нийт хөрөнгийн тогтоосон хязгаарын тодорхой хувиас багагүй хэсгийг богино хугацаат (1 жил хүртэлх) хөрөнгө болгон 6 сар хүртэлх хугацаатай хадгаламжийн хэлбэрээр байршуулах.

Гадаад арилжааны алдагдлын хязгаар 400,000 ам.доллар, арилжааны нэгжийн хязгаар 100,000 ам.доллар байх бөгөөд нэг удаагийн арилжааны хязгаар 50,000 ам.доллар байна.

Дараах хүснэгтэд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг гэрээнд заасан дуусах хугацаагаар нь харуулсан. Дуусгавар хугацааны тайланд тусгасан дүнгүүд нь санхүүгийн түрээсийн баталгаа (ирээдүйн санхүүгийн төлбөрийг хасахаас өмнөх), нийт зээлийн үүрэг, нийт санхүүгийн түрээсийн үүрэг зэргийг хамруулсан гэрээнд заасан, хямдруулаагүй мөнгөн гүйлгээ болно. Санхүүгийн байдлын тайланд дүнгүүд нь хямдруулсан мөнгөн гүйлгээн дээр үндэслэсэн байх тул хямдруулаагүй мөнгөн гүйлгээ нь тайланд тусгасан дүнгээс зөрүүтэй байна. Дуусах хугацааны шинжилгээний зорилгоор үүсмэл санхүүгийн хөрөнгийг холимог санхүүгийн хэрэгслүүдээс салгахгүй.

Аккредитивийг дэмжихэд шаардагдах төлбөрийн чадварын хэмжээ нь дуусах хугацааны шинжилгээнд харуулсан өр төлбөрийн хариуцлагын хэмжээнээс бага юм. Учир нь Банк гуравдагч талыг эдгээр гэрээн дээр үндэслэн хөрөнгө татна гэж үздэггүй байна. Доорх дуусгавар хугацааны шинжилгээний хүснэгт дэх одоогийн нийт гэрээнд үндэслэсэн өр төлбөрийн хэмжээ нь ирээдүйд шаардлагатай мөнгөний хэмжээг илэрхийлэхгүй. Учир нь ихэнх энэ төрлийн гэрээт өр төлбөр нь ямар нэгэн санхүүжилтгүйгээр хугацаа нь дуусах буюу цуцлагддаг.

Өр төлбөрийн дүн тодорхой заагаагүй тохиолдолд тодруулсан дүнг тайлант хугацааны эцсээрх нөхцөл байдлын үндсэн дээр тодорхойлно. Гадаад валютаар хийсэн төлбөрийг тайлант хугацааны эцсийн спот ханшаар шилжүүлэн тооцно.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн өр төлбөрийн гэрээгээрх дуусгавар хугацааны шинжилгээг 2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав.

2020	**Хугацаагүй ба 1 сараас бага**	**1-6 сар**	**6-12 сар**	**12 сараас дээш**	**Нийт**
	сая.төг	**сая.төг**	**сая.төг**	**сая.төг**	**сая.төг**
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	991,470	–	–	–	991,470
Төв банкны үнэт цаас	7,777,935	–	266,799	–	8,044,734
Засгийн газрын харилцах, хадгаламж	1,483,042	1,339	–	685,731	2,170,112
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	3,871,477	–	–	–	3,871,477
Гадаад өр төлбөр	300,636	214,249	5,435,870	–	5,950,755
Бусад санхүүгийн өр төлбөр	363,157	–	–	–	363,157
Нийт төлөгдсөн своп болон форвард:					
- орох урсгал	(19,153)	(188,867)	(124,978)	(749,486)	(1,082,485)
- гарах урсгал	12,751	179,781	96,025	646,846	935,403
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
-ХАБ-тай байгуулсан хэлэлцээрийн ашиглагдагүй санхүүжилт	6,000,000	–	–	–	6,000,000
-Бусад болзошгүй өр төлбөр	35,898	–	–	–	35,898
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд төлж болзошгүй өр төлбөрүүд	20,817,212	206,502	5,673,716	583,091	27,280,521
2019					
Өр төлбөр					
Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө	897,417	–	–	–	897,417
Төв банкны үнэт цаас	4,278,866	380,783	5,285	–	4,664,934
Засгийн газрын харилцах, хадгаламж	1,558,247	997	5,952	637,223	2,202,419
Дотоодын банкуудын харилцах, хадгаламж	5,623,492	416,565	–	–	6,040,057
Гадаад өр төлбөр	184,201	92,043	4,843,866	–	5,120,110
Бусад санхүүгийн өр төлбөр	29,855	–	–	–	29,855
Нийт төлөгдсөн своп болон форвард:					
- орох урсгал	40,857	1,009,778	97,940	1,081,947	2,230,522
- гарах урсгал	(50,882)	(1,461,462)	(128,949)	(873,491)	(2,514,784)
Зээлтэй холбоотой төлбөрийн үүрэг					
-ХАБ-тай байгуулсан хэлэлцээрийн ашиглагдагүй санхүүжилт	5,400,000	–	–	–	5,400,000
-Бусад болзошгүй өр төлбөр	77,387	–	–	–	77,387
Санхүүгийн үүрэг хариуцлагын хүрээнд төлж болзошгүй өр төлбөрүүд	18,039,440	438,704	4,824,094	845,679	24,147,917

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Дотоодын банкуудын хадгаламж болон засгийн газрын байгууллагуудад өгөх өр төлбөрүүдийн ихэнх хэсэг нь Банкны үйл ажиллагааг санхүүжүүлэх тогтвортой эх үүсвэр болон үндсэн хадгаламжийг илэрхийлж байна. Үүнтэй адилаар Банк хэдийгээр гэрээний дагуу төлбөр хийх хугацааг хойшлуулах эрхгүй боловч гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, мөн санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг илэрхийлж байна. Хүлээгдэж буй дуусгавар хугацааны шинжилгээг доорх хүснэгтээс харна уу.

Банк нь хөрвөх чадварыг удирдах өр төлбөрүүдийн гэрээгээрх хямдруулаагүй дуусгавар хугацаанд суурилдаг шинжилгээг ашигладаггүй. Үүний оронд Банк санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнийн хүлээгдэж буй дуусгавар хугацааг болон үүнээс үүдэх тооцоолсон хөрвөх чадварын заагийг хянадаг. Доорх хүснэгтэд санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн хүлээгдэж буй дуусгавар хугацааны шинжилгээг харуулав.

Санхүүгийн өр төлбөрийн хүлээгдэж буй дуусгавар хугацаа нь банкинд байршуулсан их хэмжээний хадгаламж (ихэвчлэн төрийн байгууллагууд болон дотоодын банкуудаас байршуулсан) болон гүйлгээн дэх бэлэн мөнгөнөөс шалтгаалаад гэрээний дуусгавар хугацаанаасаа өөр байж болно. Санхүүгийн өр төлбөрийг төлөх шаардлага гарахад борлуулахад бэлэн байдаг санхүүгийн хөрөнгө нь борлуулагдахаар хүлээгдэж буй өдөртөө үндэслэн дуусгавар хугацааны шинжилгээнд хамрагдана. Үнэ цэнийн бууралттай зээл нь ирээдүйд орж ирэх мөнгөн урсгалынхаа цаг хугацаанд тулгуурлах ба үнэ цэнийн бууралтын сангийн дүнгээр дансны үнийг цэвэршүүлсэн дүнгээр илэрхийлэгддэг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэгслийн дуусгавар хугацааны шинжилгээг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав:

	Хугацаагүй ба 1 сараас бага сая.төг	1-6 сар сая.төг	6-12 сар сая.төг	12 сараас дээш сая.төг	Нийт сая.төг
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	233,373	–	–	–	233,373
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	4,517,392	–	–	–	4,517,392
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	1,981,989	65,429	108,089	3,119,622	5,275,129
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	–	–	–	6,595	6,595
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	4,522,516	–	62,314	231,238	4,816,068
Алт ба үнэт метал	1,405,887	–	–	–	1,405,887
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	–	90,559	–	65,860	156,419
Засгийн газрын үнэт цаас	–	–	–	227,407	227,407
Дотоодын банкуудад олгосон зээл	443	966	51,378	408,527	461,314
Бусад санхүүгийн хөрөнгө	72,978	97,736	20,833	181,943	373,490
Нийт санхүүгийн хөрөнгө	12,734,578	254,690	242,614	4,241,192	17,473,074
Өр төлбөр					
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	(991,470)	–	–	–	(991,470)
Төв банкны үнэт цаас	(7,777,935)	–	(174,503)	–	(7,952,438)
Засгийн газрын харилцах, хадгаламж	(1,452,764)	(1,337)	–	(677,924)	(2,132,025)
Банкуудын харилцах, хадгаламж	(3,871,397)	–	–	–	(3,871,397)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(6,403)	(99,645)	(28,953)	(168,500)	(303,501)
Гадаад өр төлбөр	(300,636)	(212,760)	(5,276,112)	–	(5,789,508)
Бусад санхүүгийн өр төлбөр	(363,157)	–	–	–	(363,157)
Нийт санхүүгийн өр төлбөр	(14,763,762)	(356,294)	(5,437,016)	(846,424)	(21,403,496)
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	(2,029,184)	(101,604)	(5,194,402)	3,394,768	(3,930,422)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

37. САНХҮҮГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (ҮРГЭЛЖЛЭЛ)

Санхүүгийн хэрэгслийн дуусгавар хугацааны шинжилгээг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар доорх хүснэгтэд харуулав:

	Хугацаагүй ба 1 сараас бага сая.төг	1-6 сар сая.төг	6-12 сар сая.төг	12 сараас дээш сая.төг	Нийт сая.төг
Хөрөнгө					
Бэлэн мөнгө	214,244	–	–	–	214,244
Гадаадын санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө, хадгаламж	3,478,178	980,330	–	–	4,458,508
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	1,010,064	32,789	106,841	2,723,448	3,873,142
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт	–	–	–	11,734	11,734
Урвуу буцаан худалдан авах хэлцэл	2,700,444	494,481	–	59,512	3,254,437
Алт ба үнэт метал	3,057,529	–	–	–	3,057,529
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	–	–	40	260,738	260,778
Засгийн газрын үнэт цаас	–	–	–	134,028	134,028
Дотоодын банкуудад олгосон зээл	443	966	51,378	390,131	442,918
Бусад санхүүгийн хөрөнгө	50,006	57,775	97,500	268,309	473,590
Нийт санхүүгийн хөрөнгө	10,510,908	1,566,341	255,759	3,847,900	16,180,908
Өр төлбөр					
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө	(897,417)	–	–	–	(897,417)
Төв банкны үнэт цаас	(4,254,293)	(370,000)	(5,000)	–	(4,629,293)
Засгийн газрын харилцах, хадгаламж	(1,558,247)	(981)	(5,823)	(636,534)	(2,201,585)
Банкуудын харилцах, хадгаламж	(5,623,208)	(415,496)	–	–	(6,038,704)
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	(10,025)	(451,684)	(31,049)	(52,282)	(545,040)
Гадаад өр төлбөр	(184,201)	(92,043)	(4,693,440)	–	(4,969,684)
Бусад санхүүгийн өр төлбөр	(29,855)	–	–	–	(29,855)
Нийт санхүүгийн өр төлбөр	(12,557,246)	(1,330,204)	(4,735,312)	(688,816)	(19,311,578)
Хөрвөх чадварын цэвэр зөрүү	(2,046,338)	236,137	(4,479,553)	3,159,084	(3,130,670)

38. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖИЛТ

Бодит үнэ цэнээрээ бүртгэгддэг санхүүгийн хэрэгслийн хувьд бодит үнэ цэнийн шатлалын түвшингээр дараах бүлгүүдэд хуваараг авч үздэг.

- 1-р түвшин: Хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхитэй зах зээл дээрх үнэ;
- 2 дугаар түвшин: Бүртгэсэн бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх бүх өгөгдлүүдийг нь шууд болон шууд бусаар ажиглах боломжтой бусад техникүүд;
- 3 дугаар түвшин: Бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашигладаггүй аргачлалууд;

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Удирдлага бодит үнэ цэнийн шатлалыг ашиглан санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа өөрсдийн үнэлэмжийг хэрэглэдэг. Хэрэв бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон залруулга хэрэгтэй ажиглагдахуйц өгөгдлүүд хэрэгтэй бол 3 дугаар түвшингээр тооцоолдог. Үнэлгээнд оролцож буй өгөгдлүүдийн нөлөөг нийт дүнд эзлэх хэмжээгээр үнэлдэг.

Түвшин 1, 2 болон 3 хоорондын шилжилт

Бодит үнэ цэнээр бүртгэгддэг хөрөнгө болон өр төлбөрийн үнэ бодит үнэ цэнийн шатлалын түвшин хооронд шилжилт хөдөлгөөн гараагүй байна.

Бодит үнэ цэнэ болон бодит үнэ цэнийн түвшинг тодорхойлох

Бодит үнэ цэнэ гэдэг нь дампуурсан болон албадан борлуулахад хүрсэн этгээдээс бусад аливаа сонирхож буй талуудын хооронд, санхүүгийн хэрэглүүрийг зах зээл дээр арилжаалах дүн юм. Зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслийн хувьд бодит үнэ цэнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно.

Дараах хүснэгтэд 2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бодит үнэ цэнээрээ бүртгэгдсэн санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн түвшнээр нь ангилан үзүүлэв.

2020 оны 12-р сарын 31	**Түвшин 1** сая.төг	**Түвшин 2** сая.төг	**Түвшин 3** сая.төг	**Нийт** сая.төг
Хөрөнгө, бодит үнэ цэнээр				
Санхүүгийн хөрөнгө				
-РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгүүд	930,566	–	–	930,566
-Олон улсын төлбөр тооцооны банкны бонд	898,352	–	–	898,352
-АНУ-ын Засгийн газрын бонд	326,604	–	–	326,604
-Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт	146,569	–	–	146,569
-КФВ бонд	30,554	–	–	30,554
-Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	17,575	–	–	17,575
-Бусад өмчийн хөрөнгө оруулалт	–	–	6,595	6,595
-Алт, үнэт металл	1,405,887	–	–	1,405,887
-Засгийн газрын үнэт цаас	–	227,407	–	227,407
-Өрийн бичгийн авлага	–	–	282,545	282,545
Санхүүгийн бус хөрөнгүүд				
-Барилга	–	–	89,745	89,745
-Эрдэнэсийн сан	–	–	1,071,665	1,071,665
Нийт бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгүүд	3,756,107	227,407	1,450,550	5,434,064
Бодит үнэ цэнээр бүртгэгддэг өр төлбөрүүд				
Санхүүгийн үүсмэл хэрэглүүр, хөрөнгө	–	–	156,419	156,419
Санхүүгийн үүсмэл хэрэглүүр, өр төлбөр	–	–	(303,501)	(303,501)

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2019 оны 12-р сарын 31	**Түвшин 1**	**Түвшин 2**	**Түвшин 3**	**Нийт**
	сая.төг	**сая.төг**	**сая.төг**	**сая.төг**
Хөрөнгө, бодит үнэ цэнээр				
Санхүүгийн хөрөнгө				
РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгүүд	870,831	–	–	870,831
АНУ-ын Засгийн газрын бонд	327,866	–	–	327,866
ОУСБХБ-ны хөрөнгө оруулалт	136,676	–	–	136,676
Хятадын засгийн газрын бонд	35,746	–	–	35,746
КФВ бонд	67,814	–	–	67,814
Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	10,910	–	–	10,910
МИК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт	5,139	–	–	5,139
Алт, үнэт металл	3,057,529	–	–	3,057,529
Засгийн газрын үнэт цаас	–	134,028	–	134,028
Өрийн бичгийн авлага	–	–	394,621	394,621
Санхүүгийн бус хөрөнгүүд				
Барилга	–	–	43,771	43,771
Эрдэнэсийн сан	–	–	1,068,860	1,068,860
Нийт бодит үнэ цэнээр хэмжигддэг хөрөнгүүд	4,512,511	–	1,507,252	6,153,791
Бодит үнэ цэнээр бүртгэгддэг өр төлбөрүүд				
Санхүүгийн үүсмэл хэрэглүүр, хөрөнгө	–	–	260,778	260,778
Санхүүгийн үүсмэл хэрэглүүр, өр төлбөр	–	–	(545,040)	(545,040)

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хэмжсэн үнэлгээний аргачлал болон Түвшин 2-ын бодит үнэ цэнийн хэмжилтэд ашигласан өгөгдлүүдийн тодорхойлолтыг доорх хүснэгтэд харуулав:

	Бодит үнэ цэнэ 2020 сая.төг	**Бодит үнэ цэнэ 2019 сая.төг**	**Үнэлгээний аргачлал**	**Ашигласан өгөгдлүүд**
Хөрөнгө, бодит үнэ цэнээр				
Санхүүгийн хөрөнгө				
-Засгийн газрын үнэт цаас	227,407	134,028	Хямдруулсан мөнгөн урсгал	Хямдруулсан хүүгээр бодлогын хүү

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

2020 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хэмжсэн үнэлгээний аргачлал болон Түвшин 3-ын бодит үнэ цэнийн хэмжилтэд ашигласан өгөгдлүүдийн тодорхойлолтыг доорх хүснэгтэд харуулав:

Хөрөнгө, бодит үнэ цэнээр				
Санхүүгийн хөрөнгө				
-Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	156,419	260,778	Хямдруулсан мөнгөн урсгал	Z-тархалт, ЛИБОР 6 сар, Репо хүү/ (бодлогын хүү), GAP загвараар тооцсон форвард ханш
-Өрийн бичгийн авлага	281,754	394,621	Хямдруулсан мөнгөн урсгал	Өрийн бичиг гаргагчийн аудитлагдсан санхүүгийн тайлан, зах зээлийн хүү (бодлогын хүү+зээлдэгчийн эрсдэл %) болон эргэн төлөлтийн хуваарийн дагуу мөнгөн урсгалын тооцоолол
Санхүүгийн бус хөрөнгө				
-Барилга	89,745	43,771	Зах зээлийн болон өртгийн арга	Харьцуулах боломжтой зах зээлийн үнэ болон хөндлөнгийн үнэлгээний компанийн дотоод хайлтын мэдээлэл
-Эрдэнэсийн сан	1,071,665	1,068,860	Зах зээлийн болон өртгийн арга	Харьцуулах боломжтой зах зээлийн үнэ болон хөндлөнгийн үнэлгээний компанийн дотоод хайлтын мэдээлэл
Өр төлбөр, бодит үнэ цэнээр				
Санхүүгийн өр төлбөр				
-Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	-303,501	-545,040	Хямдруулсан мөнгөн урсгал	Z-тархалт, ЛИБОР 6 сар, Репо хүү/ (бодлогын хүү), GAP загвараар тооцсон форвард ханш
Түвшин 3-ын бодит үнэ цэнийн хэмжилт хийсэн нийт хөрөнгө	1,296,082	1,222,990		

Үл ажиглагдахуйц өгөгдлийн өөрчлөлтийн хувьд бодит үнэ цэнийн мэдрэмтгий байдлын шинжилгээ

Доорх хүснэгтэд үл ажиглагдахуйц өгөгдлийг мэдэгдэхүйц өөрчлөгдөх үед 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар Түвшин 3-ын бодит үнэ цэнийн үнэлэх боломжит хувилбаруудыг харуулав. Өөрчлөлтүүд нь Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгагдана. Мэдрэмтгийн байдлын хэмжээг бодит үнэ цэнэ хэмжих аргачлалын хүрээнд аргачлалд ашиглах өгөгдлийг тохиромжтой хэмжээнд тохируулж тооцоолдог.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь харьцуулах боломжгүй ба тэнцүү хэмжээгээр өсч, буурахгүй. Учир нь аргачлалд ашигладаг өгөгдлүүд таатай болон таагүй өөрчлөлт бодит үнэ цэнэд харилцан адилгүй нөлөөлдөг.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

38. БОДИТ ҮНЭ ЦЭНИЙН ХЭМЖИЛТ (ҮРГЭЛЖЛЭЛ)

			Бодит үнэ цэнийн мэдрэмтгий байдал	
Санхүүгийн хөрөнгө/ өр төлбөр	**Үл ажиглагдахуйц өгөгдөл**	**Өөрчлөлтийн хувь**	**2020 сая.төг**	**2019 сая.төг**
Санхүүгийн үүсмэл хөрөнгө	Ирээдүйн төг/ам долларын ханш	5%	(63,507)	(94,991)
		-5%	26,981	108,333
Санхүүгийн үүсмэл өр төлбөр	Ирээдүйн төг/ам долларын ханш	5%	(131,238)	(106,360)
		-5%	167,721	93,018
Өрийн бичгийн авлага	Хямдруулалтын хүүгийн түвшин	+100bps	(3,793)	(6,649)
		-100bps	1,124	3,545
Эрдэнэсийн сан	Зах зээлийн үнэ	10%	107,167	106,180
		-10%	(107,167)	(106,180)
Барилга	Зах зээлийн үнэ	20%	17,949	8,754
		-20%	(17,949)	(8,754)

Түвшин 3-ын бодит үнэ цэнийн хэмжилтийн тайлант жилийн хөдөлгөөнийг доор үзүүлэв.

Өрийн бичгийн авлага	**2020 Сая.төг**	**2019 Сая.төг**
01-р сарын 01-ний өдрөөрх	394,621	748,656
Төлбөр тооцоо	(102,575)	(272,500)
Хуримтлагдсан хүү	18,206	6,989
Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн алдагдал	(27,707)	(88,524)
12-р сарын 31-ний өдрөөрх	**282,545**	**394,621**

Санхүүгийн үүсмэл хэрэгсэл хэрэгсэл	**2020 Сая.төг**	**2019 Сая.төг**
01-р сарын 01-ний өдрөөрх	(284,262)	(169,053)
Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит бус ашиг/(алдагдал) (Тодруулга 9)	138,813	(136,512)
Хүүний орлого, цэвэр (Тодруулга 6 болон 7)	138,271	93,932
Төлбөр тооцоо	(139,904)	(72,629)
12-р сарын 31-ний өдрөөрх	(147,082)	(284,262)

Барилга байгууламж болон эрдэнэсийн сангийн бодит үнэ цэнийн тайлант жилийн хөдөлгөөнийг Тодруулга 27 болон Тодруулга 23-с тус тус харна уу.

Бодит үнэ цэнээр хэмжигдээгүй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Хөрвөх чадвар өндөртэй эсвэл богино хугацаат (нэг жилээс бага хугацаа) санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн 2019 болон 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх бодит үнэ цэнэ нь тэдгээрийн дансны цэвэр үнэтэй ойролцоо байна.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ХЭМЖИЛТЭЭР НЬ АНГИЛСАН БАЙДЛААР САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙГ ТОЛИЛУУЛАХ НЬ

Хэмжилтийн зорилгоор СТОУС 9 “Санхүүгийн хэрэглүүр” нь санхүүгийн хөрөнгийг дараах ангилалд ангилдаг: (a) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (БҮЦӨАА) хэмжих санхүүгийн хөрөнгө, (b) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод (БҮЦӨБДО) хэмжих өрийн хэрэгсэл (c) бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогод (БҮЦӨБДО) хэмжих өмчийн хэрэгсэл, (d) хорогдуулсан өртгөөрх (ХӨ) санхүүгийн хөрөнгө.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар (БҮЦӨАА) хэмжих санхүүгийн хөрөнгө нь 2 дэд ангилалтай: (1) Зайлшгүй ОЗБҮЦ-ээр хэмжих, (2) анх хүлээн зөвшөөрөхөд эсвэл дараа нь тодорхойлох хөрөнгө.

Доорх хүснэгтэд 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн хөрөнгүүдийг тэдгээрийн хэмжилтийн ангиллаар нь үзүүлэв:

	ХӨ сая.төг	БҮЦӨБДО өрийн хэрэгсэл сая.төг	БҮЦӨБДО хэмжих өмчийн хэрэгсэл сая.төг	БҮЦӨАА (зайлшгүй) сая.төг	Нийт сая.төг
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө					
-Бэлэн мөнгө	233,373	–	–	–	233,373
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө					
-Богино хугацаат хадгаламж–гадаад валютаар	3,507,650	–	–	–	3,507,650
-Хугацаагүй хадгаламж	878,047	–	–	–	878,047
-Зээлжих тусгай эрхийн хадгаламж	131,503	–	–	–	131,503
-Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	179	–	–	–	179
-Бусад хувь хөрөнгө	13	–	–	–	13
Харилцагч нарт олгосон зээл, урьдчилгаа					
-Үнэ Тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл	368,840	–	–	–	368,840
-Барьцаат зээл	6,100	–	–	–	6,100
-Бусад зээл	86,374	–	–	–	86,374
Алт ба үнэт метал	–	–	–	1,405,887	1,405,887
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт					
-РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгө	–	930,566	–	–	930,566
-АНУ-ын Засгийн газрын бонд	–	326,604	–	–	326,604
-Олон улсын төлбөр тооцооны банкинд оруулсан хөрөнгө оруулалт	–	146,569	–	–	146,569
-Олон улсын төлбөр тооцооны банкны бонд	–	898,352	–	–	898,352
- КФВ банкны бонд	–	30,554	–	–	30,554
- Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	–	17,575	–	–	17,575
-Давуу эрхтэй ИЗББ	2,287,410	–	–	–	2,287,410
-Хөгжлийн банкны үнэт цаас	55,650	–	–	–	55,650
-Эрдэнэс бонд	547,155	–	–	–	547,155
-Хөрөнгөөр баталгаажсан бонд	34,694	–	–	–	34,694
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт					
-Бусад өмчийн хөрөнгө оруулалт	–	–	6,595	–	6,595
Буцаан худалдан авах гэрээ					
- Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	4,393,375	–	–	–	4,393,375
- Дотоодын банкууд	422,693	–	–	–	422,693
Засгийн газрын үнэт цаас	–	227,407	–	–	227,407
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	–	–	–	156,419	156,419
Бусад санхүүгийн хөрөнгө	90,945	–	–	282,545	373,490
НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	13,044,001	2,577,627	6,595	1,844,851	17,473,074

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

39. ХЭМЖИЛТЭЭР НЬ АНГИЛСАН БАЙДЛААР САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛИЙГ ТОЛИЛУУЛАХ НЬ (ҮРГЭЛЖЛЭЛ)

Доорх хүснэгтэд 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн хөрөнгүүдийг тэдгээрийн хэмжилтийн ангиллаар нь үзүүлэв:

	ХӨ сая.төг	БҮЦӨБДО өрийн хэрэгсэл **сая.төг**	БҮЦӨБДО хэмжих өмчийн хэрэгсэл **сая.төг**	БҮЦӨАА **(зайлшгүй) сая.төг**	**Нийт сая.төг**
Санхүүгийн хөрөнгө					
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө					
-Бэлэн мөнгө	214,244	–	–	–	214,244
Санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө					
-Богино хугацаат хадгаламж–гадаад валютаар	3,553,803	–	–	–	3,553,803
-Хугацаагүй хадгаламж	769,351	–	–	–	769,351
-Зээлжих тусгай эрхийн хадгаламж	135,171	–	–	–	135,171
-Дэлхийн банкинд оруулсан хувь хөрөнгө	172	–	–	–	172
-Бусад хувь хөрөнгө	11	–	–	–	11
Харилцагч нарт олгосон зээл, урьдчилгаа					
-Үнэ Тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд олгосон зээл	434,400	–	–	–	434,400
-Бусад зээл	8,518	–	–	–	8,518
Алт ба үнэт метал	–	–	–	3,057,529	3,057,529
Өрийн үнэт цаасны хөрөнгө оруулалт					
-РАМП хөрөнгө оруулалтын дансны хөрөнгө	–	870,831	–	–	870,831
-АНУ-ын засгийн газрын бонд	–	327,866	–	–	327,866
- ОУСБХБ-ны хөрөнгор оруулалт	–	136,676	–	–	136,676
- КФВ банкны бонд	–	35,746	–	–	35,746
-Хятадын засгийн газрын бонд	–	67,814	–	–	67,814
- Европын хөрөнгө оруулалтын банкны бонд	–	10,910	–	–	10,910
-Давуу эрхтэй ИЗББ	2,373,777	–	–	–	2,373,777
-Хөгжлийн банкны үнэт цаас	49,522	–	–	–	49,522
Өмчийн үнэт цаасны хөрөнгө оруулалт					
- МИК-д оруулсан өмчийн хөрөнгө оруулалт	–	–	5,139	–	5,139
-Бусад өмчийн хөрөнгө оруулалт	–	–	6,595	–	6,595
Буцаан худалдан авах гэрээ					
- Нью-Йоркийн Холбооны нөөцийн банк	2,700,444	–	–	–	2,700,444
- Дотоодын банкууд	553,993	–	–	–	553,993
Засгийн газрын үнэт цаас	–	134,028	–	–	134,028
Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	–	–	–	260,778	260,778
Бусад санхүүгийн хөрөнгө	78,969	–	–	394,621	473,590
НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	10,872,375	1,583,871	11,734	3,712,928	16,180,908

2020 оны 12 дугаар сарын 31 болон 2019 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар орлого зарлагаар бодит үнэ цэнийг хэмжих ангилалд хамаарах үүсмэл хэрэглүүрээс бусад Банкны бүх санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

40. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА

Банкны өөрийн хөрөнгө нь нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассаны дараа үлдэх дүнгээс бүрдэнэ. Өөрийн хөрөнгийг удирдахад Банкны баримтлах гол зорилго нь , чиг үүргээ хараат бусаар бүрэн хэрэгжүүлэх боломжоор хангасан хөрөнгийг тохиромжтой хэмжээнд барьж байх явдал юм. Банкны нийт өөрийн хөрөнгө нь санхүүгийн байдлын тайланд толилуулсан санхүүгийн тайлангийн өөрийн хөрөнгө хэсгийн дүнтэй тэнцүү гэж үздэг.

Банк нь төв банк тул өөрийн хөрөнгийн талаарх ямар нэгэн гадаад шаардлагууд тавигддаггүй байна. Төв банкны тухай хуульд Банкны зайлшгүй байлгах хөрөнгө (дүрмийн сан)-ийн доод хэмжээ болон Банк өөрийн хөрөнгөнд хуваарилах ёстой тухайн жилийн цэвэр ашгийн доод хэмжээг заасан байдаг.

УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн 11/2200 тоот албан бичгээр уг гүйлгээг хийсэн болохыг баталгаажуулсан бөгөөд Банкыг дүрмийн сангаа дахин нэмэгдүүлэхийг үүрэг болгосон. Удирдлага нь энэхүү гүйлгээг холбогдох хууль, журамд нийцэж байгаа гэж дүгнэж байна.

2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар дүрмийн сангийн хэмжээ 60,000 сая төгрөг (2019 оны 12 дугаар сарын 31: 60,000 сая төгрөг) байгаа бөгөөд энэ нь хуульд заасан хамгийн бага дүн болох 5,000 сая төгрөгөөс их байна. Хуулинд зааснаар Банкны цэвэр орлогын дор хаяж 40 хувийг Банкны өөрийн өмчид хуваарилж болох бөгөөд үлдсэн хувийг (дээд тал нь цэвэр орлогын 60 хувь) Улсын төсвийн дансанд шилжүүлнэ. 2019 болон 2020 онуудад Улсын төсвийн дансанд шилжүүлэг хийгдээгүй байна.

Банк нь 2020 оны тайлант жилд 503,378 сая төгрөгийн алдагдалтай (2019 онд 229,879 сая төгрөгийн алдагдалтай) ба 2020 оны 12 дугаар сарын 31 өдрийн байдлаар өөрийн хөрөнгийн нийт 2,309,283 сая төгрөгийн (2019: 1,898,304 сая төгрөг) сөрөг дүнтэй байна. Төв банкны тухай хуулийн 38-р зүйлд, хэрэв Төв банк нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн дутагдалд орвол засгийн газар үнэт цаас гаргах замаар уг алдагдлыг нөхөх асуудлыг УИХ шийдвэрлэнэ гэж заасан. Тиймээс засгийн газар Банкны энэхүү дутагдлыг санхүүжүүлэх үүрэг хүлээгээгүй болно. УИХ нь засгийн газрын бонд гаргах замаар Банкны энэхүү алдагдлыг арилгах боломжтой байна.

Энэхүү хуулийн 37 дугаар зүйлд Банкны дахин үнэлгээний сан нь дараах хэсгүүдээс бүрдэнэ хэмээн заажээ. Үүнд:

- Монгол төгрөг болон гадаад валют солилцооны ханшийн хэлбэлзлээс шалтгаалан алт болон гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө ба өр төлбөрийн валютыг дахин үнэлснээс үүдэлтэй зөрүү;
- Үндсэн хөрөнгө (байшин, барилга гэх мэт.) -ийн дахин үнэлгээнээс үүдэлтэй зөрүү.

Энэхүү хуулийн 37 дугаар зүйлд гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө ба өр төлбөр болон алтны дахин үнэлгээний цэвэр зөрүүг Банкны цэвэр орлогын тооцоонд хамааруулахгүй гэж заасан.

МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА-2020 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

41. ТАЙЛАНТ ХУГАЦААНЫ ДАРААХ ҮЙЛ ЯВДЛУУД

Ковид-19 цар тахлын үед Банкнаас улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн тодорхой хариу арга хэмжээнүүдийг авч байна. Удирдлага тэдгээр арга хэмжээн нь Банкны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байгаа ба доор дурдсанаас бусдаар тайлант хугацааны дараа эдгээр санхүүгийн тайлангуудад материаллаг нөлөө үзүүлэх бусад үйл явдал гараагүй болно.

42. МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ТАЙЛАН

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи хэл дээр мөн бэлтгэсэн болно. Монгол, Англи хувиудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувийг дагана.

Сум, тосгодоор харилцах, хадгаламж болон зээл, 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

сая төгрөгөөр

Аймаг/Хот	Сум/Тосгон	Харилцах		Үүнээс: Иргэд	Хадгаламж		Үүнээс: Иргэд	Зээл		Үүнээс: Иргэд
		Төгрөг	Валют		Төгрөг	Валют		Төгрөг	Валют	
Улсын дүн		**3,428,727.2**	**1,980,821.1**	**1,561,111.9**	**13,214,289.6**	**4,640,996.7**	**15,284,340.1**	**15,124,988.3**	**1,531,148.4**	**8,488,087.1**
Баруун бүс		**112,678.6**	**2,920.7**	**90,431.4**	**694,486.8**	**13,405.0**	**695,291.0**	**783,917.9**	**2,641.4**	**722,802.1**
Завхан	**Нийт дүн**	**20,539.2**	**179.7**	**17,642.5**	**135,834.5**	**5,210.4**	**139,626.7**	**159,889.6**	**-**	**151,576.9**
	Улиастай	8,320.2	173.4	6,375.3	51,106.2	4,671.7	54,612.6	63,710.2	-	56,047.5
	Алдархаан	588.6	-	578.8	1,827.1	-	1,827.1	5,301.8	-	5,252.0
	Асгат	139.1	-	134.2	1,983.9	-	1,983.9	1,922.1	-	1,907.1
	Баянтэс	393.1	-	385.4	2,384.1	-	2,384.1	5,450.6	-	5,450.6
	Баянхайрхан	434.9	-	427.2	2,392.0	-	2,392.0	2,546.7	-	2,546.7
	Дөрвөлжин	529.5	0.1	326.7	4,241.2	256.2	4,497.4	4,424.6	-	4,417.9
	Завханмандал	231.8	0.0	224.5	2,696.4	-	2,696.4	2,155.0	-	2,155.0
	Идэр	431.9	0.0	418.1	2,810.9	-	2,810.9	4,218.1	-	4,218.1
	Их-Уул	1,093.6	0.0	1,053.4	7,090.7	1.2	7,091.9	5,929.1	-	5,740.5
	Нөмрөг	353.7	0.0	342.3	3,749.0	0.0	3,749.1	3,840.1	-	3,840.1
	Оттон	550.7	0.0	536.7	3,226.7	111.5	3,338.2	5,449.7	-	5,449.7
	Сантмаргаз	340.4	-	324.1	3,825.1	-	3,825.1	4,052.9	-	4,052.9
	Сонгино	443.3	0.0	435.9	2,898.9	-	2,898.9	2,843.2	-	2,843.2
	Тосонцэнгэл	2,326.4	5.1	2,051.5	15,524.2	58.2	15,329.5	17,984.4	-	17,694.5
	Түдэвтэй	332.7	-	321.3	3,585.9	26.8	3,612.6	3,599.2	-	3,599.2
	Тэлмэн	651.3	0.0	589.1	3,145.7	3.5	3,149.2	4,006.4	-	3,906.4
	Тэс	719.8	0.0	585.2	5,102.0	1.7	5,103.8	5,724.2	-	5,724.2
	Ургамал	194.0	0.0	189.2	2,762.1	72.7	2,834.7	1,979.8	-	1,979.8
	Цагаанхайрхан	314.9	0.1	308.0	1,870.9	0.1	1,871.0	2,431.6	-	2,431.6
	Цагаанчулуут	382.0	0.5	371.4	3,080.7	0.2	3,080.9	1,886.5	-	1,886.5
	Цэцэн-Уул	407.6	0.0	401.5	2,402.5	0.2	2,402.7	3,159.0	-	3,159.0
	Шилүүстэй	502.5	-	468.8	2,368.3	6.4	2,374.7	2,905.0	-	2,905.0
	Эрдэнэхайрхан	401.7	-	339.3	3,180.7	-	3,180.7	1,989.5	-	1,989.5
	Яруу	455.6	0.4	454.4	2,579.4	-	2,579.4	2,379.9	-	2,379.9
Говь-Алтай	**Нийт дүн**	**19,502.2**	**57.7**	**16,386.9**	**122,621.6**	**477.0**	**122,464.6**	**124,537.7**	**-**	**116,149.5**
	Есөнбулаг	9,224.3	40.5	6,423.3	54,151.3	459.8	53,997.1	53,582.8	-	46,909.9
	Алтай	690.9	-	684.5	4,306.9	1.1	4,308.0	16,420.2	-	15,012.4
	Баян-Уул	637.3	0.0	600.9	5,026.8	0.1	5,026.8	2,875.3	-	2,875.3

	Бигэр	842.4	0.0	841.1	4,531.8	0.0	4,531.8	3,251.8	-	3,190.8
	Бугат	647.3	0.0	638.0	5,407.2	-	5,407.2	2,700.3	-	2,700.3
	Дарив	521.9	0.0	406.8	3,400.4	6.2	3,386.6	2,402.1	-	2,339.4
	Дэлгэр	759.4	0.0	756.4	4,600.8	0.2	4,600.9	6,016.6	-	6,016.6
	Жаргалан	480.5	0.0	476.7	3,203.5	-	3,203.5	2,595.8	-	2,595.8
	Тайшир	332.0	-	324.5	1,053.2	-	1,053.2	2,264.9	-	2,264.9
	Тонхил	566.9	0.2	564.4	8,100.4	0.2	8,100.5	2,492.9	-	2,492.9
	Төгрөг	471.1	-	449.0	4,433.5	0.7	4,434.2	2,834.5	-	2,834.5
	Халиун	593.2	16.5	592.9	1,860.1	-	1,860.1	2,931.2	-	2,931.2
	Хөхморьт	496.8	0.0	479.7	2,511.3	-	2,511.3	3,699.5	-	3,662.5
	Цогт	1,078.8	0.4	1,041.8	5,458.4	8.9	5,467.3	5,452.9	-	5,452.9
	Цээл	948.3	0.0	923.7	5,668.1	-	5,668.1	2,889.9	-	2,885.3
	Чандмань	409.9	0.0	408.8	3,436.6	0.0	3,436.7	4,129.4	-	3,990.3
	Шарга	340.2	-	335.2	2,582.5	0.0	2,582.5	2,614.0	-	2,614.0
	Эрдэнэ	461.0	0.0	439.4	2,888.8	0.0	2,888.8	5,383.5	-	5,380.5
Баян-Өлгий	**Нийт дүн**	**22,116.6**	**1,275.5**	**18,353.4**	**135,125.6**	**2,629.5**	**134,355.4**	**154,065.9**	**2,640.4**	**141,300.9**
	Өлгий	13,580.3	691.0	10,574.5	91,694.7	2,347.1	90,642.1	107,839.9	2,640.4	95,133.5
	Алтай	512.7	0.0	495.5	4,527.3	73.5	4,600.8	3,183.5	-	3,183.5
	Алтанцөгц	461.8	0.0	461.7	1,109.1	1.4	1,110.5	2,746.5	-	2,746.5
	Баяннуур	651.5	0.0	632.1	3,703.2	1.0	3,704.2	3,063.1	-	3,063.1
	Бугат	297.7	583.7	282.9	2,228.7	105.9	2,334.6	3,301.3	-	3,262.8
	Булган	751.0	-	727.9	7,253.6	-	7,253.6	2,476.2	-	2,476.2
	Буянт	282.3	0.0	277.1	1,560.7	-	1,560.7	2,424.0	-	2,424.0
	Дэлүүн	1,218.3	0.0	1,200.6	5,439.1	0.4	5,439.5	3,513.7	-	3,513.7
	Ногооннуур	753.3	0.3	745.0	3,365.6	98.8	3,464.4	4,964.7	-	4,964.7
	Сагсай	446.2	0.1	432.8	2,589.2	-	2,589.2	5,098.0	-	5,098.0
	Толбо	529.6	-	500.2	2,177.2	0.2	2,177.5	2,911.9	-	2,911.9
	Улаанхус	947.2	-	901.5	4,176.6	0.3	4,176.9	5,043.3	-	5,043.3
	Цагааннуур	213.9	0.0	212.0	2,312.3	0.1	2,312.4	1,911.3	-	1,911.3
	Цэнгэл	1,470.7	0.3	909.5	2,988.3	0.8	2,989.1	5,588.7	-	5,568.5
Ховд	**Нийт дүн**	**26,954.8**	**669.2**	**20,108.8**	**131,971.5**	**1,697.3**	**132,000.2**	**179,492.4**	**1.0**	**163,280.0**
	Жаргалант	13,222.7	482.3	10,693.2	60,284.1	1,328.9	79,492.5	111,984.0	1.0	95,989.6
	Алтай	497.0	0.0	482.3	5,591.0	2.5	5,593.4	3,643.0	-	3,641.0
	Булган	4,865.2	186.8	1,710.6	28,120.7	310.4	8,883.1	15,816.7	-	15,662.8

	Буянт	530.3	0.0	524.1	2,893.4	-	2,893.4	2,815.4	-	2,815.4
	Дарви	581.8	0.0	526.7	4,383.5	0.8	4,384.3	3,747.8	-	3,747.8
	Дуут	327.9	-	312.9	1,732.1	9.1	1,741.2	2,598.2	-	2,598.2
	Дөргөн	342.3	-	319.1	1,873.9	0.2	1,874.2	3,444.3	-	3,444.3
	Зэрэг	582.9	-	539.7	3,469.6	0.0	3,469.7	3,307.4	-	3,307.4
	Манхан	591.5	0.0	569.8	2,979.7	3.9	2,983.6	4,974.9	-	4,921.7
	Мөнххайрхан	452.4	0.0	429.6	1,862.7	0.0	1,862.7	2,783.9	-	2,783.9
	Мөст	767.4	0.0	727.3	3,456.5	0.0	3,456.5	2,870.3	-	2,866.4
	Мянгад	566.9	0.0	556.9	1,716.0	0.7	1,716.8	2,996.2	-	2,996.2
	Үенч	715.6	0.0	696.5	4,037.0	38.7	4,075.8	6,402.1	-	6,399.7
	Ховд	437.9	-	431.7	2,796.2	0.0	2,796.2	2,513.8	-	2,513.8
	Цэцэг	1,533.1	-	693.2	3,208.1	1.9	3,210.0	3,378.5	-	3,378.5
	Чандмань	533.4	0.1	506.7	2,059.9	-	2,059.9	3,749.9	-	3,749.9
	Эрдэнэбүрэн	406.4	0.0	388.6	1,507.1	-	1,507.1	2,466.0	-	2,463.3
		Харилцах		Үүнээс: Иргэд	Хадгаламж		Үүнээс: Иргэд	Зээл		Үүнээс: Иргэд
Аймаг/Хот	Сум/Тосгон	Төгрөг	Валют		Төгрөг	Валют		Төгрөг	Валют	
Увс	**Нийт дүн**	**23,565.8**	**738.6**	**17,939.9**	**168,933.5**	**3,390.8**	**166,844.0**	**165,932.2**	**-**	**150,494.7**
	Улаангом	13,247.4	737.8	8,809.9	101,593.3	3,302.3	99,426.8	93,204.4	-	79,320.9
	Баруунтуруун	1,334.7	0.1	668.7	4,323.4	1.2	4,324.6	6,934.3	-	5,459.3
	Бөхмөрөн	425.0	-	395.5	3,192.5	0.0	3,192.5	3,616.6	-	3,616.6
	Давст	249.5	-	235.3	1,805.6	-	1,805.6	3,054.0	-	3,054.0
	Завхан	252.9	0.0	241.2	2,930.8	-	2,930.8	3,411.8	-	3,411.8
	Зүүнговь	621.4	-	585.3	2,528.5	0.0	2,528.6	4,576.5	-	4,576.5
	Зүүнхангай	639.6	0.1	569.7	6,897.0	0.1	6,885.7	3,125.0	-	3,125.0
	Малчин	463.7	-	461.3	2,797.7	0.0	2,797.7	2,707.7	-	2,707.7
	Наранбулаг	597.0	-	570.0	3,555.9	0.0	3,556.0	5,279.8	-	5,250.2
	Өлгий	360.0	0.0	356.2	2,063.3	0.3	2,063.6	3,125.9	-	3,125.9
	Өмнөговь	658.3	-	613.4	4,910.4	1.5	4,911.9	5,897.4	-	5,897.4
	Өндөрхангай	686.0	-	658.6	4,829.0	0.1	4,829.1	4,946.5	-	4,946.5
	Сагил	509.3	0.0	434.8	1,988.9	-	1,988.9	3,359.0	-	3,359.0
	Тариалан	657.0	0.0	612.8	5,329.5	-	5,329.5	2,943.0	-	2,921.0
	Түргэн	323.9	-	279.0	1,515.2	0.1	1,515.3	2,215.0	-	2,215.0

	Тэс	1,012.5	-	997.7	5,172.4	-	5,172.4	7,314.8	-	7,314.8
	Ховд	359.7	0.0	350.7	3,432.5	6.7	3,439.2	3,510.4	-	3,483.0
	Хяргас	586.8	0.0	544.8	4,906.8	78.4	4,985.2	3,377.3	-	3,377.3
	Цагаанхайрхан	581.1	0.7	554.8	5,160.7	-	5,160.7	3,332.7	-	3,332.7
Хангайн бүс		**197,153.0**	**27,595.2**	**158,321.1**	**1,124,509.4**	**64,810.6**	**1,153,536.3**	**1,226,185.6**	**69.9**	**1,126,650.9**
Орхон	**Нийт дүн**	**51,503.5**	**26,308.6**	**41,705.1**	**331,655.3**	**53,225.1**	**358,150.7**	**326,058.6**	**56.9**	**276,469.4**
	Баян-Өндөр	50,854.0	26,308.5	41,072.1	328,951.6	53,221.1	355,457.9	321,848.1	56.9	272,259.9
	Жаргалант	649.5	0.1	633.0	2,703.7	4.0	2,692.7	4,210.4	-	4,209.4
Өвөрхангай	**Нийт дүн**	**36,361.0**	**218.0**	**27,419.0**	**190,822.9**	**2,956.1**	**191,288.8**	**205,620.3**	**6.6**	**189,531.7**
	Арвайхээр	15,391.7	182.4	9,415.9	83,871.2	793.9	83,538.3	110,879.5	4.2	95,562.9
	Баруунбаян-Улаан	564.5	-	547.7	3,897.1	-	3,897.1	3,088.0	-	3,088.0
	Бат-Өлзий	2,141.3	1.1	2,015.9	14,241.6	244.3	14,485.8	11,455.8	-	11,353.0
	Баянгол	851.4	0.0	842.8	4,351.1	0.0	4,351.1	3,418.0	-	3,418.0
	Баян-Өндөр	1,000.6	-	933.5	5,921.6	3.6	5,925.1	2,814.3	-	2,814.3
	Богд	1,020.9	0.4	996.7	5,470.0	22.6	5,492.6	5,616.7	-	5,616.7
	Бүрд	703.4	-	669.0	5,049.1	0.0	5,049.1	3,426.4	-	3,426.4
	Гучин-Ус	505.8	0.1	492.3	2,954.0	1.0	2,955.0	2,426.1	-	2,426.1
	Есөнзүйл	535.4	-	525.6	1,958.5	4.2	1,962.7	2,599.7	2.4	2,602.2
	Зүүнбаян-Улаан	906.9	0.7	901.8	2,191.2	0.7	2,191.9	3,221.8	-	3,221.8
	Нарийнтээл	996.2	-	781.6	4,795.8	0.9	3,546.1	4,236.2	-	4,236.2
	Өлзийт	426.9	-	424.4	2,140.6	45.1	2,185.7	2,356.9	-	2,356.9
	Сант	617.9	0.1	593.6	3,912.3	37.4	3,949.7	3,397.5	-	3,397.5
	Тарагт	473.7	0.0	464.6	1,232.5	0.0	1,232.5	2,284.4	-	2,284.4
	Төгрөг	489.7	0.2	480.9	2,424.0	20.8	2,444.8	3,102.0	-	3,102.0
	Уянга	2,543.3	0.0	2,226.4	12,869.7	5.1	12,874.8	8,269.7	-	8,269.7
	Хайрхандулаан	808.3	2.8	806.3	3,458.9	0.0	3,458.9	3,536.3	-	3,536.3
	Хархорин	3,436.8	30.0	2,816.7	21,689.5	1,768.2	23,440.7	21,367.0	-	20,718.7
	Хужирт	2,946.3	0.1	1,483.2	8,394.4	8.3	8,306.9	8,124.0	-	8,100.6
Булган	**Нийт дүн**	**15,735.7**	**243.2**	**13,822.9**	**78,441.2**	**552.2**	**78,835.6**	**117,735.8**	**-**	**110,577.5**
	Булган	5,337.8	174.7	4,059.1	27,419.4	400.9	27,682.5	40,061.3	-	34,467.6
	Баян-Агт	671.2	2.8	661.4	3,170.4	11.3	3,181.7	5,444.8	-	5,332.0
	Баяннуур	473.2	0.3	471.4	1,517.6	-	1,507.6	4,408.8	-	4,408.8

	Бугат	373.2	-	334.2	1,961.4	0.0	1,961.4	2,636.9	-	2,476.9
	Бүрэгхангай	715.8	0.0	653.5	3,460.6	23.7	3,484.3	5,045.4	-	5,045.4
	Гурванбулаг	544.6	0.2	530.7	4,295.6	3.4	4,289.0	4,755.0	-	4,735.4
	Дашинчилэн	451.8	0.0	435.4	3,926.4	18.0	3,944.3	5,858.2	-	5,796.7
	Могод	715.0	-	713.7	5,889.0	-	5,889.0	3,807.6	-	3,807.6
	Рашаант	653.1	0.0	611.3	3,917.6	1.4	3,919.0	6,768.6	-	6,688.6
	Сайхан	691.2	0.0	671.0	4,917.5	55.7	4,973.2	4,399.5	-	4,389.5
	Сэлэнгэ	907.6	0.0	779.7	2,001.8	0.1	2,001.9	4,936.7	-	4,892.4
	Тэшиг	728.2	-	654.1	2,295.9	2.9	2,298.7	4,965.6	-	4,821.6
	Хангал	1,180.1	1.9	1,173.5	3,677.3	3.2	3,680.5	7,052.6	-	6,833.3
	Хишиг-Өндөр	684.1	59.3	555.6	3,362.2	10.6	3,372.8	4,703.5	-	4,681.5
	Хутаг-Өндөр	1,127.5	3.8	1,044.9	4,843.2	21.1	4,864.3	8,832.1	-	8,249.9
	Орхон	481.4	0.0	473.5	1,785.2	-	1,785.2	4,059.0	-	3,950.2
Баянхонгор	**Нийт дүн**	**26,663.5**	**298.8**	**21,384.2**	**157,022.4**	**2,578.3**	**156,805.1**	**204,081.6**	**-**	**194,154.8**
	Баянхонгор	10,212.8	251.6	6,303.3	66,512.5	2,324.1	66,084.5	115,558.8	-	105,850.8
	Баацагаан	1,082.9	-	977.9	4,212.1	-	4,212.1	5,112.6	-	5,112.6
	Баянбулаг	515.5	0.0	468.5	3,439.6	5.0	3,444.4	3,270.3	-	3,270.3
	Баянговь	550.9	0.0	534.3	2,645.2	1.6	2,646.8	4,657.8	-	4,657.8
	Баянлиг	710.0	-	558.6	6,510.8	37.9	6,548.7	6,211.8	-	6,211.8
	Баян-Овоо	478.5	-	377.6	853.7	0.0	853.8	3,095.3	-	3,095.3
	Баян-Өндөр	349.3	0.0	333.1	6,649.1	0.0	6,649.1	3,309.8	-	3,309.8
	Баянцагаан	671.4	1.1	652.0	6,128.0	7.3	6,135.3	4,750.4	-	4,750.4
	Богд	602.0	0.0	519.8	4,294.0	4.2	4,255.5	4,368.3	-	4,366.2
	Бөмбөгөр	657.4	34.3	579.3	4,554.4	0.2	4,554.6	6,740.6	-	6,740.6
	Буурцагаан	687.9	0.0	660.7	5,276.3	0.0	5,276.3	6,970.8	-	6,970.8
	Галуут	817.2	8.8	811.6	3,342.5	0.0	3,342.5	6,187.0	-	6,168.1
	Гурванбулаг	610.7	0.0	599.2	4,616.6	0.4	4,617.0	4,504.8	-	4,504.8
	Жаргалант	4,439.3	1.9	4,085.6	17,999.7	162.0	18,161.7	3,806.8	-	3,806.8
	Жинст	673.1	0.0	555.2	1,797.7	-	1,797.1	3,658.5	-	3,498.7
	Заг	506.0	-	496.1	3,192.0	-	3,192.0	3,725.5	-	3,707.0
	Өлзийт	588.3	0.0	576.5	2,898.7	0.2	2,898.9	4,986.2	-	4,986.2
	Хүрээмарал	515.3	0.0	491.8	3,382.4	1.3	3,383.7	3,486.8	-	3,467.2
	Шаргалжуут	362.3	-	358.9	1,417.9	0.0	1,417.9	1,159.8	-	1,159.8

	Шинэжинст	557.5	1.0	422.3	4,490.8	33.8	4,524.6	3,162.8	-	3,162.8
	Эрдэнэцогт	1,075.2	0.0	1,021.9	2,808.4	0.1	2,808.5	5,357.0	-	5,357.0
		Харилцах		Үүнээс: Иргэд	Хадгаламж		Үүнээс: Иргэд	Зээл		Үүнээс: Иргэд
Аймаг/Хот	Сум/Тосгон	Төгрөг	Валют		Төгрөг	Валют		Төгрөг	Валют	
Архангай	**Нийт дүн**	**29,510.8**	**92.1**	**25,371.8**	**165,857.8**	**1,526.3**	**166,467.5**	**151,955.2**	**-**	**146,663.1**
	Эрдэнэбулган	12,413.8	44.4	8,630.3	76,827.9	1,401.4	77,312.8	55,810.2	-	51,412.2
	Батцэнгэл	762.9	-	757.9	5,808.6	18.3	5,826.9	6,107.7	-	6,107.7
	Жаргалант	1,232.9	0.0	1,186.1	5,945.6	2.9	5,948.5	4,083.7	-	4,064.8
	Ихтамир	1,141.1	30.8	1,140.5	4,155.5	60.8	4,216.3	5,864.6	-	5,781.4
	Өгийнуур	461.3	0.0	437.7	2,950.8	0.6	2,951.4	5,169.8	-	5,157.1
	Өлзийт	744.4	10.7	730.8	5,864.5	0.6	5,865.0	6,982.6	-	6,982.6
	Өндөр-Улаан	1,513.3	-	1,498.9	6,059.3	0.2	6,059.5	4,650.4	-	4,650.4
	Тариат	1,475.0	0.0	1,437.6	5,401.3	0.5	5,401.9	6,757.8	-	6,528.7
	Төвшрүүлэх	730.8	0.0	727.7	2,971.2	18.0	2,989.2	5,372.9	-	5,170.4
	Хайрхан	807.4	0.0	764.5	6,723.7	0.4	6,724.1	6,507.4	-	6,507.4
	Хангай	601.4	-	594.4	3,564.2	-	3,564.2	3,209.8	-	3,209.8
	Хашаат	671.9	-	667.3	3,848.2	-	3,848.2	4,270.0	-	4,270.0
	Хотонт	1,128.7	0.0	1,115.0	5,095.4	0.8	5,096.2	6,996.8	-	6,924.7
	Цахир	718.7	-	690.3	4,099.0	-	4,099.0	3,077.5	-	3,077.5
	Цэнхэр	1,257.1	0.0	1,192.1	4,708.4	0.3	4,708.7	7,045.5	-	6,849.6
	Цэцэрлэг	890.8	-	867.8	5,957.4	-	5,957.4	4,714.3	-	4,714.3
	Чулуут	1,026.0	0.2	1,003.5	4,089.0	21.2	4,110.2	3,220.8	-	3,220.8
	Эрдэнэмандал	1,072.6	-	1,063.0	9,023.4	0.4	9,023.8	7,665.9	-	7,586.2
	Булган	860.7	5.8	866.3	2,764.3	-	2,764.3	4,447.3	-	4,447.3
Хөвсгөл	**Нийт дүн**	**37,378.6**	**434.5**	**28,618.1**	**200,709.7**	**3,972.8**	**201,988.6**	**220,734.1**	**6.4**	**209,254.4**
	Мөрөн	18,593.6	412.8	12,202.4	111,808.8	3,645.8	112,760.7	103,028.5	6.4	95,310.3
	Алаг-Эрдэнэ	629.6	-	596.7	2,424.0	0.2	2,424.2	4,461.8	-	4,461.8
	Арбулаг	720.9	2.8	704.8	2,095.5	-	2,095.5	5,078.3	-	5,078.3
	Баянзүрх	593.7	0.1	587.2	3,794.9	0.0	3,795.0	5,998.2	-	5,979.3
	Бүрэнтогтох	1,037.5	0.9	1,034.1	2,961.8	0.0	2,961.8	5,450.8	-	5,450.8
	Галт	1,183.1	1.2	1,156.8	6,652.2	5.5	6,657.7	6,820.9	-	6,820.9
	Жаргалант	898.5	0.1	719.0	6,719.3	0.1	6,719.4	5,516.9	-	5,511.5

	Их-Уул	1,120.9	0.4	1,039.3	4,494.1	0.1	4,494.2	6,419.0	-	6,379.0
	Рашаант	1,240.8	0.0	763.1	4,651.0	88.0	4,739.0	5,277.6	-	4,637.6
	Ренчинлхүмбэ	732.6	0.0	657.8	4,699.1	72.3	4,771.4	4,269.6	-	4,266.0
	Тариалан	1,778.6	0.6	1,059.2	6,004.3	43.9	6,048.3	11,119.7	-	8,888.3
	Тосонцэнгэл	705.3	0.0	623.1	3,984.8	-	3,984.8	5,537.2	-	5,537.2
	Төмөрбулаг	591.7	0.0	578.2	3,040.0	0.0	3,040.0	5,551.8	-	5,551.8
	Түнэл	601.6	0.0	591.9	2,251.6	-	2,251.6	5,697.4	-	5,697.4
	Улаан-Уул	791.3	0.1	745.1	3,638.4	-	3,638.4	4,899.7	-	4,899.7
	Ханх	435.5	0.0	426.7	2,004.9	-	2,004.9	4,913.5	-	4,913.5
	Хатгал	716.3	13.8	625.3	3,314.4	0.7	3,315.1	4,627.2	-	4,519.2
	Цагааннуур	417.6	1.0	412.5	1,903.7	0.8	1,904.5	2,729.6	-	2,714.8
	Цагаан-Уул	1,261.6	0.0	1,161.0	6,710.5	2.5	6,713.0	5,495.0	-	5,495.0
	Цагаан-Үүр	450.1	0.4	446.5	2,404.6	3.6	2,408.3	2,618.1	-	2,618.1
	Цэцэрлэг	966.9	0.0	843.9	4,385.5	65.7	4,451.2	5,237.7	-	5,237.7
	Чандмань-Өндөр	468.7	0.0	458.3	2,179.5	0.4	2,180.0	3,062.2	-	3,061.3
	Шинэ-Идэр	843.9	-	606.2	3,952.0	-	3,952.0	2,976.1	-	2,976.1
	Эрдэнэбулган	598.3	0.1	578.9	4,634.6	43.1	4,677.6	3,947.3	-	3,248.9
Төвийн бүс		**233,317.1**	**158,293.4**	**171,021.8**	**1,125,283.7**	**44,562.3**	**1,130,259.6**	**1,414,570.1**	**495.3**	**1,280,704.4**
Төв	**Нийт дүн**	**31,103.9**	**1,107.5**	**25,845.4**	**127,432.2**	**1,408.0**	**128,604.0**	**191,950.6**	**14.6**	**183,609.9**
	Зуунмод	9,624.7	923.1	6,473.5	42,513.2	862.0	43,324.6	65,054.0	-	57,539.9
	Алтанбулаг	1,007.5	0.0	941.1	2,760.8	13.3	2,774.1	6,258.3	-	6,258.3
	Аргалант	453.2	-	344.6	1,921.0	0.5	1,921.5	2,626.9	-	2,566.9
	Архуст	643.2	0.0	315.7	1,616.4	3.5	1,619.9	2,377.1	-	2,377.1
	Батсүмбэр	2,075.5	0.1	1,496.4	3,632.5	16.4	3,648.9	6,546.6	-	6,522.8
	Баян	445.1	0.0	443.2	2,295.3	0.0	2,295.3	5,411.7	-	5,411.7
	Баян-Өнжүүл	525.5	95.4	484.1	3,434.5	151.8	3,586.3	4,589.9	-	4,589.9
	Баяндэлгэр	361.5	-	357.0	1,293.5	59.9	1,353.4	1,486.9	14.6	1,501.5
	Баянжаргалан	348.3	19.3	358.0	3,005.2	131.6	3,136.7	2,156.3	-	2,156.3
	Баянхангай	440.0	0.1	400.2	1,040.1	0.3	1,040.5	3,170.7	-	3,170.7
	Баянцагаан	517.2	-	511.5	2,592.2	0.4	2,592.6	3,711.3	-	3,711.3
	Баянцогт	772.8	0.0	581.2	2,466.1	-	2,466.1	3,326.0	-	3,326.0
	Баянчандмань	856.0	0.1	837.5	3,865.7	6.5	3,872.2	5,987.0	-	5,987.0
	Борнуур	1,083.7	0.1	1,022.6	4,113.1	1.1	4,114.2	6,617.7	-	6,592.8

	Бүрэн	699.4	2.6	701.4	4,224.2	15.1	4,239.3	5,884.1	-	5,884.1
	Дэлгэрхаан	324.8	0.0	324.5	2,248.0	-	2,248.0	4,136.6	-	4,136.6
	Заамар	2,684.9	64.7	2,719.8	14,578.1	37.2	14,429.6	7,916.6	-	7,916.6
	Жаргалант	1,308.7	0.0	1,193.7	7,024.4	66.6	7,091.0	18,284.1	-	18,205.1
	Лүн	583.1	0.4	551.0	3,203.8	28.8	3,232.6	4,678.9	-	4,678.9
	Мөнгөнморьт	1,293.7	0.0	1,284.1	2,021.2	0.0	2,021.2	2,567.3	-	2,567.3
	Өндөршireэт	434.7	0.0	428.8	2,071.3	0.0	2,071.3	4,533.2	-	4,533.2
	Сэргэлэн	158.4	0.0	158.1	469.2	-	469.2	3,087.8	-	3,087.8
	Сүмбэр	488.6	0.0	473.3	1,256.1	0.1	1,256.1	2,561.5	-	2,561.5
	Уттаал	775.1	0.0	650.3	2,181.8	5.8	2,187.6	5,417.9	-	4,913.8
	Цээл	1,025.3	0.0	986.1	3,836.0	0.1	3,836.0	4,311.2	-	4,191.7
	Эрдэнэ	1,067.0	1.4	1,020.8	2,331.8	6.8	2,338.7	2,272.5	-	2,272.5
	Эрдэнэсант	1,106.0	0.0	786.7	5,436.9	0.2	5,437.1	6,978.8	-	6,948.8
Говьсүмбэр	**Нийт дүн**	**7,850.6**	**53.0**	**4,943.5**	**28,584.1**	**194.4**	**28,355.8**	**61,153.9**	**-**	**56,634.3**
	Сүмбэр	6,846.6	50.3	4,122.7	24,926.7	192.4	24,696.4	49,263.4	-	44,846.3
	Баянтал	158.4	0.0	151.5	1,105.5	0.6	1,106.1	3,161.2	-	3,161.2
	Шивээ-говь	845.6	2.6	669.2	2,551.9	1.4	2,553.3	8,729.2	-	8,626.8
		Харилцах		Үүнээс: Иргэд	Хадгаламж		Үүнээс: Иргэд	Зээл		Үүнээс: Иргэд
Аймаг/Хот	Сум/Тосгон	Төгрөг	Валют		Төгрөг	Валют		Төгрөг	Валют	
Сэлэнгэ	**Нийт дүн**	**44,804.5**	**9,495.5**	**36,975.0**	**154,017.2**	**3,538.7**	**156,335.4**	**263,085.3**	**451.7**	**241,321.6**
	Сүхбаатар	11,585.7	9,061.9	7,873.6	44,072.8	2,100.2	46,097.2	85,439.9	451.2	74,333.0
	Алтанбулаг	1,388.2	33.7	1,374.6	5,596.3	35.6	5,631.9	6,117.3	-	5,581.2
	Баруунбүрэн	890.0	0.1	737.4	2,763.8	0.6	2,764.5	4,071.1	-	3,991.1
	Баянгол	2,063.4	23.9	1,747.8	6,622.9	119.0	6,741.9	9,805.1	-	9,185.5
	Ерөө	2,920.7	0.7	2,461.9	9,921.3	76.2	9,997.5	14,847.0	-	12,986.9
	Жавхлант	750.3	0.1	653.7	1,221.0	0.0	1,221.0	3,348.6	-	3,348.6
	Зүүнбүрэн	739.2	0.0	732.8	3,059.6	5.3	3,064.8	2,995.1	-	2,948.0
	Мандал	13,629.2	120.2	11,746.6	44,103.0	751.9	44,849.4	73,212.2	-	69,989.2
	Орхон	462.9	-	421.2	903.6	2.3	905.8	3,240.9	-	2,878.2
	Орхонтуул	1,262.6	0.1	1,219.1	3,639.1	0.5	3,639.6	6,810.4	-	6,781.4
	Сант	571.6	0.0	559.7	1,442.2	0.4	1,442.6	5,731.4	-	5,731.4
	Сайхан	3,937.6	251.8	3,323.8	15,325.7	386.2	15,711.3	22,375.1	-	19,311.9

	Түшиг	540.7	0.1	536.3	1,257.0	3.2	1,260.2	2,666.2	-	2,666.2
	Цагааннуур	1,442.0	0.1	1,192.1	6,836.1	40.6	5,738.0	6,445.2	-	5,833.6
	Хушаат	743.8	0.5	597.2	1,808.7	0.1	1,808.8	2,968.3	-	2,768.3
	Хүдэр	873.5	0.0	854.3	2,374.1	0.1	2,374.1	4,094.2	-	4,069.1
	Шаамар	1,002.7	2.3	942.7	3,070.2	16.6	3,086.9	8,917.4	0.5	8,917.9
Дорноговь	**Нийт дүн**	**29,229.6**	**1,228.5**	**22,726.0**	**148,888.6**	**6,241.5**	**146,495.3**	**253,678.3**	**1.8**	**240,017.9**
	Сайншанд	12,963.8	770.7	7,976.8	56,686.5	2,003.4	56,475.1	104,222.1	-	95,497.1
	Айраг	858.7	5.9	808.1	3,524.0	1.9	3,525.8	6,584.5	-	6,584.5
	Алтанширээ	311.0	0.0	301.7	1,187.1	0.0	1,187.1	2,521.3	-	2,521.3
	Даланжаргалан	845.4	60.6	867.5	4,448.8	5.4	4,454.2	8,089.0	-	8,033.9
	Дэлгэрэх	592.6	0.2	560.5	1,295.2	0.4	1,295.6	4,727.1	-	4,727.1
	Замын-Үүд	8,766.1	355.1	7,798.4	62,174.5	4,106.2	59,860.7	94,351.4	1.8	89,515.0
	Иххэт	722.8	27.6	682.2	2,533.7	1.8	2,535.5	5,567.6	-	5,523.6
	Мандах	540.7	0.0	526.3	2,382.5	0.3	2,382.8	2,907.3	-	2,907.3
	Өргөн	504.1	0.3	496.3	2,109.9	85.3	2,195.2	5,310.8	-	5,310.8
	Сайхандулаан	397.0	-	395.2	1,164.5	0.1	1,164.6	2,740.8	-	2,740.8
	Улаанбадрах	437.0	0.0	420.4	2,284.4	0.1	2,284.5	2,764.6	-	2,764.6
	Хатанбулаг	1,224.6	1.6	944.1	4,785.2	25.0	4,810.2	5,812.3	-	5,812.3
	Хөвсгөл	375.8	6.2	373.7	1,954.8	6.1	1,960.9	3,304.5	-	3,304.5
	Эрдэнэ	689.9	0.2	574.8	2,357.7	5.6	2,363.3	4,775.1	-	4,775.1
Дархан-Уул	**Нийт дүн**	**46,261.5**	**1,924.6**	**33,334.1**	**346,152.7**	**22,087.8**	**361,071.6**	**277,947.1**	**25.5**	**225,549.8**
	Дархан	40,817.2	1,920.0	29,506.8	325,652.0	21,555.3	340,704.5	254,632.1	25.5	202,889.5
	Хонгор	1,416.6	1.7	1,343.8	4,751.5	56.9	4,808.4	7,966.4	-	7,387.6
	Шарын гол	3,532.8	2.8	2,029.4	13,576.2	472.2	13,382.3	11,057.4	-	11,057.4
	Орхон	494.8	0.0	454.1	2,173.0	3.4	2,176.5	4,291.1	-	4,215.3
Өмнөговь	**Нийт дүн**	**60,239.7**	**144,375.3**	**34,827.8**	**232,707.3**	**10,587.6**	**221,508.1**	**254,606.4**	**1.7**	**229,385.2**
	Даланзадгад	34,331.1	74,934.7	17,236.3	130,071.1	6,838.1	115,300.3	98,703.6	-	79,848.3
	Баяндалай	491.8	0.0	430.4	2,409.6	0.2	2,409.7	4,314.7	-	4,265.6
	Баян-Овоо	526.0	0.2	499.1	3,333.9	8.0	3,342.0	3,074.0	-	3,074.0
	Булган	623.8	1.0	547.9	3,094.1	14.1	3,108.2	3,324.4	-	3,324.4
	Гурвантэс	5,014.3	67,859.8	2,693.2	19,113.3	490.5	19,603.9	9,910.1	-	9,896.1
	Манлай	872.8	10.5	822.2	7,481.2	4.2	7,485.5	3,257.9	-	3,257.9
	Мандал-Овоо	611.7	3.3	551.4	2,350.0	0.5	2,350.5	3,773.3	-	3,557.0

	Номгон	695.6	0.1	572.4	4,558.3	0.6	4,558.9	4,792.4	-	4,792.4
	Ноён	468.3	0.4	404.6	2,888.2	26.7	2,912.4	2,937.5	-	2,937.5
	Сэврэй	690.5	0.5	600.8	5,076.0	5.8	5,081.9	2,776.7	-	2,776.7
	Ханбогд	5,927.8	677.0	4,751.2	23,936.6	1,862.0	25,789.4	63,200.1	-	62,709.5
	Ханхонгор	560.8	-	559.2	1,347.7	0.7	1,271.5	2,732.8	-	2,732.8
	Хүрмэн	616.0	40.1	480.4	1,529.9	0.1	1,530.0	3,386.0	-	3,386.0
	Цогт-Овоо	478.6	0.0	377.3	2,909.1	8.1	2,917.3	3,324.3	-	3,324.3
	Цогтцэций	8,330.7	847.7	4,301.4	22,608.1	1,327.9	23,846.6	45,098.6	1.7	39,502.6
Дундговь	**Нийт дүн**	**13,827.4**	**109.1**	**12,370.0**	**87,501.6**	**504.1**	**87,889.5**	**112,148.5**	**-**	**104,185.7**
	Сайнцагаан	6,179.3	86.5	5,092.7	42,750.1	453.3	43,087.1	50,154.4	-	43,085.5
	Адаацаг	589.2	0.0	554.4	2,324.0	-	2,324.0	5,795.0	-	5,723.4
	Баянжаргалан	330.6	0.0	307.1	1,927.3	0.5	1,927.8	3,391.2	-	3,391.2
	Говь-Угтаал	445.9	0.0	438.5	4,337.4	0.0	4,337.4	3,238.9	-	3,071.3
	Гурвансайхан	765.1	0.3	746.1	3,601.5	-	3,601.5	4,189.5	-	4,178.3
	Дэлгэрхангай	329.6	0.1	302.2	2,260.3	0.2	2,260.5	4,564.0	-	4,564.0
	Дэлгэрцогт	429.4	0.0	404.9	1,778.8	0.1	1,778.9	2,911.2	-	2,903.5
	Дэрэн	498.5	-	465.7	2,949.6	0.6	2,950.2	4,316.4	-	4,316.4
	Луус	519.0	0.0	415.8	3,665.9	-	3,665.9	3,475.7	-	3,226.2
	Өлзийт	559.9	0.0	558.4	2,650.4	-	2,650.4	6,289.1	-	6,287.7
	Өндөршил	456.0	0.0	440.7	4,547.4	12.7	4,560.1	3,832.6	-	3,709.6
	Сайхан-Овоо	501.6	1.5	491.0	2,805.9	0.5	2,806.4	3,542.6	-	3,383.6
	Хулд	564.9	0.0	545.0	4,430.8	0.0	4,430.9	4,747.7	-	4,747.7
	Цагаандэлгэр	208.2	0.0	189.0	1,374.7	19.0	1,393.7	3,019.4	-	3,001.9
	Эрдэнэдалай	1,450.0	20.5	1,418.6	6,097.6	17.2	6,114.8	8,680.8	-	8,595.5
Зүүн бүс		**73,238.3**	**6,408.6**	**56,470.9**	**369,164.3**	**41,527.9**	**377,883.4**	**504,173.2**	**27.0**	**469,155.3**
Дорнод	**Нийт дүн**	**29,154.2**	**4,645.5**	**21,095.8**	**137,223.3**	**7,924.5**	**143,349.2**	**203,050.6**	**26.2**	**181,926.5**
	Хэрлэн	21,911.7	4,617.4	14,354.7	108,266.3	7,785.7	114,254.9	147,066.3	26.2	126,034.0
	Баяндун	772.0	0.0	647.3	3,241.6	0.8	3,242.4	5,760.5	-	5,760.5
	Баян-уул	750.3	0.0	629.8	2,650.8	4.2	2,653.5	6,439.1	-	6,439.1
	Баянтүмэн	210.5	0.0	177.8	1,391.4	3.3	1,394.7	1,968.1	-	1,968.1
	Булган	384.0	-	373.6	1,173.8	34.8	1,208.6	3,130.6	-	3,082.8
	Гурванзагал	473.4	-	464.2	1,455.8	0.0	1,455.8	3,367.9	-	3,367.9
	Дашбалбар	661.1	0.7	613.3	4,025.1	0.9	4,026.0	6,441.5	-	6,441.5

	Матад	670.7	14.6	659.9	2,539.3	26.6	2,565.9	3,309.2	-	3,309.2
	Сэргэлэн	561.8	-	551.6	1,865.9	-	1,865.9	3,688.0	-	3,688.0
	Халхгол	794.8	12.7	741.1	2,197.1	26.9	2,224.0	5,510.5	-	5,507.5
	Хөлөнбуйр	285.8	0.0	269.9	1,558.7	0.1	1,558.8	2,937.4	-	2,907.4
	Цагаан-Овоо	613.4	0.0	568.2	3,532.4	0.0	3,532.4	6,207.2	-	6,207.2
	Чойбалсан	521.7	0.0	507.2	1,985.2	11.8	1,997.0	3,578.0	-	3,567.1
	Чулуунхороот	542.9	0.0	537.2	1,339.9	29.4	1,369.2	3,646.1	-	3,646.1
		Харилцах		Үүнээс: Иргэд	Хадгаламж		Үүнээс: Иргэд	Зээл		Үүнээс: Иргэд
Аймаг/Хот	Сум/Тосгон	Төгрөг	Валют		Төгрөг	Валют		Төгрөг	Валют	
Сүхбаатар	**Нийт дүн**	**21,451.1**	**1,277.1**	**16,228.0**	**98,911.7**	**29,641.9**	**98,268.5**	**134,495.0**	**-**	**127,695.0**
	Баруун-Урт	11,385.5	622.5	6,685.0	37,527.5	15,876.5	38,577.0	54,022.6	-	50,065.4
	Асгат	682.3	0.0	665.6	4,047.9	114.0	4,161.9	4,017.6	-	4,001.6
	Баяндэлгэр	1,058.0	3.7	1,035.3	7,374.5	1,994.9	9,369.3	7,344.2	-	7,302.7
	Дарьганга	855.3	0.2	814.6	4,863.8	0.7	4,864.5	3,539.0	-	3,539.0
	Мөнххаан	829.2	0.1	814.5	4,509.9	11.7	4,521.6	7,768.7	-	7,768.7
	Наран	434.3	0.0	418.8	2,997.7	23.2	3,020.9	2,217.0	-	2,217.0
	Онгон	913.2	55.4	907.9	4,996.1	17.5	5,013.6	6,464.7	-	6,418.6
	Сүхбаатар	1,774.8	586.6	1,474.6	15,594.2	11,459.0	11,595.2	21,948.2	-	19,336.2
	Түвшинширээ	547.9	0.0	543.2	2,402.0	9.6	2,411.6	5,392.4	-	5,392.4
	Түмэнцогт	614.3	0.1	593.3	3,792.2	1.2	3,793.4	3,189.3	-	3,137.0
	Уулбаян	473.7	-	454.2	2,243.2	2.1	2,245.3	4,546.5	-	4,546.5
	Халзан	490.7	-	486.7	2,480.5	-	2,480.5	2,426.5	-	2,426.5
	Эрдэнэцагаан	1,392.0	8.4	1,334.4	6,082.3	131.5	6,213.8	11,618.2	-	11,543.4
Хэнтий	**Нийт дүн**	**22,633.0**	**486.1**	**19,147.1**	**133,029.3**	**3,961.4**	**136,265.7**	**166,627.7**	**0.7**	**159,533.8**
	Хэрлэн	8,280.9	65.8	6,274.0	57,392.0	2,768.2	59,497.6	65,344.7	0.7	59,796.0
	Батноров	602.3	0.0	586.5	4,063.9	86.4	4,150.3	7,471.7	-	7,471.7
	Батширээт	814.3	0.1	788.9	3,583.0	0.1	3,583.1	2,505.6	-	2,455.6
	Баян-Адрага	716.4	-	543.6	2,683.3	0.0	2,683.3	3,336.0	-	3,202.5
	Баянмөнх	293.9	0.3	287.7	2,700.0	-	2,700.0	2,862.5	-	2,862.5
	Баян-Овоо	414.8	0.0	376.3	2,497.7	0.0	2,497.8	4,345.5	-	4,345.5
	Биндэр	1,905.7	0.0	1,332.4	5,934.5	9.3	5,943.7	4,273.8	-	4,080.8
	Галшар	385.2	0.0	372.3	1,568.7	0.2	1,568.9	3,994.5	-	3,994.5

	Гурванбаян	475.5	0.2	404.9	1,411.0	0.6	1,411.7	1,960.6	-	1,890.6
	Дадал	446.5	0.1	433.9	5,491.1	14.5	5,505.6	4,486.3	-	4,486.3
	Дархан	346.7	0.0	310.4	4,610.2	103.5	4,713.6	3,560.3	-	3,560.3
	Бор-Өндөр	3,089.3	409.4	2,836.1	16,395.9	735.4	17,068.8	29,258.2	-	28,192.1
	Дэлгэрхаан	465.1	1.4	431.0	2,295.7	0.1	2,295.8	4,549.7	-	4,549.7
	Жаргалтхаан	467.8	0.0	464.1	2,858.5	1.0	2,859.5	3,317.4	-	3,284.6
	Мөрөн	517.5	0.0	507.0	877.1	0.0	877.1	3,421.9	-	3,421.9
	Норовлин	633.8	0.2	467.3	4,401.3	69.7	4,471.0	4,282.6	-	4,282.6
	Өмнөдэлгэр	1,257.5	5.0	1,248.7	5,444.1	0.5	5,444.6	8,301.5	-	8,301.5
	Бэрх	639.9	3.5	626.7	5,591.6	26.2	5,617.8	1,743.3	-	1,743.3
	Цэнхэрмандал	478.7	0.1	457.5	1,848.5	145.5	1,993.9	4,085.4	-	4,085.4
	Баянхутаг	330.8	0.0	329.1	950.6	0.4	951.0	3,526.3	-	3,526.3
	Өлзийт	70.4	-	68.8	430.7	-	430.7	-	-	-
Нийт орон нутаг		**616,387.0**	**195,217.9**	**476,245.2**	**3,313,444.2**	**164,305.8**	**3,356,970.3**	**3,928,846.8**	**3,233.5**	**3,599,312.6**
Улаанбаатар хот		**2,812,340.2**	**1,785,603.2**	**1,084,866.7**	**9,900,845.4**	**4,476,691.0**	**11,927,369.8**	**11,196,141.5**	**1,527,914.9**	**4,888,774.5**